



БОЛОВСРОЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР



БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ  
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН



THE WORLD BANK  
IBRD • IDA | WORLD BANK GROUP

# II-V АНГИЙН МОНГОЛ ХЭЛНИЙ ХИЧЭЭЛИЙН СУРГАЛТЫН ЖИШИГ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ

(Баян-Өлгий аймгийн бага ангийн багш нарт зориулав)



Улаанбаатар хот  
2023 он



# II-V АНГИЙН МОНГОЛ ХЭЛНИЙ ХИЧЭЭЛИЙН СУРГАЛТЫН ЖИШИГ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ

(Баян-Өлгий аймгийн бага ангийн багш нарт зориулав)

Улаанбаатар хот  
2023 он



ННА  
74р

ДАА  
371.1

X-409

## **МОНГОЛ ХЭЛНИЙ ХИЧЭЭЛИЙН СУРГАЛТЫН ЖИШИГ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖИЙГ БОЛОВСРУУЛСАН БАГИЙН ГИШҮҮД:**

Багийн ахлагч:	У.Туяа	Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн секторын эрхлэгч
Багийн гишүүд:	Ж.Гэрэлмаа	Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн Монгол хэл бичгийн судалгаа аргазүйн төвийн эрдэм шинжилгээний ажилтан
	Ц.Баясгалан	Боловсролын ерөнхий газрын Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, үнэлгээний хөгжлийн газрын суралцахуйн орчин, хэрэглэгдэхүүний хөгжүүлэлт хариуцсан мэргэжилтэн
	Б.Аяужан	Баян-Өлгий аймгийн Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн захирал
	А.Аххайн	Баян-Өлгий аймгийн Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн бага ангийн багш
	М.Харшыга	Баян-Өлгий аймгийн Ерөнхий боловсролын 6 дугаар сургуулийн бага ангийн багш
	Б.Гүлжан	Баян-Өлгий аймгийн Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн сургалтын менежер
	З. Жанаргүл	Баян-Өлгий аймгийн Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн бага ангийн багш
Редактор:	Д.Эрдэнэсан	Монгол Улсын Багшийн их сургуулийн Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургуулийн Монгол хэлний тэнхимийн багш, доктор, дэд профессор
Техник редактор:	Л.Батсүрэн	Боловсролын ерөнхий газрын ТХБХ-ийн Үндэсний цөөнх, хилийн чанад дахь Монгол хүүхдийн хэл, соёлын асуудал хариуцсан арга зүйч, мэргэжилтэн

Энэхүү зөвлөмжийг Боловсрол, Шинжлэх Ухааны Яам, Дэлхийн Банкны хамтран хэрэгжүүлж буй “Боловсролын чанарын шинэчлэл төсөл”-ийн дэмжлэгээр боловсруулж хэвлэв.

© Боловсролын ерөнхий газар

ISBN 978-9919-9055-8-3

“Эдмаркет” ХХК-д эхийг бэлдэж хэвлэв.



## ГАРЧИГ

Удиртгал . . . . . 6

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН БАГА БОЛОВСРОЛЫГ ЭХ ХЭЛЭЭРЭЭ ЭЗЭМШИЖ БУЙ II-V АНГИЙН СУРАГЧДАД  
ЗОРИУЛСАН МОНГОЛ ХЭЛНИЙ ХИЧЭЭЛИЙН СУРГАЛТЫН ЖИШИГ ХӨТӨЛБӨР (БШУ-ы сайдын 2021 оны  
А/338 тоот тушаал) . . . . . 7

### **НЭГДҮГЭЭР ХЭСЭГ.** СУРГАЛТЫН ЖИШИГ ХӨТӨЛБӨРИЙГ ОЙЛГОХ НЬ


- 1.1. Тохируулгат сургалтын хөтөлбөр гэж юу? . . . . . 19
- 1.2. Сургалтын жишиг хөтөлбөрийг хэрхэн боловсруулсан бэ? . . . . . 19
- 1.3. Сургалтын жишиг хөтөлбөр ямар онцлогтой вэ? . . . . . 20
- 1.4. Монгол хэлний хичээлийн сургалтын жишиг хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд анхаарах зүйлс . . . . . 27

### **ХОЁРДУГААР ХЭСЭГ.** СУРАГЧДАД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА БОЛОН ДАСГАЛ АЖЛЫН ДЭВТРИЙН ХЭРЭГЛЭЭ

- 2.1. Гарын авлага болон дасгал ажлын дэвтрийн танилцуулга . . . . . 38
- 2.2. Нэгж болон ээлжит хичээлийн жишиг төлөвлөлт . . . . . 46
- 2.3. Нэгж хичээлийн үнэлгээний жишиг даалгавар . . . . . 107

## УДИРТГАЛ

Бага ангийн багш нарт зориулсан энэхүү зөвлөмж нь 2021 онд Боловсрол, шинжлэх ухааны сайдын А/338 дугаар тушаалаар баталсан Баян-Өлгий аймгийн ерөнхий боловсролын сургуулийн II-V ангийн сурагчдад зориулсан “Монгол хэлний хичээлийн сургалтын жишиг хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхэд багш нарт дэмжлэг үзүүлэх зорилготой.



Зураг. Зөвлөмжийн агуулга

Мөн БШУЯ, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн (БСҮХ)-ээс орон нутгийн бага ангийн багш нар болон багш бэлтгэх их сургуулийн багш, боловсролын байгууллагын мэргэжилтэн, судлаачдын төлөөлөлтэй хамтран боловсруулсан монгол хэлний гарын авлага, дасгал ажлын дэвтрийг сургалтад ашиглахтай холбоотой нэгж, ээлжит хичээлийн жишиг хөтөлбөр, заах арга зүй болон үнэлэх арга зүйн зөвлөмж, мэдээллийг багтаасан болно.

Сурагчид гарын авлагыг сургуулийн номын сангаар дамжуулан хэрэглэнэ. Дасгал ажлын дэвтэр нь бичиж, тэмдэглэхэд зориулсан тул номын сангаар дамжуулан ашиглах боломжгүй. Дасгал ажлын дэвтрийг жил бүр сурагчдын тоогоор олшруулан түгээхийг холбогдох байгууллагууд хариуцна. Гарын авлага дасгал ажлын дэвтрийн цахим хувилбар болон сонсох хэрэглэгдэхүүнийг [www.medle.mn](http://www.medle.mn) болон [www.mier.mn](http://www.mier.mn) веб сайтад байршуулах бөгөөд та бүхэн уг сайтаас авч ашиглах боломжтой.

II-V ангийн сурагчдад зориулсан монгол хэлний гарын авлага, дасгал ажлын дэвтэр нь монгол хэлний хичээлийн сургалтын жишиг хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд багш танд дэмжлэг болно гэдэгт итгэж байна.

ТА БҮХНИЙ СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ ИХ ҮЙЛСЭД АМЖИЛТ ХҮСЬЕ.



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2021 оны 10 сарын 04 өдөр

Дугаар А/338

Улаанбаатар хот

Жишиг хөтөлбөр батлах тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2 дахь заалт, Бага, дунд боловсролын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалт, Боловсролын хүрээлэнгийн 2021 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн 201 дүгээр албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Баян-Өлгий аймгийн ерөнхий боловсролын сургуулиудад бага боловсролыг эх хэлээрээ эзэмшиж байгаа II-Ү ангийн сурагчдад зориулсан "Монгол хэлний хичээлийн сургалтын жишиг хөтөлбөр"-ийг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү тушаалын хавсралтаар баталсан "Монгол хэлний хичээлийн сургалтын жишиг хөтөлбөр"-ийг 2022-2023 оны хичээлийн жилээс эхлэн ерөнхий боловсролын сургалтын сайжруулсан хөтөлбөртэй уялдуулан хэрэгжүүлэхийг Баян-Өлгий аймгийн Боловсролын газрын дарга /Г.Амантай/, энэхүү тушаалын 1 дэх хэсэгт заасан ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт тус тус үүрэг болгосугай.

3. "Монгол хэлний хичээлийн сургалтын жишиг хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Бага, дунд боловсролын газар /Т.Ням-Очир/, хөтөлбөр хэрэгжүүлэхэд арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Боловсролын хүрээлэн /П.Лхагвасүрэн/ нарт тус тус үүрэг болгосугай.


САЙД



Л.ЭНХ-АМГАЛАН

142111249

Боловсрол, шинжлэх ухааны сайдын  
2021 оны 10 дугаар сарын 24-ны  
өдрийн 11 дугаар тушаалын хавсралт.



**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД БАГА  
БОЛОВСРОЛЫГ ЭХ ХЭЛЭЭРЭЭ ЭЗЭМШИЖ БАЙГАА II-Ү АНГИЙН СУРАГЧДАД  
ЗОРИУЛСАН “МОНГОЛ ХЭЛНИЙ ХИЧЭЭЛИЙН СУРГАЛТЫН ЖИШИГ ХӨТӨЛБӨР”**

**УДИРТГАЛ**

Энэхүү Монгол хэлний хичээлийн сургалтын жишиг хөтөлбөрийг Монгол улсын бага боловсролын үндэсний сургалтын хөтөлбөрийн нийтлэг үндэслэл, сургалтын хөтөлбөр боловсруулсан зарчим, зорилго зорилтыг баримтлан, тус үндэсний хөтөлбөртэй адил бүтэц, дизайнтайгаар тохируулга хийж боловсруулсан болно. Үүний зэрэгцээ сурагчдын ялгаатай байдал (хэлний онцлог), монгол хэлийг сурагчид II ангиасаа эхлэн 4 жил судалж буй онцлог зэргийг харгалзсан.

Үндэсний бага боловсролын монгол хэлний сургалтын хөтөлбөрт тохируулга, агуулгын хуваарилалт хийхдээ сурагчдын онцлогт тохируулан тодруулах, шилжүүлэх зэрэг аргыг хэрэглэн сурагчид монгол (төрийн) хэлийг эзэмших, цаашид хичээлээ монгол хэлээр судлахад шаардлагатай унших, бичих, ярих, сонсох чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн агуулга, арга зүй, орчин, хэрэглэгдэхүүн, үнэлгээг багтаасан болно.

Үндэсний сургалтын хөтөлбөрт дараах байдлаар тохируулга хийсэн болно: Үүнд:

- Нэмэх, дэлгэрүүлэх
- Тодчилох (Тодорхой болгох)
- Хураах
- Шилжүүлэх
- Дахин найруулах (хялбаршуулах) зэрэг болно.

**НЭГ. ЗОРИЛГО, ЗОРИЛТ**

**1.1. Зорилго**

Сурагчид монгол хэлээр харилцах, унших, бичих чадвар эзэмшиж, монгол хэлийг хэрэглэх хүсэл эрмэлзэлтэй болно.

**1.2. Зорилт**

1.2.1. Хэл зүй, үгийн сангийн анхан шатны мэдлэг ойлголтыг эзэмших;

1.2.2. Монгол хэлээр сонсож, уншиж ойлгох, санаа бодлоо амаар болон бичгээр илэрхийлэх арга барил эзэмших;

1.2.3. Монгол хэл, соёлыг эрхэмлэн дээдлэх, суралцах хүсэл эрмэлзлийг төлөвшүүлэх; Монгол хэлний сургалтын жишиг хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах чадварыг эзэмшсэн байна.

Хэлний чадвар	2-5 дугаар ангид эзэмших чадвар
Хүлээн авах	С1. Харилцан ярилцахдаа сонсох аргад суралцах
	С2. Сонссон мэдээллийн агуулгыг ойлгосноо илэрхийлэх
	С3. Шүлэглэсэн эхийн утгыг ойлгож, цээжлэн тогтоох
	С4. Хүүрнэсэн эхийг сонсож, агуулгыг задлан шинжлэх
	С5. Хэрэглээний эхийг сонсож, чухал санааг ялгах



	Унших	У1. Уншлагын чадваруудыг (зөв, хурдан, ойлгож унших) эзэмших
		У2. Мэдээлэл, танилцуулгыг уншиж, агуулгыг тайлбарлах
		У3. Шүлэглэсэн эхийг уран унших
		У4. Хүүрнэсэн эхийг уншиж, агуулга, бүтцийг задлан шинжлэх
		У5. Хэрэглээний эхийг уншиж, зорилго, бүтцийг задлан шинжлэх
Илэрхийлэх	Ярих	Я1. Харилцан ярилцахдаа санаа бодлоо оновчтой илэрхийлэх
		Я2. Сэдвийн хүрээнд тоочин ярих
		Я3. Шүлэглэсэн эхийг цээжилж тогтоосноо харуулах
		Я4. Дүрийг төлөөлөн ярих (хүүрнэсэн эх)
		Я5. Нөхцөл байдалд тохируулан ярих (хэрэглээний эх)
	Бичих	Б1. Дэгийн дагуу, хичээнгүй бичих
		Б2. Эхийг загварын дагуу тоочин бичих
		Б3. Шүлэглэсэн эхийн хэлбэрийг дуурайн бичих
		Б4. Эхийг үйл явдлын дарааллаар хүүрнэн бичих
		Б5. Хэрэглээний эхийг бүтцийн дагуу зохион бичих
Хэрэглэх	Хэл зүй, үгийн сан	Х1.Зөв дуудах
		Х2. Зөв бичих
		Х3. Үгийн утга, үүргийг ойлгох, хэрэглэх
		Х4. Өгүүлбэрийг хэрэглэх
		Х5. Үгийн сан, толь бичгийг хэрэглэх

## ХОЁР. АГУУЛГА

### 2.1. Суралцахуйн зорилт

## II АНГИ

### СОНСОХ

- 2.С1. Харилцан ярилцахдаа асуулт, зааврыг анхааралтай сонсож, үг хэллэгийн авианы дуудлагыг ялгах
- 2.С2. Танилцуулгыг сонсоод, хэний, юуны тухай болохыг зургаар илэрхийлэх
- 2.С3. Шүлэг (дуу), зүйр цэцэн үгийг сонсож, давтан хэлэх замаар цээжлэн тогтоох
- 2.С4. Сонссон эхийн (үлгэр, хүүхэлдэйн кино) үйл явдлын дарааллыг цуврал зургаар илэрхийлэх
- 2.С5. Хаяг байршлыг заасан ярианаас чухал зүйлийг зураг, тэмдэглэгээ ашиглан илэрхийлэх

### УНШИХ

- 2.У1. Цагаан толгойн 35 үсгийг ялган таних, үе, үг, өгүүлбэрийг зөв дуудан, хурдан унших
- 2.У2. Зурагт танилцуулга, дасгалын зааврыг уншиж, түлхүүр үг хэллэгийг нүдэлж тогтоох
- 2.У3. Шүлэг (дуу), зүйр цэцэн үгийг бусдын өмнө тод, чанга дуугаар уран унших
- 2.У4. Үлгэр, богино эхийг уншиж, асуултад (хэн? юу? хаана? хэзээ? яасан?) бусдын дэмжлэгтэй хариулах
- 2.У5. Хаяг, байршлыг заасан эхийг уншиж, бүтэц (дараалал)-ийг тайлбарлах

### ЯРИХ

- 2.Я1. Харилцан ярилцахдаа санаа бодлоо ойлгомжтой, тод дуугаар илэрхийлэх
- 2.Я2. Өөрийгөө болон хүрээлэн буй юмсыг товч тоочин танилцуулах
- 2.Я3. Шүлэг (дуу), зүйр цэцэн үгсийн үе үгийг зөв хэлж, сольж гээлгүй, тод, чанга, цээжээр унших (хэлэх, дуулах)



2.Я4. Богино эхийн (үлгэр, хүүхэлдэйн кино) баатрын үг хэллэг, үйл хөдлөлийг дуурайн дүрд тоглох

2.Я5. Гэр, сургуулийн хаяг, байршлыг зураг ашиглан тайлбарлах, тодруулж асуух

### **БИЧИХ**

2.Б1. Үг, өгүүлбэр, эхийг хуулж бичихдээ дэгийн дагуу (том, жижиг үсгийн зурлага, холболт), цэвэр сайхан, алдаагүй бичих

2.Б2. Өөрийн болон хүрээлэн буй юмсын танилцуулгыг загвар ашиглан тоочин бичих

2.Б3. Үгсийг зөв дараалалд оруулах, нөхөх замаар шүлэг, зүйр үгийг гүйцээж бичих

2.Б4. Эхийг сэдэвт болон цуврал зургийн дагуу хүүрнэн бичих

2.Б5. Хаяг байршлыг газрын зураг, бүдүүвч ашиглан, тодорхойлж бичих

### **ХЭЛ ЗҮЙ, ҮГИЙН САН**

2.Х1. Богино, урт, хос эгшгийг ялган таньж, зөв дуудах

2.Х1. Цагаан толгойн үсгийг эгшиг, гийгүүлэгч, тэмдэг үсэг гэж ангилж, бүлэглэх

2.Х3. Хүн ба юмсын нэр, шинж чанар, тоо, үйл хөдлөл, орон байр, цаг хугацаа заасан үгсийн утгыг ялгаж, хэрэглэх

2.Х4. Оноосон нэр, өгүүлбэрийг том үсгээр эхлэн бичих, цэг тэмдгийг хэрэглэх

2.Х5. Танил бус үгийн үндсэн утгыг зурагт толь ашиглан тайлбарлах, хэрэглэх

## **III АНГИ**

### **СОНСОХ**

3.С1. Харилцан ярилцахдаа анхааралтай, идэвхтэй сонсож, ойлгосноо нүүрний хувирал, үйл хөдлөлөөр илэрхийлэх

3.С2. Гэр бүл, найз нөхөд, хүрээлэн буй орчны танилцуулгыг сонсож, зураг, дүрс, өнгөөр илэрхийлэх

3.С3. Шүлэг (дуу), зүйр цэцэн үг, ертөнцийн гурав, хэл зүгшрүүлэх үгийг сонсож, утгыг үйл хөдлөлөөр илэрхийлэх замаар цээжлэн тогтоох

3.С4. Сонссон эхийн (үлгэр, хүүхэлдэйн кино) үйл явдал хэрхэн өрнөхийг таамаглаж, асуултад хариулах

3.С5. Мэндчилгээ, талархал, уучлал хүссэн эхийг сонсож, чухал үг хэллэгийг ялган, тэмдэглэж тогтоох

### **УНШИХ**

3.У1. Харилцан яриаг (ойролцоо үгийн утгыг ялгаж) зөв, хурдан, ойлгож унших

3.У2. Гэр бүл, найз нөхөд, хүрээлэн буй орчны танилцуулгыг уншиж, агуулгыг асуултын дагуу тайлбарлах

3.У3. Шүлэг (дуу), зүйр цэцэн үг, ертөнцийн гурвыг дууны өнгө, хурд, хэмнэлийг тохируулан унших

3.У4. Үлгэр, богино эхийг уншиж, үйл явдлыг (эхлээд, дараа нь, эцэст нь), асуултын дагуу (хэн? хаана? хэзээ? юу? ямар учраас? яав?) тайлбарлах

3.У5. Мэндчилгээ, талархал, уучлал хүссэн эхийн зорилго, бүтцийг тайлбарлах

### **ЯРИХ**

3.Я1. Харилцан ярилцахдаа санаа бодлоо өөртөө итгэлтэй, чөлөөтэй илэрхийлэх

3.Я2. Гэр бүл, найз нөхөд, хүрээлэн буй орчны сэдэвт зургийг бүтэн өгүүлбэрээр, тоочин танилцуулах

3.Я3. Шүлэг (дуу), ертөнцийн гурав, зүйр цэцэн үг, хэл зүгшрүүлэх үгийг амьсгалаа зөв хуваарилж, түгдрэлгүй цээжээр унших (хэлэх, дуулах)

3.Я4. Эхийн (үлгэр, хүүхэлдэйн кино) баатрын үг яриаг цээжлэн тогтоож, харилцан яриагаар дүрд тоглох

3.Я5. Түлхүүр үгсийг ашиглан мэндчилэх, талархах, уучлал хүсэж ярих



## БИЧИХ

- 3.Б1. Өгүүлбэр, эхийг цээжээр бичихдээ дэгийн дагуу (том, жижиг үсгийн өндөр, өргөн, налуу, холболт) цэвэр сайхан, алдаагүй бичих
- 3.Б2. Гэр бүл, найз нөхөд, хүрээлэн буй орчны танилцуулгыг түлхүүр үг ашиглан загварын дагуу тоочин бичих
- 3.Б3. Ертөнцийн гурвын хэлбэрийг дуурайн зохион бичих
- 3.Б4. Эхийн үйл явдлын дарааллыг (богино үлгэр, өгүүллэг) түлхүүр үг, асуултын дагуу хүүрнэн бичих
- 3.Б5. Мэндчилгээ, талархал, уучлал хүссэн зурвасыг түлхүүр үг ашиглан, бүтцийн дагуу зохион бичих

## ХЭЛ ЗҮЙ, ҮГИЙН САН

- 3.Х1. Н, г, х, ц, ч, с, ш, зөөлөрсөн гийгүүлэгч авиа орсон үгсийг утга, дуудлага, бичлэгээр ялгах
- 3.Х2. Эр, эм, саармаг эгшиг болон эр, эм үгийг ялган таних, “-ы, -ий”-г хэрэглэх
- 3.Х3. Эх, өгүүлбэрээс хэн? юу? ямар? хэд хэчнээн? яах? яав? яасан? гэсэн асуултад хариулагдах үгсийг олох, эх, өгүүлбэр зохиоходоо хэрэглэх
- 3.Х4. Өгүүлбэрийг хэлэх зорилгоор (хүүрнэх, асуух, анхааруулах өгүүлбэр) ангилан ялгах, цэг тэмдгийг хэрэглэх
- 3.Х5. Ойролцоо ба эсрэг утгатай үгийг тайлбар толь бичиг ашиглан утгыг мэдэх, хэрэглэх

## IV АНГИ

### СОНСОХ

- 4.С1. Харилцан ярилцахдаа (илтгэл, хэлэлцүүлгийн үед) дуустал хүлээцтэй сонсож, асуулт асуух
- 4.С2. Бараа бүтээгдэхүүний танилцуулга-сурталчилгааг сонсож, агуулгыг зураглах
- 4.С3. Шүлэг, зүйр цэцэн үг, ертөнцийн гурав, оньсогыг сонсож, утгыг зурж дүрслэх замаар цээжлэн тогтоох
- 4.С4. Сонссон эхийн (үлгэр хүүхэлдэйн кино, болсон явдал) үйл явдал хаана, хэзээ өрнөж байгааг төсөөлж тайлбарлах
- 4.С5. Урилга, уриалга, номын тэмдэглэлийг сонсож, чухал санааг тодруулан ярилцаж тэмдэглэх

### УНШИХ

- 4.У1. Зохиолын баатруудын үг хэллэгийг харилцан ярианаас зөв, хурдан, ойлгож, унших
- 4.У2. Бараа бүтээгдэхүүний танилцуулга-сурталчилгаа, хаяг, шошго зэргийг уншиж, агуулгыг зураглах
- 4.У3. Шүлэг, оньсого, зүйр цэцэн үг, ертөнцийн гурвыг өргөлт, зогсолт, аялгыг тохируулан уран унших
- 4.У4. Үлгэр, өгүүллэгийн баатрын сайн, муу үйлийн учир шалтгааныг ойлгож, бодит амьдралтай харьцуулан жишээ татан дүгнэх
- 4.У5. Урилга, уриалга, номын тэмдэглэлийн зорилго, бүтцийг жишээ татан тайлбарлах

### ЯРИХ

- 4.Я1. Харилцан ярианд шинэ санаа нэмж оролцох
- 4.Я2. Бараа бүтээгдэхүүний танилцуулга, сурталчилгааг ойлгомжтой, сонирхолтой байдлаар тоочин танилцуулах
- 4.Я3. Цээжилсэн шүлэг, зүйр цэцэн үг, ертөнцийн гурав, оньсогыг ярианы хурд, дууны өнгийг тохируулан хэлэх
- 4.Я4. Эхийн (үлгэр, хүүхэлдэйн кино) баатруудын дуу хоолой, биеийн хөдөлгөөн, харцыг дуурайн дуу оруулан, дүрд тоглох
- 4.Я5. Урилга, уриалга, ном уншсан сэтгэгдлээ бусдад хүргэж ярих



## **БИЧИХ**

- 4.Б1. Өгүүлбэр, эхийг зохион бичихдээ тууш шугамтай дэвтэрт дэгийн дагуу (том, жижиг үсгийн өндөр, өргөн, налуу, холболт) цэвэр сайхан, алдаагүй бичих
- 4.Б2. Бараа бүтээгдэхүүний танилцуулга, хаяг шошго зэргийг асуулт, загварын дагуу тоочин бичих
- 4.Б3. Юмсын адил, төстэй шинжийг харьцуулан, утгыг далдалж оньсого, тааврыг дуурайн зохион бичих
- 4.Б4. Өөрт тохиолдсон явдлыг дарааллын дагуу хүүрнэн бичих
- 4.Б5. Уриалга, урилга, номын тэмдэглэлийг загвар ашиглан, бүтцийн дагуу зохион бичих

## **ХЭЛ ЗҮЙ, ҮГИЙН САН**

- 4.Х1. Үгийг үелэх
- 4.Х2. Балархай эгшгийн үүрэг (ялгах, эгшигжүүлэх, зөөлрүүлэх) -ийг тайлбарлах, хэрэглэх
- 4.Х3. Нэрийн (олон тоо, тийн ялгал, хамаатуулах) нөхцөлийн утгыг мэдэж, зөв хэрэглэх
- 4.Х4. Өгүүлбэр (хүүрнэх, асуух, анхааруулах, захирах) зохиож, хувиргах
- 4.Х5. Дуудлага ижил утга, бичлэг өөр үгсийн утгыг зөв бичих дүрмийн толь бичиг ашиглан мэдэх, хэрэглэх

## **V АНГИ**

### **СОНСОХ**

- 5.С1. Харилцан ярилцахдаа (илтгэл, хэлэлцүүлгийн үед) идэвхтэй, хүлээцтэй, зорилготой сонсож, санаа бодлоо илэрхийлэх
- 5.С2. Хувийн төлөвлөгөө, өдрийн тэмдэглэлийг анхааралтай сонсож, агуулгыг хүснэгт, бүдүүвчээр илэрхийлэх
- 5.С3. Шүлэг, ерөөл, магтаалыг сонсож, дүрслэлийг төсөөлөх замаар цээжлэн тогтоох
- 5.С4. Сонссон эхийн (үлгэр, өгүүллэг, болсон явдал) үйл явдлаас баатруудын хийсэн үйлийг ялган, дүгнэх
- 5.С5. Зарлал, мэдээг (радио, зурагт, нисэх онгоц, галт тэрэгний буудал, гудамж талбайн) сонсож, чухал зүйлийг лавшруулан тодруулж, тэмдэглэх

### **УНШИХ**

- 5.У1. Эхээс баатрын болон зохиолчийн үгийг ялган зөв, хурдан, ойлгож унших
- 5.У2. Хувийн төлөвлөгөө, өдрийн тэмдэглэлийг уншиж, агуулгыг харьцуулан тайлбарлах
- 5.У3. Шүлэг, бэлгэ дэмбэрлийн үгээс дүрслэлийн (хүншүүлсэн, адилтгасан, хэтрүүлсэн) санааг мэдэрч, уран унших
- 5.У4. Үлгэр, богино өгүүллэгийн эхлэл, гол, төгсгөлийн хэсгийн үйл явдлын ялгааг харьцуулж дүгнэх
- 5.У5. Зарлал, мэдээллийг эрж хайн сонгож унших, зорилго, бүтцийг тайлбарлах

### **ЯРИХ**

- 5.Я1. Харилцан ярилцахдаа өөрийн санаа бодлыг жишээ татан, оновчтой илэрхийлэх
- 5.Я2. Өөрийн гаргасан төлөвлөгөө, өдрийн тэмдэглэлийг товч тодорхой, тоочин танилцуулах
- 5.Я3. Цээжилсэн шүлэг, бэлгэ дэмбэрлийн үгийг мэдрэмж, сэтгэгдлээ илэрхийлэн унших
- 5.Я4. Эхийн (үлгэр, өгүүллэг, болсон явдал) баатруудын хэлэх үгийг таамаглан дуу оруулан жүжиглэх
- 5.Я5. Зарлал, мэдээг (радио, зурагт, нисэх онгоц, галт тэрэгний буудал, гудамж талбайн) бусдад ойлгомжтой, дэс дараалалтай дамжуулах

### **БИЧИХ**

- 5.Б1. Эхийг бүтцийн дагуу (эхлэл, гол, төгсгөл хэсэгтэй) догол мөрөөр зааглан цэвэр сайхан, алдаагүй бичих



5.Б2. Хувийн төлөвлөгөө, өдрийн тэмдэглэлийг хүсэл, мөрөөдөл, зорилгодоо нийцүүлэн бичих

5.Б3. Шүлэг, бэлгэ дэмбэрлийн үгийн хэлбэрийг дуурайн зохиож бичих

5.Б4. Эхийн (үлгэр, өгүүлэг, болсон явдал) үйл явдлыг учир шалтгааны уялдаа холбоотой, өрнүүлэн бичих

5.Б5. Зарлал, товч мэдээг баримт, зураг, график ашиглан, бүтцийн дагуу зохион бичих

## ХЭЛ ЗҮЙ, ҮГИЙН САН

5Х1. Я-ийн төрлийн эгшгийг зөв дуудан унших, “-ъ, -ь”-ийг зөв унших, бичих

5.Х2. Эгшигт, заримдаг, онцгой гийгүүлэгчийг ялган таних, эгшиг гээгдэх, гээгдэхгүй тохиолдлыг мэдэх, хэрэглэх

5.Х3. Үйл үгийн (холбох, төгсгөх) нөхцөлийн утгыг мэдэж, хэрэглэх

5Х4. Өгүүлбэрийг хураах, дэлгэрүүлэх.

5.Х5. Танил биш үг, зарим түгээмэл хэлц үгийн утгыг эх сурвалж (толь бичиг, нэвтэрхий толь, цахим сүлжээ) ашиглан ойлгож, толь бичиг хөтлөх

## 2.2. Хам сэдэв

Дараах хам сэдвүүдийн хүрээнд сурагчдын үгийн санг нэмэгдүүлж, суралцахуйн зорилтуудыг хэрэгжүүлнэ.

№	Хам сэдэв	2-р анги	3-р анги	4-р анги	5-р анги
1	Би	<ul style="list-style-type: none"> <li>✓ Би</li> <li>✓ Миний бие эрхтэн</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>✓ Миний товч танилцуулга (анкет)</li> <li>✓ Миний хүсэл, сонирхол</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>✓ Миний мөрөөдөл</li> <li>✓ Миний бахархал</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>✓ Миний намтар</li> <li>✓ Миний хувийн төлөвлөгөө</li> </ul>
2	Гэр бүл	<ul style="list-style-type: none"> <li>✓ Гэр бүлийн гишүүд</li> <li>✓ Тоо</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>✓ Гэр бүлийн чөлөөт цаг</li> <li>✓ Гэр бүлийн гишүүдийн ажил мэргэжил</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>✓ Гэр бүлийн гишүүдийн үүрэг хариуцлага</li> <li>✓ Гэр бүлийн бахархал</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>✓ Гэр бүл, төрөл садан</li> <li>✓ Ургийн мод</li> </ul>
3	Сургууль	<ul style="list-style-type: none"> <li>✓ Анги танхим</li> <li>✓ Хичээлийн хэрэглэл</li> <li>✓ Өнгө, дүрс</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>✓ Манай анги</li> <li>✓ Хичээл дээр</li> <li>✓ Ангийн дүрэм</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>✓ Дугуйлан</li> <li>✓ Миний найз нөхөд</li> <li>✓ Номын сан</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>✓ Эрдэм номын ач тус</li> <li>✓ Сургуулийн цайны газар</li> <li>✓ Уралдаан, тэмцээн</li> </ul>
4	Ажил хөдөлмөр	<ul style="list-style-type: none"> <li>✓ Өдөр, долоо хоног</li> <li>✓ Хичээлийн хуваарь</li> <li>✓ Өдөр тутмын ажил</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>✓ Цаг, хугацаа</li> <li>✓ Өдрийн дэглэм</li> <li>✓ Гэрийн ажилд туслах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>✓ Ажил, мэргэжил</li> <li>✓ Сурагчийн хөдөлмөр</li> <li>✓ Чөлөөт цаг</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>✓ Малчны хөдөлмөр</li> <li>✓ Урлаг</li> <li>✓ Спорт</li> </ul>
5	Хүрээлэн буй орчин харилцаа холбоо	<ul style="list-style-type: none"> <li>✓ Манай баг, хороо</li> <li>✓ Манай гэр, байшин</li> <li>✓ Утсаар ярих</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>✓ Манай аймаг, сум</li> <li>✓ Гэр, орон сууц</li> <li>✓ Тээврийн хэрэгсэл</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>✓ Миний эх орон Монгол улс</li> <li>✓ Хот, хөдөө</li> <li>✓ Замын хөдөлгөөн</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>✓ Дэлхийн улс орнууд</li> <li>✓ Байшин барилга</li> <li>✓ Цахим сүлжээ</li> </ul>
6	Эрүүл амьдрал	<ul style="list-style-type: none"> <li>Хоол хүнс (хүнсний ногоо, жимс жимсгэнэ)</li> <li>✓ Үдийн цай</li> <li>✓ Гараа арчлах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>✓ Хоол хүнс (цагаан идээ)</li> <li>✓ Гал тогоонд (хоолны жор)</li> <li>✓ Хувийн ариун цэвэр</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>✓ Хүнсний дэлгүүр, зах дээр</li> <li>✓ Хоолны цэс</li> <li>✓ Дасгал хөдөлгөөн</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>✓ Эрүүл хоол хүнс</li> <li>✓ Эрүүл амьдралын хэв маяг (аялал)</li> <li>✓ Эмнэлэг дээр</li> </ul>



7	Амьтад	<ul style="list-style-type: none"> <li>✓ Гэрийн тэжээмэл болон зэрлэг амьтад</li> <li>✓ Амьтны үр төл</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>✓ Таван хошуу мал, түүний ашиг шим</li> <li>✓ Шувууд</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>✓ Монгол орны амьтдын тухай</li> <li>✓ Амьтад хаана амьдардаг вэ?</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>✓ Ховордсон ан амьтад</li> <li>✓ Амьтдыг хамгаалах</li> </ul>
8	Байгаль дэлхий	<ul style="list-style-type: none"> <li>✓ Байгаль (ой, хээр, уул, ус, тэнгэр, газар)</li> <li>✓ Миний дуртай улирал</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>✓ Байгалийн үзэгдэл ба цаг агаарын мэдээ</li> <li>✓ Жилийн дөрвөн улирал ба цаг агаар</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>✓ Байгалийн болон түүхийн дурсгалт газрууд</li> <li>✓ Усны ач тус</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>✓ Эх дэлхий бидний гэр</li> <li>✓ Байгаль хамгаалал</li> </ul>
9	Хувцаслалт, хувийн соёл, харилцаа	<ul style="list-style-type: none"> <li>✓ Миний гутал, хувцас (охид, хөвгүүдийн хувцас)</li> <li>✓ Зан чанар</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>✓ Улирал ба хувцаслалт, хувцасны өнгө</li> <li>✓ Сэтгэл хөдлөл (ээрэг ба сөрөг)</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>✓ Хувцасны дэлгүүрт (эмэгтэй, эрэгтэй хувцас, хувцасны хэмжээ, үнэ)</li> <li>✓ Сэтгэл хөдлөлөө удирдах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>✓ Хувцас биеийн чимэг (хувцас, гутлыг арчлах)</li> <li>✓ Харилцааны соёл</li> </ul>
10	Уламжлал, ёс заншил, тэмдэглэлт баяр ёслол	<ul style="list-style-type: none"> <li>✓ Мэндлэх, хүндлэх ёс</li> <li>✓ Үндэсний тоглоом</li> <li>✓ Миний дуртай баяр (төрсөн өдөр, шинэ жил)</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>✓ Ахмадыг хүндлэх, талархах ёс</li> <li>✓ Үндэсний хоол</li> <li>✓ Бидний баяр (цагаан сар, наурызын баяр)</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>✓ Асарч тэтгэх ёс</li> <li>✓ Үндэсний хувцас</li> <li>✓ Хамтдаа баярлая (хүүхдийн баяр, эрийн гурван наадам)</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>✓ Ёс заншлаа дээдэлье (бэлгэдэл цээрлэх ёс)</li> <li>✓ Үндэсний бахархал</li> <li>✓ Баяр ёслол</li> </ul>

## ГУРАВ: АРГА ЗҮЙ БА ОРЧИН, ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

### 3.1 Арга зүйн онцлог

Монгол хэлний хичээл нь сурагчдын сонсохуй, уншихуй, бичихуй, ярихуйн үйлийг дэмжсэн “сурагч төвтэй” байна. Үүний тулд дараах арга зүйг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Асуудал шийдвэрлэх арга зүй (толь бичгийн ажил, үлгэр, өгүүллэг унших, эхтэй ажиллах, шүлэг цээжлэх, төрөлжсөн даалгавар гүйцэтгэх, зурагт хуудастай ажиллах, дүрийн тоглолт хийх зэрэг бие даан суралцаж, мэдлэг бүтээх арга барилыг хөгжүүлэх)
- Ялгаатай байдлыг харгалзах арга зүй (хэлний түвшин, хөгжлийн онцлог зэрэг сурагчдын түвшинд тохирсон, тэдний судалж буй сэдэвтэй ойр, танил эх, хам сэдвийг ашиглах)
- Үнэлгээний арга зүй (оношлох, явцын, үр дүнгийн үнэлгээ, өөрийн болон багшийн үнэлгээ, хэрэглэн сургалтын үйл ажиллагааны үр дүнг үнэлэх, төлөвлөх) Сургалтыг ганцаарчилсан, хосоор, багаар, хамтын хэлбэрээр зохион байгуулж, сурагчдыг идэвхтэй, бүтээлч үйл ажиллагаанд татан оролцуулах, тэдний бие биеэсээ суралцах, санаа бодлоо солилцох, бие биеэ хүндэтгэн харилцах, хариуцлагатай байх, өөрийгөө болон бусдыг үнэлэх, багаар болон хосоор хамтран ажиллахад нь дэмжлэг үзүүлнэ.

Толь бичиг хөтлөх, төрөл бүрийн бүтээл хийх (баримлын шавраар дүрслэх, зурах, эвлүүлэх, альбом, бяцхан ном) бүтээлийн үзэсгэлэн гаргах, дүрд тоглох зэрэг суралцахуйг дэмжсэн үйл ажиллагааг мэдээлэл харилцааны технологид суурилан, сурагчийн өөрийн үнэлгээтэй хослуулан хэрэгжүүлнэ.

### 3.2 Сургалтын орчин

*Сэтгэл зүйн орчин:*

- Ангийн уур амьсгал нь сурагч чөлөөтэй, айдасгүй, бие биеэ хүндэтгэн харилцах, монгол хэлээр өөрийгөө илэрхийлэх боломжтой, найрсаг орчинтой байх



#### *Материаллаг орчин:*

- Анги танхимын тавилга, тоног төхөөрөмж нь сурагчид хоорондоо болон багштай чөлөөтэй харилцаж болохуйц байрлалтай байх;
- Сурах бичиг, ном, гарын авлага, дасгал ажлын дэвтэр, толь бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн бүхий тусгайлан байгуулсан монгол хэлний булантай байх;

#### *Менежментийн орчин:*

- Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, багш, сурагчдын хөгжлийн хангахад сургуулийн удирдлага, эцэг эхийн зүгээс дэмжлэг үзүүлэх зохион байгуулалтын арга хэмжээнүүд байж болно.
- Сурагчийн хэрэгцээ сонирхол, насны онцлог, эзэмшсэн суурь чадварыг харгалзан тэдэнд үзүүлэх дэмжлэгийг тодорхойлох. Мөн ээлжит болон нэгж хичээлийн төлөвлөлтийг сайжруулахдаа сурагчдаас цуглуулсан мэдээлэлд (судалгаа) үндэслэнэ.

### **3.3. Сургалтын хэрэглэгдэхүүн**

Сургалтын хэрэглэгдэхүүн нь хүүхдийн нас сэтгэхүй, танин мэдэхүйн түвшинд тохирсон, хөгжлийн онцлог, үндэсний онцлог, хэлний түвшин зэрэг ялгаатай байдлыг харгалзан хүүхэд бүр ашиглах боломжтой, хүртээмжтэй, багшид дэмжлэг болохуйц байна. Тухайлбал:

- Баримт бичиг, ном, сурах бичиг: Сургалтын жишиг хөтөлбөр, суралцахуйн удирдамж, сурах бичиг, гарын авлага, дасгал ажлын дэвтэр, толь бичиг зэрэг болон шаардлагатай бол хууль, эрх зүйн баримт бичиг нь бага боловсролын сургалтын үйл ажиллагааг зохион байгуулахад багшид шаардлагатай арга зүйн дэмжлэг үзүүлэхүйц, хүртээмжтэй байх;
- Мэдээлэл, харилцааны технологи (МХТ): Сургалтын цахим, нээлттэй хэрэглэгдэхүүнийг (боловсролын цахим агуулга (CONTENT), сурах бичиг, теле болон интерактив хичээл)-ыг судлах, цахим сүлжээнд нэвтрэх компьютерын тоног төхөөрөмж нь багш, сурагчдад ашиглахад тохиромжтой, технологийн бэлэн байдлын шаардлагыг хангасан байх;
- Хэвлэмэл болон дижитал сургалтын хэрэглэгдэхүүн: Хэвлэмэл үзүүлэн (зурагт хуудас, хүснэгт, бүдүүвч), дэлгэцийн болох дуут хэрэгсэл (аудио бичлэг, видео кино, слайд үзүүлэх) зэрэг нь чанарын шаардлагыг хангасан байх.

Багш хичээл заахдаа унших, ярих, сонсох, бичих чадварыг тэнцвэртэй хөгжүүлэхүйц хүүхдийн онцлогт нийцсэн тохиромжтой хэрэглэгдэхүүнийг сонгоно. Үүнд:

#### *Сонсох чадварыг хөгжүүлэх:*

- Сурагчдын сонсох чадварыг хөгжүүлэхүйц танин мэдэхүйн түвшинд тохирсон үлгэр, дуу, шүлгийн цуглуулга, ажлын хуудас, цахим (аудио, видео, интерактив) хэрэглэгдэхүүн
- Харилцан ярианы загвар эхүүд (хэвлэмэл, аудио, цахим)
- Зорилготой, анхааралтай сонсох чадварыг хөгжүүлэх төрөл бүрийн өгүүлбэр, эхүүд, түүнд тохирсон дасгал, даалгаврын сан

#### *Ярих чадварыг хөгжүүлэх:*

- Сурагчдын хэл яриа, зөв дуудлагыг хөгжүүлэхүйц танин мэдэхүйн түвшинд тохирсон дуу, шүлгийн цомог, ТӨМ, бодит юмс, зураг, аудио, видео, ажлын хуудас
- Мэндчилэх, уучлах, талархах, уриалах зорилготой танил болон танихгүй хүмүүс, хамаатан садан, найз нөхөд, үе тэнгийнхэн, томчуул эсвэл өөрөөсөө бага хүүхдүүдтэй харилцахтай холбоотой бяцхан дүрийн тоглолт, харилцан ярианы загвар эхүүд (хэвлэмэл, аудио, цахим)
- Сургуулийн бага насны хүүхдийн нас, сэтгэц, танин мэдэхүйн онцлогт тохирсон аман зохиол болон уран зохиолын бус эхүүд

#### *Унших чадварыг хөгжүүлэхэд:*

- Зурагт болон үгэн картууд, харааны уншлагын картууд



- Зурагт толь, сурагчийн тайлбар толь, зөв бичих дүрмийн журамласан толь, хэлц үгийн толь, казах монгол толь, сурах бичгийн толь, харилцан ярианы толь гэх мэт толь бичгүүд
- Сургуулийн бага насны хүүхдийн нас, сэтгэц, танин мэдэхүйн онцлогт тохирсон уран зохиол, уран зохиолын бус эхүүд болон харилцан ярианы загвар эхүүд
- Зурагт болон хэвлэмэл үзүүлэн таниулах, тэмдэглэгээ, бүдүүвч, схем, мэдээлэл технологийн хэрэгсэл, бодит материалууд

**Бичих чадварыг хөгжүүлэх:**

- Төрөл бүрийн эхийн загвар (богино эх, ертөнцийн гурав, мэндчилгээ, танилцуулга, урилга, уриалга, захидал, өдрийн тэмдэглэл, номын танилцуулга)
- Үг, өгүүлбэр, зураг, тэмдэглэгээ бүхий картууд, дэгийн дагуу хичээнгүй, алдаагүй бичүүлэх, хүндэвтэр үгсийн толь хөтлөх дасгал, даалгаврууд
- Сургалтын идэвхтэй үйл ажиллагааг дэмжсэн дасгал даалгаврууд (харсан, дуртай зүйлс, тоглоомын талаар зурагт өгүүлбэр, бяцхан эх зохион бичих, өөрийн зохион бичсэн эхийг багшийн тусламжтайгаар шалгах)

**ДӨРӨВ. ҮНЭЛГЭЭ**

Сурагчийг оношлох, явцын болон үр дүнгийн үнэлгээгээр үнэлнэ. Оношлох үнэлгээ нь суралцах явцад гарч байгаа асуудал буюу түүний шалтгааныг тодорхойлох зорилгоор хичээлийн жил, хагас жил, улирал, бүлэг сэдвийн эхэнд сурагчийн мэдлэг, чадвар, хандлагын түвшнийг тандаж илрүүлэхэд чиглэнэ.

Явцын үнэлгээ нь сурагчийн ахиц амжилтын талаар мэдээлэл цуглуулах, суралцахуйг дэмжих, сайжруулах зорилгоор багш, сурагч, эцэг эхэд мэдээлэл өгөх, эргэх холбоо бий болгоход чиглэнэ.

Үр дүнгийн үнэлгээ нь сурагчийн тухайн хичээлийн жил, хагас жил, бүлэг сэдвийн хүрээнд эзэмшсэн мэдлэг, чадварын түвшнийг тогтоох, хандлага төлөвшилд үнэлэлт, дүгнэлт өгөхөд чиглэнэ. Үнэлгээний зорилт, шалгуур, жинг үндэслэн үр дүнгийн үнэлгээ хийнэ.

Сурагчдын хандлагыг ажиглалт, ярилцлага, рубрик зэрэг аргаар үнэлж болно.

Үнэлгээнд дараах үнэлгээний зорилт, шалгуур, жинг баримтална.

**4.1 Үнэлгээний зорилт**

- А. Үгийн сан, хэлзүйн мэдлэг, ойлголт
- Б. Мэдлэгээ хэрэглэх чадвар
- В. Хэл эзэмших хандлага

**4.2 Үнэлгээний шалгуур**

Үнэлгээний зорилт	Үнэлгээний шалгуур	II анги	III анги	IV анги	V анги
А. Мэдлэг, ойлголт	Зөв дуудах	Урт, хос, богино эгшигтэй үгийг ялган дуудах	“н, г” орсон үгийн утгыг ялгах, дуудах	Үгийг үелэх	я-ийн төрлийн эгшиг, ь, ь-тэй үгийн утгыг ялган зөв дуудах
	Зөв бичих	Цагаан толгойн үсэг, авиаг ялган, таних	“-ий, -ы”-г зөв бичих	Балархай эгшгийн үүргийг таних	Эгшиг гээгдэх, гээгдэхгүй тохиолдлыг ялгах
	Үгсийг бүлэглэн ангилал	Үгсийг сэдвийн дагуу ангилж, бүлэглэх	Үгсийг асуултаар бүлэглэх	Нэрийн нөхцөлийг зөв хэрэглэх	Үйлийн нөхцөлийг зөв хэрэглэх



		Өгүүлбэр зохиох, ангилах	3-4 үгтэй энгийн бүтэцтэй хүүрнэх, асуух өгүүлбэрийг ялгаж, цэг тэмдгийг зөв хэрэглэх	Өгүүлбэрийг хэлэх зорилгоор ангилах, цэг тэмдгийг зөв хэрэглэх	Хүүрнэх, асуух, анхааруулах, захирах өгүүлбэр зохиож, хувиргах	Өгүүлбэрийг хураах, дэлгэрүүлэх	
		Үгийн сан	Зурагт толь ашиглах (Үгийн нөөц 350-500)	Тайлбар толь ашиглах. Эсрэг ба ойролцоо үгийн утгыг ялгах (Үгийн нөөц 600-750)	Журамласан толь ашиглах. Ижил үгийн утгыг ялгах (Үгийн нөөц 1000-1200)	Төрөл бүрийн эх сурвалж ашиглах. Түгээмэл хэлц үг хэллэгийн утгыг мэдэх (Үгийн нөөц 1500-2000)	
Б. Мэдлэгээ хэрэглэх чадвар	Сонсох чадвар	Сонсох аргад суралцах	Анхааралтай сонсох	Анхааралтай, идэвхтэй сонсох	Дуустал хүлээцтэй сонсох	Зорилготой сонсох	
		Сонсож, ойлгосноо илэрхийлэх	Зургаар илэрхийлэх	Зураг, дүрс, өнгөөр илэрхийлэх	Агуулгыг зураглах	Хүснэгт, бүдүүвчээр илэрхийлэх	
		Сонссоноо тогтоох	Сонссоноо давтан хэлж, тогтоох	Сонссоноо үйл хөдлөлөөр харуулж, тогтоох	Сонссоноо дүрслэн харуулж, тогтоох	Сонссоноо төсөөлөн тогтоох	
		Үйл явдлын дарааллыг сонсож ойлгох	Үйл явдлын дарааллыг цуврал зургаар илэрхийлэх	Үйл явдлыг таамаглах, асуултад хариулах	Үйл явдлаас орон, цагийг ялгах, агуулгыг зураглах	Үйл явдлаас баатруудын үйлийг ялган дүгнэх	
		Сонссон зүйлээс чухлыг ялгах	Чухлыг зураг тэмдэглэгээгээр илэрхийлэх	Чухал үг хэллэгийг ялгах	Чухал санааг ялгах	Чухал зүйлийг лавшруулан тодруулах	
	Ярих чадвар	Харилцан ярилцах	Ойлгомжтой, тод дуугаар харилцах	Өөртөө итгэлтэй, чөлөөтэй харилцах	Шинэ санаа нэмж харилцах	Жишээ татан, баталж харилцах	
		Тоочин ярих	Товч тоочих	Бүтэн өгүүлбэрээр, ойлгомжтой тоочих	Сонирхолтой байдлаар тоочих	Товч тодорхой тоочих	
		Цээжилж тогтоосноо харуулах	Үе үгийг сольж гээлгүй, тод чанга хэлэх	Амьсгалаа зөв хуваарилж, түгдрэлгүй хэлэх	Ярианы хурд, дууны өнгийг тохируулах	Мэдрэмж, сэтгэгдлээ илэрхийлэх	
		Төлөөлөн ярих	Үг хэллэг, үйл хөдлөлийг дуурайн ярих	Харилцан ярилцаж, дүрд тоглох	Дуу хоолой, биеийн хөдөлгөөн, харцыг дуурайн дуу оруулах, дүрд тоглох	Хэлэх үгийг таамаглан, үг нэмж жүжиглэх	
		Нөхцөл байдалд тохируулан ярих	Зураг ашиглан ярих	Түлхүүр үгсийг ашиглаж ярих	Бусдад хүргэж ярих	Ойлгомжтой, дэс дараалалтай дамжуулж ярих	
	Унших чадвар	Зөв унших	Үе, үг, өгүүлбэрийг зөв дуудан унших	Ойролцоо үгсийг ялгаж унших	Харилцан ярианы үг хэллэгийг зөв унших	Баатрын болон зохиолчийн үгийг ялгаж унших	
		Хурдан унших (танил бус ба танил эх)	Нэг минутад зөв уншсан үгийн тоог нийт уншсан үгийн тоотой харьцуулж тооцож түвшнийг тодорхойлох (97-100% бол чадварлаг, 90-96% бол хангалттай, 90%-аас доош бол хангалтгүй)				
			Намар	30-60 үг	50-90 үг	70-110 үг	80-120 үг
			Өвөл	50-80 үг	70-100 үг	80-120 үг	100-140 үг
			Хавар	70-100 үг	80-110 үг	100-140 үг	110-150 үг
	Эхийн агуулгыг ойлгон унших	Түлхүүр үг хэллэгийг тогтоох	Агуулгыг асуултын дагуу тайлбарлах	Агуулгын зураглал хийх	Агуулгыг харьцуулан тайлбарлах		



		Уран унших	Бусдын өмнө тод, чанга дуугаар унших	Уншлагын хурд, хэмнэл, дууны өнгийг тохируулан унших	Өргөлт, зогсолт, аялгыг тохируулан унших	Дүрслэлийг ялган, зохиолчийн санааг мэдэрч унших	
		Хүүрнэсэн эхийн агуулга, бүтцийг задлан шинжлэх	Эхийн баатрууд болон тэдний үйл хөдлөлийг нэрлэж, асуултад бусдын дэмжлэгтэй хариулах	Эхийн үйл явдлын дарааллыг асуултын дагуу тайлбарлах	Эхийн баатруудын сайн, муу үйлийн учир шалтгааныг бодит амьдралтай харьцуулан жишээ татах	Эхийн эхлэл, гол, төгсгөлийн хэсгийн үйл явдлын ялгааг харьцуулах	
		Хэрэглээний эхийн зорилго, бүтцийг задлан шинжлэх	Эхийн бүтцийг тайлбарлах	Эхийн зорилго, бүтцийг тайлбарлах	Эхийн зорилго, бүтцийг жишээ татан тайлбарлах	Сонгон уншиж, зорилго, бүтцийг тайлбарлах	
	Бичих чадвар	Хичээнгүй бичих	Хуулж бичихдээ дэгийн дагуу, цэвэр сайхан, алдаагүй бичих	Цээжээр бичихдээ дэгийн дагуу цэвэр сайхан, алдаагүй бичих	Зохион бичихдээ тууш шугамтай дэвтэрт дэгийн дагуу цэвэр сайхан, алдаагүй бичих	Догол мөрөөр зааглан, цэвэр сайхан, алдаагүй бичих	
		Тоочин бичих	Загварын дагуу үгийн нөөцөө ашиглан тоочих	Загварын дагуу түлхүүр үг ашиглан тоочих	Загварын дагуу асуултад хариулан тоочих	Хүсэл, мөрөөдөл, зорилгодоо нийцүүлэн бичих	
		Дуурайн бичих	Үгсийг зөв дараалалд оруулан, нөхөж, гүйцээн бичих	Хэлбэрийг дуурайн бичих	Утгыг далдалж, дуурайн бичих	Хэлбэрийг дуурайн, шүлэглэж бичих	
		Хүүрнэн бичих	Зургийн дагуу хүүрнэн бичих	Түлхүүр үг, асуултын дагуу хүүрнэн бичих	Дарааллын дагуу хүүрнэн бичих	Үйл явдлыг учир шалтгааны уялдаа холбоотой, өрнүүлэн бичих	
		Бүтцийн дагуу зохион бичих	Газрын зураг, бүдүүвч ашиглан тодорхойлж бичих	Түлхүүр үг ашиглан, бүтцийн дагуу зохион бичих	Загвар ашиглан, бүтцийн дагуу зохион бичих	Баримт, зураг, график ашиглан, бүтцийн дагуу зохион бичих	
	В. Хандлага	1. Бусдыг хүндэтгэн сонсож байгаа эсэх					
		2. Бусдын өмнө тодорхой ярихыг чармайж байгаа эсэх					
3. Багаар ажиллаж, бусдыг ойлгон, хүндэтгэлтэй харилцах							
4. Ном унших сонирхолтой болж, уншсанаа хуваалцах							
5. Хэл сурах хүсэл сонирхолтой эсэх							

### 4.3. Үнэлгээний жин

Үнэлгээний зорилт	Эзлэх хувийн жин
Мэдлэг, ойлголтыг үнэлэх даалгавар	40%
Мэдлэг, ойлголтоо хэрэглэх чадварыг үнэлэх даалгавар	60%



# НЭГДҮГЭЭР ХЭСЭГ.

## СУРГАЛТЫН ЖИШИГ ХӨТӨЛБӨРИЙГ ОЙЛГОХ НЬ

### 1.1 | ТОХИРУУЛГАТ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР ГЭЖ ЮУ ВЭ?

Өнөө үед дэлхий дахин хэнийг ч орхихгүй, ялангуяа, ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг орхилгүй, тэдний харилцан адилгүй эрэлт хэрэгцээнд нийцүүлэн тэгш хамран сургахыг чухалчилж байна. Хүүхэд бүрийг тэгш хамран сургахад сургалтын хөтөлбөр чухал ач холбогдолтой. Сургалтын хөтөлбөр бол багш бидний хувьд хичээлээ зохион байгуулах, сурагчдаа удирдан чиглүүлэхэд баримталдаг «замын зураг», удирдамж байдаг.

Ялгаатай сургалтын хөтөлбөр, суралцахуйн зорилт нь үр дүнгийн хувьд өөр шаардлага агуулж, тэгш хамралтад саад учруулж, ялгаварласан байдал үүсгэдэг болохыг Боловсролын хяналт шинжилгээний дэлхийн тайланд тэмдэглэсэн байна. Тухайлбал, казах хүүхдүүд монгол хэл сурч чадахгүй тул тэдэнд зориулсан монгол хэлний сургалтын хөтөлбөрийг түвшин доогуур боловсруулах, суралцахуйн үр дүнг үе тэнгийнхнээс нь доогуур түвшинд үнэлэх гэсэнтэй агаар нэг. Үүнийг шийдэх арга зам нь уян хатан, сонголттой, ач холбогдолтой тохируулгат сургалтын хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх явдал юм.

Сургалтын хөтөлбөрийг өөрчлөх, тохируулга хийх нь мэргэжлийн, нарийн үйл явц байдаг. Тухайлбал, сургалтын агуулга-суралцахуйн зорилт, үнэлгээ, сургалтын хэрэглэгдэхүүн, багшлахуй, сургалтын орчин зэрэг сургалтын хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсгүүдийн хүрээнд тохируулга хийх хэрэгтэй болдог. Сургалтын агуулгыг өөрчлөхөө хэт доогуур түвшинд болгох, агуулгын уян хатан байдлыг санал болгох зэрэг нь сурагчид болон сургуулиудын хооронд хүсээгүй ялгааг бий болгож, нийгмийн ялгаатай бүлгийн тухайлбал, чинээлэг болон амьжиргааны түвшин доогуур өрхийн хүүхдүүдийн хоорондын зөрүүг ихэсгэж болзошгүйг судлаачид анхааруулдаг. Сургалтын хөтөлбөрт тохируулга хийх замаар өөрчлөлт оруулахын өмнө сурагч бүрийн сургалтын зорилго, хэрэгцээг тодорхойлж, тэдний чадварыг үнэлсэн байх учиртай.

### 1.2 | СУРГАЛТЫН ЖИШИГ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРХЭН БОЛОВСРУУЛСАН БЭ?

Монгол Улсын ерөнхий боловсролын сургуулийн бага ангид монгол хэл, математик, хүн ба орчин, хүн ба байгаль зэрэг үндэсний сургалтын хөтөлбөр хэрэгжүүлдэг. Эдгээрээс монгол хэлний сургалтын хөтөлбөрт Баян-Өлгий аймгийн бага боловсролыг эх хэлээрээ эзэмшиж буй II-V ангийн сурагчдад зориулан тохируулга хийв. Учир нь тус аймгийн бага боловсролыг эх хэлээрээ эзэмшиж буй сурагчдын нөхцөл байдал дараах онцлогтой. Үүнд:

- Бага боловсролын Монгол хэлний сургалтын хөтөлбөрийг I ангиас хэрэгжүүлж эхэлдэг бол Баян-Өлгий аймгийн зарим сургуулийн бага ангийн сурагчид II ангиасаа монгол хэлийг судалж эхэлдэг.
- Сурагчид гэртээ болон СӨБ-д эх хэлээрээ (казах, тува) харилцаж байгаад сургуульд элсэн ордог.
- II-V ангид бага боловсролын Монгол хэлний сургалтын хөтөлбөрөөр хичээл сургалтыг зохион байгуулж ирсэн нь сурагчдад дараах хүндрэл бэрхшээлийг учруулдаг байна. Үүнд:
  - ✓ Монгол хэлний үндэсний сургалтын хөтөлбөрийг судлахад агуулгын хувьд зарим талаар хүнддэх, 1 жилээр хоцорч судалдаг тул агуулга нь багтахгүй байх;
  - ✓ Бага ангиас эхлэн сурагчид монгол хэлний хичээлээр сурлагын хоцрогдолд орсны улмаас дунд болон ахлах ангидаа амжилттай суралцахад сөргөөр нөлөөлөх;

Дээр дурдсан нөхцөл байдалтай холбоотойгоор үндэсний хэмжээнд I-V дугаар ангид 5 жил хэрэгжүүлдэг Монгол хэлний үндэсний сургалтын хөтөлбөрийг II ангиас эхлэн 4 жил судлахад зориулан агуулгын хуваарилалт хийх, агуулгыг үндэсний цөөнхийн хүүхдүүдэд зориулан боловсруулах, улмаар бага боловсролыг төгсөхдөө эзэмшсэн байх монгол (төрийн) хэлний мэдлэг, чадварыг тодорхойлох байдлаар тохируулах хэрэгцээ шаардлага гарсан байна.



Боловсрол, шинжлэх ухаан (БШУ)-ы сайдын 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн А/338 дугаар тушаалаар Баян-Өлгий аймгийн ерөнхий боловсролын сургуулиудад бага боловсролыг эх хэлээрээ эзэмшиж байгаа II-V ангийн сурагчдад зориулсан “Монгол хэлний хичээлийн сургалтын жишиг хөтөлбөр”-ийг (цаашид Сургалтын жишиг хөтөлбөр гэх) баталсан. Уг тушаалаар баталсан сургалтын жишиг хөтөлбөрийг 2022-2023 оны хичээлийн жилээс ерөнхий боловсролын сайжруулсан сургалтын хөтөлбөртэй уялдуулан хэрэгжүүлэхийг Баян-Өлгий аймгийн Боловсролын газрын даргад, холбогдох ЕБС-ийн удирдлагад, хөтөлбөрийн хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг БШУЯ-ны Бага, дунд боловсролын газарт, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Боловсролын хүрээлэнд тус тус үүрэг болгосон байна.

Энэхүү хэрэгцээг үндэслэн сургалтын жишиг хөтөлбөрийг бага боловсролын монгол хэлний үндэсний сургалтын хөтөлбөрийн нийтлэг үндэслэл, сургалтын хөтөлбөр боловсруулсан зарчим, зорилго зорилтыг баримтлан, үндэсний хөтөлбөртэй адил бүтэц, дизайнтайгаар тохируулга хийсэн бөгөөд Баян-Өлгий аймгийн БСУГ-ын бага боловсрол болон монгол хэлний сургалт хариуцсан арга зүйч, бага ангийн багш нар, БСҮХ-ийн ЭША, БМДИ-ын арга зүйчдийн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ажилласан болно. Сургалтын жишиг хөтөлбөрийг боловсруулах хугацаанд тухайн орон нутгийн бага ангийн багш нарт танилцуулж, санал авч тусгасан байна.

Сургалтын жишиг хөтөлбөр нь үндэсний цөөнхийн хүүхдийн төрийн хэл-монгол хэлийг сурах, цаашид хичээлээ монгол хэлээр судлахад шаардлагатай унших, бичих, ярих, сонсох чадварыг хөгжүүлэхэд ач холбогдолтой юм.

### 1.3 | СУРГАЛТЫН ЖИШИГ ХӨТӨЛБӨР ЯМАР ОНЦЛОГТОЙ ВЭ?

Дээр танилцуулснаар сургалтын жишиг хөтөлбөрт бага боловсролын монгол хэлний сургалтын хөтөлбөрийн нийтлэг үндэслэл, сургалтын хөтөлбөр боловсруулсан зарчим, зорилго зорилтыг баримтлан, сургалтын хөтөлбөртэй адил бүтэц, дизайнтайгаар тохируулга хийсэн.

Сургалтын жишиг хөтөлбөрийг хэрэгжүүлснээр сурагчид монгол хэлээр харилцах, унших, бичих чадвар эзэмшиж, монгол хэлийг хэрэглэх хүсэл эрмэлзэлтэй болох зорилгод хүрсэн байх учиртай бөгөөд үүний тулд үндсэн гурван зорилт тавьсан.

Мөн сурагчдын эзэмшсэн байх чадварыг хэлний хүлээн авах, илэрхийлэх, хэрэглэх чадварын хүрээнд тодорхой заасан болно.

Сурагчдын эзэмших хүлээн авах чадвар	
Сонсох чадвар	Унших чадвар
C1. Харилцан ярилцахдаа сонсох аргад суралцах	У1. Уншлагын чадваруудыг (зөв, хурдан, ойлгож унших) эзэмших
C2. Сонссон мэдээллийн агуулгыг ойлгосноо илэрхийлэх	У2. Мэдээлэл, танилцуулгыг уншиж, агуулгыг тайлбарлах
C3. Шүлэглэсэн эхийн утгыг ойлгож, цээжлэн тогтоох	У3. Шүлэглэсэн эхийг уран унших
C4. Хүүрнэсэн эхийг сонсож, агуулгыг задлан шинжлэх	У4. Хүүрнэсэн эхийг уншиж, агуулга, бүтцийг задлан шинжлэх
C5. Хэрэглээний эхийг сонсож, чухал санааг ялгах	У5. Хэрэглээний эхийг уншиж, зорилго, бүтцийг задлан шинжлэх

Эх сурвалж. “Монгол хэлний хичээлийн сургалтын жишиг хөтөлбөр”-өөс, БШУ-ы сайдын А/338 дугаар тушаал

#### Суралцахуйн зорилт

Үндэсний сургалтын хөтөлбөрийн суралцахуйн зорилтыг тухайн бүлгийн сурагчдад зориулан ойлгомжтой, хэрэгжүүлэх болон хэмжихэд дөхөм болгох үүднээс дараах байдлаар тохируулсан.



- **Нэмэх, дэлгэрүүлэх:** Жишээ нь, Үндэсний хөтөлбөрийн 1.3б. Бусдын яриа, асуулт, зааврыг анхааралтай сонсож ойлгосноо харуулах гэсэн суралцахуйн зорилтыг Сургалтын жишиг хөтөлбөрт “2.С5. Хаяг байршлыг заасан ярианаас ойлгосноо зураг, тэмдэглэгээ ашиглан илэрхийлэх, 3.С1. Яриаг анхааралтай, идэвхтэй сонсож, ойлгосноо нүүрний хувирал, үйл хөдлөлөөр илэрхийлэх, 3.С2. Гэр бүл, найз нөхөд, хүрээлэн буй орчны тухай эхийг сонсоод, агуулгыг зураглах, 4.С2. Бараа бүтээгдэхүүний танилцуулга-сурталчилгаа, хаяг шошгыг сонсож, чухал санааг зураг, дүрс, өнгөөр илэрхийлэх” гэх мэт.
- **Тодчилох (Тодорхой болгох):** Жишээ нь, Үндэсний хөтөлбөрийн 0.1а. Бусдын уншсан үлгэр, өгүүлэгийг сонсож, асуултад хариулах гэсэн суралцахуйн зорилтыг Сургалтын жишиг хөтөлбөрт “2.С4. Сонссон эхийн (үлгэр, хүүхэдэйн кино) үйл явдлын дарааллыг цуврал зургаар тодорхойлох, бусдын дэмжлэгтэйгээр асуултад хариулах” гэж найруулсан.
- **Хураах:** Жишээ нь, Үндэсний хөтөлбөрийн бичих чадварын 0.3а. Үсэг бүтээдэг зурлагуудыг дэвтрийн шугамаар баримжаалан дэгийн дагуу бичих зэрэг суралцахуйн зорилтыг Сургалтын жишиг хөтөлбөрт “2.Б1. Үг, өгүүлбэрийг хуулж болон цээжээр бичихдээ дэгийн дагуу (том, жижиг үсгийн зурлага, холболт), цэвэр сайхан, алдаагүй бичих” болгон хураасан.
- **Шилжүүлэх:** Үндэсний хөтөлбөрийн бичих чадварын дараах суралцахуйн зорилтуудыг жишиг хөтөлбөрийн “Хэл зүй, үгийн сан” руу шилжүүлсэн. Тухайлбал, 2.Х1. Цагаан толгойн үсгийг эгшиг, гийгүүлэгч, тэмдэг үсэг гэж ангилж, бүлэглэх, 3.Х2. “Эр, эм, саармаг” эгшиг болон эр, эм үгийг «-ы, -ий»-г ялган таних, хэрэглэх, 4.Х2. Үгийг үеэр таслах, мөр шилжүүлж зөв бичих, 5.Х1. Балархай эгшгийн үүрэг (ялгах, эгшигжүүлэх, зөөлрүүлэх) -ийг тайлбарлах, хэрэглэх гэх мэт.
- **Дахин найруулах (хялбаршуулах):** Үндэсний хөтөлбөрийн 5.1в. Уншсан жүжгийн зохиолын гол санааг тайлбарлах, 5.1д. Эхээс хүншүүлсэн, хэтрүүлсэн дүрслэлийг тайлбарлах замаар үлгэрийн утгыг ойлгосноо харуулах гэсэн суралцахуйн зорилтуудыг “5.У3. Шүлэг, бэлгэ дэмбэрлийн үгээс дүрслэлийн (хүншүүлсэн, адилтгасан, хэтрүүлсэн) санааг мэдэрч, уран унших” гэх мэт.
- **Нэгтгэх:** Үндэсний хөтөлбөрийн 5.1в. Уншсан жүжгийн зохиолын гол санааг тайлбарлах, 5.1д. Эхээс хүншүүлсэн, хэтрүүлсэн дүрслэлийг тайлбарлах замаар үлгэрийн утгыг ойлгосноо харуулах гэсэн суралцахуйн зорилтуудыг “5.У3. Эхээс (шүлэг, жүжиг) хүншүүлсэн, адилтгасан, хэтрүүлсэн дүрслэлийг ялгаж, тайлбарлах, эхийг уран унших” гэх мэт.



Зураг. Суралцахуйн зорилтыг тохируулсан аргачлал (жишээ)

**2.2. Хам сэдэв**

Дараах хам сэдвүүдийн хүрээнд сурагчдын үгийн санг нэмэгдүүлж, суралцахуйн зорилтуудыг хэрэгжүүлнэ.

№	Хам сэдэв	2-р анги	3-р анги	4-р анги	5-р анги
1	Би	✓ Би ✓ Миний эрхтэн	✓ Бие ✓ Миний тусч танилцуулга (анивт) ✓ Миний хусал, сонирхол	✓ Миний мөрөөдөл ✓ Миний бахархал	✓ Миний намтар ✓ Миний хувийн төлөвлөгөө
2	Гэр бүл	✓ Гэр бүлийн гишүүд ✓ Тоо	✓ Гэр бүлийн чөлөөт цаг ✓ Гэр бүлийн гишүүдийн ажил мэргэжил	✓ Гэр бүлийн гишүүдийн үүрэг хариуцлага ✓ Гэр бүлийн бахархал	✓ Гэр бүл, төрөл садан ✓ Үргийн мод
3	Сургууль	✓ Анги танхим ✓ Хичээлийн хэрэглэл ✓ Өнгө, дүрс	✓ Манай анги ✓ Хичээл дээр ✓ Ангийн дүрэм	✓ Дугуйлан ✓ Миний найз нөхөд ✓ Номын сан	✓ Эрдэм номын ач тус ✓ Сургуулийн цайны газар ✓ Уралдаан, тэмцээн
		✓ Өдөр, долоо			

Зураг. Хам сэдвийг агуулгын өргөсгөл, гүнзгийрэлт

Мөн суралцахуйн зорилтуудыг хэрэгжүүлэх, сурагчдын үгийн санг нэмэгдүүлэх сургалт, үйл ажиллагааг зохион байгуулахдаа ашиглах хам сэдвүүдийг анги бүрд агуулгыг өргөсгөж, гүнзгийрүүлэх зарчмаар зааж өгсөн нь багш нарын хичээл төлөвлөлтөд туслах ач холбогдолтой юм

## Агуулгын залгамж холбоо

Сургалтын жишиг хөтөлбөрийн суралцахуйн зорилтыг хэлний дөрвөн чадварын хувьд залгамж холбоотойгоор, агуулгын хувьд өргөсөл, гүнзгийрлийг харгалзан боловсруулсан. Энэхүү хөтөлбөрт ангийг тоогоор, хэлний дөрвөн чадварыг үсэг (С-сонсох, Я-ярих, У-унших, Б-бичих, Х-хэлзүй үгийн сан)-ээр кодолсон болно.

Хүснэгт. Сонсох чадварын залгамж холбоо

Эзэмших ерөнхий чадварууд	Суралцахуйн зорилтууд			
	2-р анги	3-р анги	4-р анги	5-р анги
С1. Харилцааны янз бүрийн өнгө аясыг мэдэрч, сонсох арга барил эзэмших	2.С1. Харилцан яриа, асуулт, зааврыг анхааралтай сонсож, үг хэллэгийн авиа, дуудлагыг ялгах	3.С1. Яриаг анхааралтай, идэвхтэй сонсож, ойлгосноо нүүрний хувирал, үйл хөдлөлөөр илэрхийлэх	4.С1.Бусдын яриаг (илтгэл, хэлэлцүүлэг) дуустал хүлээцтэй сонсож сурах	5.С1. Бусдын яриаг (илтгэл, хэлэлцүүлэг) идэвхтэй, хүлээцтэй, зорилготой сонсох, дүгнэх
С2. Сонссон мэдээллийн утга санааг үг, үйлдэл, зураг тэмдэглэгээгээр илэрхийлэх	2.С2. Танилцуулгыг сонсоод, хэний, юуны тухай болохыг зураглаж илэрхийлэх	3.С2. Гэр бүл, найз нөхөд, хүрээлэн буй орчны тухай эхийг сонсоод, агуулгыг зураглах	4.С2. Бараа бүтээгдэхүүний танилцуулга-сурталчилгаа, хаяг шошгыг сонсож, чухал санааг зураг, дүрс, өнгөөр илэрхийлэх	5.С2. Зар, мэдээг (радио, зурагт, нисэх онгоц, галт тэрэгний буудал, гудамж талбайн) сонсоод, чухал зүйлийг төлөөлүүлэх, тэмдэглэх илэрхийлэх
С3. Уран сайхны эхийн утгыг ойлгож, цээжлэн тогтоох	2.С3. Дуу, шүлэг, зүйр цэцэн үгийг сонсож, давтан хэлэх, цээжлэн тогтоох	3.С3. Дуу, шүлэг, зүйр цэцэн үг, ертөнцийн гурав, хэл зүгшрүүлэх үгийг сонсож, цээжлэн тогтоох	4.С3. Шүлэг, оньсого, зүйр цэцэн үг, ертөнцийн гурвыг сонсоод тогтоосноо цөөн үгээр илэрхийлэх, цээжлэн тогтоох	5.С3. Эхийн (шүлэг, жүжиг) дүрслэлийг төсөөлөн сонсох, мэдрэмж, сэтгэгдлээ үг, үйлдлээр илэрхийлэх цээжлэн тогтоох
С4. Сонссон эхийн үйл явдал, гол санааг задлан шинжлэх	2.С4. Сонссон эхийн (үлгэр, хүүхэлдэйн кино) үйл явдлын дарааллыг цуврал зургаар тодорхойлох, бусдын дэмжлэгтэйгээр асуултад хариулах	3.С4. Сонссон зохиолын (үлгэр, хүүхэлдэйн кино) үйл явдал хэрхэн өрнөхийг таамаглах	4.С4. Сонссон эхээс (үлгэр хүүхэлдэйн кино, болсон явдал) баатрын үг, үйлдлийг ялган, дүгнэх	5.С4. Эхийг (үлгэр, өгүүлэг, болсон явдал) сонсоод, үйл явдлыг хаана, хэзээ өрнөж байгааг бодож, төсөөлөх
С5. Хэрэглээний эхийг сонсоод, чухал санааг тэмдэглэх	2.С5. Хаяг байршлыг заасан ярианаас ойлгосноо зураг, тэмдэглэгээ ашиглан илэрхийлэх	3.С5. Мэндчилэх, талархах, уучлал хүсэх ярианаас тодруулан асууж, идэвхтэй сонсох	4.С5. Аудио ном, урилга, уриалгыг сонсоод, чухал санааг тэмдэглэх	5.С5. Зорилгодоо хүрэх төлөвлөгөө, өдрийн тэмдэглэлийг анхааралтай сонсож, тэмдэглэл хөтлөх

Хүснэгт. Агуулгын өргөсөл

С2. Сонссон мэдээллийн утга санааг үг, үйлдэл, зураг тэмдэглэгээгээр илэрхийлэх	2.С2. Танилцуулгыг сонсоод, хэний, юуны тухай болохыг зураглаж илэрхийлэх	3.С2. Гэр бүл, найз нөхөд, хүрээлэн буй орчны тухай эхийг сонсоод, агуулгыг зураглах	4.С2. Бараа бүтээгдэхүүний танилцуулга-сурталчилгаа, хаяг шошгыг сонсож, чухал санааг зураг, дүрс, өнгөөр илэрхийлэх	5.С2. Зар, мэдээг (радио, зурагт, нисэх онгоц, галт тэрэгний буудал, гудамж талбайн) сонсоод, чухал зүйлийг төлөөлүүлэх, тэмдэглэх
---	---	--	--	--



Я2. Сэдвийн хүрээнд ойлгомжтой, дэс дараалалтай, цэгцтэй, товч, тодорхой ярих	2.Я2. <b>Өөрийгөө болон хүрээлэн буй юмсыг</b> зураг ашиглан танилцуулах, ойлгомжтой ярих	3.Я2. <b>Гэр бүл, найз нөхөд, хүрээлэн буй орчны сэдэвт зургийг</b> бүтэн өгүүлбэрээр, ойлгомжтой тайлбарлан танилцуулах	4.Я2. <b>Бараа бүтээгдэхүүний хаяг, шошгыг</b> бүтэн өгүүлбэрээр, ойлгомжтой, товч, тодорхой тоочин танилцуулах	5.Я2. <b>Зар, мэдээг (радио, зурагт, нисэх онгоц, галт тэрэгний буудал, гудамж талбайн)</b> бусдад дамжуулахдаа ойлгомжтой, дэс дараалалтай, цэгцтэй ярих
У2. Төрөл бүрийн эхийг уншаад, чухал хэсгийг ялган, утгын холбоо хамаарлыг тайлбарлах	2.У2. <b>Зурагт танилцуулга, дасгалын зааврыг</b> зөв, ойлгож унших, түлхүүр үг хэллэгийг нүдэлж тогтоох	3.У2. <b>Гэр бүл, найз нөхөд, хүрээлэн буй орчны талаарх танилцуулгыг</b> уншиж, агуулга, бүтцийг тайлбарлах	3.У2. <b>Бараа бүтээгдэхүүний танилцуулга-сурталчилгаа, хаяг, шошго зэргийг</b> уншиж, агуулга, бүтцийг тайлбарлах	5.У2. <b>Сонины зар, мэдээний зорилго, бүтцийг</b> тодорхойлж, чухал зүйлийг тэмдэглэн тайлбарлах
Б2. Эхийг дэлгэрүүлж, товчилж бичих	2.Б2. <b>Өөрийн болон хүрээлэн буй юмсын танилцуулгыг</b> загварын дагуу үгийн нөөцөө (тоо, өнгө, хэлбэр заасан үгс) ашиглан хүүрнэн бичих	3.Б2. <b>Гэр бүл, найз нөхөд, хүрээлэн буй орчны танилцуулгыг</b> тоочин бичих	4.Б2. <b>Бараа бүтээгдэхүүний танилцуулгыг</b> асуулт, загварын дагуу тоочин бичих	5.Б2. Өгсөн асуулт, баримт, зураг, график ашиглан <b>товч мэдээ</b> бичих
Х2. Зөв бичих дүрмийн алдаагүй бичих	2.Х2. <b>Богино, урт, хос эгшигийг</b> ялган таньж, зөв дуудаж, бичих	3.Х2. <b>Эр, эм, саармаг эгшиг болон эр, эм үгийг</b> ялган таних, «-ы, -ий»-г хэрэглэх	4.Х2. <b>Үгийг</b> үеэр таслах, мөр шилжүүлж зөв бичих	5.Х2. <b>Эгшигт, заримдаг, онцгой гийгүүлэгчийг</b> ялган таних, <b>эгшиг гээгдэх, гээгдэхгүй тохиолдлыг</b> мэдэх, хэрэглэх

Хүснэгт. Агуулгын гүнзгийрэл

Я1. Янз бүрийн нөхцөл байдалд харилцах, санаа бодлоо оновчтой илэрхийлэх	2.Я1. Харилцан ярилцахдаа (сургууль, гэр бүлийн хүрээнд) юуны тухай ярьж байгааг <b>ойлгож, асуултад хариулах, асуулт тавих</b>	3.Я1. Харилцан ярианы өнгө аясыг (талархах, уучлал хүсэх, хүндлэх) мэдэрч, асуух үг хэллэгийг зөв <b>сонгож хэрэглэх</b>	4.Я1. Харилцан ярианд өөрийн байр суурийг илэрхийлэн шинэ санаа <b>нэмж оролцох, тодруулах асуулт асуух</b>	5.Я1. Хэлэлцэх, илтгэх үед өөрийн санаа бодлыг жишээ татан, товч, тодорхой, оновчтой <b>илэрхийлэх</b>
Я2. Сэдвийн хүрээнд ойлгомжтой, дэс дараалалтай, цэгцтэй, товч, тодорхой ярих	2.Я2. Өөрийгөө болон хүрээлэн буй юмсыг зураг ашиглан <b>танилцуулах</b> , ойлгомжтой ярих	3.Я2. Гэр бүл, найз нөхөд, хүрээлэн буй орчны сэдэвт зургийг бүтэн өгүүлбэрээр, ойлгомжтой <b>тайлбарлан танилцуулах</b>	4.Я2. Бараа бүтээгдэхүүний хаяг, шошгыг бүтэн өгүүлбэрээр, ойлгомжтой, товч, тодорхой <b>тоочин танилцуулах</b>	5.Я2. Зар, мэдээг (радио, зурагт, нисэх онгоц, галт тэрэгний буудал, гудамж талбайн) бусдад дамжуулахдаа ойлгомжтой, дэс дараалалтай, цэгцтэй <b>ярих</b>



Я3. Уран сайхны эхийн утгыг өөрийн үгээр ярих, цээжилснээ хэмнэлтэй уран унших	2.Я3. Сурсан дуу, шүлэг, зүйр цэцэн үгсийг тод, чанга, цээжээр, түгдрэлгүй унших (хэлэх, дуулах)	3.Я3. Цээжилсэн шүлэг, ертөнцийн гурав, зүйр цэцэн үгийг сонсоод, юуны тухай өгүүлснийг өөрийн үгээр тайлбарлах	4.Я3. Цээжилсэн шүлэг, оньсого, зүйр цэцэн үг, ертөнцийн гурвын утгыг өөрийн үгээр тайлбарлах, уран унших	5.Я3. Эхээс (шүлэг, жүжиг) төрсөн мэдрэмж, сэтгэгдлээ илэрхийлэх
Я4. Сонссон, уншсан эхийн баатрын үг, яриа, үйл хөдлөлийг дуурайн дүрд тоглох, утгыг ойлгосноо харуулах	2.Я4. Богино эхийн (үлгэр, хүүхэлдэйн кино) үйл явдлыг өөрийн үгээр хүүрнэн ярих	3.Я4. Эхийн (үлгэр, хүүхэлдэйн кино) үйл явдлыг дарааллаар нь ярих	4.Я4. Зохиолын баатруудын дуу хоолой, биеийн хөдөлгөөн, харцыг дуурайн дүрд тоглох	5.Я4. Эхийн (болсон явдал, үлгэр, өгүүллэг) үйл явдлын төгсгөлийг таамаглан, гүйцээж ярих
Я5. Хэрэглээний эхийг ойлгомжтой, тодорхой тайлбарлан ярих	2.Я5. Гэр, сургуулийн хаяг, байршлыг зураг ашиглан тайлбарлах, тодруулж асуух	3.Я5. Мэндчилгээ, талархал, уучлал хүссэн эхийн талаар санаа бодлоо илэрхийлэх	4.Я5. Урилга, уриалга болон уншсан зохиолын тухай бусдын өмнө ойлгомжтой ярих, тодруулж асуух	5.Я5. Өөрийн гаргасан төлөвлөгөөгөө ойлгомжтой, товч тодорхой, цэгцтэй ярих

## Арга зүй

Сургалтын жишиг хөтөлбөрийн 3 дугаар хэсэгт сургалтын арга зүйн талаар тусгасан. Тухайлбал, монгол хэлний хичээл нь сурагчдын хэлний дөрвөн чадварыг хөгжүүлэх үйлийг дэмжсэн “сурагч төвтэй” байна гэдгийг онцолж, дараах арга зүйг ашиглахыг заасан. Үүнд:

- Толь бичиг, зурагт хуудастай ажиллах, эхтэй ажиллах, төрөлжсөн даалгавар гүйцэтгэх, дүрийн тоглолт хийх, мэдлэг бүтээх арга барилыг хөгжүүлэх, асуудал шийдвэрлэх арга зүй,
- Сурагчдын хэлний түвшин, хөгжлийн онцлогийг харгалзсан, танил эх, хам сэдвийг ашиглах, ялгаатай байдлыг харгалзах арга зүй гэх мэт

Мөн сурагч толь бичиг хөтлөх, төрөл бүрийн бүтээл хийх (баримлын шавраар дүрслэх, зурах, эвлүүлэх, альбом, бяцхан ном) бүтээлийн үзэсгэлэн гаргах, дүрд тоглох зэрэг суралцахуйг дэмжсэн үйл ажиллагааг зохион байгуулахдаа мэдээлэл харилцааны технологи ашиглахаар тусгасан.

## Сургалтын орчин

Хэл сурах орчин нь хүн бүр өөрийгөө аюулгүй нөхцөл байдалд, дэмжиж, урамшуулж байгааг мэдэрч, өөрийгөө илэрхийлж чаддаг, хүртээмжтэй, суралцахад таатай байх ёстой бөгөөд анги хамт олны эерэг уур амьсгалыг бий болгоход сурагчдаа татан оролцуулахад онцгойлон анхаарах хэрэгтэй. Суралцах, эерэг харилцаа тогтоох, нөхөрлөх, нэг нэгнээ ойлгож хүлээж авахад үе тэнгийнхний бүлгийн зохион байгуулалт үр дүнтэй байдгийг хүлээн зөвшөөрөх нь ийм орчныг бүрдүүлэхэд тустай.

Сургалтын жишиг хөтөлбөрт сургалтын сэтгэл зүйн, материаллаг болон менежментийн орчныг тусгайлан тусгасан. Учир нь шинэ хэл сурч буй хүүхдүүдийн хувьд эдгээр орчин цогц бүрдэж байж суралцахуйд нь үр нөлөөтэй дэмжлэг болох учиртай.

Анги танхимдаа буруу, хазгай хэлэхээс айх айдасгүй, бие биеэ шоолж, эвгүй байдалд оруулдаггүй бол, шинээр сурсан үг бүхнээ ашиглан харилцах боломжийг бүрдүүлж чадсан бол хэл сурахад нь дэмжлэг болно. Мөн тэдний гарын дор, хажууд нь сөхөөд харах толь бичиг байвал тэд буруу бичсэн үгээ өөрсдөө засаад авах боломжтой.



Хэрвээ хүүхэд шинэ үгийг (бусад үг ч орно) буруу хэлсэн тохиолдолд багш Та “буруу байна, зөв болго” гэдэг шаардлага тавихаасаа илүү харин “дагаад хэлээрэй”, “баярлалаа” гэдэг үгийг ашиглаарай. Энэ нь дараах ач холбогдолтой.

- Хүүхдүүд бие биеэ шоолохгүй харин “зөв болговол сайн юм байна” гэдэг дохиог өгч ангийн уур амьсгалыг эерэг болгоно.
- Хүүхэд буруу хэлсэн үгээ багшийн тусламжтайгаар засаад авна.

Та “буруу байна, зөв болго” гэвэл тэр хүүхэд дахиад л буруу хэлнэ, ангийнхан нь шоолж магад, бас тэр хүүхэд дахиад буруу хэлэхээсээ айж, ичих болно.

Монгол хэл сурч байгаа хүүхдэд ганцхан багшийн дэмжлэг хангалтгүй. Багшид сургуулийн удирдлага, эцэг эхийн дэмжлэг хэрэгтэй. Харин тэдний дэмжлэг танд хэзээ хэрэгтэй, хэрхэн дэмжвэл үр дүнтэй болохыг тэдэнд ойлгуулж, хамтран ажиллах менежментийг хийх нь таны ажил гэдгийг мартаж болохгүй. Жишээлбэл, тухайн өдөр хичээлээр танилцсан шинэ үгсийг цээжлэх, өгүүлбэрт оруулж хэрэглэхэд эцэг эх, асран хамгаалагчийн дэмжлэг хэрэгтэй. Тиймээс шинэ үгсээ нэгж хичээлээр багцлан танилцуулж, гэртээ хүүхдийн хамгийн ойр газар наан байрлуулж, хүүхэдтэйгээр ямар өгүүлбэрт оруулж ярилцаж болох талаар, түүнийгээ хэрхэн үнэлэх талаар зөвлөгөө мэдээлэл өгч хамтран ажиллаж болно.

### Сургалтын хэрэглэгдэхүүн

Хэл сурахад тохиромжтой сургалтын хэрэглэгдэхүүн маш чухал. Сургалтын жишиг хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зайлшгүй ашиглах сургалтын хэрэглэгдэхүүний жагсаалтыг ерөнхийд нь болон хэлний дөрвөн чадвар бүрээр уг хөтөлбөрт жагсаан оруулсан.

*Хүснэгт. Хэлний чадвар ба сургалтын хэрэглэгдэхүүн*

Хэлний 4 чадвар	Сургалтын хэрэглэгдэхүүн
Сонсох чадварыг хөгжүүлэх	<ul style="list-style-type: none"> <li>- Сурагчдын сонсох чадварыг хөгжүүлэхүйц танин мэдэхүйн түвшинд тохирсон үлгэр, дуу, шүлгийн цуглуулга, ажлын хуудас, цахим (аудио, видео, интерактив) хэрэглэгдэхүүн</li> <li>- Харилцан ярианы загвар эхүүд (хэвлэмэл, аудио, цахим)</li> <li>- Зорилготой, анхааралтай сонсох чадварыг хөгжүүлэх төрөл бүрийн өгүүлбэр, эхүүд, түүнд тохирсон дасгал, даалгаврын сан</li> </ul>
Ярих чадварыг хөгжүүлэх	<ul style="list-style-type: none"> <li>- Сурагчдын хэл яриа, зөв дуудлагыг хөгжүүлэхүйц танин мэдэхүйн түвшинд тохирсон дуу, шүлгийн цомог, ТӨМ, бодит юмс, зураг, аудио, видео, ажлын хуудас</li> <li>- Мэндчилэх, уучлах, талархах, уриалах зорилготой танил болон танихгүй хүмүүс, хамаатан садан, найз нөхөд, үе тэнгийнхэн, томчуул эсвэл өөрөөсөө бага хүүхдүүдтэй харилцахтай холбоотой бяцхан дүрийн тоглолт, харилцан ярианы загвар эхүүд (хэвлэмэл, аудио, цахим)</li> <li>- Сургуулийн бага насны хүүхдийн нас, сэтгэц, танин мэдэхүйн онцлогт тохирсон аман зохиол болон уран зохиолын бус эхүүд</li> </ul>
Унших чадварыг хөгжүүлэх	<ul style="list-style-type: none"> <li>- Зурагт болон үгэн картууд, харааны уншлагын картууд</li> <li>- Зурагт толь, сурагчийн тайлбар толь, зөв бичих дүрмийн журамласан толь, хэлц үгийн толь, казах монгол толь, сурах бичгийн толь, харилцан ярианы толь гэх мэт толь бичгүүд</li> <li>- Сургуулийн бага насны хүүхдийн нас, сэтгэц, танин мэдэхүйн онцлогт тохирсон уран зохиол, уран зохиолын бус эхүүд болон харилцан ярианы загвар эхүүд</li> <li>- Зурагт болон хэвлэмэл үзүүлэн таниулах, тэмдэглэгээ, бүдүүвч, схем, мэдээлэл технологийн хэрэгсэл, бодит материалууд</li> </ul>
Бичих чадварыг хөгжүүлэх	<ul style="list-style-type: none"> <li>- Төрөл бүрийн эхийн загвар (богино эх, ертөнцийн гурав, мэндчилгээ, танилцуулга, урилга, уриалга, захидал, өдрийн тэмдэглэл, номын танилцуулга)</li> <li>- Үг, өгүүлбэр, зураг, тэмдэглэгээ бүхий картууд, дэгийн дагуу хичээнгүй, алдаагүй бичүүлэх, хүндэвтэр үгсийн толь хөтлөх дасгал, даалгаврууд</li> <li>- Сургалтын идэвхтэй үйл ажиллагааг дэмжсэн дасгал даалгаврууд (харсан, дуртай зүйлс, тоглоомын талаар зурагт өгүүлбэр, бяцхан эх зохион бичих, өөрийн зохион бичсэн эхийг багшийн тусламжтайгаар шалгах)</li> </ul>

*Эх сурвалж. “Монгол хэлний хичээлийн сургалтын жишиг хөтөлбөр”-өөс, БШУ-ы сайдын А/338 дугаар тушаал*



Сургалтын жишиг хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор II-V ангийн сурагчдад зориулсан монгол хэлний гарын авлага, дасгал ажлын дэвтэр, сонсох хэрэглэгдэхүүнийг боловсруулан энэ хичээлийн жилээс сургалтад хэрэглэхэд бэлэн болгож байна. Энэ талаар та бүхэн зөвлөмжийн хоёрдугаар хэсгээс тодорхой судлах болно.

## Үнэлгээ

Сургалтын жишиг хөтөлбөрийн үнэлгээний хэсэг нь “Үнэлгээний зорилт, үнэлгээний шалгуур, үнэлгээний жин” гэсэн хэсэгтэй. Үнэлгээний шалгуур хэсэгт үнэлгээний гурван зорилтын хүрээнд анги тус бүрээр нь хэлний чадварыг илрүүлэх шалгуурыг тодорхойлсон. Энэ нь сурагчийн ахиц, амжилт, сургалтын жишиг хөтөлбөрийн хэрэгжилтийг илрүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Тухайлбал, багш үнэлгээний даалгавар боловсруулахдаа тухайн зорилт болон хэлний чадварын хүрээний үнэлгээний шалгуурыг баримталснаар суралцахуйн зорилтын хэрэгжилтийн түвшнийг илрүүлж, сурагчид үзүүлэх дэмжлэг, туслалцааг тодорхойлно. Боловсруулсан даалгаврын гүйцэтгэлийн дөрвөн түвшнийг илрүүлэх шалгуурыг боловсруулахдаа 2021 онд БҮТ-өөс гаргасан “Бага боловсролын хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг хэрэглэх зөвлөмж”-ийг ашиглах хэрэгтэй.

Хүснэгт. Сургалтын жишиг хөтөлбөр дэх үнэлгээний шалгуурын жишээ

Ү/ зорилт	Үнэлгээний шалгуур	II анги	III анги	IV анги	V анги
Б. Мэдлэгээ хэрэглэх чадвар Бичих чадвар	Хичээнгүй бичих	Хуулж бичихдээ дэгийн дагуу, цэвэр сайхан, алдаагүй бичих	Цээжээр бичихдээ дэгийн дагуу цэвэр сайхан, алдаагүй бичих	Зохион бичихдээ тууш шугамтай дэвтэрт дэгийн дагуу цэвэр сайхан, алдаагүй бичих	Догол мөрөөр зааглан, цэвэр сайхан, алдаагүй бичих
	Тоочин бичих	Загварын дагуу үгийн нөөцөө ашиглан тоочих	Загварын дагуу түлхүүр үг ашиглан тоочих	Загварын дагуу асуултад хариулан тоочих	Хүсэл, мөрөөдөл, зорилгодоо нийцүүлэн бичих
	Дуурайн бичих	Үгсийг зөв дараалалд оруулах, нөхөж, гүйцээн бичих	Хэлбэрийг дуурайн бичих	Утгыг далдалж дуурайн бичих	Хэлбэрийг дуурайн шүлэглэж бичих
	Хүүрнэн бичих	Зургийн дагуу хүүрнэн бичих	Түлхүүр үг, асуултын дагуу хүүрнэн бичих	Дарааллын дагуу хүүрнэн бичих	Үйл явдлыг учир шалтгааны уялдаа холбоотой, өрнүүлэн бичих
	Бүтцийн дагуу зохион бичих	Газрын зураг, бүдүүвч ашиглан тодорхойлж бичих	Түлхүүр үг ашиглан, бүтцийн дагуу зохион бичих	Загвар ашиглан, бүтцийн дагуу зохион бичих	Баримт, зураг, график ашиглан, бүтцийн дагуу зохион бичих

Эх сурвалж. “Монгол хэлний хичээлийн сургалтын жишиг хөтөлбөр”-өөс, БШУ-ы сайдын А/338 дугаар тушаал

Үнэлгээний жинг явцын болон үр дүнгийн үнэлгээний даалгавар боловсруулахад болон сурагчийн ахиц, амжилтыг үнэлэхдээ харгалзана. Жишээ нь, нэгж хичээлийн үр дүнг нийт 10 даалгаврын гүйцэтгэлээр илрүүлэхээр төлөвлөсөн бол тэдгээрийн 4 нь хэл зүйн мэдлэг, ойлголтыг илрүүлэхэд чиглэсэн байх бол 6 нь хэрэглэх чадварыг илрүүлэхэд чиглэнэ гэсэн үг юм. Эсхүл нэг эх дээр ажиллуулахаар 4-5 даалгавар өгсөн бол 1-2 даалгавар нь хэл зүйн мэдлэг ойлголтыг илрүүлэх, бусад нь чадварыг илрүүлэх зорилготой байна.



## 1.4 МОНГОЛ ХЭЛНИЙ ХИЧЭЭЛИЙН СУРГАЛТЫН ЖИШИГ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД АНХААРАХ ЗҮЙЛС

“Сурагчдын сурах чадварын талаар тодорхой эсвэл тогтсон итгэл үнэмшилтэй, мөн жендэрийн хэвшмэл ойлголттой багш нар сурагчдын суралцах чадварыг хязгаарладаг. Ялангуяа, амжилт муутай суралцдаг болон амьжиргааны түвшин доогуур өрхийн сурагчид, хэлний цөөнх хүүхдүүдийн суралцах чадварыг хязгаарладаг”-ийг судлаачид тогтоосон байна. Тиймээс “манай сурагчид өөр хэлтэй, монгол хэл сурах орчин байхгүй” гэх мэт үзэлтэй багш нар хандлагаа өөрчилж, итгэл үнэмшил, урам зоригоо сэргээх хэрэгтэй юм. Энэ нь танд сурагч бүрийнхээ суралцах онцлогийг ойлгох, хүлээн зөвшөөрөх, тэдэнд туслах уян хатан арга зам боловсруулах, хичээлийн оролцоог хангахуйц орчин бий болгоход тустай.

Мөн багш сурагчийн чадварын түвшнийг үнэлсэн үр дүндээ үндэслэн хичээлийн хөтөлбөрөө боловсруулж, төлөвлөхөд анхаарна. Багшийн үнэлгээнд зөвхөн монгол хэлний сурлагын амжилтаас гадна сурахад бэлэн байдал, тэдний сурах сонирхол, сурах арга барил ч багтах учиртай. Сурагчдын сурах арга барил, хөгжлийн түвшин, чадвар ялгаатай байдаг тул багш зааварчилгаа өгөхөөс эхлээд үүнийг бодолцож төлөвлөсөн байх ёстой. Багш хичээлдээ ашиглах арга зүй, ангийн зохион байгуулалт, сургалтын хэрэглэгдэхүүнийг боловсруулж төлөвлөхөд дээрх үнэлгээ чухал.

Монгол хэлний хичээлд сургалтын орчин чухал үүрэгтэй. Учир нь зарим сурагчийн хувьд монгол хэлээр огт харилцаж үзээгүй байдаг бөгөөд тэдний монгол хэл сурах орчин нь зөвхөн анги, сургуулийн орчин болдог гэдгийг мартаж болохгүй. Ангид хэл сурахад шаардлагатай материаллаг болон сэтгэл зүйн орчин бүрдүүлэх олон янзын арга зам байдгийг ашиглах хэрэгтэй.

### “ Монгол хэлний хичээлийн жишиг хөтөлбөрт дасан зохицон суралцахад туслаарай ”

Ялгаатай хэрэгцээтэй, дэмжлэг шаардлагатай сурагчдад сургалтын хөтөлбөрөө амжилттай эзэмших, уг хөтөлбөрт дасан зохицоход дэмжлэг үзүүлэх олон арга замыг багш сурган хүмүүжүүлэгчид хайж, боловсруулж, хэрэгжүүлж ирсэн. Энэ бүхнээс олон улсын багш нарын өргөн хэрэглэдэг “Сургалтын хөтөлбөрт дасан зохицох есөн хэлбэр”-ээс наймыг нь тайлбарлан танилцуулж байна. Эдгээр хэлбэрийг нэг ч сурагчийг орхилгүй, тэдний онцлог, түвшин зэргийг харгалзан, тэгш оролцоог хангасан хичээл сургалт зохион байгуулахдаа олон багш ашигладаг бөгөөд Та ч өөрийн туршлага, заах аргадаа тулгуурлан монгол хэлний хичээл дээр ашиглаарай.

#### Тоо хэмжээ \* \*\*

Тухайн нэгж болон ээлжит хичээлийн цагт сурагчийн сурах ёстой зүйлсийн тоо эсвэл нэгж болон ээлжит хичээлийн үр дүнд эзэмших чадварыг үнэлэхийн өмнө хийх үйл ажиллагааны тоог тохируулаарай. Жишээ нь:

- Тухайн нэгж болон ээлжит хичээлийн шинэ үг, ухагдахууны тоог цөөрүүл. Тухайн хүүхэд зарим сурагчдаас цөөн үгийг цээжилж, хэрэглэсээр аажимдаа бусдыгаа гүйцэх боломжтой болно.
- Дэмжлэг шаардлагатай сурагчид зориулан цөөн дасгал эсвэл бага даалгавартай ажлын хуудас боловсруулж хэрэглээрэй.

#### Цаг \*

Та сурагчийнхаа түвшин, чадамжийг мэдэх тул даалгавраа дуусгах эсвэл сорил хийхэд хуваарилсан болон зөвшөөрөгдсөн цагийг түүнд тохируулаарай. Жишээ нь:

- Даалгавраа дуусгах цагийг уртасга. Мөн өмнө хийлгэх болон нэмэлт цаг өг.

#### Дэмжлэг \*

Сурагчийг даалгавраа гүйцэтгэх эсвэл тодорхой ур чадвараа хөгжүүлэхэд нь насанд хүрэгчид болон бусад хүмүүсээс тусламж аваарай. Жишээ нь:



- Үе тэнгийн найзууд, багшид тусалж болох хүмүүс эсвэл бусад багш нарын туслалцааг авч болно.
- Дунд ангийн сурагчидтай өдөр бүр тодорхой хугацаагаар монгол хэлээр ярилцуулах зохион байгуулалтыг сургуулийнхаа монгол хэлний багш нартай хамтран зохион байгуулж болно.

### **Оролт \***

Тухайн сурагчийн түвшин, онцлогт тохируулан зааварчилгаа өгөх арга замыг тохируулаарай. Жишээ нь:

- Төрөл бүрийн үзүүлэн ашиглах, эхийг зургаар бэлтгэх, сурагчид ойр, танил жишээ төлөвлөх, практик үйл ажиллагаа явуулах. Тухайлбал, сурагч эхийн агуулгыг ойлгосон боловч амаар илэрхийлэх чадвар нь хангалттай бус байвал үйл явдлыг зургаар (зураглал) үзүүлэх, эсхүл үйл явдлын зургуудыг зөв дараалалд оруулах зааварчилгаа өгч болно.
- Сурагчдыг багт хуваах, хичээл эхлэхээс өмнө тэднийг нэгтгэх, зарим эх, шинэ үг зэргийг тэдэнд урьдчилан заах г.м.

### **Хэцүү байдал \* \*\***

Хичээлийн үеэр сурагчид гарч болох хүндрэлийг тооцоолон хичээлийн хэрэглэгдэхүүн, ангид баримтлах дүрмийг тохируулаарай. Жишээ нь:

- Бичих дасгал хийх үеэр болон эхийг уншихад толь бичиг ашиглахыг зөвшөөрөх, түүнийг хэрэглэх зааварчилгаа бэлтгэх;
- Сурагчийн хийх ажлын чиглэлийг хялбарчлах; суралцагчдын хэрэгцээнд нийцүүлэн дүрмийг өөрчлөх г.м

### **Гаралт \***

Сурагч таны өгсөн зааварчилгаа, даалгаварт хэрхэн хариу үйлдэл үзүүлэхийг тохируулаарай. Жишээ нь:

- Асуултад бичгээр хариулах даалгавар өгсөн ч амаар хариулахыг зөвшөөрөх;
- Мөн ном ашиглуулж, түүн дээр гараараа зааж, мэдэж байгаагаа харуулах боломж олгох г.м.

### **Оролцоо \***

Сурагч даалгавар, үйл ажиллагааг гүйцэтгэхэд гар бие оролцох боломжоор хангаарай. Жишээ нь:

- Дүрийн тоглолт хийхэд дүр оногдоогүй хүүхэд "тайз"-ыг бэлтгэхэд оролцох, эсвэл дүр оногдсон хүүхдэд үгийг нь барьж харуулах, дүрүүдийг зарлах г.м
- Сурагчаас багийг удирдахыг хүсээрэй.

### **Өөр зорилго \*\***

Сурагчийн ахиц, амжилтын түвшнээс шалтгаалж тухайн сэдвийн зорилго эсвэл үр дүнгийн хүлээлтийг тохируулаарай. Энэ нь зөвхөн монгол хэлний чадварын хувьд ихээхэн хоцрогдолтой сурагчид хамааралтай.

Жишээ нь:

- Сэдвийн хүрээнд унших эхийн асуултыг хөнгөвчилж, зөвхөн хэн, хэн гарсныг хэлэх, эсвэл том үсгээр бичсэн үгсийн олох, аль нь хүний нэр, аль нь газар орны нэр болохыг хэлэх;
- Бусад сурагч дэлгэрэнгүй өгүүлбэр бичих бол заримд нь хураангуй өгүүлбэр бичих даалгавар өгөх г.м.

\* Сурагч суралцахуйн зорилтыг хангасан гэдгээ харуулж чадвал энэхүү дасан зохицох арга ач холбогдолтой байна гэсэн үг юм. Гол нь сурагчийн хүрэх үр дүн хангагдсан байхад анхаарна.

\*\* Энэхүү дасан зохицох арга нь үнэлгээний явцад тухайн сурагч суралцахуйн зорилтыг хангаж чадахгүй байгаа тохиолдолд хийсэн өөрчлөлт юм.

“**Монгол хэлний хичээлд багшийн заах арга чухал**”

Эх хэлээрээ уншиж, бичиж, өөрийгөө илэрхийлж сурсан сурагчид эдгээр чадвараа зорилтот хэл сурахдаа шилжүүлэн хэрэглэдгийг судлаачид тогтоосныг анхаарах хэрэгтэй. Тухайлбал,



- Зорилтот хэлийг заах нь эх хэлийг заахаас харьцангуй ялгаатай боловч эх хэлээ сайтар эзэмшсэн, үгийн нөөц, ярианы чадвар сайтай хүүхэд хоёр дахь хэлээр уншиж бичихийг амархан сурдаг.
- Эх хэлээрээ цаг хугацааг хэрхэн илэрхийлэхийг мэддэг хүүхэд цаг хугацааг илэрхийлэх зүй тогтлыг (дүрмийг) ойлгоно. Хоёр дахь хэл дээр (жишээ нь олонхын хэл дээр) цаг хугацааг хэлэхэд, тэдэнд цаг хугацааг тодорхойлох зүй тогтлыг цоо шинээр сурах шаардлага байхгүй, тэд урьд эзэмшсэн оюуны чадавхын хувьд шинэ илэрхийлэл, эсвэл “гадаад бүтэц”-ийг л сурах хэрэгтэй болно. Яг ийм хэлбэрээр сургалтын дараагийн шатанд ур чадвар ба боловсрол нь нэг хэлээс нөгөө хэл рүү дамжих процесс (үйл явц) явагдана.

Монгол хэлийг анх удаа, зорилтот хэл болгон судалж буй хүүхдүүдийн хувьд багшийн заах арга нэн чухал. Та бүхэн зорилтот хэлийг заах арга зүйгээр тусгайлан мэргэшээгүй боловч хос хэлтэй сурагчдад монгол хэл зааж ирсэн туршлагаа хөгжүүлэн, заах аргаа сайжруулж сургалтын жишиг хөтөлбөрийг хэрэгжүүлнэ гэдэгт итгэж байна. Санал болгож буй дараах арга, аргачлалыг ашиглаарай.

## АЛЖААЛ ТАЙЛАХ ДАСГАЛ

Алжаал тайлах хөдөлгөөнт дасгал хийснээр сурагчдын идэвх оролцоо нэмэгдэнэ.

### Дасгал 1

**Заавар:** Сурагчид багшийн зааврын дагуу дасгалыг багшийн хэлсэн үгийг давтан хэлээд 4-5 давталттайгаар хийнэ.

1. Бамбарууш би сэрлээ. (Босож зогсоод хоёр гараа алдлан сунана)
2. Нүүр гараа угаалаа. (Нүүр гараа угаах хөдөлгөөн хийнэ)
3. Би цайгаа уулаа. (Хоёр гараа урдаа авч амандаа ээлжлэн ойртуулж цай уух хөдөлгөөн хийнэ.)
4. Би хичээлдээ явлаа. (Хоёр гараа хаян хөлөө өргөн алхах хөдөлгөөн хийнэ.)
5. Тоглож наадах боллоо. (Хоёр гараа ташаандаа тулаад хөлөө мөрний хэмжээтэй тавьж хоёр тийш ганхах хөдөлгөөн хийнэ.)
6. Би ээждээ тусаллаа. (Хоёр гараа урдаа аван юм угаах хөдөлгөн хийнэ.)
7. Даалгавраа хийх сайхан даа. (Гараараа агаарт юм бичих зурах хөдөлгөөн мөн ном унших хөдөлгөөн хийж болно.)
8. Одоо сайхан унтана даа. (Гараа хоёр алгаар нийлүүлэн хацрынхаа хажууд байрлуулан нүдээ аньж, зөөлхөн хурхирах чимээ гаргана.)

### Дасгал 2

**Заавар:** Энэ дасгалыг хийхдээ толгой гэвэл толгойгоо, мөр гэхэд мөрөө, өвдөг гэхэд өвдгөө зааж хэлээд тус бүр хоёр удаа давтана.

- Толгой, мөр өвдөг, хөл (2 удаа)
- Нүд, чих, хамар, ам (2 удаа)

### Дасгал 3

Дээрх үгсийг багш хэлсний дараа хүүхдүүд давтан хэлээд дараах хөдөлгөөнийг хамтад нь хийнэ.

- Алгаа ташаарай 1 2 3
- Өвдгөө цохиорой 1 2 3
- Хөлөө дэвсээрэй 1 2 3

### Дасгал 4. Тоорой, тоорцог, тогоруу тоглоом

**Заавар:** Тоорой гэхэд хамраа дарна. Тогоруу гэхээр гараа алдалж нисэх хөдөлгөөн хийнэ. Тоорцог гэхэд гараа толгой дээрээ тавина. Багшийн зааврын дагуу хэлсэн амьтныг нэгэн зэрэг дуурайж хийнэ. Мөн энэ тоглоомтой адил “Хэрээ хэрэм” гэдэг тоглоомыг ашиглаж болно.

## Дасгал 5. Нар гарлаа

### Заавар:

- Нар гарлаа гэхээр сурагчид хоёр гараа өргөн хөдөлгөнө.
- Мод ургалаа гэвэл гараараа модны навчны ургаж байгааг дүрсэлнэ.
- Бороо орлоо гэвэл хуруугаараа ширэн дээр хөнгөхөн товшино.
- Салхи салхиллаа гэхээр хоёр гараар найгах хөдөлгөөн хийнэ.

Нар гарлаа	1 2 3	Мод	1 2 3
Бороо орлоо	1 2 3	Салхи салхиллаа	1 2 3

## ТОГЛООМЫН АРГА

Энэ хэсэгт монгол хэлний хичээлд тусгайлан ашиглаж болох тоглоомын зарим аргыг оруулсан. Багш та эдгээр тоглоомыг шинэ үг тогтоох, үг яриаг хөгжүүлэх, анхаарлыг төвлөрүүлэх, идэвхийг нэмэгдүүлэх зорилгоор баяжуулан ашиглаарай.

### Бөмбөг шидэх

#### Заавар:

1. Сурагчид тойрог болж зогсоно.
2. Багш (сурагч байж болно) бөмбөгийг бусдад дамжуулж монголоор эсвэл казахаар үг хэлнэ.
3. Бөмбөг очсон сурагч тухайн үгийг орчуулан хэлнэ.
4. Буруу хэлсэн буюу огт хариу хэлээгүй тохиолдолд тоглоомоос хасагдана.

### Анхаарах зүйл:

- Хасагдсан сурагч тухайн үгсийг цээжилж тогтоож, дахин тоглоомд оролцож болно.

### Үг дамжуулцгаая

#### Заавар:

1. Сурагчдын дундаас багш сонгоно.
2. Багш сурагчдыг нэг эгнээнд зогсож, хамгийн эхний сурагчийн чихэнд нэг үг хэлнэ.
3. Эхний сурагч ямар нэг үг хэлэхэд дараагийн сурагч өмнөх сурагчийн хэлсэн үгийг зөв сонсож дараагийн сурагчид дамжуулна.
4. Энэ мэтчилэн хамгийн сүүлчийн сурагчаас эхэлж ямар үг дамжуулсныг асууж, хэнээс өөр үг дамжуулагдсаныг тодруулна.

Сурагчид дамжуулсан болон солигдсон үгийг мартахааргүй цээжилсэн байх нь энэ тоглоомын үндсэн зорилт байх болно.

### Анхаарах зүйл (дүрэм):

- Үгийг дамжуулж хэлэхдээ бусад сурагчдад сонсогдохгүйгээр шивнэж хэлнэ.

### Гинжин тоглоом

#### Заавар:

- Сурагчид тойргоор зогсоно.
- Эхний сурагч тухайн нэгжийн хүрээнд танилцсан шинэ үгсээс нэгийг өөрөө сонгоно.
- Сонгосон үгээ дараагийн сурагчид дамжуулна.
- Дараагийн сурагч нь өмнөх сурагчийн хэлсэн үгийн сүүлчийн үсгээр эхэлсэн үгийг хэлж дараагийн сурагчид дамжуулна.
- Хэрвээ аль нэг сурагч хэлж чадахгүй бол гинж тасарч, тухайн сурагч тоглоомоос хасагдана.
- Хасагдаагүй үлдсэн сурагчид тоглоомд хожно.

### Анхаарах зүйл (дүрэм):

- Бусдын хэлсэн үгийг давтахгүй.
- Сурагчид дамжуулах үгээ эхний үсгээр нь эхэлсэн үгээр үргэлжлүүлэх үү, эсвэл сүүлчийн үсгээр нь үргэлжлүүлэх үү гэдгээ тоглоомын эхэнд ярилцаж шийдсэн байна.



- Сурагчдын шинэ үгийн нөөц хязгаартай тохиолдолд сурагчдад хүндэл гарч болзошгүйг багш тооцоолох хэрэгтэй.

### **Нисдэг үг**

#### **Заавар:**

1. Сурагчид тойрог болж зогсоно.
2. Багш бөмбөг барин тойргийн голд зогсоно.
3. Аль нэг сурагч руу бөмбөгөө шидэж үг хэлнэ.
4. Сурагч уг үгийг оролцуулан холбоо үг, өгүүлбэр зохиож хэлнэ.
5. Хэрвээ сурагч хэлж чадахгүй бол дэвтэртээ бичээд, багш болон ангийнхандаа уншиж өгнө.

### **Биеэрээ үзүүлэх**

#### **Заавар:**

1. Багш нэг сурагчид нэг үгийг шивнэн хэлнэ эсвэл зураг үзүүлнэ.
2. Тухайн сурагч бусдад үйлдлээр үзүүлэхэд, бусад сурагчид түүнийг тааж нэрлэнэ. Жишээ нь, гараа дэвэх хөдөлгөөн үзүүлэхэд сурагчид “шувуу” гэж хэлэх г.м.

### **Анхаарах зүйл:**

- Багш хэлэх үг болон зургаа сонгохдоо сурагчдын үгийн нөөц, аль анги зэргийг харгалзах хэрэгтэй. Тухайлбал, 2, 3 дугаар ангид ашиглах бол амьтны болон хичээлийн хэрэглэгдэхүүний нэр, зургийг ашиглах нь тохиромжтой байж болох юм.
- Багш хэлэх үг болон зургаа бусад хүүхдэд сонсогдохгүй, харагдахгүй байхад анхаарна.

### **Хэн олон үг олох вэ?**

#### **Заавар:**

1. Сурагчдыг баг болгон урт, хос, богино эгшигтэй (өөр хувилбартай байж болно) үг хэлүүлэн тоглуулна.
2. Сурагч үгээ хэлж чадахгүй түгдрэнгүүт дараагийн сурагч үгээ хэлнэ.
3. Багийн зөв хэлсэн үгийг самбарт бичиж аль баг олон үг хэлснийг харж дүгнэнэ.

### **Хэн хурдан бэ?**

#### **Заавар:**

1. Багш самбарт тухайн нэгж болон ээлжит хичээлд холбогдох шинэ үгсийг бичнэ.
2. Багш казахаар эсвэл монголоор үгийг хэлэхэд сурагчид тухайн үгийг олж тэмдэглэнэ.
3. Хамгийн олон, зөв тэмдэглэсэн сурагч ялагч болно.

### **Анхаарах зүйл:**

- Хэрэв багш сурагчдыг самбарт гаргаж тэмдэглүүлэхээр төлөвлөсөн бол нэг удаад 4-5 сурагч оролцож болно.
- Харин бүх сурагчдыг оролцуулах бол шинэ үгсийг тараах материал болгон олшруулж бэлтгэсэн байна.

### **Ижил картуудыг нийлүүлэх**

#### **Заавар:**

- Сурагчид зургийг үгтэй, үгийг зурагтай, асуултыг хариулттай олж тохируулна.
- Хоорондоо таарахгүй картуудыг нийлүүлсэн байгаа нь даалгаврыг биелүүлж чадаагүйг харуулна.

### **Анхаарах зүйл:**

- Багш үг, зураг, асуулт, хариулт зэргийг нэг бүрчлэн сонгож, боловсруулж, сурагчдад хүртээмжтэй байхаар сагс юм уу хайрцагт хийж бэлтгэсэн байна.
- Хэрэв сурагч бүрд хүртээмжтэй биш бол багаар ажиллуулна.

## БҮТЭЭЛЧ СЭТГЭЛГЭЭГ ХӨГЖҮҮЛЭХ АРГА

Монгол хэлний хичээлд зориулан хувирган ашиглаж болох, сурагчдын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх зарим аргыг авч үзсэн. Тухайлбал, эдгээр аргыг тогтмол, зорилготойгоор хэрэглэснээр сурагчдыг үгийг бүлэглэх, өгүүлбэр зохиох, багаар ажиллах чадвар хөгжихийн зэрэгцээ анхаарал төвлөрөлт нь сайжирч, хичээлийн оролцоо, идэвх нь сэргэх болно.

### Сэтгэмж тоглоом

#### Заавар:

- Багш ямар нэг үг хэлэхэд сурагч уг үгтэй холбоотой, өөрийн санаанд орж ирсэн үгсийг хэлнэ, эсвэл дэвтэртээ бичнэ. Тухайлбал,
- Багш: сургууль гэхэд сурагч: анги, сурагч, ном..... Г.М
- Багш: улаан гэхэд сурагч: өнгө, цамц, будаг..... Г.М
- Багш: мал гэхэд сурагч: тэмээ, адуу, сүү, тараг..... Г.М
- Сурагчид бүлэглэсэн үгээ ашиглах өгүүлбэр, улмаар эх зохиох байдлаар үргэлжлүүлж болно.

### Том цаас дүүрэн бичих арга

Энэ арга нь дараах ач холбогдолтой. Үүнд:

- Сурагч бүрийн оролцоог нэмэгдүүлж, санал бодлоо чөлөөтэй бичих боломж олгоно.
- Сурагчдын тухайн сэдвийн талаарх мэдлэг, чадварыг нээн илрүүлж, өөрийн мэдлэгээ дайчлан ажиллах хүч өгдөг, мэдлэгээ нэгтгэж сурдаг.
- Сурагчдын бичих чадварыг ахиулж, бусдаасаа суралцах боломж олгодог.

### Ашиглах хэрэглэгдэхүүн: Том цагаан цаас, бал, өнгийн эсгий бал, наадаг цаас

#### Заавар:

1. Сурагчдыг баг болгон хувааж, багийн дунд том цагаан цаас өгнө.
2. Уг цаасан дээр тухайн бичих сэдвийн дагуу хүүхэд бүр мэддэг зүйлээ үгээр, холбоо үгээр, өгүүлбэрээр бичнэ. Тухайлбал,



#### "Хэрэм" сэдвийн хүрээнд:

... хар, саарал, самар цөмдөг, самар нөөцөлдөг, ойд амьдарна, хөөрхөн, жижигхэн, арьс нь үнэтэй, арьсаар нь дээл, малгай хийдэг, модноос модонд дүүлдэг...

- Энэ мэтээр багуудад судлах гэж байгаа сэдвээр мэдээллийг цуглуулах даалгавар өгч ажиллуулна.
- Хугацаа дуусмагц цуглуулсан мэдээллээ багийн нэг гишүүн танилцуулна.
- Багшийн бусад гишүүд нэмж тайлбарлана.

#### Анхаарах зүйл:

- Багш багийн ажлын үр дүнг танилцуулах хэсгийг зохион байгуулахдаа багууд хоорондоо харилцах танилцуулгад багийн бүх гишүүд оролцох боломжоор хангахад анхаарна.

Ийм боломж олгодог нэг арга нь "Эвлүүлгийн арга" байдаг. Зарим багш нар "Нэг нь үлдэж, бусад нь явах" арга гэдэг.

Үнэлгээ нь сурагч бүрийн давуу болон сул талыг тодорхойлж, сурагчийнхаа ахиц дэвшлийг олж харах, тэдэнд үзүүлэх дэмжлэгийг тодорхой болгох, сургалтын дараагийн алхмуудыг удирдан чиглүүлэхэд үнэлж баршгүй чухал үүрэгтэйг та бүхэн мэднэ. Багш сурагч бүрийн гүйцэтгэлийг үнэлэхийн тулд оношилгооны, явцын, үр дүнгийн зэрэг үнэлгээний янз бүрийн арга, аргачлалыг ашигладаг. Эдгээрийн дотроос сурагчийг суралцаж байгаагаар нь үнэлэх буюу суралцахуйн үнэлгээ чухал ач холбогдолтой. Суралцахуйн үнэлгээ нь явцын үнэлгээнд хамаарах бөгөөд багшаас гадна сурагчийн өөрийн үнэлгээг чухалчилдаг. Суралцахуйг үнэлэх нь сурагчид өөрсдийн сурч боловсрох үйл явцыг эргэцүүлж, өөрсдийн

“Уламжлалт үнэлгээнээс гадна уян хатан үнэлгээг ашиглаарай”



чадварыг хөгжүүлэх үйл ажиллагаанд ухамсартайгаар, зорилготойгоор оролцох боломж олгодог. Үүний тул багш сурагчаа өөртөө зорилго тавих, түүнийхээ хэрэгжилтийг өөрөө үнэлж, дүгнэж сурахад нь дэмжлэг үзүүлэх хэрэгтэй байдаг. Тухайлбал, багш тухайн нэгж болон ээлжит хичээлийн шинэ үгсийг танилцуулаад “Хүүхэд бүр хэдэн үгийг алдаагүй цээжилж, өгүүлбэрт оруулж сурахаа бичээрэй.” гэвэл сурагч “Би энэ долоо хоногийн хичээлээр танилцсан шинэ үгээс 5-ыг цээжилж, өгүүлбэрт оруулж бичиж чаддаг болно” гэх байдлаар зорилгоо тодорхойлж сурахын зэрэгцээ шинэ үг орсон 5 өгүүлбэр зохиож сурсан эсэхээ өөрөө хянаад явах боломжтой. Харин багш энэхүү зорилгоо хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлж, тухайн сурагчтай ярилцаж, анхаарах зүйлийг нь сануулж хэлэх, урамшуулах, дагуулж хийх, түүнд зориулан өөрийгөө үнэлэх, шалгах хуудас боловсруулж өгөх зэргээр ажиллавал үр дүнтэй. Мэдээж энэ нь нэг удаагийн оролдлогоор бүрэн амжилтад хүрч чадахгүй байж болно. Харин тасралтгүй хичээх тохиолдолд сурагч бүр өөрийн суралцахуйгаа удирдах, өөрийн удирдлагатай суралцах арга барил эзэмшихэд туслах болно.

**Суралцахуйн буюу явцын үнэлгээ нь:**

- Тасралтгүй байдаг;
- Сургалтын хөтөлбөрийн суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэдэг;
- Сурагчдад суралцах үйл явцаа ухамсарлахад нь тусалдаг;
- Сурагч өөрийгөө хянах, өөрийгөө үнэлэх үйл ажиллагааг багтаадаг;
- Багшийн удирдлага, дэмжлэгийг шаарддаг;

Монгол хэл нь сурагчийн эзэмшиж буй хоёр дахь хэл тул үнэлгээ хийхдээ үүнийг анхаарах нь зүйн хэрэг юм. Тухайлбал,

- Сурагчдад боловсруулах, хариулах нэмэлт цаг гаргаж өгөх;
- Аман ярилцлага, ахиц амжилтын бүртгэл, бүтээлийн сан зэрэг үнэлгээний өөр өөр хэлбэрийг ашиглах;
- Агуулгын мэдлэгийг хэлний чадвараар нь дамжуулж үнэлэх;
- Олон сонголттой, үнэн/худал даалгавраас зайлсхийх;
- Ахиц дэвшлийг тэмдэглэж, ажиглалтын аргыг ашиглах;
- Сурагчдыг өөрсдийн зорилгоо тодорхойлж, ахиц дэвшлийг нь үнэлэх замаар үнэлгээнд оролцуулах;
- Гэрийн даалгаврыг цөөлөх, эсвэл нэмэлт цаг гаргах гэх мэт.

*Хүснэгт. Уламжлалт бус үнэлгээний арга, хэрэгсэл (жишээ байдлаар)*

Сонсох, ярих чадварыг үнэлэх	Унших чадварыг үнэлэх	Зөв бичих, бичих чадварыг үнэлэх
<ul style="list-style-type: none"> <li>- Сурагчтай ганцаарчилсан яриа өрнүүлэх, сонирхсон сэдвээр нь ярилцах</li> <li>- Дүрд тоглуулах</li> <li>- Сурагчийг ярих үед аудио эсвэл видео бичлэг хийх, өмнөх бичлэгтэйгээ харьцуулах, ахиц дэвшлийг нь сурагчид сонсгох</li> <li>- Зураг, тоглоомуудыг ангилах, тохируулах, дараалуулах даалгавар хийлгэх</li> <li>- Сурагчдын харилцан яриаг сонсох, тэмдэглэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Зураг болон үг, үсгэн картуудыг ашиглах</li> <li>- Сурагчдын чанга уншсан бичлэгийг ашиглан үнэлэх</li> <li>- Хам сэдвийг ашиглах, шаардлагатай хэсгүүдийг хоосон үлдээж бөглүүлэх, гүйцээлгэх</li> <li>- Эхийг ойлгосныг үнэлэхийн тулд зураг, бүдүүвч ашиглах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Бэлтгэсэн асуулт, сурагчийн сонирхсон сэдэв, зураг, видео клип зэргийг ашиглан өгүүлбэр, эх зохиолгох</li> <li>- Зураг, бүдүүвч, диаграмм, шошго хийлгэх, цахим шуудан бичүүлэх,</li> <li>- Жижиг, том ном бүтээлгэх</li> <li>- Хичээлийн жилийн (улирлын) туршид бичгийн ажлаар нь сан бүрдүүлэх</li> </ul>
<ul style="list-style-type: none"> <li>- Тоглоом, интерактив үйл ажиллагаа, сэдэл төрүүлэх ангийн даалгавруудыг ашиглан үнэлгээг хөгжилтэй, сонирхолтой болгоорой.</li> <li>- Интерактив үнэлгээ нь сурагчдыг хэрхэн идэвхжүүлж урамшуулж байгааг, багш нартай хуваалцаарай.</li> </ul>		

Хоёр дахь хэл сурах явцад мэдээллийг шингээх “чимээгүй үе”-ийг туулдаг гэдгийг судлаачид тэмдэглэсэн байдаг. Тиймээс багш сурагчийг үнэлэхдээ “тэвчээртэй” байж, тэднийг “чимээгүй үе”-ээ даван туулахад нь туслах хэрэгтэй.



Хэлний ур чадварын хамгийн сайн хэмжүүр бол уламжлалт сорил, бичгийн шалгалт бус харин хичээлийн явцын гүйцэтгэл юм. Тасралтгүй үнэлэх нь хоёрдогч хэлний хувьд онцгой чухал юм. Ангид гүйцэтгэх даалгавруудыг үнэлгээний боломж болгон ашиглаж, сурагчдад тодорхой зөвлөмж өгч, урмыг нь хугалж зэмлэхгүй, айдас төрүүлэхгүй, хөгжилтэй байдлаар үнэлэхийг хичээгээрэй.

Энэ хэсэгт бид уламжлалт бус үнэлгээний зарим арга, хэрэгслийг та бүхэнд танилцуулж байгаа бөгөөд нэгжийн үр дүнгийн үнэлгээний жишээ, даалгаврыг зөвлөмжийн гуравдугаар хэсгээс хараарай.

### **Асуултад суурилсан арга**


Асуулт нь хүмүүсийн хооронд харилцаа үүсгэх гол хэрэгсэл төдийгүй хичээл заах арга зүй, явцын (суралцахуйн) болон үр дүнгийн үнэлгээний хэрэгсэл болдог. Өөрөөр хэлбэл, хүнийг тавьж буй асуултаар нь үнэлж болно гэсэн үг. Мөн асуулт тавина (зохионо) гэдэг нь тэр тухайн хүнийг бодох, эргэцүүлэх, унших, суралцахад түлхэц өгдөг. Жишээ нь, 4-р ангийн сурагч гарын авлагынхаа “Кришტიан Роналдо” эхийг уншаад асуулт зохиох даалгавар өгч, зохиосон асуултаар нь түүний асуулт зохиох чадвар, юу сурахыг хүсэж байгаа зэргийг үнэлж тодруулж болно. Тухайлбал, сурагч

- “Тэр хэзээнээс хөл бөмбөг тоглох болсон” талаар асуувал илүү тодорхой зүйлийг ойлгохыг хичээж байгааг багш харж болно.
- Мөн “Кришტიан Роналдо яагаад хөл бөмбөг тоглох болсон бэ?” эсвэл “Түүнийг хөл бөмбөгт дуртай болоход юу нөлөөлсөн бэ?” гэж асуувал тэд шалтгаан, үр дагавар гэх мэт нарийн төвөгтэй зүйлсийг ойлгохыг хичээж байна гэсэн үг юм. Учир нь энэ асуултын хүрээнд зөвхөн аавын бэлэглэсэн бөмбөг төдийгүй эцэг, эхээ хайрлах хайр, дурсамж зэрэг ёс суртахууны, хүн чанарын талаар ярилцаж, эргэцүүлэх боломжтой болно.

Хэрэв сурагчид юу ч асуухгүй бол энэ нь маш олон зүйлийг «илчлэх» болно. Өөрөөр хэлбэл, энэ нь зөвхөн үгийн баялгаас гадна суурь мэдлэг дутмаг, өөртөө итгэх итгэл, оролцоо дутмаг байгааг бидэнд харуулна. Эсвэл тэдэнд асуух зүйл үнэхээр байхгүй, эсвэл яг одоо идэвхгүй суралцаж байна гэсэн үг болно.

Асуулттай холбоотойгоор багш дараах зүйлсийг анхаарах хэрэгтэй. Үүнд:

- Ойлгомжтой асуух. Үүний тулд багш сурагчид тавих гол, гол асуултыг урьдчилан бэлтгэж, хичээлийн төлөвлөлтөд тусгасан байхыг шаарддаг.
- Асуултаа шалгах, шаардах маягаар бус нөхөрсгөөр тавих. Үүний тулд “Багшид нь нэг (2-3) асуулт байна. Миний тавих асуултад хариулж өгөөч” гэх мэтээр хандаж болно.
- Бодох хугацаа өгөх. Та асуултынхаа цар хүрээнээс хамаарч сурагчдад бодох хугацаа өгөөрэй. Тухайлбал, “Энэ асуултад хариулахын тулд та нар 1 минут бодоорой, тэгээд хариултыг сонсьё” гэх мэт.
- Асуултаа тодруулах. Хэрвээ сурагч таны тавьсан асуултыг ойлгохгүй байвал өөр хэлбэрээр тавьж болно, өөрөөр хэлбэл асуултад ашигласан үеийг солих, асуултын найруулгыг өөрчлөх гэх мэт. Тухайлбал, “Чи хэдэн настай вэ? - Чиний нас хэд вэ?” “Эхийн агуулга юу вэ? – Та бүхний уншсан эхэд юуны тухай өгүүлсэн (гарсан) бэ? – Та бүхэн юуны тухай уншсан бэ?”
- Хариултыг “зөв эсхүл буруу” гэж яаран бүү зарлаарай. Тэдэнд бодох, залруулах хугацаа өгч болно. Мөн бусад нөхдийнхөө хариултаас алдаагаа өөрөө олж, засах боломж өгөөрэй.



Асуулт нь хэд хэдэн төрөл хэлбэртэй бөгөөд багш тухайн нэгж, ээлжит хичээлийн суралцахуйн зорилт, асуулт ашиглаж буй зорилго зэргээсээ хамааран аль төрөл хэлбэрийг асуултыг ашиглахаа бодож төлөвлөдөг. Тухайлбал, Эхийн үйл явдлыг ялгаж, нэрлэж, дараалуулж чадаж буй эсэхийг илрүүлэхэд агуулгын шинжтэй, ихэвчлэн “хэн, юу, хэзээ, хаана” зэрэг асуух үгийг ашиглан дараах хэлбэрийн асуултыг ашигладаг.

Жишээ нь,

- Эхэд ямар үйл явдлууд гарсан бэ? Эхлээд юу болсон бэ? Дараа нь ....? г.м
- Үйл явдлууд хэзээ, хаана болсон бэ?
- Хэн, юу хэлсэн бэ? Эсвэл хэн, юу хийсэн бэ? г.м

Харин эхийн үйл явдлын учир шалтгаан, үр дүнг тодорхойлж чадаж буй эсэхийг илрүүлэх бол “яагаад, ямар учраас, хэрхэн, яаж,” зэрэг асуух үгийг ашиглан агуулга-үнэлгээний асуултыг ашигладаг. Жишээ нь,

- .... (тэр) яагаад ..... гэж хэлсэн бэ?
- Үйл явдлуудын дараа юу болов? Яагаад ийм үйл явдал болов?
- Түүний хийсэн үйлдэл зөв үү? Хэрэв чи байсан бол ямар шийдвэр гаргах вэ? гэх мэт

Багш нар ихэвчлэн агуулгын асуултыг ашигладаг бөгөөд үүнийг нэрлэсэн, хаалттай асуулт ч гэж үздэг. Ийм төрлийн асуулт нэг л хариултыг шаарддаг бөгөөд сурагчдын тоочих, нэрлэх, жагсаах зэрэг танин мэдэхүйн доод эрэмбийн чадварыг хөгжүүлэх ач холбогдолтой. Харин задлан шинжлэх, бүтээх зэрэг дээд түвшний чадварыг хөгжүүлэхийн тулд агуулга, үнэлгээний дүгнэлтийн асуулт тусалдаг бөгөөд үүнд нээлттэй асуулт ч мөн хамаарна. Эдгээр асуулт нь сурагчийн эргэцүүлэх, олон санаа гаргах, хувилбар дэвшүүлэх, өөрийн санал бодлыг илэрхийлэх боломж олгодог.

Асуултаа боловсруулахдаа 2018 онд Бага боловсролын чанарын шинэчлэл төслийн хүрээнд гарсан “Бага ангийн сурагчдын унших чадварыг хөгжүүлэх, үнэлэх зарим арга хэрэгсэл” номыг ашиглаарай.

### **Шалгуурт суурилсан ярих, өөрийгөө илэрхийлэх чадварыг үнэлэх арга**

Энэхүү арга, хэрэгслийг ашигласнаар:

- Сурагчдынхаа монголоор ярих, өөрийгөө илэрхийлэх чадварыг илрүүлнэ;
- Ярих үед нь гарч буй бэрхшээлийг тодорхойлж, дэмжлэг үзүүлэх арга замыг тодорхойлно;

Танд санал болгож буй энэхүү арга, хэрэглэгдэхүүнийг дараах байдлаар ашиглаж болно. Үүнд:

- Тухайн ээлжит хичээл дээр судалж буй хам сэдвийн хүрээний эхийг ярьсан сурагч бүрээр дор өгсөн шалгуур үзүүлэлтийн дагуу тэмдэглэл хийх;
- Мөн нэгж хичээлийн үр дүнгийн үнэлгээг хийхдээ ашиглах, нэгж бүрийн эцэст сонгосон сурагчдын хүрээнд үнэлгээ хийх;

Сурагчдын гүйцэтгэлийн түвшний үзүүлэлт нь танд сурагчдаа хэрхэн туслах арга замыг тодорхойлоход дэмжлэг үзүүлэх боломжтой. Тухайлбал, ярихдаа бусдад санаагаа ойлгомжтой илэрхийлж чадахгүй байгаа болон салангид үг, холбоо үгээр ярьж байгаа сурагчдаа дэмжих нэг арга зам нь бүтэн өгүүлбэрээр ярьж сурахад нь туслах хэрэгтэй гэдэг нь тодорхой болно. Ингэхийн тулд та өгүүлбэрийн загвар өгч өгүүлбэрүүд



зохиолгох, зохиосон өгүүлбэрээ эхлээд бусдад уншиж өгөх, дараа нь ярьж өгөх дасгал даалгавруудыг хийлгэхээр төлөвлөж болох юм. Мөн сурагчаа өөртөө итгэлтэй яриулж сургахын тулд “багшийгаа хараад яриарай, ангийнхнаа хараад хэлээрэй” гэх мэтээр зоригжуулж байх, “цэх зогсох”-ыг хүсэж байх хэрэгтэйг та шалгуур үзүүлэлтүүдээс ойлгох боломжтой.

**Багшийн анхааралд:**

- Эхээс гадна хам сэдвийн хүрээнд холбогдох зураг, газрын зураг зэргийг бэлтгэсэн байхад анхаарна.
- Сурагчид бэлтгэх хугацаа гаргаж өгөх нь ярианы чадварт болон цаашид суралцахуйн арга барилыг хөгжүүлэхэд чухал болохыг анхаарна.
- Сурагчийг ичих, айх, сандрах зэрэг сэтгэлзүйн таагүй байдалд орохоос сэргийлнэ.

**Үнэлгээний шалгуур**

- Сурагчдыг монголоор ярих, өөрийгөө илэрхийлэх чадварыг дараах таван шалгуурын дагуу үнэлнэ. Үүнд
  - 1). Нүдэн харилцаа
  - 2). Ярьж буй зүйлийн агуулга
  - 3). Ярианы чанар
  - 4). Бэлтгэсэн байдал
  - 5). Дуудлага, дүрмийн хэрэглээ
- Үнэлгээний үр дүнг сурагч бүрээр гаргаж, тухайн сурагчид цаашид үзүүлэх дэмжлэг, хөгжүүлэх арга замыг тодорхойлно. Ингэхдээ дараах хүснэгтийг загвар болгон ашиглах боломжтой.

Сурагчийн нэр: _____		
Үнэлгээ хийсэн хугацаа:		
Хам сэдэв (эх)		

№	Ажиглаж, үнэлэх үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			
		Хангалтгүй	Сайжруулах шаардлагатай	Сайн	Маш сайн
		I	II	III	IV
1.	Нүдэн харилцаа				
2.	Ярьж буй зүйлийн агуулга				
3.	Ярианы чанар				
4.	Бэлтгэсэн байдал				
5.	Дуудлага, дүрмийн хэрэглээ				

**Багшийн тэмдэглэл**

Үнэлгээний үр дүнг ашиглан багш дараах хүснэгтийг ашиглан тухайн сурагчтай ажиллах арга зүй, төлөвлөлтөө тэмдэглэнэ.



Дараагийн үнэлгээ хүртэл үүнийгээ хэрэгжүүлэх бөгөөд үр дүнд хүрсэн эсэхийг дараагийн үнэлгээний үр дүн харуулна.

№	Сурагчтай ажиллах чиглэл	Хүрэх үр дүн
1.	Сурагчид үзүүлэх дэмжлэг	
2.	Ашиглах хэрэглэгдэхүүн	
3.	Эцэг, эхтэй хамтран ажиллах чиглэл	
4.	Бусад тэмдэглэл (сургалтын менежер, бусад багш нартай хамтрах талаар г.м)	

### Үнэлгээний Рубрик

Сурагчдын монголоор ярих, өөрийгөө илэрхийлэх чадварыг таван шалгуурын дагуу үнэлэхдээ шалгуур бүрд харгалзах дараах гүйцэтгэлийн дөрвөн түвшний үзүүлэлтийг ашиглана.

№	Ажиглаж, үнэлэх үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			
		Хангалтгүй	Сайжруулах шаардлагатай	Сайн	Маш сайн
		I	II	III	IV
1.	Нүдэн харилцаа	- Ярих туршдаа хэн рүү ч хараагүй, доошоо эсвэл өөр тийшээ харсан	- Ярих туршдаа харцаа тогтоож, харилцаа үүсгэж чадаагүй	- Ярилцагч дээр харц нь тогтож, харилцаа үүсгэх оролдлогыг амжилттай хийсэн - Биеийн хэлээрээ өөртөө итгэлтэй байгаагаа харуулахыг оролдсон	- Ярилцагч дээр харц нь тогтож, харилцаа үүсгэсэн - Цэх зогсох, багшийгаа болон ангийнхнаа харж ярих зэрэг биеийн хэлээрээ өөртөө итгэлтэй байгаагаа харуулсан
2.	Ярьж буй зүйлийн агуулга	- Сэдвийн агуулгатай холбоогүй зүйл ярьсан.	- Сэдвийн агуулгыг хагас дутуу ярьсан - Жишээ авч чадаагүй	- Сэдвийн агуулгыг гаргаж, өөрийн үгээр ярьсан - Зарим зүйл дээр жишээгээр баталсан	- Сэдвийн агуулгыг бүрэн гаргаж, өөрийн үгээр ярьсан - Жишээ баримт авч тайлбарласан
3.	Ярианы чанар	- Амандаа бувтнасан, яриаг нь ойлгох боломжгүй - Салангид үг, холбоо үг хэлсэн	- Ярихдаа бусдад санаагаа ойлгомжтой илэрхийлж чадаагүй - Бүтэн өгүүлбэрээр санаагаа илэрхийлж чадаагүй	- Ярьсан хугацааны туршид ойлгомжтой, тодорхой ярихыг оролдсон. - Бүтэн өгүүлбэрээр ярьсан - Тод ярьсан	- Ярьсан хугацааны туршид тодорхой, ойлгомжтой ярьсан - Сэдвийн хүрээнд утга төгс, бүтэн өгүүлбэрээр ярьсан - Тод, чанга буюу сонсогдохуйц ярьсан
4.	Бэлтгэсэн байдал	- Ярих, хэлэх зүйл бэлтгээгүй	- Бэлтгэх хугацаанд бага зэрэг бэлтгэсэн	- Бэлтгэх хугацаанд хангалттай бэлтгэсэн	- Бэлтгэх хугацааг үр дүнтэй ашигласан - Бэлтгэл сургуулилт хийсэн
5.	Дуудлага, дүрмийн хэрэглээ	- Дуудлага ойлгомжгүй - Нөхцөл, дагаврыг хэрэглэж чадаагүй	- Дуудлага тааруу, гэхдээ зарим хэсэг нь ойлгомжтой - Үгийн нөхцөл, дагавар, холбоо үгийн ихэнхийг алдаатай хэрэглэсэн	- Зарим авиа үсэг, үгийг буруу дуудсан боловч яриа нь ойлгомжтой - Зарим үгийн нөхцөл, дагавар, холбоо үгийг алдаатай хэрэглэсэн	- Авиа үсэг, үг, өгүүлбэрийг зөв дуудсан - Үгийн нөхцөл, дагавар, холбоо үгийг алдаагүй зөв холбож ярьсан



# ХОЁРДУГААР ХЭСЭГ.

## СУРАГЧДАД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА БОЛОН ДАСГАЛ АЖЛЫН ДЭВТРИЙН ХЭРЭГЛЭЭ

### 2.1 ГАРЫН АВЛАГА БОЛОН ДАСГАЛ АЖЛЫН ДЭВТРИЙН ТАНИЛЦУУЛГА

Баян-Өлгий аймгийн II-V ангийн сурагчдад зориулсан монгол хэлний гарын авлага, дасгал ажлын дэвтэр, сонсох хэрэглэгдэхүүн нь сургалтын жишиг хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх сургалтын хэрэглэгдэхүүн юм. Уг гарын авлага, дасгал ажлын дэвтрийг (цаашид ГА, ДАД гэх) боловсруулахдаа дараах зүйлсийг анхаарсан болно. Үүнд:

- Хос хэлтэй хүүхдийн онцлогийг харгалзсан;
- Хам сэдвийн дагуу үгийн санг баяжуулсан;
- Харилцааны аргад суурилсан;
- Хэлний 4 чадварыг жигд хөгжүүлэхэд зорьсон;
- Хэл зүйн хэрэглээг хэлний чадварыг эзэмшүүлэх дасгал даалгавруудад шингээсэн зэрэг болно.

Хүснэгт. ГА, ДАД-ийн онцлог

Агуулга, бүтцийн хувьд	Арга зүйн хувьд	Үнэлгээний хувьд
- Нэг эхэд тулгуурлан хэлний 4 чадварыг тэгш хөгжүүлэх, өөрөөр хэлбэл, хам сэдвийн хүрээнд төрөл бүрийн эхийг сонсож, уншиж, ярьж бичнэ. Тухайлбал, ГА, ДАД дэх даалгавар харилцан ярианд суурилсан байна.	- ГА, ДАД-т төлөвлөсөн үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулах нь багш танд нээлттэй юм. Гол нь сурагч сургалтын жишиг хөтөлбөрийн суралцахуйн зорилтыг хэрэгжүүлж, хэлний чадвараа хичээлийн жилийн эцэст эзэмшсэн байх нь чухал. Таны хувьд тухайн зорилтод хүрэхийн тулд сурагчаа чиглүүлж, суралцахуйг нь оновчтой, үр дүнтэй дэмжих арга, хэрэгслийг боловсруулахад анхаарна.	- Бүлэг бүрийн төгсгөлд “Өөрийгөө үнэлье” үнэлгээний даалгавар оруулсан.
- ГА, ДАД нь тус бүр 12 бүлэг сэдэвтэй бөгөөд анги бүрийн агуулга нь хам сэдвээр өргөсөж, хэлний чадвараар гүнзгийрнэ. Эхлээд хэлний хүлээн авах буюу сонсох, унших чадварыг эзэмшиж байж, илэрхийлэх буюу ярьж, бичих чадвар эзэмшүүлэхийг зорьсноос гадна чадваруудын босоо болон хөндлөн холбоог харгалзаж хүүхдийн хэлний чадварыг ахиулна.	- ГА, ДАД-ийн дасгал даалгаврууд нь тухайн чадварт хүрэх алхмууд бөгөөд дасгалын тавилуудыг анзаарч, сурагчид гүйцэтгэхдээ ямар аргаар хийж, өөрийгөө яаж хөгжүүлж байгаагаар нь тооцож, цагаа баримжаална. - Сурагч бүрийн эзэмшихүйн үйл ажиллагааны ялгаатай байдлыг харгалзаж, ямар чадварыг дараагийн бүлэгт давтаж болохыг багш та арга зүйгээрээ шийдэх боломжтой. Тухайлбал, зарим нэг хүндэвтэр дасгалыг дараагийн бүлэг сэдвийн хүрээнд ажиллах явцад давтан хийлгэж болно. Хамгийн гол нь хөтөлбөрт туссан суралцахуйн зорилтыг дахин нэг харж, ийм л зорилгод хүрэхийн тулд бид ажиллах юм байна гэдгийг тунгаана уу. - “Сонсоод, уншаад, ярилцаад, ажиглаад, бичихдээ, ярихдаа, тайлбарлахдаа” гэх мэт даалгаврын тавил нь хүүхдийг сурах аргад суралцуулах зорилготой. - Зөв бичих дүрэм болон хэл зүйн даалгаврыг хоосон цээжлэх биш дадлагад суурилан чадвар, хэрэглээ болохыг чухалчилсныг анхаарч, холбогдох мэдлэг, ойлголтыг цаг тухайд нь тайлбарлаж, таниулах нь чухал.	- Суралцахуйн үйлийг үнэлэх зорилготой явцын үнэлгээний даалгаврыг ажиллахдаа цаашид хүүхдийн чадварыг яаж, ямар аргаар сайжруулж болохыг сурагчидтай зөвлөлдөж болно. Тухайлбал, юуг, яаж хийвэл амжилттай байхыг ярилцаж болох юм. Багшийн зүгээс үнэлгээг хэрхэн хийж болох аргачлалыг судалж, өөрийн арга зүйгээр баяжуулаарай. - Аливаа дасгал даалгаврыг гүйцэтгэх сурагчдын арга барил янз бүр учир тэдний ялгаатай байдлыг тооцож, даалгавар гүйцэтгэх хугацаа, даалгаврын хэлбэр зэргийг өөрчилж болно. - Сурагч хэрхэн хөгжиж байгаагаар хичээлийнхээ үр дүнг тооцож, сурагч бүрийн гүйцэтгэлд үндэслэн, ахиц хөгжлийг үнэлнэ.



### Хэрэглэгдэхүүний хувьд

Хос хэлтэй хүүхдийн онцлогийг харгалзан харилцааны аргад суурилсан тул харилцан яриаг түлхүү оруулснаараа онцлогтой. Мөн монгол ардын аман зохиол, зүйр цэцэн үгс, оньсого, ертөнцийн гурав, монголын болон дэлхийн хүүхдийн шүлэг, үргэлжилсэн үгийн зохиолын дээжис, үлгэр, зурагт эх, урилга, уриалга, өөрийн танилцуулга, номын танилцуулга зэрэг баримтын ба баримтын бус эхийг сургалтад хэрэглэнэ.

ГА болон ДАД нь хоорондоо салшгүй уялдаа холбоотой бөгөөд багш үүнийг сайтар судалж хичээлдээ ашиглах нь чухал.

Гарын авлага	Дасгал ажлын дэвтэр
<ul style="list-style-type: none"> <li>- Шинэ үгийг зурагт толь хэлбэрээр бүлэг сэдвийн эхэнд өгсөн. Сурагчид зургийг ажиглан харж, эхлээд сонсоно, сонссоноо давтан хэлнэ (зөв дуудна), дараа нь уншина, нүдэлнэ, тогтооно. Энэхүү хэсэг нь эхийг сонсож, уншихад танил болсон, мэдэхгүй үгийг эргэн харж ойлгоход туслах болно.</li> <li>- Бүлэг сэдвийг хам сэдвээр хуваасан бөгөөд хам сэдвүүд 4 ангид адил боловч дэд сэдвүүдээр өргөжиж, гүнзгийрнэ.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Бүлэг сэдвүүд сонсох даалгавраар эхлэх бөгөөд даалгавруудыг дасгал ажлын дэвтэрт зурж, тэмдэглэж, нөхөж, зохиож бичих байдлаар ажиллана.</li> <li>- Зөвхөн тэмдэглээд зогсохгүй, яагаад үүнийг сонгосон, ямар учраас холбосон, зурсан бэ? гэх мэтээр эхтэй холбоотой асуултаар хөтөлж хүүхдийн ярих, зөв дуудах чадварыг хөгжүүлэх боломжтой.</li> </ul>
<ul style="list-style-type: none"> <li>- Дасгал, даалгаврыг эхэд (харилцан яриа, мэдээлсэн эх, хүүрнэсэн эх, шүлэг, хэрэглээний эх) суурилсан ба уншиж ойлгон түүнийгээ задлан шинжлэх даалгавруудаар эхэлж алхамчилсан шатлалаар бичих үйлд хөтлөх зорилготой боловсруулсан болно.</li> <li>- ГА-ын дасгал даалгаврыг бүгдийг дэвтэрт бичиж ажиллах бөгөөд ном дээр ямар нэг тэмдэглэл хийхгүй.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Бүлэг сэдэв бүрийн сүүлийн нүүрэн дэх өөрийгөө үнэлэх жишиг даалгаврууд нь тухайн бүлэг сэдвээр эзэмшсэн байх суралцахуйн үр дүнг үнэлэх зорилготой бөгөөд сурагч, багш, эцэг эхчүүдэд нээлттэй байх юм. Энэхүү бүлэг сэдвийн дүгнэлтээр багш өөрийн үйл ажиллагааг ч давхар үнэлэх боломжтой бөгөөд алдаа дутагдал, амжилтуудаа олж харж цаашдын үйл ажиллагаагаа төлөвлөхөд ашиглана.</li> </ul>

ГА, ДАД-ээр дамжуулж сурагчийн монгол хэлний үндсэн 4 чадварыг хөгжүүлэх боломжтой.



Зураг. Хэл эзэмших үйл ажиллагаа


**Үгийн сан-зурагт толь бичиг.** ГА-д бүлэг сэдэв бүр зурагт толиор эхэлсэн. Учир нь шинэ үгийн утгыг мэдэхгүйгээр хэлний чадварыг хөгжүүлэх боломжгүй юм.

Олон судалгаагаар хоёрдогч хэлний унших чадварыг үгийн сантай холбож тайлбарласан байдаг. Зарим судалгаанууд үгийн сан нь үг уншихад ихээхэн нөлөө үзүүлдэг болохыг баталсан байдаг. Үүнийг харгалзан ГА-ын бүлэг сэдвүүдийг зурагт толиор эхлүүлж шинэ үгтэй танилцуулах зорилготой боловсруулсан. Шинэ үгтэй холбогдох зургийг харна, сонсоно, уншина. Ингэж мэдрэхүйн (харааны болон сонсголын ой) үйлүүдээр дамжуулан шинэ ойлголт, шинэ тэмдэгтэй танилцаж хүлээн авсны дараа эхэд суурилсан даалгаврууд дээр ажиллах юм. Хэдийгээр үгийг цээжилсэн, утгыг мэддэг ч хэрэглэж чаддаггүй бол тэр үгийг мэдэхгүйтэй адил. Тиймээс бид тухайн үгийн үүрэг, зорилго, хэрэглээний онцлогийг дасгал даалгавраар таниулахыг зорьсон. Тухайлбал, ойролцоо ба эсрэг утга, олон утгын ялгааг илрүүлсэн хам сэдвийн хүрээнд өгүүлбэр зохиолгох зэргээр хэрэглэхийг (ярьж, бичихдээ) сургана. Эдгээр нь бүлэг сэдвийн үгийн санг ашиглан хэлний чадварыг эзэмшүүлэх суралцахуйн зорилтод чиглэсэн юм.

ЗУРАГТ ТОЛЬ



сургууль



анги



номын сан



биеийн тамирын заал




цайны газар




самбар




цонх



хөшиг



бариул



багшийн ширээ


2-р ангийн гарын авлагын зурагт толийн жишээ



хог



цаас



дугуйлан



номын сан



үйлчлэгч




тогооч



манаач



дотуур байр




цайны газар



хаях

3-р ангийн гарын авлагын зурагт толийн жишээ




бүрээ



хийл



даам




зуслан




аварга



аялгуу




дуулах



нисэх



амрах



бүжиглэх

4-р ангийн гарын авлагын зурагт толийн жишээ



**Сонсох чадвар.** Сурагчдын сонсох чадварыг хөгжүүлснээр бие даан суралцах чадварыг нь хөгжүүлж, зөв сонсоноор хэл зүйн дүрмийн талаарх ойлголтыг сайжруулж, үгийн санг нэмэгдүүлэх боломжтой юм.

Эхийг хамгийн эхлээд сонсож хүлээж авах ба сонсож ойлгосныг илрүүлэх дасгал даалгавруудыг ДАД-т гүйцэтгэнэ. Эдгээр дасгалууд дотор шинэ үг болон хэл зүйн ойлголтууд давтагдана. Даалгавар гүйцэтгэхэд тулгарах бэрхшээл саадыг аль болох хөнгөвчлөх зорилгоор алхамчилсан, дөхүүлсэн даалгавруудыг бид оруулсан. Дасгал ажлын дэвтэр нь ихэвчлэн эхийг сонсож ойлгох дасгал даалгавраар эхэлнэ. Энэ нь зөвхөн сонсож ойлгох чадварыг хөгжүүлээд зогсохгүй ярих чадварыг хөгжүүлэх хөшүүрэг болох юм. Мөн сонссон эхээр дамжуулан шинэ үгийг бататгаж, унших бичих чадварыг хөгжүүлэх суурь болно. Сонсох даалгаврыг ажиллуулахдаа дараах гурван дараалал баримтлаарай.

*Сонсохын өмнө*

- Сурагчдаа сонсоход бэлдэнэ.
- Сурагчдыг сонсох хүсэл эрмэлзэлтэй болгохын тулд асуулт асуух, сонирхлыг татахуйц орчин бүрдүүлэх гэх мэтээр сэдэлжүүлнэ.

Жирийн бичлэг сонсох нь хиймэл сонсогддог, тохиромжгүй байдаг. Сонсох эх нь сурагчдад ойлгоход хялбар үгсийн сонголтыг өөрчилсөн, сурагчдын даалгавар гүйцэтгэх зорилго хүлээлтэд нь тохиромжтой байх бөгөөд үүнийг харгалзан даалгавруудыг боловсруулсан.

Эхийн үгсийн сан, үг хэллэг нь даалгаврыг гүйцэтгэхэд тодорхой байж, ингэснээр сонсох явцад тохиолдсон бэрхшээл нь сурагчдын анхаарлыг сарниулж, идэвхийг бууруулахааргүй, тухай бүрд ойлгоод явахаар багш зохион байгуулах хэрэгтэй юм.

*Сонсох явцад* анхаарлыг нь эх дээр төвлөрүүлж, ойлголтыг хөгжүүлэхэд анхаарна. Ямар нэг зүйлийг сонсоход шалтгаан, зорилго хэрэгтэй. Сурагчид ч гэсэн анхаарлаа төвлөрүүлэн сонсохын тулд зорилго тодорхой байх нь чухал. Анх удаа эхийг сонсож байхад сандардаг учраас эх нь ярианы хурд, хэмнэлд тохирсон байх шаардлагатай. Эхийг хэдэн ч удаа сонсож болно.

- Эхний сонсолт. Эхийн талаар ерөнхий ойлголттой болоход нь туслах учраас ганц асуулт хангалттай байх бөгөөд сурагчдад хэт их дарамт учруулахгүй байхыг анхаарна.
- Хоёр дахь сонсолт. Сурагчдаас эхийг илүү нарийвчлан ойлгохыг шаарддаг. Сонсонгоо бичиж болох ч энэ нь тусдаа ур чадвар учраас даалгаврыг ганц үгээр, товчлуур товших эсвэл ямар нэг тэмдэгт хэлбэрээр өгч болох юм.
- Гурав дахь сонсолт. Хоёр дахь сонсолтоос ялгаатай нь өөрийн хариултыг шалгах, нягтлах юм уу эсвэл эхийг илүү нарийн тайлбарлах зорилготой байна.

*Сонссоны дараа* сурагчид эхээс сурч мэдсэн зүйлээ өөрийн мэдлэгтэйгээ уялдуулан хэлний чадвараа хөгжүүлнэ. Сонссоны дараа ойлгосон эсэхийг дараах байдлаар илрүүлнэ. Үүнд:

- Эхийн агуулгыг ойлгосон эсэхийг илрүүлэх. Эхийн агуулгатай холбоотой даалгаврууд хамгийн чухал бөгөөд бидний байнга хийдэг зүйлсийн нэг. Хүмүүс заавал нэг шалтгаанаар сонсдог тул хариу үйлдэл үзүүлэх, сонссон зүйлийнхээ талаар хэлэх зүйлтэй байдаг. Харин та асуултаа энгийнээс эхлэх хэрэгтэй. Тухайлбал:
  - Эхэд ямар үйл явдлууд гарсан бэ? Эхлээд юу болсон бэ? Дараа нь ....?
  - Үйл явдлууд хэзээ, хаана болсон бэ?
  - Хэн, юу хэлсэн бэ? Эсвэл хэн, юу хийсэн бэ?
- Хэл зүйн мэдлэг ойлголтыг илрүүлэх. Энэ нь эхэд байгаа өгүүлбэр, үгсийг ашиглан сурагчдын хэл зүйн мэдлэг, ойлголтыг тухайлбал, үгийн сан, үгийн хувилал, өгүүлбэрийн ангилал, эхийн төрөл зэргийн талаарх мэдлэг, ойлголтыг илрүүлэхэд чиглэнэ. Та дараах асуултыг ашиглаж болно. Үүнд:
  - Эхэд хэдэн асуух өгүүлбэр байна вэ? Яагаад асуух өгүүлбэр гэж бодсон (үзсэн) бэ?
  - Бидний сонссон эх ямар төрлийн эх вэ? Яагаад?


ГА, ДАД-т сонсож ойлгосныг илрүүлэх дасгал даалгаврыг дараах байдлаар оруулсан.

- Сонссоноо схем, зураг, газрын зураг, график, бүдүүвчээр илэрхийлэх;
- Сонсоод хүснэгт бөглөх;
- Тодорхой мэдээлэл (огноо, тоо, цаг)- ийг сонсож тэмдэглэл хийх;
- Мэдээллийг сонсож, эрэмбэлэх;
- Байршлыг сонсож газруудыг тодорхойлох;
- Эхийн үйл явц, заавар, дарааллыг сонсож тэмдэглэх;
- Өгүүлбэрийн цэгийн оронд нөхөх гэх мэт.


1. Шүлгийг сонсоод, зургийг холбоорой.



2. Нөхөж бичээрэй.



1. Ертөнцийн гурвыг сонсоод, зөв харгалзуулаарай.



2. Зөв хариултыг олоорой.

Тэнгэр үндэсээр баян	<input type="radio"/> тийм <input type="radio"/> үгүй	Ус хүнд	<input type="radio"/> тийм <input type="radio"/> үгүй
Газар үүлээр баян	<input type="radio"/> тийм <input type="radio"/> үгүй	Өд хүнд	<input type="radio"/> тийм <input type="radio"/> үгүй
Далай загасаар баян	<input type="radio"/> тийм <input type="radio"/> үгүй	Өвс хөнгөн	<input type="radio"/> тийм <input type="radio"/> үгүй



А. Эхийн үйл явдал хаана болж байна вэ? Дугуйлаарай.

- а. хотын гудамжинд
- б. уулын модонд
- в. хөдөө талд



Б. Эхийн үйл явдал хэзээ болж байна вэ?  Тэмдэглээрэй



В. Зөв холбоод, тайлбарлан яриарай.

Боорцогны үлдэгдлийг цуглуулж  
ЦҮНХЭНДЭЭ хийсэн.

Боорцогны үлдэгдлийг цаасанд  
ороож, бутан доогуур хаяв.

Муу үйл

Сайн үйл



Г. Чи ийм үйлдэл хийдэг үү? Ийм үйлдэл хийж байгаатай тааралдаж байсан уу? Тэр үед яах хэрэгтэй вэ? Ярилцаарай.



1. “Сургууль минь амархан сайн байна уу?” дууг сонсоорой. Сэтгэлдээ сургуулиа, багш нараа, найзуудаа төсөөлөөрэй.

1 Мэддэг бол дагаад дуулаарай.

2 Дууг сонсоход чамд юу юу төсөөлөгдсөн бэ? Бичээд яриарай.



3 Төрсөн сэтгэгдлээ бичээд, хуваалцаарай.



1. “Эрдэм сурсан нь” үлгэрийг анхааралтай сонсоход бэлтгээрэй.

1 Үлгэрийг сонсоод, үйл явдлын дарааллыг алдагдуулахгүй товч бичээд, уншаарай.



Эрт цагт элээ чогчиго хоёр дуу сурахаар алсын алсад явах болжээ.



элээ зөвхөн унага шиг дуугардаг болсон юм гэнэ.

Сонсоод хийх даалгаврын жишээ



**Унших чадвар.** Унших чадварыг хөгжүүлэхэд үгийн сангийн мэдлэг ихээхэн ач холбогдолтой гэдгийг олон улсын судлаачид баталсан байдаг. Тухайлбал, “Унших чадварын өсөлт нь үгийн нөөцийн тасралтгүй өсөлтөөс хамаардаг” -ийг тогтоосон байна. Тиймээс бид гарын авлагын өмнө талд бүлэг сэдвийн шинэ үгсийг зурагт толь хэлбэрээр оруулсан бөгөөд багш эхийг уншуулахдаа танил бус шинэ үг байгаа эсэхийг, тэр үгсийн утгыг мэдэж байгаа болон мэдэх боломж, дөхүүлэх арга хэрэглэсэн эсэхийг (ангийн хананд шинэ үгсийг байрлуулах гэх мэт) тооцоолох хэрэгтэй. Мөн сурагчдад толь бичиг ашиглан танил бус үгийн утгыг мэдэх боломж олгон, хичээлээ зохион байгуулах боломжтой.

<b>1 ЗӨВ УНШИХ</b> Үе, үсэг сольж гээлгүй, үгийг зөв хэлж, амьсгалаа зөв тохируулан унших	<b>2 ХУРДАН УНШИХ</b> Хүний ярианы хурдтай ойролцоо хурдаар буюу хэт хурдан биш, бас хэт удаан биш унших	<b>3 ОЙЛГОЖ УНШИХ</b> Унших явцдаа утгыг бүрэн ойлгож авах	<b>4 УРАН УНШИХ</b> Зогсолт, аялга, хурд, өргөлт, амьсгалын хуваарилалт, дууны өнгийг зохицуулан унших
--	---	---	---

Зураг. Уншихуйн дөрвөн чадвар

Сургалтын жишиг хөтөлбөрт зөв, хурдан, ойлгож, уран унших чадварыг эзэмших суралцахуйн зорилтуудыг тодорхойлсон бөгөөд гарын авлагад алхамчилсан байдлаар даалгаврууд оруулсан. Гарын авлагад даалгавар бүрийн 1-р ажил “Эхийг уншаад...” гэж эхлэх ба үүнд зөв, хурдан уншуулах суралцахуйн зорилт багтаж байгаа гэдгийг багш анхаарч хичээлээ төлөвлөнө. Үүнийг мөн сурагчдаа үнэлэхдээ анхаарна.

- 1. Зөв унших.** Авиаг зөв дуудан, өргөлт болон өгүүлбэрийн зааг, зогсосхийлтийг мэдэрч, дууны өндөр нам, баатрын хэлсэн үг, эшлэл зэргийг илэрхийлж уншиж чадаж байгаа эсэхэд анхаарна. Буруу дуудах болон, бусад алдааг багш тухай бүрд нь засаж хэлэх, дагуулж хэлэх зэргээр залруулж байхын зэрэгцээ зөв дуудахад нь урамшуулж байх нь чухал. Зөв унших чадвар эзэмшихэд төрөл бүрийн эх сонгох нь чухал ач холбогдолтой. Нэмэлтээр, хэлэхэд хэцүү авиа орсон, ойролцоо дууддаг ч өөр утга илэрхийлдэг үгсээр тусгай дасгал даалгавар боловсруулан оруулсан билээ.
- 2. Хурдан унших.** Уншлагын хурд нэмэгдэх тусам ойлгох чадвар сайжирна гэж үздэг. Авиаг зөв дуудан уншихын дараагийн алхам бол үгийг бүхэлд нь унших юм. Энэ нь уншлагын хурдыг нэмэгдүүлэх эхний алхам бөгөөд олон үетэй үгийг торолгүй уншихаас хурдан унших нөхцөл бүрдэнэ. Эхийн бүтэц нь авиа-үг-холбоо үг-өгүүлбэр-догол мөрийн түвшинд задардаг гэдгийг ойлгож тус бүрд үнэлж, бэрхшээлийг дор бүр шийдэж алдааг засаж цааш явах нь багшийн үүрэг юм.
- 3. Ойлгож унших.** Уншиж ойлгох нь хамгийн чухал чадвар бөгөөд сурагчдаас үгийн утгыг ойлгох, хам сэдвийн санааг ойлгох, гол санаанд анхаарах, суурь мэдлэгээ ашиглах, уншиж буй зүйлээ таамаглах, дүгнэх, бодит амьдралтай холбож ойлгох зэрэг чадварыг шаарддаг. Эхийг уншиж ойлгох эхний алхам нь дараалал тогтоон ойлгох юм. Дараа нь чухал, чухал бишийг ялган, өөрийн хэмжээнд дүгнэх чадвар байдаг. Дүгнэлт хийхийн тулд мэдээлэл хоорондын уялдаа холбоог ойлгох нь чухал бөгөөд ингэхийн тулд шаардлагатай суурь мэдээлэл, мэдлэгтэй байх хэрэгтэй. Багш ойлгож байгаа эсэхийг үнэлэхийн тулд алдаа хаана гарч буйг тогтоох нь чухал. Тухайлбал, эхийн үйл явдал болон дүр, дүрийн онцлогийн талаарх асуултад хариулахдаа зөв хариулж байвч гол санааг дүгнэж чадахгүй байвал асуудал байна гэсэн үг. Энэ асуудлыг илрүүлсэн нь багш тухайн сурагчтай ажиллах, түүнд дэмжлэг үзүүлэх арга зүйгээ боловсруулах чиг замыг заах ач холбогдолтой болно.
- 4. Уран унших.** Уран уншихын тулд сурагчид эхийг зөв, хурдан, ойлгож уншдаг байх нь чухал. Сурагч унших явцдаа утгыг сайн ойлгохгүй байгаа бол уран унших боломжгүй. Ном их уншдаг хүүхэд энэ үгийн ард үйл хөдлөл заасан үг орно гэсэн үгийн хэрэглээ, хэлний зарчмыг аяндаа мэдсэн байдаг. Өөрөөр хэлбэл, үйл хөдлөл, цаг хугацаа, орон зайн холбоосыг анхааран, өгүүлбэрийн агуулгыг алдаа мадаггүй уншиж ойлгож, нэг харахдаа хэд хэдэн үгийг утгат хэсгээр нь зааглан, зэрэг уншиж чаддаг



болсон байх ба хаана зогсолт авахаа сайн мэднэ гэсэн үг. Ингэснээр сурагч утга санаанд нь тохируулан зогсолт, аялга, хурд хэмжээг тааруулан, амьсгалын хуваарилалт, дууны өнгийг зохицуулан, нүүрний хувирал, дохио зангаа хэрэглэн уншина. Энэ нь үгийн төдийгүй өгүүлбэр, цогцолборуудын санааг ойлгож, тэдгээрийн хоорондын учир шалтгааныг ойлгож чадаж байгааг илэрхийлнэ. Ингэж ойлгож уншсанаар уран унших нөхцөл бүрдэнэ. Уран уншлагын чанар нь бусад чанараа өөртөө багтаасан байдаг. Уран уншлага нь уншиж буй сэдвийн агуулгыг гүн гүнзгий ойлгуулахаас гадна сурагчдын сэтгэл хөдлөл, мэдрэмжийг хөгжүүлнэ.

Уран тод уншлага нь уншлагын хамгийн дээд шат юм. Сурагчид уран уншиж сурснаар уншсан зүйлээ ойлгож, ойлгосноо бусдад илэрхийлэх чадварт суралцан гоо зүйн мэдрэмж нь хөгжинө.

**Ярих чадвар.** Хүүхдийн ярих чадварыг сайжруулахын тулд юуны өмнө маш их сонсгох шаардлагатай гэдгийг судлаачид баталсан байдаг. ГА, ДАД-ийн бүтцийг энэхүү арга зүйг баримтлан тогтоосон.

Багш сурагчид шууд “яриарай” гэж даалгавар өгөхөөс өмнө алхамчилсан даалгавруудыг ажиллуулах нь чухал. Тухайлбал, зөв дуудах, зөв бүтэцтэй ярих, санаагаа оновчтой илэрхийлэх, сул үггүй яриулах, шаардлагатай үгсийг харааны түвшинд байрлуулах, өгүүлбэрийн бүтцийн бэлэн загвар өгөх, зураг бүрдүүвч ашиглуулах гэх мэт.

Мөн “ярилцаарай” гэсэн даалгаврууд дээр багш нар анхаарч ажиллах нь зүйтэй. Зөвхөн багштайгаа ярилцахаас гадна хүүхдүүд хоорондоо ярилцах нь ихээхэн үр дүнтэй байдаг. Ярих чадварыг хөгжүүлэхдээ дараах арга, техникээс ашиглах боломжтой.

- Харилцан ярилцах. Сурагчидтай ярилцаж, асуулт асууж хариулахад нь дэмжлэг үзүүлнэ.
- Өгүүлбэрийн бүтцийн загвар өгөх. Бүтэн өгүүлбэрээр, зөв бүтэцтэй ярихад нь дэмжих. Энэ нь бичих чадварыг хөгжүүлэхэд ч тустай.
- Аман бус харилцааг ашиглан дэмжих. Сурагчдад сонирхолтой байдлаар, айдсыг арилган багш тусална.
- Чанга, тод дуугаар, өөртөө итгэлтэй ярихыг дэмжих. Бусдад нөлөөлөхүйц, анхаарлыг нь татахаар ярихын тулд өөртөө итгэлтэй байх нь чухал гэдгийг ойлгуулаарай.
- Тодруулж асуух. Харилцах үед ойлгомжгүй, тодорхойгүй, эргэлзээтэй зүйл гарахад ичиж эмээлгүй шууд асууж байхыг заана.
- Эхлэхэд нь туслах. Ярианы чадварт суралцаж байхад яриаг эхлүүлэхэд бэрхшээлтэй байх нь бий. Тиймээс яриаг эхлүүлэх арга, үг хэллэгийг хэлж өгөх нь зүйтэй. Бас асуулт асуух болон ярих даалгавар өгсний дараа бэлдэх хугацааг хангалттай өгснөөр хүүхэд дадлага туршлагатай болдог.
- Ярианы өнгө аясыг тохируулахад нь туслах. Үг хэлэхэд дууны өндөр нам, хурд хэмнэл нь ярианы өнгө аясыг илэрхийлж, хандлагыг илэрхийлдэг тул хэрхэн тохируулахыг заах хэрэгтэй.
- Өдрийн асуулт. Багш монгол хэлний хичээл орох бүр хүүхдүүдийг ангидаа орж ирэхээс өмнө нэг сонирхолтой асуулт бэлдэн самбарт бичсэн байна. Энэ асуултад хариулах замаар харилцан ярилцах боломжтой. Дараагийн хичээл дээр асуултыг бага зэрэг хүндрүүлж болно.

**Бичих чадвар.** Сургалтын жишиг хөтөлбөрийн дэгийн дагуу хичээнгүй бичих, тоочин бичих, дуурайн бичих, хүүрнэн бичих, зохион бичих чадварыг хөгжүүлэх суралцахуйн зорилтуудыг хэрэгжүүлэх дасгал даалгавруудын онцлог нь уншсан эхдээ тулгуурлан бичих юм. Өөрөөр хэлбэл, сайн бичих хамгийн чухал түлхүүр нь их унших юм. Энэ нь үгийн санг өргөжүүлж, үгийн хэлбэржилт, хэрэглээг таниулж өгүүлбэрийн бүтцийг ойлгуулдаг. Тиймээс хичээлээс гадуур монгол хэл дээрх ном унших нь бичих чадварыг хөгжүүлэх хамгийн шилдэг арга юм.


Гарын авлага, дасгал ажлын дэвтэрт хамгийн хялбараас эхлэн бичүүлэх алхамчилсан даалгавруудыг оруулсан ба үсэг, үг нөхөж бичих, холбоо үг бүтээж бичих, өгүүлбэрийг дуурайн бичих, өгүүлбэр зохиож бичихээс эхлэн загвар бүрдүүвч ашиглан бичих гэх мэт хөнгөнөөс хүнд рүү чиглэсэн аргачлалаар оруулсан.



Тухайлбал,

- Зургийн үйл явдлын дагуу зохион бичих;
- Асуултын дагуу эх зохиох;
- Уншиж өгсөн эхээс юуг ухаарсныг бичих (сургамжит өгүүллэг);
- Оюуны зураглал хийх;
- Эхийн эхлэл буюу гол, төгсгөл хэсгийг гүйцээн үргэлжлүүлэн бичих;
- Чөлөөт зохион бичлэг хийх (Тодорхой сэдвээр бичих);
- Шооны аргаар хэн, хэзээ бичихээ сонгож бичих;
- Магтаж, сайшааж бичих;
- Тоглоомын заавар бичих;
- Шүлэг дуурайн бичих;

Багш бичих даалгавар гүйцэтгэхийн өмнө бичлэг үзүүлэх, аяс сонсгох, шилдэг эшлэлүүдийг уншиж утгыг сонсгох гэх мэтээр сурагчийн бичих, зохиох сэдэл тэмүүллийг төрүүлэхэд анхаарах хэрэгтэй.



Зураг. Ангид хийх үйл ажиллагааны зураглалын жишээ

## 2.2 | НЭГЖ БОЛОН ЭЭЛЖИТ ХИЧЭЭЛИЙН ЖИШИГ ТӨЛӨВЛӨЛТ



Сургалтын хөтөлбөр бол тухайн хөтөлбөрөөр сурагчдын эзэмших мэдлэг, чадвар, хандлагын хүрэх үр дүн буюу зорилго, зорилтоор тодорхойлж, түүнд хүрэхийн тулд судлах агуулга, хэрэгжүүлэх арга зүй, үнэлгээг тодорхойлсон баримт бичиг юм. (сургалтын хөтөлбөр, 2019 он)

Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан сургалтын төлөвлөгөө, сургалтын хөтөлбөр, сургалтын жишиг хөтөлбөрөөр жилийн, нэгжийн хичээлийн, ээлжит хичээлийн төлөвлөлтийг боловсруулдаг.





Сургалтын жишиг хөтөлбөрөө судлан хэрэгжүүлэхэд жилийн, нэгж хичээлийн, ээлжит хичээлийн төлөвлөлт дараах хувь нэмрийг оруулна гэж үзэж болно.

Хам сэдэв			
Жилийн төлөвлөлт	Хөтөлбөрөөр эзэмших чадамж, сурах арга барилд хувь нэмэр оруулах үе		
	Нэгж хичээл	Нэгж хичээл	
Нэгж хичээлийн төлөвлөлт	Тодорхой нэг багц мэдлэг, чадвар, аргын тухай үйлийн баримжаа эзэмших үе		
	Ээлжит	Ээлжит	Ээлжит
Ээлжилт хичээлийн төлөвлөлт	Нэгж хичээлийн тодорхой нэг зорилтыг хэрэгжүүлэх үе		

Хам сэдвийн хүрээнд нэгж хичээлийн бүтцийг хэрхэн ойлгох вэ?


Нэгжийн бүтэц	Хэрхэн ойлгох вэ?
Нэгжийн сэдэв	Нэгж хичээлээр эзэмших чадваруудын нэгдсэн томъёолол
Нэгж хичээлийн зорилго	Юуны тулд яах гэж судалж байна вэ?
Нэгж хичээлийн зорилт	Юуг судлах вэ?
Агуулгын залгамж холбоо /босоо түвшинд/	Анги ахих тусам сурагчдын эзэмших чадвар яаж өргөсөн гүнзгийрэх вэ?
Агуулгын залгамж холбоо /хөндлөн түвшинд/	Өмнөх болон дараагийн нэгжийн төлөвлөлтөөс сурагчдын сурлагын ахицыг хэрхэн оношлох вэ?
Арга зүйн төлөвлөлт	Ямар арга хэрэглэн, ямар дидактик шийдлээр агуулгыг эзэмшүүлэх вэ?
Агуулгын төлөвлөлт /хэрэглэгдэхүүн орчин, зохион байгуулалт хугацаа/	Агуулга яаж зохион байгуулж, сурагчдадаа мэдлэг чадварыг эзэмшүүлэх вэ? Хандлагыг яаж төлөвшүүлэх вэ?
Үнэлгээний төлөвлөлт	Юунд хүрэх вэ?
	Юуг үнэлэх вэ?
Оношлох эсвэл үр дүнгийн үнэлгээний даалгавар	Сурагчдын сурсан зүйлийг, эсвэл дараагийн нэгжид үргэлжлүүлж сурах зүйлийг хэрхэн илрүүлэх вэ?

Нэгж хичээлийн зорилтоор юуг судлахыг тодорхойлсон бол юунд хүрэх, юуг үнэлэхийг үнэлгээний төлөвлөлтөөр тодорхойлж, оношлох болон үр дүнгийн үнэлгээний даалгавраа боловсруулна.

## II АНГИ. НЭГЖ ХИЧЭЭЛИЙН СЭДЭВ. АЖИЛ ХӨДӨЛМӨР

### Нэгж сэдвийн агуулгын ерөнхий хүрээ

1. Хүүхдийн сургууль дээр хийдэг үйл, үйл ажиллагааны хүрээнд авч үзсэн. Тухайлбал, долоо хоног, хичээлийн нэр, хичээлийн хуваарь, хичээл болгон дээр хийх үйл, үйлдлүүд (унших, бичих, бодох, зурах, будах, дуулах, бүжиглэх, тоглох)
2. Хүүхдийн гэртээ хийдэг өдөр тутмын үйл, үйл ажиллагааны хүрээнд авч үзсэн. Тухайлбал, босох, унтах, угаах, цэвэрлэх, идэх, уух, үзэх, чадах, дуртай, дургүй, сэтгэл хөдлөл (баярлах, уйлах, инээх, өвдөх, уурлах)



Зураг. Гарын авлагын даалгавар

3. Хэл зүйн хувьд зөв дуудах (богино, урт, хос эгшиг), зөв бичих (хүний нэр, өгүүлбэрийг том үсгээр бичиж, цэг тавих), үгсийн утгыг (хүн ба юмсын нэр, үйл хөдлөл, цаг хугацаа заасан үгсийг) ойлгон, ялгаж хэрэглэнэ. Жишээ нь, дараах байдлаар нийлүүлж бичсэн хэсгээс үг олох гэх мэт

г. Зургаан үг олж уншаад, бичээрэй.

уншаарайбүжиглээрэйзураарайдуулаарайтоглооройдуулаарай

Зураг. Гарын авлагын даалгавар

### Судлах цаг 8 цаг

- Эхний жилдээ монгол хэл судалж байгаа тул нэгжийг эхийн хэмжээг харгалзан 35 минутаар ээлжит хичээлд хуваарилсан болно.
- Багш сурагчдын хэлний болон сурах чадварын түвшнийг харгалзан ялгаатай даалгавар ажиллуулж болно.

### Нэгжийн зорилго

- Өдөр, долоо хоног, хичээлийн хуваарь, өдөр тутмын ажилтай холбоотой агуулгыг монгол хэлээр хүлээн авч (сонсох, унших), амаар болон бичгээр (ярих, бичих) илэрхийлэх чадвараа хөгжүүлнэ.

### Хүрэх үр дүн

Суралцахуйн зорилтууд	Суралцахуйн үр дүн
2.C1, 2.C2, 2.C3, 2.C4, 2.C5.	Үг хэллэгийн авианы дуудлагыг ялгах, эхийн үйл явдал хэний, юуны тухай болохыг <b>сонсож</b> ойлгоно.
2.Y1, 2.Y2, 2.Y3, 2.Y4, 2.Y5.	Үг, өгүүлбэр, эхийг зөв дуудан, хурдан <b>уншиж</b> , асуултад (хэн, юу, хэзээ, хаана, яав) хариулна.
2.Y1, 2.Y2, 2.Y3, 2.Y4, 2.Y5.	Өөрийгөө болон хүрээлэн буй юмсыг зураг ашиглан ойлгомжтой тоочин танилцуулж <b>ярина</b> .
2.B1, 2.B2, 2.B3, 2.B4, 2.B5.	Үг, өгүүлбэр, эхийг дэгийн дагуу цэвэр алдаагүй <b>бичиж</b> , загвар, бүдүүвч, зураг ашиглан өгүүлбэр, эх зохионо.
2.X1, 2.X2, 2.X3, 2.X4, 2.X5.	Богино, урт, хос эгшигийг зөв дуудаж, хүний нэр, өгүүлбэрийг том үсгээр эхэлж, цэг тэмдэг тавих, хүн ба юмсын нэр, үйл хөдлөл, цаг хугацаа заасан үгсийн утгыг ойлгоно.



## Агуулгын залгамж холбоо

Чадвар	2 дугаар анги		3 дугаар анги
	Өмнө эзэмшсэн	Нэгжийн хүрээнд эзэмших	
Сонсох	Өмнөх нэгж сэдвүүдээр богино, урт, хос эгшгийн дуудлагыг эзэмшсэн. Танил үгсийн утгыг ойлгоно.	Долоо хоног, хичээлийн нэр, өдөр тутмын үйл хөдлөлийг нэрлэсэн үгсийг сонсож, зургаар, үйл хөдлөлөөр илэрхийлнэ.	Цаг, хугацаа, өдрийн дэглэм, гэрийн ажил,
Унших	Цагаан толгой, би, сургууль, гэр бүл нэгж хичээлээр танилцсан, цээжилсэн үгсийг ашиглана.	Долоо хоногийн нэр, хичээлийн нэр, өдөр тутмын үйл хөдлөлийг заасан түлхүүр үг, үг хэллэгийг тогтоох, бусдын өмнө тод чанга дуугаар унших.	Цаг, хугацаа, өдрийн дэглэм, гэрийн ажлын тухай эхийг зөв, асуулт (Хэн? Юу? Хаана? Хэзээ? Ямар учраас? Эхлээд яасан? дараа нь яасан? эцэст яав?) -ын дагуу ойлгож унших, хурд хэмнэлийг тохируулан унших,
Ярих	Өмнөх нэгж сэдвүүдээр үзсэн 180 үгийн хүрээнд ярих чадвартай	Долоо хоногийн нэр, хичээлийн нэр, өдөр тутмын үйл хөдлөлийг заасан үг, өгүүлбэрийг зөв дуудах, асуултад хариулах.	Цаг, хугацаа, өдрийн дэглэм, гэрийн ажлын тухай санаа бодлоо илэрхийлэх, тоочин танилцуулах, цээжээр хэлэх, дуулах, дүрд тоглох, мэндчилэх, талархах, уучлал хүсэх
Бичих	Дэгийн дагуу цэвэр сайхан, алдаагүй хуулж бичнэ.	Өгсөн бүтцийн дагуу долоо хоногийн нэр, хичээлийн нэр, өдөр тутмын үйл хөдлөлийг заасан үгс орсон өгүүлбэр бичих. Зураг, түлхүүр үгсийг ашиглан загварын дагуу 3-4 үгээс бүтсэн хураангуй өгүүлбэр зохиож бичих.	Цаг, хугацаа, өдрийн дэглэм, гэрийн ажлын тухай түлхүүр үг ашиглан тоочин бичих, асуултын дагуу хүүрнэн бичих
Үгийн сан	Цагаан толгой, би, гэр бүл, сургууль нэгж сэдвийг судалснаар 175 үгийн нөөцтэй болсон.	Долоо хоног, хичээлийн хуваарь, өдөр тутмын ажилтай холбоотой 42-50 шинэ үгээр үгийн сангаа нэмэгдүүлнэ.	Цаг хугацаа, өдрийн дэглэм, гэрийн ажилтай холбоотой 20-30 шинэ үгийг өгүүлбэрт хувилган оруулж үгийн сангаа баяжуулна.

### Өгүүлбэрийн загвар

- Өгүүлбэр бичиж сурахад нь сурагчид туслахын тулд дараах өгүүлбэрийн загварууд дээр ажиллуулах боломжтой. Энэ нь багшаас өгч буй "өгүүлбэр бичээрэй, асуултад хариулаарай" гэсэн даалгавруудыг илүү ойлгомжтой, тодорхой болгодог.
- Загварын дагуу өгүүлбэр зохиож бичих дадлагууд нь тэднийг бие дааж өгүүлбэр, эх зохиож бичих чадварыг хөгжүүлэхэд тусалдаг.

Өнөөдөр ..... гараг. Маргааш .....	Зургийн хичээл дээр ..... ..... хичээл дээр уншина. Би ..... чадна.
---------------------------------------	---

- Мөн доорх асуух, хүүрнэх өгүүлбэрүүдийн жишээг ашиглан яриулж, бичүүлж сургана.

Асуух өгүүлбэрийн жишээ	Хүүрнэх өгүүлбэрийн жишээ
<ul style="list-style-type: none"> <li>- Өнөөдөр ямар гараг вэ?</li> <li>- Ямар хичээл орох вэ?</li> <li>- Тооны хичээл дээр юу хийдэг вэ?</li> <li>- Чи юу хийх дуртай вэ?</li> <li>- Чи дуулж чадах уу?</li> <li>- Чи өглөө юу хийдэг вэ?</li> <li>- Хэн юу хийж байна вэ?</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Өнөөдөр баасан гараг.</li> <li>- Өнөөдөр математикийн хичээл орно.</li> <li>- Тооны хичээл дээр тоо боддог.</li> <li>- Би тоглох дуртай.</li> <li>- Би дуу дуулж чадна.</li> <li>- Би өглөө босдог...</li> <li>- Цолмон шүдээ угааж байна.</li> </ul>

## Цагийн төлөвлөлт (Ээлжит хичээлийн цагийн задаргаа)

№	Ээлжит хичээлийн сэдэв	Цаг	Эхийн төрөл	Хэрэглэгдэхүүн	Шинэ үг
1.	Долоо хоног	1	Шүлэглэсэн эх	ГА –ын 42-р хуудас, ДАД-ийн 28-р хуудас, PPT, аудио бичлэг (сонсох эх), зураг, бодит юмс Өгүүлбэр зохиох загвар, жишээ: Өнөөдөр ..... гараг. ..... Баасан гараг. Маргааш .....	даваа, мягмар, лхагва, пүрэв, баасан, бямба, ням, өчигдөр, өнөөдөр, маргааш,
2.	Хичээлийн хуваарь	1	Шүлэглэсэн эх	ГА –ын 43-р хуудас, ДАД-ийн 29-р хуудасны 1-р дасгал, аудио бичлэг (сонсох эх), зураг, бодит юмс Өгүүлбэр зохиох загвар, жишээ: Өнөөдөр ..... хичээл орно.	тооны хичээл, монгол хэл, хүн ба орчин, дүрслэх урлаг технологи, иргэний ёс зүйн боловсрол, дуу хөгжим, биеийн тамир
3.	Сургууль дээр юу хийх вэ?	1	Танилцуулга эх (тоочимж эх)	ГА –ын 44-р хуудас, ДАД-ийн 29-р хуудасны 2,3-р дасгал, аудио бичлэг (сонсох эх), зураг, бодит юмс, үгэн карт, өгүүлбэрийн загвар жишээ: Зургийн хичээл дээр ..... ..... хичээл дээр уншина. Би .....	тоо бодох, ярих, цээжлэх, дуулах, бүжиглэх, хөгжим тоглох, дасгал хийх, чадна, чадахгүй
4.	Найз Чөлөөт цаг	1	Танилцуулга эх (тоочимж эх)	ГА –ын 45-р хуудас, ДАД-ийн 30-р хуудасны 1-р дасгал, аудио бичлэг (сонсох эх), зураг, бодит юмс, үгэн карт, өгүүлбэрийн загвар жишээ: Туяа ном ..... дуртай. .... ном уншиж байна. Би .....	үлгэр, шүлэг, шатар, даам, дугуйлан, дуртай, дургүй, чөлөөт цаг
5.	Өдөр тутмын ажил	1	Үйл явдалтай эх (Хүүрнэмж эх)	ГА –ын 46-р хуудас, ДАД-ийн 30-р хуудасны 2,3-р дасгал, аудио бичлэг (сонсох эх), зураг, бодит юмс, үгэн карт, өгүүлбэрийн загвар жишээ: Өглөөний цайгаа ..... сургуульдаа явдаг. Өдөр ..... Би шөнө унт...	өглөө, орой, өдөр, шөнө ирэх, очих, явах, унтах, амрах, уух, идэх, цэвэрлэх, угаах,
6.	"Олуулаа" дуу	1	Шүлэглэсэн эх	ГА –ын 47-р хуудас, дууны аудио, видео бичлэг, зураг, бодит юмс, үгэн карт, өгүүлбэрийн загвар жишээ: Хүүхдүүд хөгжилтэй байдаг. Хүүхдүүд ..... байдаг.	олуулаа, жаалууд, багачууд, баяртай, хөгжилтэй, жаргалтай, авьяастай, авхаалжтай
7.	Харилцан яриа	1	Харилцан яриа	ГА –ын 48-р хуудас, аудио, видео бичлэг, зураг, бодит юмс, үгэн карт, өгүүлбэрийн загвар жишээ: Миний ..... өвдөж байна. Миний дүү ..... байна.	Ууртай, гунигтай, уйтгартай, уйлах, инээх, уурлах, өвдөх
8.	Бататгал	1	Үнэлгээний даалгавар	ГА –ын 41-р хуудасны зурагт толь, ДАД-ийн 31-р хуудас "Өөрийгөө үнэлье"	Зурагт толийг давтах 41-р хуудас

### Нэгжийн заах арга

Багш бүр монгол хэлний жишиг хөтөлбөрийн маш сайтар уншиж судлах, өөрийн болгож өдөр тутмын сургалтын үйл ажиллагаанд ашиглахыг хэвшил болгох нь чухал. Ээлжит хичээл тус бүрд хэрэгжүүлэх дөрвөн чадварыг хөгжүүлэх үйл ажиллагаануудыг бие биеэ дэмжсэн уялдаа холбоотой байхаар алхамчлан төлөвлөж, идэвхтэй сургалтын аргуудтай хослуулан хэрэгжүүлэхийг зөвлөж байна. Үүний тулд,

**Сонсох чадварыг хөгжүүлэх:** Сурагчид анхааралтай сонсож сурах нь зөв унших, ярих, бичих чадварын суурь болно. Тиймээс багш өөрөө унших, аудио, видео бичлэг сонсох, бусдын яриаг анхааралтай сонсох дасгал хийлгэх чухал. Улмаар багшийн зааврыг анхааралтай сонсож ойлгосноо илэрхийлэх даалгавар хийнэ. Сонсох даалгаврын аудио бичлэг нь шаардлага хангасан чанартай байвал зохино.



Унших чадварыг хөгжүүлэхэд дараах зүйлсийг анхаарна.

- Аль болох алдаагүй, тод, чанга хэлж уншуулахыг хичээх;
- Зөв уншиж сурахад танил биш шинэ үгийн утгыг ойлгуулах; Зөв уншиж чаддаггүй хүүхэд уншиж байгаа зүйлээ төдийлөн сайн ойлгодоггүй. Зөв уншлага нь голдуу бусдад уншихаар илэрхийлэгддэг тул гэр бүлийн гишүүдийг хүүхэдтэйгээ хамтарч ажиллан хүүхдийнхээ зөв уншилтыг хянах, туслах, дэмжих чиглүүлэг өгөөрэй.

Сурагчид түгээмэл гаргадаг алдааг анхаарах. Үүнд:

- Авиа үсгийг буруу дуудах
- Үгийн төгсгөлийг буруу унших
- Ойролцоо дуудлагатай үсгийг сольж унших
- Урт, хос, богино эгшгийг буруу унших зэрэг болно.

Зөв унших нь авиа зөв дуудахаас эхлэх тул цагаан толгой заах үеэс авианы ижил төстэй шинжийг харьцуулан ялгаж зөв дуудах, сонсоод дагаж дуудах, үгийг сонсож авиаг ялгах, үе, үгийг уншихдаа авиаг зөв дуудах зэргээс эхэлдэг тул ГА, ДАД-т ийм төрлийн даалгавруудыг оруулсан болно.

Хурдан уншиж сурахад нь туслахын тулд дараах дасгалыг хийлгэх боломжтой. Үүнд:

- Нүдний хөдөлгөөн сайжруулах дасгал. Мөрийн эхний ба төгсгөлийн үгийг уншихдаа дугуй дүрсийг дарааллын дагуу харна.
- Үг таних дасгал. Бүтэн үгээр уншиж сургах аргыг голлож, үг нүдлэн тогтоож уншсаны дараа хийлгэж болох өөр нэгэн үг таних дасгалын хувилбарыг харуулъя.

Унших явцдаа утгыг бүрэн ойлгож авахыг ухамсартай уншлага буюу агуулгыг ойлгон унших гэдэг. Хоёрдугаар ангийн сурагчид нэг удаа уншаад ойлгоход бэрхшээлтэй тул багш

- Үлгэрлэн унших, бичлэг сонсон дагуулан уншуулах,
- Хамтын уншлага хийх, бие даан уншуулах зэрэг хэд хэдэн унших аргыг хослуулах хэрэгтэй.

### Давтан уншлага хийх аргууд

- **Үлгэр жишээ уншлага.** Сурагч эхийг уншихаас өмнө багш эсвэл маш сайн уншдаг үе тэнгийн хүүхдийн үлгэр жишээ уншсан бичлэгийг сонсож болно. Ингэснээр зөв унших, уншсанаа ойлгох, дууны өнгө, өргөлт, зогсолтыг мэдрэхэд дэмжлэг үзүүлэхээс гадна уншиж үзэх хүслийг төрүүлж анхаарлыг төвлөрүүлнэ.
- **Багшийг дуурайж унших.** Эхийг өгүүлбэр өгүүлбэрээр багшийг дуурайж унших байдлаар аудио, эсвэл бичлэг бэлтгэж болно. Энэ нь зөв, хурдан унших, ойлгох чадварыг зэрэг хөгжүүлэх, өгүүлбэр бүрийн утгыг тайлбарлан ярихад дэмжлэг үзүүлнэ.
- **Ээлжлэн унших.** Багш, сурагч хоёр өгүүлбэр өгүүлбэрээр ээлжлэн унших зорилготой аудио, эсвэл бичлэг хийж болно.
- **Төлөөлөн унших.** Баатруудын дуу, дүрс, хөдөлгөөн бүхий бичлэг сонсох явцдаа аль нэг баатрын дүрд тоглон, төлөөлөн унших үйлийг хийлгэж болно.
- **Эхийг зургаар унших.** Зохиолын баатрууд, үйл явдлыг харуулсан зургийг хөдөлгөөнт зураг хэлбэрээр харуулж баатрын хэлсэн үг, хийсэн үйлдлийг давтан уншуулж болно. Энэ арга нь эхийг ойлгоогүй сурагчдад дэмжлэг үзүүлэх зорилготой.
- **Дуу бичлэг ашиглан унших.** Хүүхэд гар утасны дуу бичлэгийн цэсийг ажиллуулан эхийг чанга дуугаар дуудан уншина. Дараа нь өөрийн уншилтыг сонсохдоо эхээ дагуулан хараагаар унших явцдаа өөрийн зөв уншилтыг хянахын зэрэгцээ давтан уншиж агуулгыг ойлгох юм. Энэхүү аргыг агуулгаараа зааварчлан чиглүүлж болох юм. Энэ мэт давтан уншлагын олон аргыг ашиглаж болно.



Багш унших үйл ажиллагааг удирдахдаа эхийг хэсэглэн уншуулж, үйл явдлыг нягтлан ярилцаж, уншсаны дараа эхийн агуулгыг тодруулах асуулт асуух, уншаад юу ойлгосноо дахин ярих, ойлгосноо дахин уншиж шалгах, асуулт хариулт зохиох, зургаар, бичгээр тайлбарлах, дүрд тоглох, цуврал ном, ярилцлага бүтээх гэх мэт үйл ажиллагаа хийлгэж болно. Эхийг уншсанаар юу ойлгож авсан тухай яриулж, хичээлээс гадна тухай сэдэвтэй холбоотой хичээлээс гадуур уншлагын сэдэв эхүүд сонгон хэрэглэх нь сурагчдын унших дур хүслийг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

Ярих чадварыг хөгжүүлэхэд энэ нэгжийн онцлогийг харгалзана. Тухайлбал, “Ажил хөдөлмөр” сэдвийн агуулгатай холбоотой үг хэллэг, үйл хөдлөлийг багтаасан тул сурагчдаар хийлгэх үйл, үйл ажиллагаа нь голдуу үйл хөдлөлд суурилсан байна. Тухайлбал, “Туяа ном уншиж байна” гэдэг өгүүлбэрийг ойлгосон эсэхээ хүүхэд хүнийг заах, номыг харуулах, номын хуудсан дээгүүр нүдээ гүйлгэх зэрэг үйл хөдлөлөөр харуулж, илэрхийлж болно.

Мөн энэхүү зөвлөмжийн 30, 31-р талд танилцуулсан тоглоомын аргуудыг ашиглаж болно. (Бөмбөг шийдэх, дүрд тоглох, хөзөр, үгэн карт г.м) Энэ үед авианы дуудлагыг засах үйл ажиллагаа голлон явуулна. Сурагчдыг шинэ үгийн утгыг бүрэн ойлготол нь өгүүлбэр зохиож хэлүүлэх нь үр дүнтэй.

Сурагчид монгол хэлийг эхлэн судалж байгаа боловч өмнө нь эх хэлээ судалсан, эх хэлээрээ уншиж бичиж чадна гэдгийг мартаж болохгүй. Гэхдээ монголоор анхнаас нь алдаагүй, зөв, хичээнгүй бичих техник чадварыг хөгжүүлэхэд анхаарах нь чухал. Үүний тулд дараах зүйл анхаараарай. Үүнд:

- Үсгийг элементийн зөв дарааллаар бичих;
- Үсгийн налалтыг зөв гаргах;
- Үсгийн өндөр, намыг тааруулж бичих;
- Үсгийн холбоосыг зөв хийх;
- Үсэг, үг хоорондын зайг зөв авах;

Хоёрдугаар ангид зураг болон бусад хэрэглэгдэхүүн ашиглаж, асуултын дагуу эхлээд 2 үгтэй, дараа нь 3-4 үгтэй өгүүлбэр зохиолгоно. Мөн ГА, ДАД-т оруулсан дараах хэлбэрийн даалгаврыг ашиглаарай. Үүнд:

- Өгүүлбэрт дутуу үгийг нөхөж бичих;
- Үйл үгийг түүж бичих;
- Өгүүлбэрийг дэлгэрүүлж бичих;
- Асуултад хариулт бичих;
- Өгсөн үгсээр өгүүлбэр зохиож бичих;
- Үгэнд тохирох залгавар залгаж, өгүүлбэрийг гүйцээх;
- Цуврал зургийн утгыг холбоотой хүүрнэн бичих;
- Ойлгосноо бичгээр илэрхийлэх (жагсаан бичих, зөвхөн үйлийг дараалуулан ялгаж бичих, үйл явдлын орон, цагийг бичих);
- Эхээс хүний нэрийг ялгаж, том үсгээр бичих;
- Өгүүлбэрийг таньж, том үсгээр бичих;
- Хүүрнэх өгүүлбэрийн төгсгөлд цэг, асуух өгүүлбэрийн төгсгөлд асуултын тэмдэг тавих гэх мэт.

Мөн эхлэн сурагчдад дуурайн бичүүлэх нь ач холбогдолтой. Багшийн өөрөө бичсэн болон үлгэр жишээ хичээнгүй бичлэг харан дуурайн бичүүлнэ.

Хэл зүй, үгийн санг нэмэгдүүлэхдээ танил биш үгийг утгыг ойлгуулахад дараах үндсэн аргыг ашиглаарай. Үүнд:

- Үзүүлэн таниулах (зурагт толь)
- Тайлбарлан таниулах (тайлбар толь)

Хоёрдугаар ангид үзүүлэн таниулах аргыг чухалчлах ба тухайн зүйлийг биет байдлаар харуулах, зураг, видео бичлэг үзүүлэх, зурган толь ашиглан тайлбарлах нь илүү үр дүнтэй. Хийсвэр утгатай зарим үгсийг эх хэлээр нь орчуулж өгч болно. Жишээ нь хэн?, юу?, авьяастай, амрах г.м



Зураг. Зурагт толь

### Нэгжийн үнэлгээ

Нэгжийн үр дүнгийн үнэлгээ нь суралцахуйн үр дүнд суурилж, шалгуур, жинг үндэслэн, эзэмшсэн мэдлэг, чадварын түвшин тогтоож, үнэлэлт, дүгнэлт өгөхөд чиглэнэ. Харин хандлагыг өдөр тутмын хичээлийн явцад хичээлийн дэг дээр тусган, төлөвшлийг нь үнэлнэ. Даалгавар нь хөнгөнөөсөө хүндрүүлэх танин мэдэхүйн түвшнийг харгалзсан байхыг анхаарна уу.

Үнэлгээний нэгж	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэл
Сонсох	Үг хэллэгийн авианы дуудлагыг ялгах, эхийн үйл явдал хэний, юуны тухай болохыг сонсож ойлгох чадвартай болно.	Анхааралтай сонсох	Асуулт, зааврыг анхааралтай сонсож, үг хэллэгийн авианы дуудлагыг ялгаж чаддаг.
		Зургаар илэрхийлэх	Хичээлийн нэр, үйл хөдлөл, цаг хугацааг нэрлэсэн үгсийг сонсоод зургаар илэрхийлдэг.
		Сонссоноо давтах хэлж тогтоох	Дуу, шүлгийг мөр мөрөөр нь сонсоод, давтаж хэлэх замаар цээжлэн тогтоодог.
		Үйл явдлын дарааллыг цуврал зургийн дагуу илэрхийлэх.	Сонссон эхийн үйл явдлыг харуулсан цуврал зургийг дарааллаар нь байрлуулдаг, дугаарлаж чаддаг
		Чухлыг зураг тэмдэглэгээгээр илэрхийлэх	Нэг өдрийн хичээлийн хуваарийг сонсоод тухайн хичээлүүдийн зургийг сонгох.
Унших	Үг, өгүүлбэр, эхийг зөв дуудан, хурдан уншиж, асуултад (хэн, юу, хэзээ, хаана, яав) хариулах чадвартай болно	Үе, үг, өгүүлбэрийг зөв дуудан унших	Үе, үг, өгүүлбэрийг шууд уншиж чаддаг.
		Харилцан ярианы үг хэллэгийг зөв унших	Танил эхийг үг үгээр зааглан уншиж, утгыг ойлгож чаддаг.
		Хурдан унших (30-100 үг)	Минутад танил бус эхээс 30-70, танил эхээс 60-100 үг уншина.
		Түлхүүр үг хэллэгийг тогтоох	Зурагт танилцуулга, дасгал зааврыг уншиж, түлхүүр үг хэллэгийг олж чаддаг.
		Бусдын өмнө тод чанга дуугаар унших	Шүлэг, дуу, зүйр цэцэн үгийг бусдын өмнө чанга тод дуугаар уншиж өгдөг.
		Эхийн баатруудын болон тэдний үйл хөдлөлийг нэрлэж, асуултад бусдын дэмжлэгтэйгээр хариулах	Богино эхийг уншиж, хүний үйл хөдлөлийг нэрлэн, хэн? юу? хаана? хэзээ? яасан? зэрэг асуултад хариулдаг.
		Эхийн бүтцийг тайлбарлах	Хичээлийн хуваарийн бүтэц (гараг, цаг, орох хичээлийн нэр)-ийг тайлбарлана.



Ярих	Өөрийгөө болон хүрээлэн буй юмсыг зураг ашиглан ойлгомжтой тоочин танилцуулж, асуултын дагуу хүүрнэн ярих чадвартай болно.	Ойлгомжтой тод дуугаар харилцах	Асуулт, зааврыг ойлгосноо ойлгомжтой, тод дуугаар илэрхийлдэг.
		Товч тоочих	Өөрийнхөө болон бусдын өдөр тутмын үйл хөдлөлийг тоочиж ярьдаг.
		Үе үгийг сольж гээлгүй, тод чанга хэлэх	Шүлэг, зүйр цэцэн үгсийн үе, үгийг зөв хэлж, сольж гээлгүй, тод чанга цээжээр унших, сурсан дуугаа дуулдаг.
		Үг хэллэг, үйл хөдлөлийг, дуурайн ярих	Бусдын үг хэллэг, үйл хөдлөлийг дуурайн ярьдаг, дүрд тоглодог.
		Зураг ашиглан ярих	Хичээл, сургууль, өдөр тутмын үйл хөдлөлийг харуулсан зургийн үйл явдлыг дарааллын дагуу ярьж чаддаг, тодруулж асуулт асуудаг.
Бичих	Үг, өгүүлбэр, эхийг дэгийн дагуу цэвэр алдаагүй бичиж, загвар, бүдүүвч, зураг ашиглан өгүүлбэр, эх зохионо.	Хуулж бичихдээ дэгийн дагуу цэвэр сайхан, алдаагүй бичих	Цагаан толгойн үсгийн дэвтрийн шугамыг баримжаалан үсгийн хэмжээ, налууг, чиглэлийг тохируулан зөв холбон бичдэг.
		Загварын дагуу үгийн нөөцөө ашиглан тоочих	Өөрийн тухай болон зургийн үйл явдлыг үйл үгийн нөөцөө ашиглан 2-3 өгүүлбэрээр тоочиж бичдэг.
		Үгсийг зөв дараалалд оруулах, нөхөж, гүйцээн бичих	Уншсан, цээжилсэн шүлэг, зүйр цэцэн үгийн үгсийг зөв дараалалд оруулах, нөхөж гүйцээн бичдэг.
		Зургийн дагуу хүүрнэн бичих	Сэдэвт болон цуврал зургийн дагуу үйл үгийн нөөцөө ашиглан 3-4 үгээс бүтсэн хүүрнэх өгүүлбэр бичдэг.
		Газрын зураг, бүдүүвч ашиглан тодорхойлж бичих	Хүснэгт, бүдүүвч ашиглан хичээлийн хуваарь бичдэг.
Хэл зүй, үгийн сан	Богино, урт, хос эгшгийг зөв дуудаж, хүний нэр, өгүүлбэрийг том үсгээр эхэлж, цэг тэмдэг тавих, хүн ба юмсын нэр, үйл хөдлөл, цаг хугацаа заасан үгсийн утгыг ойлгох чадвартай болно..	Урт, хос, богино эгшигтэй үгийг ялган дуудах	Цагаан толгойн үсгийн дэвтрийн шугамыг баримжаалан үсгийн хэмжээ, налууг, чиглэлийг тохируулан зөв холбон бичдэг.
		Цагаан толгой үсэг, авиаг ялган таних	Цагаан толгойн авиаг ялган сонсож, зөв дуудан, үсгийн нэрийг зөв хэлдэг. Хатуу, зөөлний тэмдгийг эхээс ялган таньж, зөв нэрлэдэг.
		Үгсийг сэдвийн дагуу ангилж бүлэглэх	Нэгж сэдвийн хүрээнд хүн ба юмсын нэр, шинж чанар, тоо, үйл хөдлөл, орон байр, цаг хугацаа заасан үгсийг ялгадаг.
		3-4 үгтэй энгийн бүтэцтэй хүүрнэх, асуух өгүүлбэрийг ялгаж, цэг тэмдгийг зөв хэрэглэх	Сурагч танил бус үгээс бүтсэн 2-4 өгүүлбэрийг хуулж, танил үгээс бүтсэн 2-4 өгүүлбэрийг цээжээр бичихдээ том үсгийн дүрмийг хэрэглэн зөв бичдэг.
		Зурагт толь ашиглах (Үгийн нөөц 350-500 )	Зурагт толь ашиглан 42-50 шинэ үгийг тогтоож, үгийн утгыг ойлгоно. 225 үгийн нөөцтэй болно.



Явцын үнэлгээ нь ээлжит хичээлийн хувьд суралцахуйн үр дүн, шалгуурт суурилан хандлага төлөвшлийг үнэлэхэд чиглэнэ. Явцын үнэлгээний олон төрөл, хэлбэрийг ашиглаж болно. Суралцагчийн оролцоог дэмжих, амжилттай сургахад туслах чухал үүрэгтэй.

Үнэлгээний даалгавар боловсруулахдаа дээрх хүснэгтэд харуулсан Монгол хэлний жишиг хөтөлбөрийн “Суралцахуйн үр дүнгийн шалгуур”-ыг үндэслэх шаардлагатай. Хичээлийн явцад юуг, яаж хийснээ шалгуурын дагуу хянаж, өөрийгөө үнэлэх боломжтой байх оновчтой арга, хэлбэрийг сонгоорой. Үүний тулд, сурагчдад тодорхой эхийг сонгож, уншуулсны дараа “зургийг тохирох үгтэй холбох, сонгох, зурагт тохирох өгүүлбэр олох, сонгох, хэрчмэл үсгүүдээр үг бүтээх, цэгийн оронд тохирох үг сонгож өгүүлбэр бүтээх, асуулт асууж, хариулт авах, зураг зуруулах, яриулах, үйл хөдлөл нэрлэсэн үгийг дарааллаар байрлуулах, үйлийг түүж бичих, зурагт харгалзуулах, тохирох хариултыг олох, үйл явдлын дарааллыг цуврал зургийн дагуу илэрхийлэх” гэх мэт олон аргаар хэрхэн ойлгосныг илрүүлж болно.

Мөн шүлгийн мөр, үгсийг зөв дарааллыг олох, орхигдсон үгийг нөхөх замаар шүлгийг дуурайн, эвлүүлж бичнэ. Нэгж сэдвийн хүрээнд танил үгсийг утгаар нь, асуултаар нь ангилах, бүлэглэх, өгсөн үгсээр өгүүлбэр зохиож, цэг тэмдгийг тавих, өгүүлбэрээр зааглан том үсэг ба цэг, асуултын тэмдэг нөхөж бичих даалгавар өгч болно. Жишээ нь болгон ДАД 28-р хуудасны даалгаврыг оруулав.

3. Зурагт тохирох өгүүлбэрийг бүтээж, цэг тэмдгийг тавин бичээрэй. (? , .)

Хүү

хүүхдүүдтэй

ирдэг вэ [ ]

Тэр

хэзээ

очдог вэ [ ]

Гэртээ

хаана

тоглодог [ ]


Сурагчаар өөрийн болон болон үе тэнгийнхний үнэлгээ хийлгэхдээ дараах зурагт үзүүлсэнчлэн дүрс тэмдэг ашиглах нь энэ ангийн сурагчдад тохиромжтой.

Даалгавар	1	2	3	4	5
Өөрийн үнэлгээ 					

### ЭЭЛЖИТ ХИЧЭЭЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Ээлжит хичээлийн төлөвлөлт хийхэд зорилго, зорилтоо оновчтой тодорхойлох нь чухал. Үүний тулд тухайн ээлжит хичээлээр уншуулах эхийг үндэслэн түүнтэй уялдсан суралцахуйн зорилтыг сонгоно. Жишээ нь, “Долоо хоног” эх нь шүлэглэсэн эх бөгөөд 2.СЗ, 2.УЗ, 2.ЯЗ, 2.БЗ суралцахуйн зорилтуудыг хэрэгжүүлнэ.

Суралцахуйн зорилтыг баримжаалан хичээлийн зорилго, зорилтыг тодорхойлно. Улмаар хичээлийн үйл ажиллагааг сонсох, унших, ярих, бичих, хэл зүй гэсэн үйл ажиллагааны дарааллаар төлөвлөхийг анхаарна уу.

Ээлжит хичээлийн цагийг хуваарилахдаа багш, сурагчийн үйл ажиллагаа нь 20/80 хувь байхад анхаараарай.



**Ээлжит хичээлийн сэдэв:**



Долоо хоног

**Судлах цаг:**

35 минут

Ээлжит хичээлийн зорилго	Ээлжит хичээлийн зорилт
Долоо хоногийн тухай үг хэллэгийн дуудлагыг ялгаж, зөв дуудаж, уншиж, бичиж сурна.	<ul style="list-style-type: none"> <li>- Шүлгийг сонсож, давтан хэлэх замаар цээжлэн тогтоох;</li> <li>- Шүлгийг бусдын өмнө чанга, тод дуугаар уран унших;</li> <li>- Шүлгийн үгийг сольж гээлгүй, тод чанга цээжээр унших;</li> <li>- Шүлгийг үйл явдлыг зөв дараалалд оруулах, гүйцээж бичих;</li> <li>- Оноосон нэрийг том үсгээр бичих, өгүүлбэрийн цэг тэмдгийг хэрэглэх;</li> </ul>

**Хичээлийн явц, арга зүй**

Үе шат	Суралцахуйн үйл ажиллагаа	Явцын үнэлгээ
	<p>Зохион байгуулалт хийнэ. Хичээлийн дэгийг танилцуулна. Багш сурагчдад хуанли харуулж, яагаад хуанлид ДА, МЯ, ЛХ, ПҮ, БА, БЯ, НЯ гэсэн үгс байдгийг асууж, ярилцана.</p>	Хичээлийн дэгийг баримталж буй эсэхийг ажиглана.
Эхлэл хэсэг 3 мин (Сонсох 2.С3)	<p>Алхам 1. Шинэ үгсийн утгыг ойлгуулах РРТ харуулж, багш тайлбарлаж өгнө. (Слайд 1)</p> <p>Тайлбар: (Даваа-долоо хоногийн нэг дэх өдөр Мягмар-долоо хоногийн хоёр дахь өдөр Лхагва-долоо хоногийн гурав дахь өдөр Пүрэв-долоо хоногийн дөрөв дэх өдөр Баасан-долоо хоногийн тав дахь өдөр Бямба-долоо хоногийн зургаа дахь өдөр Ням-долоо хоногийн долоо дахь өдөр)</p> 	Аудио бичлэгийг анхааралтай сонсож байгаа эсэхийг ажиглана.
Эхлэл хэсэг 3 мин (Сонсох 2.С3)	<p>1. Аудио бичлэг сонсож ойлгосноо шалгах даалгавар хийнэ. Сурагчид ДАД-ийн 28-р хуудасны даалгавар 1.1 дээр ажиллана.</p> <p><b>1. Долоо хоногийг дугаарлаарай. Дараалуулж бичээрэй.</b></p> <p><input type="checkbox"/> бямба    <input checked="" type="checkbox"/> 1 даваа    <input type="checkbox"/> пүрэв    <input type="checkbox"/> мягмар</p> <p><input type="checkbox"/> ням    <input type="checkbox"/> лхагва    <input type="checkbox"/> баасан</p>  <p>Багш хариултыг дэлгэцээр харуулна. Слайд 2 (хөдөлгөөнтэй)</p> <p>Алхам 2. "Долоо хоног" шүлгийг 3 удаа сонсоно. (Сонсох эх: ГА 42-р хуудасны Дасгал 1.6)</p> <p>Сурагчид шүлгийг 2 удаа анхааралтай сонсоно. 3 дахь удаа сонсохдоо дагаж, давтаж хэлнэ.</p>	Сурагчид өөрийн хийснийг зөв эсэхийг шалгаж, долоо хоногийг дарааллаар нь бичнэ. Багш ангийн сурагчдын шүлгийг давтан хэлж буй байдлыг сайтар ажиглана.
	<p><b>Санал болгох идэвхтэй арга:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Сурагчид шүлгийн босож зогсоод сонсож болно.</li> <li>- Сонсоод дагаж, давтаж хэлж байхдаа ангийн ханан дээр энд тэндгүй наасан 7 хоногийн гарагуудын нэрийг хуулан авч багшийн урьдчилан бэлтгэсэн ханын хэсэгт зөв дараалалд оруулан нааж болно.</li> </ul> <p><b>Бэлтгэх зүйл:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Багш гарагуудын нэрийг хэд хэдээр хувилж гялгар цаасаар бүрээд ангийн хананд, энд тэндгүй байрлуулсан байна.</li> </ul>	



<p>Гол хэсэг 28 мин (Бичих 2.Б3, Ярих 2.Я3, Унших 2.У3)</p>	<p>Алхам 3. Шинэ үгсийг уншуулна. Холбоо үг, өгүүлбэр зохиох дасгал хийнэ.</p> <p>1. Багш хуанли ашиглан өчигдөр, өнөөдөр, маргааш ямар гараг болохыг ярилцана.</p> <div data-bbox="247 302 798 470"> </div> <p>(Слайд 3)</p> <p>2. Өгүүлбэр зохиох загвар, жишээ:          Өнөөдөр ..... гараг. .... Баасан гараг.          Маргааш .....          Самбарт сар өдөр бичнэ. Сурагчид дэвтэртээ бичнэ.</p>	<p>Дэвтэрт сар өдрийг зөв бичсэн эсэхийг харна.</p>																																
	<p>Алхам 4. Шүлгийг уншина.</p> <div data-bbox="231 672 1021 952"> <p><b>б. Шүлгийг тод чанга уншаарай.</b></p> <p><b>Долоо хоног</b></p> <table border="0"> <tr> <td>Нэг хоёр, нэг хоёр</td> <td>Харин <b>Пүрэв, Баасанд</b></td> </tr> <tr> <td>Нэг хоёр гурав</td> <td>Харьж гэртээ ирнэ</td> </tr> <tr> <td>Найз аа! Найз аа!</td> <td>Амралтын <b>Бямба, Нямд</b></td> </tr> <tr> <td>Намайг дагаад хэлээрэй</td> <td>Айлын хүүхдүүдтэй тоглоно</td> </tr> <tr> <td><b>Даваа, Мягмар, Лхагвад</b></td> <td>Эхнээс нь дахиад хэлээрэй</td> </tr> <tr> <td>Дандаа эмээгийн д очно.</td> <td>Энэ тооллыг давтаарай</td> </tr> </table> </div>	Нэг хоёр, нэг хоёр	Харин <b>Пүрэв, Баасанд</b>	Нэг хоёр гурав	Харьж гэртээ ирнэ	Найз аа! Найз аа!	Амралтын <b>Бямба, Нямд</b>	Намайг дагаад хэлээрэй	Айлын хүүхдүүдтэй тоглоно	<b>Даваа, Мягмар, Лхагвад</b>	Эхнээс нь дахиад хэлээрэй	Дандаа эмээгийн д очно.	Энэ тооллыг давтаарай	<p>Сурагчдын зөв, тод чанга уншиж байгаа эсэхийг ажиглаж, дуудлагыг засна.</p>																				
Нэг хоёр, нэг хоёр	Харин <b>Пүрэв, Баасанд</b>																																	
Нэг хоёр гурав	Харьж гэртээ ирнэ																																	
Найз аа! Найз аа!	Амралтын <b>Бямба, Нямд</b>																																	
Намайг дагаад хэлээрэй	Айлын хүүхдүүдтэй тоглоно																																	
<b>Даваа, Мягмар, Лхагвад</b>	Эхнээс нь дахиад хэлээрэй																																	
Дандаа эмээгийн д очно.	Энэ тооллыг давтаарай																																	
<p>Гол хэсэг 28 мин (Бичих 2.Б3, Ярих 2.Я3, Унших 2.У3)</p>	<p>(ГА 42-р хуудасны дасгал 1.б)</p> <ul style="list-style-type: none"> <li>- Багш үлгэрлэн уншина.</li> <li>- Сурагчид гүйлгэн уншина.</li> <li>- ДАД-ийн 28-р хуудасны даалгавар 1.2 дээр ажиллана.</li> <li>- Багшийн уншсан шүлгийг сонсож, хүснэгтэд тэмдэглэнэ.</li> </ul> <div data-bbox="231 1153 1005 1534"> <p><b>2. Шүлгийг сонсоод, хүснэгтэд тэмдэглээрэй. ☑</b></p> <table border="1"> <thead> <tr> <th></th> <th>Даваа</th> <th>Мягмар</th> <th>Лхагва</th> <th>Пүрэв</th> <th>Баасан</th> <th>Бямба</th> <th>Ням</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Эмээгийн д очно.</td> <td>✓</td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>Гэртээ ирнэ.</td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>Айлын хүүхэдтэй тоглоно.</td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> <td></td> </tr> </tbody> </table> </div> <ul style="list-style-type: none"> <li>- Өөртөө уншуулна (Сурагч зөвхөн өөртөө зориулж уншина)</li> <li>- Хамтын уншлага (Бүх сурагч хамтарч дуу нийлүүлэн зэрэг уншина) хийлгэнэ</li> <li>- Давтан уншуулна (Шүлгийг мөр мөрөөр хэсэгчлэн хэд хэдэн сурагчаар уншуулна)</li> </ul> <p><b>Санал болгох идэвхтэй арга:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Идэвхтэй уншилтын дээрх аргаас гадна шүлгийг мөр бүрээр нь бүх хүүхэд унших марафон аргыг ашиглаарай.</li> </ul> <p>Энэ аргыг хэрэглэхэд сурагч дараа нь өөрөө унших тул аль мөр дээр явааг нь алдахгүйг хичээж бусдыг анхааралтай сонсож сурдаг. Мөн бүх сурагчийг хамрах давуу талтай.</p> <p>Багш энэ аргыг байнга ашигласнаар сурагч хэн нэг, сайн уншдаг хүүхдийг хүлээхээс илүү “бүх хүүхэд уншдаг тул би ч бас уншина” гэсэн бэлтгэлтэй болно.</p>		Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням	Эмээгийн д очно.	✓							Гэртээ ирнэ.								Айлын хүүхэдтэй тоглоно.								<p>Багш сурагчдын хүснэгтэд тэмдэглэснийг шалгана.</p> <p>Багш аль болох олон сурагч хамруулахыг зорино. Сурагчдын дуудлагыг засна.</p>
	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням																											
Эмээгийн д очно.	✓																																	
Гэртээ ирнэ.																																		
Айлын хүүхэдтэй тоглоно.																																		



	<p>Алхам 5 Уншиж ойлгосноо асуултын дагуу ярилцана.</p> <p><b>в. Асуултын дагуу ярилцаарай.</b></p> <div style="border: 1px solid purple; padding: 5px; background-color: #f0e6ff;"> <ul style="list-style-type: none"> <li>➤ Хүү эмээгийн дээ хэзээ очдог вэ?</li> <li>➤ Хүү хэзээ гэртээ ирдэг вэ?</li> <li>➤ Тэр бямба, нямд юу хийдэг вэ?</li> <li>➤ Өнөөдөр ямар гараг вэ?</li> <li>➤ Маргааш ямар гараг вэ?</li> <li>➤ Өчигдөр ямар гараг байсан бэ?</li> </ul> </div> <p>(ГА 42-р хуудасны дасгал 1.в)</p>	<p>Хүүхдүүд гараа өргөж хариулна. Зөв эсэхийг сурагчдаас асууж, хариултыг гүйцээхийг хүснэ.</p>
	<p>Алхам 6. Шүлгийг зургийн дагуу цээжээр уншуулна.</p> <p><b>г. Шүлгийг цээжээр уншаарай.</b></p> <div style="display: flex; justify-content: space-around; text-align: center;"> <div style="border: 1px solid green; padding: 2px; background-color: #e0ffe0;">Даваа, Мягмар, Лхагвад</div> <div style="border: 1px solid green; padding: 2px; background-color: #e0ffe0;">Пүрэв, Баасанд</div> <div style="border: 1px solid green; padding: 2px; background-color: #e0ffe0;">Бямба, Нямд</div> </div> <p>(ГА 42-р хуудасны дасгал 1.Г-д буюу Слайд 5)</p>	<p>Цээжээр уншсан сурагчдыг аман үнэлгээгээр урамшуулна.</p>
	<p>Алхам 7. Өгүүлбэрийг зөв дараалалд оруулж бичнэ.</p> <p><b>д. Өгүүлбэрийг дараалалд оруулж дэвтэртээ бичээрэй.</b></p> <div style="border: 1px dashed orange; padding: 5px; background-color: #fff9c4;"> <p> Айлын хүүхдүүдтэй тоглоно. Би эмээгийн д очно. Пүрэв, баасанд гэртээ ирнэ.</p> </div> <p>(ГА 42-р хуудасны дасгал 1.Д) Зөв дараалал: 1. Би эмээгийн д очно 2. Пүрэв, баасанд гэртээ ирнэ. 3. Айлын хүүхдүүдтэй тоглоно.</p>	<p>Зөв хариултыг эхний 3 сурагчаар самбарт бичүүлж, бусад нь өөрийнхөө зөв хийсэн эсэхээ шалгана. Сурагчдын өгүүлбэрийг том үсэг, цэг тэмдгийг зөв хэрэглэж бичихэд нь анхаарна.</p>
<p>Төгсгөл хэсэг 4 мин</p>	<p>Алхам 8. “Долоо хоног” шүлгийг бүрэн эхээр нь цээжээр уншуулж автана.</p> <p>Алхам 9. Гэрийн даалгаварт өгнө. 1. ДАД 28-р хуудасны даалгавар 1.3</p> <p><b>3. Зурагт тохирох өгүүлбэрийг бүтээж, цэг тэмдгийг тавин бичээрэй. (? , .)</b></p> <div style="display: flex; justify-content: space-around; align-items: flex-start;"> <div style="text-align: center;"> <p>Хүү Тэр Гэртээ</p> </div> <div style="text-align: center;"> <p>хүүхдүүдтэй хэзээ хаана</p> </div> <div style="text-align: center;"> <p>ирдэг вэ [ ] очдог вэ [ ] тоглодог [ ]</p> </div> </div> <div style="margin-top: 10px;"> <p>_____</p> <p>_____</p> <p>_____</p> <p>_____</p> <p>_____</p> </div> <p>2. Сурагчид шүлгээ цээжилнэ. Шинэ үгсийг тогтооно.</p>	<p>Цээжилсэн сурагчдыг аман үнэлгээгээр урамшуулна.</p> <p>Зурагт тохирох өгүүлбэрийг бүтээж, цэг тэмдгийг тавин бичнэ. Сурагчид даалгавар бүрийн гүйцэтгэлийн дараа өөрөө өөрийгөө үнэлнэ.</p>



**Ээлжит хичээлийн сэдэв:**






Сургууль дээр юу хийх вэ?

**Судлах цаг:**


35 минут

Ээлжит хичээлийн зорилго	Ээлжит хичээлийн зорилт
Үйл хөдлөл заасан үгсийг сонсож, үг хэллэгийг зөв дуудаж, унших, бичих чадвартай болно.	<ul style="list-style-type: none"> <li>- Үйл хөдлөл заасан үгсийг сонсоод, зургаар илэрхийлэх;</li> <li>- Эхийг уншиж, түлхүүр үг хэллэгийг нүдэлж тогтоох;</li> <li>- Үйл хөдлөл заасан үгсийг тоочих, үйл хөдлөлөөр илэрхийлэх;</li> <li>- Үйл хөдлөлийг загварыг ашиглан тоочин бичих;</li> <li>- Үйл хөдлөл заасан үгсийг утгыг ялгаж хэрэглэх;</li> </ul>

**Хичээлийн явц, арга зүй**

Үе шат	СЗ	Суралцахуйн үйл ажиллагаа	Явцын үнэлгээ
Эхлэл хэсэг 5 МИН		<ul style="list-style-type: none"> <li>- Ангид зохион байгуулалт хийнэ.</li> <li>- Хичээлийн дэгийг танилцуулна.</li> <li>- Гэрийн даалгавар шалгаж, өмнөх хичээлийг давтана.</li> </ul> <p>Алхам 1. Багш урьдчилан бэлтгэсэн PPT эсвэл зургийг нэг нэгээр үзүүлж, ажиглуулна.</p>  <p>Багш зураг тус бүрийг харуулж, асуулт асууна.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Ямар хичээл орж байна вэ?</li> </ul> <p>Сурагчид зургийг хараад, багшийн асуултад бүтэн өгүүлбэрээр хариулна.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Дүрслэх урлагийн хичээл орж байна.</li> <li>- Биеийн тамирын хичээл орж байна.</li> <li>- Хөгжмийн хичээл орж байна.</li> <li>- Математикийн хичээл орж байна. г.м</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Хичээлийн дэгийг баримталж буй эсэхийг ажиглана.</li> <li>- Багшийн асуултад бүтэн өгүүлбэрээр хариулж буй эсэхэд анхаарч, сурагчдад сануулна.</li> </ul>
	Сонсох 2.С2	 <p>Алхам 2.</p> <p>а) Зураг харуулж, аудио бичлэг сонсоно.</p> <p>Сонсох бичлэг: Бат хөгжим тоглов. Алимаа бүжиглэв. Туяа дуу дуулав.</p>  <p>Сурагч тоо бодов. Ном уншив. Зураг зурж, будав.</p>  <p>Хүүхдүүд бөмбөг тоглож, дасгал хийв.</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Аудио бичлэгийг анхааралтай сонсож байгаа эсэхийг ажиглана.</li> <li>- Зургуудыг оруулж доор нь үйл хөдлөлийг бичих.</li> <li>- Багш хариултыг</li> <li>- дэлгэцээр харуулна.</li> </ul>
		<p>б) Сонсож ойлгосноо шалгах даалгавар хийлгэнэ. Ажлын хуудсан дээр ажиллана. Үгсийг зурагтай нь холбоорой. Жишээ нь: Бат</p> 	<p>Сурагчид өөрийн хийснийг зөв эсэхийг шалгана.</p>



	<p>Унших 2.У2</p> <p>Алхам 3. ГА 44-р хуудасны дасгал 3. Б “Сургууль дээр” эхийг уншина. Сургууль дээр Багш хичээл заана. Монгол хэлний хичээл дээр уншина, бичнэ. Тооны хичээл дээр тоо бодно. Зургийн хичээл дээр зураг зурна, будна. Хөгжмийн хичээл дээр дуулна, бүжиглэнэ, хөгжим тоглоно. Биеийн тамирын хичээл дээр тоглоно. Дасгал хийнэ. 1. Зурагт танилцуулгыг уншуулж, түлхүүр үг хэллэгийн утгыг зурагт толь ашиглан нүдэлж тогтоолгоно. 2. “Сургууль дээр” эхийг хараагаар чимээгүй уншина.Өөртөө уншина 3. Бусдад уншина (Хүүхэд бүр нэг нэг өгүүлбэрээр уншина)</p>	<p>Сурагчдын зөв, тод чанга уншиж байгаа эсэхийг ажиглаж, - дуудлагыг засна. - олон сурагч хамруулахыг зорино.</p>										
<p>Гол хэсэг 28 мин</p>	<p>Ярих 2.Я2</p> <p>Алхам 4. а) ГА-ын 44-р хуудасны дасгал 3.в Уншиж ойлгосноо асуултын дагуу ярилцана. Асуултад бүтэн өгүүлбэрээр хариулаарай.</p> <p><b>в. Асуултын дагуу ярилцаарай.</b></p> <div data-bbox="395 810 1011 954" style="border: 1px solid purple; padding: 5px;"> <ul style="list-style-type: none"> <li>☞ Та нарт ямар, ямар хичээл ордог вэ?</li> <li>☞ Ямар хичээл дээр юу хийдэг вэ?</li> <li>☞ Чи сургууль дээр юу хийж сурсан бэ?</li> <li>☞ Чи ямар хичээлд дуртай вэ?</li> </ul> </div> <p>Өгүүлбэрийн загвар жишээ: Зургийн хичээл дээр ..... ..... хичээл дээр уншина. Би ..... чадна. Би.....хичээлд дуртай.</p>	<p>- Багшийн асуултад бүтэн өгүүлбэрээр хариулж буй эсэх.</p>										
	<p>Бичих 2.Б2</p> <p>б) ДАД-ийн 29-р хуудасны даалгавар 2.2</p> <div data-bbox="343 1214 1024 1684" style="border: 1px solid orange; padding: 10px;"> <p><b>2. Зөв харгалзуулан өгүүлбэр зохион бичээрэй.</b></p> <table style="width: 100%; border-collapse: collapse;"> <tr> <td style="width: 50%;">Зургийн хичээл дээр ★</td> <td style="width: 50%;">★ уншиж, бичнэ.</td> </tr> <tr> <td>Тооны хичээл дээр ★</td> <td>★ тоглоно, дасгал хийнэ.</td> </tr> <tr> <td>Монгол хэлний хичээл дээр ★</td> <td>★ дуулж, бүжиглэнэ.</td> </tr> <tr> <td>Хөгжмийн хичээл дээр ★</td> <td>★ зурж, будна.</td> </tr> <tr> <td>Биеийн тамирын хичээл дээр ★</td> <td>★ тоо бодно.</td> </tr> </table>  </div> <p>Биеийн тамирын хичээлд тоо бодно. Зургийн хичээл дээр зурж, будна. г.м -Өгүүлбэрийг том үсгээр эхлэн бичиж, цэг тэмдгийг тавиарай. Дэгийн дагуу цэвэр сайхан, алдаагүй бичээрэй.</p>	Зургийн хичээл дээр ★	★ уншиж, бичнэ.	Тооны хичээл дээр ★	★ тоглоно, дасгал хийнэ.	Монгол хэлний хичээл дээр ★	★ дуулж, бүжиглэнэ.	Хөгжмийн хичээл дээр ★	★ зурж, будна.	Биеийн тамирын хичээл дээр ★	★ тоо бодно.	<p>- Багш сурагчдын даалгаврыг шалгана. Зөв хариултыг уншуулна. - Зөв эсэхийг сурагчдаас асууж, хариултыг гүйцээхийг хүснэ. - Сурагчдын өгүүлбэрийг том үсэг, цэг тэмдгийг зөв хэрэглэж бичихэд нь анхаарна.</p>
Зургийн хичээл дээр ★	★ уншиж, бичнэ.											
Тооны хичээл дээр ★	★ тоглоно, дасгал хийнэ.											
Монгол хэлний хичээл дээр ★	★ дуулж, бүжиглэнэ.											
Хөгжмийн хичээл дээр ★	★ зурж, будна.											
Биеийн тамирын хичээл дээр ★	★ тоо бодно.											
	<p>Алхам 5. ГА 44-р хуудасны дасгал 3.г</p> <p><b>г. Өгүүлбэрийг уншаад, дэвтэртээ цэвэр сайхан бичээрэй.</b></p> <div data-bbox="438 1948 997 2038" style="text-align: center;"> </div>	<p>- Хүүхдүүд гараа өргөж бичсэнээ уншина. - Уншсан сурагчдыг аман үнэлгээгээр урамшуулна.</p>										



	<p><b>Санал болгох идэвхтэй үйл ажиллагаа:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Сурагчдын бичих дасгал, даалгаврын үр дүнг илрүүлэхийн тулд зөвхөн гараа өргөсөн сурагчийг сонсох болон багш шалгахаас гадна бүх сурагчийг оролцуулах боломжтой. Үүнд:</li> <li>- Бүх сурагчдыг оролцуулахын тулд сурагчид дэвтрээ солилцон, бие биедээ хийсэн ажлаа үзүүлж, зааж, тайлбарлах цаг гаргаж өгөөрэй.</li> <li>- Харин та тэдний бие биеийнхээ хийсэн зүйлийг үзэж, ярилцаж буй байдлыг сонсож, шаардлагатай сурагчдад дэмжлэг үзүүлж болно. Мөн сурагчдын гаргаж буй нийтлэг алдаа болон тусгайлсан дэмжлэг шаардлагатай сурагчийг ялган, алдааг нь засах, сурагчтай ажиллах талаар шийдвэр гаргаж болно.</li> <li>- Энэ аргыг давтамжтай, зорилготой хэрэглэснээр сурагчид зөвхөн гараа өргөсөн сурагчид найдахаа больж, бүгд хичээх болно.</li> </ul>
Төгсгөл хэсэг 2 мин	<p>Хэлзүй, хэрэглээ 2.Х4</p> <p>Алхам 6.</p> <p>1. ДАД-ийн 29-р хуудасны даалгавар 2.3-ыг гэрийн даалгаварт өгнө.</p> <p><b>3. Үг нөхөж, өгүүлбэр бичээрэй.</b></p> <p>2. Эхийг унших</p> <p>3. Түлхүүр үг хэллэгийг нүдэлж тогтоох</p>

Өгүүлбэрийг бүтээж, цэг тэмдгийг тавин бичнэ. Сурагчид даалгавар бүрийн гүйцэтгэлийн дараа өөрөө өөрийгөө үнэлнэ.

**Ээлжит хичээлийн сэдэв:**

Өдөр тутмын ажил

**Судлах цаг:**





35 минут

Ээлжит хичээлийн зорилго	Ээлжит хичээлийн зорилт
Үйл хөдлөл заасан үгсийг сонсож, үг хэллэгийг зөв дуудаж, унших, бичих чадвартай болно.	<ul style="list-style-type: none"> <li>- Үйл хөдлөл заасан үгсийг сонсоод, зургаар илэрхийлэх;</li> <li>- Эхийг уншиж, түлхүүр үг хэллэгийг нүдэлж тогтоох;</li> <li>- Үйл хөдлөл заасан үгсийг тоочих, үйл хөдлөлөөр илэрхийлэх;</li> <li>- Үйл хөдлөлийг загварыг ашиглан тоочин бичих;</li> <li>- Үйл хөдлөл заасан үгсийг утгыг ялгаж хэрэглэх;</li> </ul>




**Хичээлийн явц, арга зүй:**

Үе шат	СЗ	Суралцахуйн үйл ажиллагаа	Явцын үнэлгээ
Эхлэл хэсэг 5 мин		Зохион байгуулалт хийнэ. Хичээлийн дэгийг танилцуулна. Гэрийн даалгавар шалгаж, өнгөрснийг давтана.	Хичээлийн дэгийг баримталж буй эсэхийг ажиглана.
Гол хэсэг 28 мин	Сонсох 2.С3	<p>Алхам 1. Шинэ үгсийн утгыг ойлгуулах. Слайд 1</p> <p>Сурагчид ГА 41-р хуудасны зурагт толь дээр ажиллана. Багш зургуудыг дэлгэцээр харуулж, нэрлүүлнэ.</p>	Дэлгэцээр гарсан зургуудыг зөв нэрлэж байгаа эсэхийг анхаарна. (өглөө, өдөр, орой, шөнө, унтах, явах, ирэх, очих цай уух, хоол, идэх, цэвэрлэх, угаах)



	<p>Алхам 2. Аудио бичлэгээр сонсоно. (2-3 удаа) Сонсох эх: ГА 46-р хуудасны дасгал 5.6 Эхийн үйл явдлын дарааллыг харуулсан цуврал зургийг дэлгэцээр гаргаж, эхийн аудио бичлэгийг сонсоно.</p> 	<p>Аудио бичлэгийг анхааралтай сонсож байгаа эсэхийг ажиглана. Багш хариултыг дэлгэцээр харуулна. Сурагчид өөрийн хийснийг зөв эсэхийг шалгана.</p>
	<p>Сонсож ойлгосноо шалгах даалгавар хийлгэнэ. Эхийг сонсож, үйл хөдлөл заасан үгсийг харгалзуулна. ДАД-ийн 30-р хуудасны даалгавар 3.2 Слайд 2</p>  <p>явах      тоглох      унтах      босох      угаах      идэх</p>	
<p>Унших 2.У4</p>	<p>Алхам 3. Эхийг уншина. ГА 46-р хуудасны дасгал 5.6 1. Эхийг багш үлгэрлэн уншина.     Чи өглөө юу хийдэг вэ? Би өглөө найман цагт босдог. Нүүр гараа угаадаг. Бас шүдээ угаадаг. Дасгал хийдэг. Цайгаа уугаад, сургуульдаа явдаг.     Чи өдөр юу хийдэг вэ? Би сургуулиас ирээд, өдрийн хоолоо иддэг. Гэрийн даалгавраа хийдэг. Ном уншиж, зураг зурна. Бас тоглоно Чи орой юу хийдэг вэ? Оройн хоолоо иддэг. Аав ээждээ тусалдаг. Зурагт үзнэ.     Шөнө унтаж амарна. 1. Сурагчид хараагаа гүйлгэн уншина. 2. Өөртөө уншина (Сурагч зөвхөн өөртөө зориулж уншина) 3. Хэсэгчлэн унших уншлага хийлгэнэ. (Эхийг нэг нэг өгүүлбэрээр уншуулна)</p>	<p>Багш аль болох олон сурагч хамруулахыг зорино. Уншихдаа үг нэг бүрийг зөв уншиж буй эсэхээ анхаарна. Дуудлагыг засаж өгнө.</p>
<p>Ярих 2.Я4</p>	<p>Алхам 4. Уншиж ойлгосноо ГА 46-р хуудасны 5.В-гийн асуултын дагуу ярилцана. Та нар өдөр бүр юу хийдэг вэ? Зургийн дагуу яриулна</p>  <p>(Слайд 3) Сургуульдаа хэзээ явдаг вэ?</p>  <p>А.      Б.      В.      Г.</p> <p>Өгүүлбэр зохиож ярина. Хэрэглэх үгс: өглөө, өдөр, орой, шөнө ..... сургуульдаа явдаг. .... цайгаа уудаг. .... тоглодог. Би .....унтдаг.</p>	<p>Сурагчид гараа өргөж, өөрийн хийдэг үйлээ бүтэн өгүүлбэрээр ярина. Сурагч бүрээс хариулт авахыг хичээнэ. Зөв эсэхийг бусад сурагчдаас асууж, хариултыг гүйцээхийг хүснэ.</p>




		<p>Санал болгох идэвхтэй арга:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Идэвхжүүлэх, анхааралд төвлөрүүлэх сонсох чадварыг хөгжүүлэх зорилгоор “Анхаар” тоглоомыг тоглуулна.</li> </ul> <p><i>Тоглоомын заавар:</i> Тоглоомд анги нийтээр оролцоно. Багш үйл хөдлөл заасан үгсийг хэлэхэд сурагчид хөдөлгөөнөөр илэрхийлнэ. Гэхдээ “Босоорой” гэвэл босохгүй. “Анхаар, босоорой” гэвэл босно. Үйлдлийг алдаж хийсэн хүүхэд хасагдана. Хамгийн сүүлд үлдсэн хүүхэд ялагч болно. Сурагч хөтөлж болно.</p>	
		<p>Анхаарах зүйл, зааварчилга:</p> <ul style="list-style-type: none"> <li>- 1 гэж тоолсон хүүхэд эхлээд ярина.</li> <li>- Нэг хүүхэд 1-2 минут ярихаар цагийг хуваарилна. Гэхдээ хүүхдийн ярианы чадвараас шалтгаалан хугацааг өөрчилж болно.</li> <li>- Багш “эхэл” гэсэн команд өгөхөд ярьж эхэлнэ. “Цаг дууссан, зогс” команд өгөхөд ярьж буй 1 гэж тоолсон сурагч яриагаа зогсооно. Дахин эхэл” гэсэн команд өгөхөд 2 гэж тоолсон сурагч ярина.</li> <li>- Энэ аргын давуу тал нь бага хугацаанд бүх сурагч ярих боломж олгодог.</li> <li>- Багш нар “хүүхэд ярьж чадахгүй, анги замбараагүй болно” гэх мэтээр болгоомжилдог боловч байнга хэрэглэдэг багш нарын туршлагаас харахад             <ul style="list-style-type: none"> <li>• Сайн бэлтгэсэн тохиолдолд амжилттай болдог. Эхний үед сурагчид тулгамддаг ч дараа нь тайвширч, ярианы чадвар нь сайжирдаг, өөртөө итгэлтэй болдог гэж үздэг.</li> <li>• Мөн бие биеийнхээ яриаг сонсож байгаа хүүхдүүдийн анхаарал сарнидаггүй болохыг баталдаг.</li> </ul> </li> </ul>	
<p>Бичих 2.Б4, 2.Х4</p>		<p>Алхам 5. Зургийн дагуу өгүүлбэр зохиож бичнэ. ДАД-ийн 30-р хуудасны 3.2 дээр ажиллана.</p>  <p>Өглөө долоон цагт босов.г.м Хэд хэдэн сурагчаар зохиосон өгүүлбэрийг нь уншуулна. Мөн самбарт бичүүлж болно.</p>	<p>Сурагчид өөрийнхөө зөв хийсэн эсэхээ шалгана. Сурагчдын өгүүлбэрийг том үсэг, цэг тэмдгийг зөв хэрэглэж бичихэд нь анхаарна.</p>
<p>Төгсгөл хэсэг 2 мин Төгсгөл хэсэг 4 мин</p>	<p>Бататгал</p>	<p>Алхам 6. Ажлын хуудас дээр ажиллана. Ажлын хуудсаар ажиллах зааварчилгаа өгнө. Зургийг хараад, зөвийг тэмдэглэнэ. Зөв бол √, буруу бол Х тэмдэг тавина.</p>  <ul style="list-style-type: none"> <li>○ босох</li> <li>○ унтах</li> <li>○ зураг зурах</li> <li>○ дуу дуулах</li> <li>○ шүд угаах</li> <li>○ нүүр угаах</li> <li>○ цай уух</li> <li>○ хоол идэх</li> </ul>	<p>Зөв хариултыг дэлгэцээр гаргана, сурагчид өөрийнхөө зөв хийсэн эсэхээ шалгана.</p>
<p>Гэрийн даалгавар өгөх</p>		<p>Алхам 7. ГА 46-р хуудасны дасгал 5.г-г гэрийн даалгаварт өгнө.</p> <p><b>г. Өгүүлбэр зохиож бичээрэй.</b></p>  <p>2. Эхийг уншиж, шинэ үгсийг тогтооно.</p>	<p>Сурагчдын хийсэн даалгаврын гүйцэтгэлийг дараа өдөр багш, сурагчид хамтран үнэлнэ.</p>


### III АНГИ. НЭГЖ ХИЧЭЭЛИЙН СЭДЭВ. БИ

Нэгж сэдвийн агуулгын ерөнхий хүрээ: “Би” сэдэвт нэгжийн агуулгыг гарын авлага дээр дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

- Хүүхэд өөрөө болон найз нөхөд, гэр бүлийн хүрээнд өөрийн товч танилцуулга, гэр бүлийн гишүүд, найз нөхдийн хүсэл сонирхлыг танилцуулахдаа сонсож, ярьж тайлбарлаж, уншиж, бичиж хэлний 4 чадварыг хөгжүүлнэ.



- Харилцан яриа, танилцуулга, шүлэг, богино эхийг сонсоод дасгал даалгаврыг бие даан ажиллахдаа өөрийгөө бусдад танилцуулж, бусдыг сонсож, өөртөө итгэлтэй суралцаж, өөрийгөө үнэлж сурна.



- Хэл зүйн хувьд эхээс н, г, х орсон үгийн утга ялгах, хэн?, юу?, яав?, яадаг? яасан? гэсэн асуултад хариулагдах үгсийг бүлэглэх, зөв дуудах, ойролцоо утгыг тайлбар толь, зурагт толь ашиглан мэдэх, зөв бичих дадал эзэмшинэ.

#### 1. “Дөрвөн хүсэл” эхээс доорх асуултад хариулах үгсийг түүж бичээрэй.

Хэн?	Юу?	Ямар?	Яав?

#### Судлах цаг: 10 цаг

- Гуравдугаар ангид нэгжийг 40-80 минутаар ээлжит хичээлд хуваарилсан болно.
- Багш сурагчдын хэлний болон сурах чадварын түвшнийг харгалзан ялгаатай даалгавар ажиллуулж болно.

#### Нэгжийн зорилго:

Сурагчийн өөрийгөө танилцуулах, гэр бүл, найз нөхдийн хүсэл сонирхлыг илэрхийлсэн эхүүдийг монгол хэлээр сонсох, унших, ярих, тайлбарлах, цээжээр бичих, хуулан бичих чадварыг хөгжүүлнэ.



## Суралцахуйн зорилтод нэгж хичээлийн оруулах хувь нэмэр

Суралцахуйн зорилт	Нэгж хичээлийн суралцахуйн үр дүн
3.С1. Харилцан ярилцахдаа анхааралтай, идэвхтэй сонсож, ойлгосноо нүүрний хувирал, үйл хөдлөлөөр илэрхийлэх 3.С2. Гэр бүл, найз нөхөд, хүрээлэн буй орчны танилцуулгыг сонсож, зураг, дүрс, өнгөөр илэрхийлэх 3.Я1. Харилцан ярилцахдаа санаа бодлоо бусдын өмнө чөлөөтэй илэрхийлэх 3.Я2. Гэр бүл, найз нөхөд, хүрээлэн буй орчны сэдэвт зургийг бүтэн өгүүлбэрээр, тоочин танилцуулах 3.У1. Харилцан яриаг (ойролцоо үгсийн утгыг ялгаж) зөв, хурдан, ойлгож унших 3.У2. Гэр бүл, найз нөхөд, хүрээлэн буй орчны танилцуулгыг уншиж агуулгыг асуултын дагуу тайлбарлах 3.Б1. Өгүүлбэр, эхийг цээжээр бичихдээ дэгийн дагуу (том, жижиг үгсийн өндөр, өргөн, налуу, холболт) цэвэр сайхан, алдаагүй бичих 3.Б2. Гэр бүл, найз нөхөд, хүрээлэн буй орчны танилцуулгыг асуулт, загварын дагуу тоочин бичих 3.Х1. Н, г, х, ц, ч, с, ш, зөөлөрсөн гийгүүлэгч авиа орсон үгсийг утга, дуудлага, бичлэгээр ялгах 3.Х2. Эр, эм, саармаг эгшиг болон эр, эм үгийг ялган таних, “-ы, -ий”-г хэрэглэх	Сурагч харилцан яриа, товч танилцуулга, шүлэг, богино эхийг анхааралтай, идэвхтэй <b>сонсож</b> , ойлгосноо илэрхийлж чаддаг болно.  Өөрийгөө танилцуулж, гэр бүл, найз нөхдөө төлөөлөн харилцан <b>ярилцаж</b> , бүтэн өгүүлбэрээр тоочин танилцуулж сурна.  Сурагч харилцан яриа, танилцуулгын утгыг ойлгож, <b>унших</b> даа ойролцоо үгийн утгыг ялгаж, асуултын дагуу тайлбарлаж чаддаг болно.  Сурагч өөрийн болон гэр бүл, найз нөхдийн танилцуулга, хүсэл сонирхлыг асуулт, загварын дагуу танилцуулж, тоочиж, цээжээр дэгийн дагуу, дүрмийн алдаагүй, зөв <b>бичиж</b> чаддаг болно.

## Агуулгын залгамж холбоо

Чадвар	Би нэгжийн хүрээнд		
	Өмнө судалсан нэгжийн хүрээнд (2-р анги)	Одоо судлах нэгжийн хүрээнд (3-р анги)	Дараа судлах нэгжийн хүрээнд (4-р анги)
	Би Миний бие эрхтэн	Миний товч танилцуулга Миний хүсэл сонирхол	Миний мөрөөдөл Миний бахархал
Сонсох	- Асуулт, зааврыг анхааралтай сонсож, үг хэллэгийн авианы дуудлагыг ялгах	- Анхааралтай, идэвхтэй сонсож ойлгосноо нүүрний хувирал, үйл хөдлөлөөр илэрхийлэх	- Харилцан ярилцахдаа (илтгэл, хэлэлцүүлгийн үед) дуустал хүлээцтэй сонсож санаа бодлоо илэрхийлэх
Ярих	- Санаа бодлоо ойлгомжтой, тод дуугаар илэрхийлэх - Товч, тоочин танилцуулах - Зураг ашиглан тайлбарлах, тодруулах, асуух - Дуурайн дүрд тоглох	- Санаа бодлоо өөртөө итгэлтэй, чөлөөтэй илэрхийлэх - Бүтэн өгүүлбэрээр тоочин танилцуулах - Амьсгалаа зөв хуваарилж, түгдрэлгүй хэлэх - Харилцан яриагаар дүрд тоглох - Түлхүүр үгсийг ашиглаж ярих	- Шинэ санаа нэмж харилцах - Сонирхолтой байдлаар тоочих - Ярианы хурд, дууны өнгийг тохируулах - Дуу хоолой, биеийн хөдөлгөөн, харцыг дуурайн дуу оруулах, дүрд тоглох
Унших	- Үе, үг, өгүүлбэрийг зөв дуудан, хурдан унших - Бусдын өмнө чанга, тод дуугаар уран унших	- Зөв, хурдан, ойлгож унших - Шүлэглэсэн эхийг дууны өнгө, хурд, хэмнэлийг тохируулан унших - Дүрээр олж унших	- Харилцан ярианы үг хэллэгийг зөв унших - Өргөлт, зогсолт, аялгыг тохируулан унших
Бичих	- Дэгийн дагуу цэвэр сайхан, алдаагүй бичих - Тоочин бичих - Цуврал болон сэдэвт зургийн дагуу хүүрнэн бичих	- Цээжээр бичихдээ дэгийн дагуу, цэвэр сайхан алдаагүй бичих - Түлхүүр үг ашиглан загварын дагуу тоочин бичих	- Асуулт, загварын дагуу асуултад хариулан тоочин бичих - Дарааллын дагуу хүүрнэн бичих



### Шинэ үг хэллэг

- *Өглөө:* Өглөөний мэнд. Сайхан амарсан уу?
- *Өдөр:* Өдрийн мэнд. Сайн байна уу? Өдрийн мэнд багш аа.
- *Орой:* Оройн мэнд. Үдшийн мэнд. Тавтай нойрсоорой. Сайхан амраарай.
- *Нэрлэсэн үг:* тэмдэглэлийн дэвтэр, цана, чарга, тэшүүр, баг, хүсэл, мөрөөдөл, сонирхол, ирээдүй
- *Шинж төрхийг нэрлэсэн үг:* амин, үнэтэй, эрх, сайн
- *Тоо хэмжээг нэрлэсэн үг:* мянга, арван мянга, зуун мянга, сая
- *Үйл хөдлөлийг нэрлэсэн үг:* гулгах, хөөх, түүх, зугаалах, аялах, дуулах, шатар тоглох, бай онох, хээр хонох, санах, сонирхох

### Өгүүлбэрийн загвар

- Асуултын дагуу тоочин бичих даалгаврууд нь бүтэн өгүүлбэрээр, үйл явдлын дарааллыг алдагдуулахгүйгээр бичиж сурахад дөхөмтэй.

*Гарын авлагын хуудас 12. "Миний товч танилцуулга"-ыг уншаад асуултад тодорхой хариулна.*

#### ✓ 2. Асуултад хариулаарай

1. Туяа хэдэн настай вэ?
2. Туяагийн гэр хаана байдаг вэ?
3. Туяа хэддүгээр ангид сурдаг вэ?
4. Тэр юунд дуртай вэ?

1. Туяа найман настай.
2. Туяагийн гэр Баян-Өлгий аймгийн Өлгий сумын 8 дугаар багт байдаг.
3. Туяа гуравдугаар ангид сурдаг.
4. Тэр ном унших, зураг зурах дуртай.

- Өгсөн загвар, түлхүүр үг ашиглан тоочин бичих нь бие даан өгүүлбэр, танилцуулга, дуурайн бичих чадварыг хөгжүүлэхэд тусалдаг.

Би . . . . . сумын . . . . .  
сургуулийн . . . . . ангид сурдаг.  
Би чөлөөт цагаараа . . . . .  
дугуйланд явдаг.

Би Цэнгэл сумын хоёрдугаар сургуулийн  
гуравдугаар ангид сурдаг. Би чөлөөт  
цагаараа зургийн дугуйланд явдаг:

- Сурагчид түлхүүр үг ашиглан, загварын дагуу танилцуулга, дэлгэрэнгүй өгүүлбэр, хүүрнэсэн эх зэргийг бичиж сурахад нь туслахын тулд дараах өгсөн өгүүлбэрийн загварууд дээр ажиллуулах боломжтой. Багшаас өгч буй "тоочин бичээрэй, бүлэглэн бичээрэй, өгүүлбэр зохиож бичээрэй, асуултад хариулаарай, асуулт зохиож бичээрэй" гэсэн зааварчилгаа нь даалгавруудыг гүйцэтгэхэд дэмжлэг болдог.

*Түлхүүр үг, загвар ашиглан өөрийгөө бусдыг төлөөлөн танилцуулна.*

2. Түлхүүр үгийг ашиглан өөрийн танилцуулгыг бүтээгээрэй.

**Миний танилцуулга**

чөлөөт цаг 5

сурдаг 4

амьдардаг 3

нас, хүйс 2

овог, нэр 1

- *Овог:* Мурат, *нэр:* Айнагүл
- *Нас:* 8, *хүйс:* эмэгтэй
- *Амьдардаг газар:* Баян-Өлгий аймгийн Өлгий сум 1 дүгээр баг
- *Сургууль:* Ерөнхий боловсролын 5 дугаар сургууль
- *Чөлөөт цаг:* Зургийн дугуйлан









## Цагийн төлөвлөлт (Ээлжит хичээлийн задаргаа)

№	Ээлжит хичээлийн сэдэв	Цаг	Эхийн төрөл	Хэрэглэгдэхүүн	Шинэ үг
1.	Мэндэлье- танилцъя	40 мин	Харилцан яриа	ГА 10-11, ДАД 9-10 нүүр - Өгүүлбэр зохиох загвар - Сайхан амарсан уу?, миний найз - Тавтай нойрсоорой, аав аа. - Чамайг хэн гэдэг вэ? - Чамд монгол хэлний ном байна уу?	Өглөө: Өглөөний мэнд. Сайхан амарсан уу. Өдөр: Өдрийн мэнд. Сайн байна уу. Өдрийн мэнд багш аа. Орой: Оройн мэнд. Үдшийн мэнд. Тавтай нойрсоорой. Сайхан амраарай.
2.	Миний товч танилцуулга (Туяагийн товч танилцуулга)	40 мин	Танилцуулга эх (тоочимж эх)	ГА 12-нүүр, ДАД 11-нүүр - Өгүүлбэр зохиох загвар Миний найзуудыг Эрхэс, Баттулга гэдэг. Эрхэс дуу дуулдаг, ирээдүйд алдартай дуучин болохыг хүсдэг. Харин Баттулга .....	Нэрлэсэн үг: хүсэл, мөрөөдөл, сонирхол, ирээдүй
3.	Өөрийгөө танилцуулж сурцгаая.	40 мин	Харилцан яриа	ГА 15-нүүр, ДАД 12-нүүр - Өгүүлбэр зохиох загвар Би.....сумын.....сургуулийн .....ангид сурдаг. Би чөлөөт цагаараа ..... дугуйланд явдаг.	Үйл хөдлөлийн нэрлэсэн үг: дуулах, тоглох, унших, зурах, наах, будах, хураах, харайх, үсрэх, бүжиглэх
4.	Товч танилцуулга бөглөх загвар	40 мин	Хэрэглээний эх	ГА 15-нүүр, ДАД 13-нүүр Зөв уншаарай. мянга, арван мянга, зуун мянга Эх - Өгүүлбэр зохиох загвар, жишээ Өөрийгөө болон бусдыг түлхүүр үг ашиглан танилцуулах - нэр..... - нас..... - амьдардаг ..... - сурдаг ..... - чөлөөт цаг.....	Нэрлэсэн үг: нас, аймаг, сум, сургууль, анги Тоо хэмжээг нэрлэсэн үг: гуравдугаар, мянга, арван мянга, зуун мянга, сая
5.	Амин хүү дээ би	40 мин	Шүлэглэсэн эх	ГА 16 нүүр, ДАД 14-нүүр - Өгүүлбэр зохиох загвар, жишээ - Цэгийн оронд шүлгээс тохирох үгийг олж өгүүлбэрийг нөхөж бичих, тоочин бичих Аав, ээжийн .....	Шинж төрхийг нэрлэсэн үг: амин, үнэтэй, эрх, сайн
6.	Найзуудын мөрөөдөл	80 мин	Танилцуулга эх	ГА 17-18 нүүр, ДАД 15-16 нүүр - Асуултын дагуу өгүүлбэр бүтээх Хэн?, юу?, яахыг?, яадаг? Миний найз ном уншиж, тэмдэглэл хөтөлдөг. - Сонирхдог, хүсдэг, мөрөөддөг үгсийг ашиглан 4-8 үгтэй өгүүлбэр зохиох. Үгсийг зөв хэрэглэх	Үйл хөдлөлийг нэрлэсэн үг: дуулах, шатар тоглох, бай онох, хээр хонох, санах уншдаг, бичдэг, хөтөлдөг, зурдаг, мөрөөддөг, хүсдэг, сонирхдог эмч, багш, барилгачин, цагдаа, тариачин, хоньчин, онгоцны нисгэгч, дуучин
7.	Дөрвөн хүсэл	80 мин	Хүүрнэсэн эх	ГА 21-22 нүүр, ДАД 17-18 нүүр - Эхийн үйл явдлын зургийг дараалалд оруулан ярих, дүрд тоглох, тоочин бичих	Нэрлэсэн ба үйл хөдлөлийг нэрлэсэн үгсийг ашиглана. Жишээ нь, тэмдэглэлийн дэвтэр, цана, чарга, тэшүүр, баг, хүсэл, мөрөөдөл, сонирхол, ирээдүй, гулгах, хөөх, түүх, зугаалах, аялах, сонирхох
8.	Нэгжийн үнэлгээ	40 мин	"Би" нэгжийн үнэлгээний даалгавар	- Зөв, хурдан унших чадварыг илрүүлэх даалгавар - Сонсох-ярих чадварыг үнэлэх даалгавар - Уншаад ойлгосныг үнэлэх даалгавар - Бичих даалгаврыг үнэлэх даалгавар	• "Миний найзын танилцуулга" хэрэглээний эх

## Нэгж хичээлийн заах арга

Сурагчдын чадвар өөр өөр учраас багш хэнд, ямар дэмжлэг хэрэгтэй байгааг судлах хэрэгтэй. Тухайн сурагч анги хамт олондоо эх бичвэрийг уншиж өгөхөөр бэлтгэж байхад нь эцэг, эхчүүд гэртээ унших дасгал хийхэд нь анхааралтай сонсогч байж, хамтран ажиллаж, туслах нь илүү үр дүнтэй.

“Би” сэдвийн хүрээнд сонгосон эхүүд нь хүнийг нэрлэсэн, хүний хүсэл мөрөөдлийг илэрхийлсэн агуулгад суурилсан бөгөөд уншуулахдаа өөртөө унших, бусдад унших, давтан унших, хамтарч унших, төлөөлөн унших, хосоор унших, харилцан ярих, дүрд тоглох зэрэг идэвхтэй сургалтын аргыг хэрэглэнэ.

Уншлагад сургах арга	Тайлбар	Жишээ									
Өөртөө унших	Бусад хүний сонсоход зориулж биш, зөвхөн өөртөө зориулж унших хэлбэрийг хэлнэ. Нэг, хоёрдугаар ангид сурагчид ихэвчлэн амандаа үглэн “чанга” уншдаг нь ойлгохын тулд зөвхөн “өөртөө” зориулан уншиж байгаа хэрэг гэдгийг багш нар ойлгох хэрэгтэй. Энэ нь бага насны хүүхдийн өөрийн уншсаныг сонсож байж ойлгодог онцлогтой нь холбоотой. Харин дараагийн шатанд буюу гурав, дөрөвдүгээр ангиас эхлэн сурагчид “харааны уншлага”-д суралцаж эхэлдэг	Самбарт унших зурагт болон үгэн карт, өгүүлбэр, эхийг байрлуулж хугацаа зааж (20 сек-1 мин) ажиглуулна. Уруулаар үг давахгүй. <b>Би хүсэл мө-рөөд-лөө тэм-дэг-лэ-лийн дэв-тэр-тээ бичдэг.</b> <table border="1"> <tr> <td></td> <td>а</td> <td>н</td> </tr> <tr> <td></td> <td>а</td> <td>н</td> </tr> <tr> <td><b>1</b></td> <td>э</td> <td>н</td> </tr> </table>		а	н		а	н	<b>1</b>	э	н
	а	н									
	а	н									
<b>1</b>	э	н									
Бусдад унших	Бусдын сонсож ойлгоход зориулан чанга дуугаар уншихыг бусдад унших гэнэ. Бусдад унших уншлагыг өөртөө унших “чанга” уншлагатай андуурч болохгүй. Зорилгын хувьд ялгаатай. Энэ уншлага нь нэг талаас уншихдаа сонсож байгаа хүний анхаарлыг татаж, сэтгэлд нь хүртэл унших чадварыг харуулдаг бол нөгөө талаас сонсож байгаа хүн нь хүний уншсаныг ойлгох чадварыг шаарддаг. Бусдад унших нь уран уншлагад сургах эхний алхам болно. Уншиж сурах цагаан толгойн үеэс сурагчид үг, өгүүлбэрийг алдаа мадаггүй, тод хэлж уншихад суралцах бол анги ахих тусам үг, өгүүлбэрийн утгын өргөлт гаргах, их, бага зогсолт хийх, уншлагын хурд, өнгө аялгыг тохируулан уран унших чадварт суралцдаг. Зөв, ухамсартай уншлага нь уран уншлагын бэлтгэл болдог.	Бие даан уншуулахдаа хэн, хэнээр уншуулахаа төлөвлөнө. Сайн уншдаг сурагчаар тод чанга дуугаар уншуулах; Сайн уншдаг, тааруу уншдаг сурагчийг хослуулж уншуулах; Тааруу уншдаг сурагчийг өмнө нь тухайн уншуулах хэсгийг ангид уншуулахаар бэлдүүлсэн байна. Учир нь тухайн сурагчийг бусдын өмнө энэ хүүхэд уншиж чаддаггүй гэсэн хандлагаас хамгаалж, хүүхэд өөртөө итгэлтэй сурахад дэмжлэг болно. “Дөрвөн хүсэл” хүүрнэсэн эх Гэрэл уу-ланд чар-гаар, гол дээр тэ-шүү-рээр гул-гаж гэр-тээ ирэв. -Тэгээд аавдаа: “Өвөл яасан сайхан юм бэ? Би үр-гэлж өвөл бай-гаа-сай гэж бо-дох юм” гэв. -Аав нь: “Чи тэг-вэл өө-рийн хүслээ миний дэв-тэрт би-чээ-рэй” гэ-хэд Гэрэл бичжээ.									
Давтан уншлага	Энэ уншлагын гол зорилго бол сурагчдын унших дадал, чадварыг хөгжүүлэхэд чиглэнэ. Давтан уншлагад олон сурагчийг хамруулах шаардлагатай тул эх зохиолыг хэсэглэн хэд хэдэн сурагчаар уншуулах хэрэгтэй. Сурагчид өмнө уншсаныг давтан уншиж байгаа тул өмнө гаргасан алдааг дутагдлыг нь гаргуулахгүй байхад багш анхаарна. Давтан унших явцад сурагчийн гаргасан алдаа, оноог бусад сурагчаар ажиглуулж, тухай бүр хэлэлцүүлж байх нь өөрийн алдаанаас суралцах боломжийг сурагчдад олгодог сайн талтай.	“Дөрвөн хүсэл” хүүрнэсэн эх Зурагт тохирох хэсгийг уншуулахдаа 4 цогцолбор бүрээр 3,3 сурагчаар давтан уншуулж болно. Цогцолбор бүрээр уншихад сурагчид охины хүслээ хэлж байгаа, аавын охиндоо хэлж байгаа үг хоёрын ижил давтагдаж байгаа санааг ухаарч уншихад чиглэнэ.									



Хамтын уншлага	Бага ангийн сурагчид унших дадал сайн эзэмшиж сураагүй байдаг тул энэ аргыг үе үе хичээлд ашиглах нь үр дүнтэй. Энэ нь ангийн бүх сурагч хамтарч дуу нийлүүлэн зэрэг уншихыг хэлнэ. Энэ уншлага нь зохиолыг хамт олноороо цээжлэх, улмаар уран унших бэлтгэл болохын зэрэгцээ хийх, хэлэхэд төвөгтэй хүндэвтэр үгийг зөв дуудаж сурахад ач холбогдолтой.	<p>“Амин хүү дээ би” шүлэг</p> <p>Энэ шүлгийг хамтаараа уншихад өнгөөр ялгасан мөрүүдийг өмнөх мөртэй үргэлжлүүлэн унших гээд байдаг. Тиймээс шүлгийг сонсохдоо хаана зааг гаргаж буюу өргөлт гаргаж уншиж байгааг багш ялгуулна.</p> <p>Аав ээжийн  <b>Амин хүү дээ би</b>          Алт мөнгөнөөс  <b>Үнэтэй хүү дээ би</b>          Сонссон шүлгийн хэсэг, багш өөрөө Аав ээжийн амин хүүдээ би          Алт мөнгөнөөс үнэтэй хүүдээ би          гээд үргэлжлүүлэн уншиж өгч сонсоно.</p>
Төлөөлөн уншлага	<p>Төлөөлөн унших буюу дүрээр унших уншлага нь сурагчид зохиогчийн болон баатруудын өгүүлэмжийг дүрээр төлөөлөн унших явцдаа оногдсон хэсгээ зөв олж уншихын тулд өөрсдийн ээлжийг болтол бусдын уншиж байгаа хэсгийг алдалгүй, харааны уншлагаар уншдаг.</p> <p>Энэ нь хүүхдийн анхаарлыг, үзэж байгаа сэдэв дээр төвлөрүүлэх чухал арга юм. Уншлагын явцад зохиолын агуулга, үйл явдал дүрслэгдэж буй хүмүүсийн хоорондын харьцаанаас хүүхэд бүр төлөөлж байгаа дүрүүдийнхээ зан чанар, төрх байдал, хүсэл зорилгыг танин мэдэж түүнийг илэрхийлэх чадвараас суралцдаг.</p>	<p>“Дөрвөн хүсэл” хүүрнэсэн эх</p> <p>Өгүүлэгч, охин, аавын хэлсэн үгээр сурагчдыг 3,3-аар нь давтан уншуулж болно.</p> <p><b>Өгүүлэгч- хөх</b> өнгөөр  <b>Охин- улаан</b> өнгөөр  <b>Аав-ногоон</b> өнгөөр бичсэн хэсгийг уншина.</p> <p><b>Өвлийн улирал болж байв. Гэрэл ууланд чаргаар, гол дээр тэшүүрээр гулгана. Тэгээд аавдаа: “Өвөл яасан сайхан юм бэ? Би үргэлж өвөл байгаасай гэж бодох юм” гэв. Аав нь “Чи тэгвэл өөрийн хүслээ миний дэвтэрт бичээрэй” гэхэд Гэрэл бичжээ.</b></p>

Харилцан ярианд өргөн хэрэглэж буй “чиний, миний, чамайг, намайг” гэсэн үгс нь өмнөх ангид түлхүү ашиглаж байсан “би, чи, та” гэсэн үгийн хувилал болоход сурагчдын анхаарлыг хандуулаарай. Мөн энэхүү нэгжээр сурагчдын бүтэн өгүүлбэрээр харилцан ярилцах чадварыг хөгжүүлэхэд анхаарч арга зүйгээ төлөвлөх хэрэгтэй. Тухайлбал, өмнөх хэсэгт танилцуулсан “Хэн хурдан бэ?” тоглоомын аргыг ашиглан “би, чи, та” гэдэг үгсийг хэн хурдан хувиргаж, харилцан яриа зохиох вэ? гэдэг тоглоом тоглуулж болно. Мөн “хувиргасан үгсийг хэн хурдан олох вэ? Хэн хурдан олох вэ? гэж болох юм.

Сурагчдын гаргаж болзошгүй алдаануудыг багш төлөвлөлт хийхдээ тодруулан тэмдэглэх, засаж залруулах арга аргачлалыг тодорхой бичих нь чухал. Үүнд:

- н, г орсон үгсийг зөв дуудах;
- ангилах, ялгах, бүлэглэн бичих;
- загвар, схем, зураглал, зааврын дагуу бие даан хийж гүйцэтгэх;
- цэг, таслал, ?, !-ын тэмдгийг зөв нэрлэх, өгүүлбэрт зөв хэрэглэх;

### Орчин

#### Материаллаг орчин

- Гарын авлага, дасгал ажлын дэвтэр, дидактик хэрэглэгдэхүүн бэлтгэнэ.
- Сонсох хөгжим, компьютер, телевизор, өсгөгч, уртасгагч зэрэг техник хэрэгслийг тогтмол ашиглахаар аюулгүй байдлыг хангасан орчин бүрдүүлсэн байна.

Сонсох	Ярих	Унших	Бичих
Би сэдвийн хүрээнд сонсох эхүүд байна.	Ярилцахад тохиромжтой байдлаар хосоор, багаар суух, зогсох, ширээгүй орчин бүрдүүлнэ.	Зурагт болон үгэн карт, харааны уншлагын карт, өнгөөр ялган бичсэн өгүүлбэр, богино эх бэлтгэсэн байна.	Тодруулан бичих, нөхөж бичих, ялган бичих, бүлэглэн бичих, дуурайн бичих загвар карт, эхүүд бэлтгэсэн байна.
<ol style="list-style-type: none"> <li>1. Харилцан яриа</li> <li>2. Харилцан яриа</li> <li>3. Туяагийн товч танилцуулга</li> <li>4. Харилцан яриа</li> <li>5. Амин хүү дээ би шүлэг</li> <li>6. Найзуудын мөрөөдөл эх</li> <li>7. Дөрвөн хүсэл эх</li> </ol>		 	<p>Хүүхдүүд ойгоос юу түүсэн бэ?</p> <p>Хүүхдүүд ойгоос ..... , ..... , ..... түүлээ.</p> <p> <input type="checkbox"/> нэрс   <input type="checkbox"/> хад   <input type="checkbox"/> мөөг   <input type="checkbox"/> тошлой   <input type="checkbox"/> мойл  <input type="checkbox"/> алим   <input type="checkbox"/> сакал   <input type="checkbox"/> аяс   <input type="checkbox"/> лир   <input type="checkbox"/> хурж         </p>



### Харилцааны орчин

- Тухайн төлөвлөсөн нэгжийн хүрээнд 10 цагийн турш монгол хэлээр харилцана.
- Сурагчдын мэддэг танил үгсийг ашиглан, үгийн нөөцийг нэмэгдүүлэх замаар багштай болон хоорондоо харилцахыг дэмжээрэй. Жишээ нь, сурагчид өдөр бүр “Өглөөний мэнд”, “Сайхан амарсан уу” зэрэг шинэ үг хэллэгээр мэндлэх орчин бүрдүүлээрэй.
- Мөн сурагчид ангидаа ирээд “тэврэх, гараа цохих, тонгойх, зүрхэн хэлбэр” зэрэг биеэр харилцах хөдөлгөөн хийх нь илүү дотно харилцахад нөлөөлдөг.

### Нэгж хичээлийн үнэлгээг

- Явцын үнэлгээ - 9 ээлжит хичээл бүрийн зорилтоос шалтгаалан биеэр үзүүлж байгаа үйлдэл, хариултыг ажиглалтын хуудсаар тэмдэглэл хөтөлж болно.
- Багш хичээлийг удирдах явцдаа сурагчид өөрийгөө танилцуулах, харилцан мэндчилж байгаа эсэх, мэндчилгээний үгсийг ашигласан эсэх, мөн асуулт тавих чадвар нь ахиж хөгжиж буй байдлыг ажиглалтын болон тэмдэглэлийн хуудсаар хөтөлж, дэмжлэг шаардлагатай сурагчдад туслах хэрэгтэй.
- Мөн бусдын ярьсныг хүндэтгэн сонсож, харилцаж байгаа байдал, идэвхтэй сонсох чадвараа хөгжүүлсэн эсэх, бүтэн өгүүлбэрээр хариулсан байдал, өөрийн болон бусдын танилцуулгыг харьцуулж санаа авах, өөрийн танилцуулгаа сайжруулж буй байдал зэрэг нь үнэлгээний үзүүлэлт болох боломжтой.

Хүснэгт. Ээлжит хичээлийн үеийн ажиглалт, тэмдэглэлийн хуудасны загвар

Сурагчдын нэр	Мэндчилгээний үг хэллэгийг ашиглан мэндэлсэн эсэх			Асуулт тавьсан байдал			Бүтэн өгүүлбэрээр танилцуулж буй эсэх			Багшийн зөвлөмж
	....	....	...	...	....	....	....	....	....	
Тэмдэглэсэн сар өдөр										
М.Болат										
Х.Айнагүл										

Сануулга. Нэг хичээл дээр бүх сурагчийг ажиглаж, тэмдэглэж амжихгүй тул хэдэн хүүхэд ажиглахаа төлөвлөх хэрэгтэй.

### Үнэлгээний шалгуур

Сурагч монгол хэлээр зөв ярьж, бие биеэ хүндэтгэлтэй сонсох, бүтээлчээр уншиж, бичих чадвар эзэмшиж, монгол хэлээр сонирхон судлах хүсэл эрмэлзлэлтэй болно.

Мэдлэг			
"Би" хам сэдвийн хүрээнд үгийн сан, хэлний хэрэглээ: Үг, өгүүлбэр, эхийн утга, бүтэц, зүй тогтол, хэрэглээ			
Чадвар			
Сонсох чадвар	Унших чадвар	Ярих чадвар	Бичих чадвар
- Анхааралтай, идэвхтэй сонсож, ойлгох - Сонсож ойлгосноо харуулах (нүүрний хувирал болон үйл хөдлөлөөр, зураг, дүрс, өнгөөр илэрхийлэх)	Зөв, хурдан, ойлгож унших - Шүлэглэсэн эхийг дууны өнгө, хурд, хэмнэлийг тохируулан унших - Эхийг ойлгож уншиж, асуултын дагуу тайлбарлах	- Санаа бодлоо өөртөө итгэлтэй, чөлөөтэй илэрхийлэх - Ярихдаа бүтэн өгүүлбэрээр тоочин танилцуулах - Дүрд тоглох	- Эхийг цээжээр бичихдээ дэгийн дагуу, алдаагүй, цэвэр сайхан бичих - Загварын дагуу тоочин бичих - Түлхүүр үг, асуултын дагуу хүүрнэн бичих - Бүтцийн дагуу бичих
Хандлага			
1. Бусдын ярьсныг хүндэтгэн сонсож байгаа эсэх 2. Бусдын өмнө тодорхой ярихыг чармайж байгаа эсэх 3. Идэвхтэй байж, бусдыг ойлгон, хүндэтгэлтэй харилцах 4. Ном унших сонирхолтой болж, уншсанаа танилцуулах 5. Хэл сурах хүсэл сонирхолтой эсэх			

Эх сурвалж: Сургалтын жишиг хөтөлбөрөөс



## Нэгж хичээлийн суралцахуйн үр дүн, үр дүнгийн шалгуур

Нэгжийн үр дүнгийн шалгуураар сурагч тухайн агуулгын хүрээнд үр дүнд хүрсэн эсэхийг илрүүлэх бөгөөд сурагчийн амжилт, гүйцэтгэлийн талаар дүгнэлт хийх боломж гэж ойлгож болно.

СЗ	Нэгж хичээлийн суралцахуйн үр дүн	Үр дүнгийн шалгуур
3.С1. 3.С2.	Сурагч харилцан яриа, товч танилцуулга, шүлэг, богино эхийг анхааралтай, идэвхтэй <b>сонсож</b> , ойлгосноо илэрхийлж чаддаг болно.	Харилцан яриа, товч танилцуулга, шүлэг, богино эхийг анхааралтай, идэвхтэй <b>сонсож</b> , ойлгосныг нүүрний хувирал, үйл хөдлөлөөр илэрхийлдэг.
3.Я1. 3.Я2.	Би, гэр бүл, найз нөхдөө төлөөлөн харилцан <b>ярилцаж</b> , бүтэн өгүүлбэрээр тоочин танилцуулж сурна.	Өөрийгөө танилцуулж, гэр бүл, найз нөхдөө төлөөлөн зургийн үйл явдлын дагуу бүтэн өгүүлбэрээр тоочин танилцуулдаг.
3.У1. 3.У2.	Сурагч харилцан яриа, танилцуулгын агуулгыг зөв, хурдан ойлгож <b>уншсаныг</b> асуултын дагуу тайлбарлана.	Харилцан яриа, танилцуулгыг зөв, хурдан ойлгож уншдаг. Уншсан харилцан яриа, танилцуулгын агуулгыг бүрэн ойлгосноо асуултын дагуу тайлбарлаж чаддаг.
3.Б1. 3.Б2. 3.Х1. 3.Х2.	- Сурагч өөрийн болон гэр бүл, найз нөхдийн танилцуулга, хүсэл сонирхлыг асуулт, загварын дагуу танилцуулж, тоочиж, цээжээр дэгийн дагуу, дүрмийн алдаагүй, зөв бичиж чаддаг болно.	Үг, өгүүлбэр, эхийг цээжээр бичихдээ дэгийн дагуу зөв холбон, дүрмийн алдаагүй бичдэг. (н, г, х, ц, ч, с, ш, зөөлөрсөн гийгүүлэгч авиа орсон үгсийг утга, дуудлага, бичлэгээр ялгах, эр, эм, саармаг эгшиг болон эр, эм үгийг ялган таних, «-ы, -ий»-г хэрэглэх) Танилцуулгыг асуулт, загварын дагуу танил бус үгээс бүтсэн 4-өөс дээш өгүүлбэрийг хуулж, танил үгээс бүтсэн 3-аас дээш өгүүлбэрийг цээжээр тоочин бичдэг.

## Шалгуур бүрийн гүйцэтгэлийн түвшин

Сурагч нэгжийн суралцахуйн үр дүнгийн шалгуурыг ямар түвшинд эзэшсэнээр мэдлэг, чадвар, төлөвшил хандлага эзэмшилт тодорхойлогдоно.

	Үр дүнгийн шалгуур	I түвшин	II түвшин	III түвшин	IV түвшин
Сонсох	Харилцан яриа, товч танилцуулга, шүлэг, богино эхийг анхааралтай, идэвхтэй сонсоно.	Сонсож байгаа харилцан яриа, танилцуулга, шүлэг, богино эхийн үйл явдлыг зураг харж ерөнхийд нь нэрлэдэг.	Сонсож байгаа харилцан яриа, танилцуулга, шүлэг, богино эхийн үйл явдлыг ойлгосноо асуултаар чиглүүлэн тоочиж нэрлэдэг.	Сонсож байгаа харилцан яриа, танилцуулга, шүлэг, богино эхийн зарим үйл явдлыг орхигдуулан ойлгомжтой ярьдаг, бичиж тэмдэглэдэг.	Сонсож байгаа харилцан яриа, танилцуулга, шүлэг, богино эхийн утгыг ойлгосныг үйл явдлыг орхигдуулахгүй ярьдаг, бичиж тэмдэглэдэг.

Харилцан яриа, танилцуулга, шүлэг, богино эхийг сонсох хугацааг дуустал сурагчийн нүүрний хувирал, үйл хөдлөлөөр хэрхэн анхааралтай, идэвхтэй сонсож байгааг ажиглана.

	Үр дүнгийн шалгуур	I түвшин	II түвшин	III түвшин	IV түвшин
Ярих	Би, гэр бүл, найз нөхдөө төлөөлөн зургийн дарааллын дагуу бүтэн өгүүлбэрээр тоочин танилцуулна.	Бусдыг төлөөлөн зургийн дарааллаар ерөнхийд нь нэрлэдэг.	Бусдыг төлөөлөн зургийндарааллаар эхлээд?, дараа нь?, эцэст нь? гэсэн асуултын чиглүүлгээр тоочиж ярьдаг.	Бусдыг төлөөлөн зургийн дарааллыг сольж, ойлгомжтой ярьдаг.	Бусдыг төлөөлөн зургийн дарааллаар бүтэн өгүүлбэрээр тоочин ярьдаг.



	Үр дүнгийн шалгуур	I түвшин	II түвшин	III түвшин	IV түвшин
Унших	Харилцан яриа, танилцуулгыг зөв, хурдан ойлгож уншдаг.	Ойролцоо үгийг ялгахгүй, 50-60 үгийг уншдаг.	Ойролцоо үгийг ялган, 50-70 үгийг уншдаг.	Ойролцоо үгийг ялган, 50-80 үгийг уншдаг.	Ойролцоо үгийг ялган, 50-90 үгийг уншдаг.
	Уншсан харилцан яриа, танилцуулгын агуулгыг бүрэн ойлгосноо асуултын дагуу тайлбарлаж чаддаг.	Харилцан яриа, танилцуулгыг үйл явдлын дарааллыг алдагдуулж тоочдог.	Харилцан яриа, танилцуулгыг хэн? юу? яав? зэрэг асуултын дагуу дараалан тоочдог.	Харилцан яриа, танилцуулгыг бүтцийн хүрээнд тайлбарладаг.	Харилцан яриа, танилцуулгын агуулгыг бүтцийн хүрээнд асуултын дагуу тайлбарладаг

	Үр дүнгийн шалгуур	I түвшин	II түвшин	III түвшин	IV түвшин
Бичих	Үг, өгүүлбэр, эхийг цээжээр бичихдээ дэгийн дагуу зөв холбон, дүрмийн алдаагүй бичдэг. (н, г, х, ц, ч, с, ш, зөөлөрсөн гийгүүлэгч авиа орсон үгсийг утга, дуудлага, бичлэгээр ялгах, эр, эм, саармаг эгшиг болон эр, эм үгийг ялган таних, “-ы, -ий”-г хэрэглэх)	Цээжээр бичихдээ зөв үг нь 65%-аас дээш, үсэг бүрийг дэгийн дагуу бичээгүй.	Цээжээр бичихдээ зөв үг нь 75%-аас дээш, дэгийн дагуу бичээгүй, үсгийн өндөр нам жигд, үсгийн холболт буруу, таталж, сунгаж бичдэг.	Цээжээр бичихдээ зөв үг нь 90%-аас дээш, үсгийн өндөр нам жигд, зарим нэг үсгийн холболт буруу, таталж сунгаж бичдэг.	Цээжээр бичихдээ эр, эм үг, зөөлөрсөн гийгүүлэгчийн дүрмийн алдаагүй, дэгийн дагуу зөв холбон бичдэг.
	Танилцуулгыг асуулт, загварын дагуу танил бус үгээс бүтсэн 8-аас дээш өгүүлбэрийг хуулж, танил үгээс бүтсэн 6-аас дээш өгүүлбэрийг цээжээр тоочин бичдэг.	Танилцуулгыг асуулт, загварын дагуу танил бус үгээс бүтсэн 4-өөс дээш өгүүлбэрийг хуулж, танил үгээс бүтсэн 3-өөс дээш өгүүлбэрийг цээжээр зарим хэсгийн утгыг орхигдуулан тоочин бичдэг.	Танилцуулгыг асуулт, загварын дагуу танил бус үгээс бүтсэн 5-аас дээш өгүүлбэрийг хуулж, танил үгээс бүтсэн 4-өөс дээш өгүүлбэрийг цээжээр зарим хэсгийн утгыг орхигдуулан тоочин бичдэг.	Танилцуулгыг асуулт, загварын дагуу танил бус үгээс бүтсэн 6-аас дээш өгүүлбэрийг хуулж, танил үгээс бүтсэн 5-аас дээш өгүүлбэрийг цээжээр утгыг орхигдуулалгүй тоочин бичдэг.	Танилцуулгыг асуулт, загварын дагуу танил бус үгээс бүтсэн 8-аас дээш өгүүлбэрийг хуулж, танил үгээс бүтсэн 6-аас дээш өгүүлбэрийг цээжээр утгыг орхигдуулалгүй бүрэн тоочин бичдэг.

### ЭЭЛЖИТ ХИЧЭЭЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Энэ хэсэгт “Би” нэгж хичээлийн төлөвлөлтөөс зарим ээлжит хичээлийн жишиг төлөвлөлтийг танилцуулж байна.

Багш ээлжит хичээлийн төлөвлөлт хийхэд зорилго, зорилтоо зөв тодорхойлох нь чухал. Тухайн ээлжит хичээлээр сонсох, унших, бүтээлчээр ажиллах эхийн хэв маягийг илрүүлж, түүнтэй уялдсан суралцахуйн зорилтыг сонгоно. Жишээ нь:

- Харилцан яриа бол 3.С1, 3.У1, 3.Я1, 3.Б1
- Танилцуулга эх бол 3.С2, 3.У2, 3.Я2, 3.Б2
- Шүлэглэсэн эх бол 3.С3, 3.У3, 3.Я3, 3.Б3
- Хүүрнэсэн эх бол 3.С4, 3.У4, 3.Я4, 3.Б4
- Хэрэглээний эх бол 3.С5, 3.У5, 3.Я5, 3.Б5 суралцахуйн зорилтуудыг хэрэгжүүлнэ.



Суралцахуйн зорилтыг баримжаалан хичээлийн зорилго, зорилтыг тодорхойлно. Улмаар хичээлийн үйл ажиллагааг сонсох, унших, ярих, бичих, хэлзүй гэсэн үйл ажиллагааны дарааллаар төлөвлөхийг анхаарна уу. Суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэхийн тулд дасгал даалгаврыг багш өөрөө боловсруулж бас гарын авлага, ДАД-ийн дасгал, даалгаврыг гүйцэтгүүлэн эзэмшүүлнэ.

Сонсох даалгаврыг 2-3 удаа сонсож болно. Тухайн эхийг сонсоод, сонссоноо ойлгосныг илрүүлэх даалгавар заавал хийлгэнэ. Ээлжит хичээлийн цагийг хуваарилахдаа багш, сурагчийн үйл ажиллагааг 20/80 харьцааг баримтлах нь зүйтэй.

**Ээлжит хичээлийн сэдэв:** Харилцан ярилцъя

**Бүлэг сэдэв:** “Би” Хугацаа 40 минут

Ээлжит хичээлийн зорилго	Ээлжит хичээлийн зорилт	
Үг хэллэгийн дуудлагыг ялгаж, зөв дуудаж, уншиж, бичиж, зөв хэрэглэж сурна.	<ul style="list-style-type: none"> <li>Харилцан ярилцахдаа анхааралтай, идэвхтэй сонсож, ойлгосноо нүүрний хувирал, үйл хөдлөлөөрөө илэрхийлэх</li> <li>Харилцан яриаг зөв, хурдан, ойлгож унших</li> <li>Санаа бодлоо өөртөө итгэлтэй, чөлөөтэй илэрхийлэх</li> <li>Дэгийн дагуу, цэвэр сайхан алдаагүй бичих</li> </ul>	
<i>Хүрэх үр дүн: Харилцан яриагаар дамжуулан сурагчдын монгол хэлээр зөв мэндэлж, харилцана.</i>		
<i>Бүх сурагчид:</i> С: Харилцан яриаг сонсож, өглөө, өдөр, оройн мэндчилгээг зөв тогтооно. У: Бусдад уншиж, өгсөн түлхүүр үгээр төлөөлөн илэрхийлнэ. Б: Дүрмийн алдаагүй, цэг, тэмдэг, холболтыг зөв хийж бичнэ.	<i>Ихэнх сурагчид:</i> С: Харилцан яриаг сонсож, өглөө, өдөр, оройн мэндчилгээг тогтооно. У: Харилцан уншиж, өгсөн түлхүүр үгээр илэрхийлнэ. Б: Цэг, тэмдэг, холболтыг зөв хийж бичнэ.	<i>Зарим сурагчид:</i> С: Харилцан яриаг сонсож, аль нэг мэндчилгээг тогтооно. У: Харилцан уншина. Б: Цэг, тэмдэг, холболтыг зөв хийж бичнэ.
Үгийн сан	Хүнд үгс: амраарай, тавтай, нойрсоорой	
Хандлага	Бие биедээ хүндэтгэлтэй хандаж мэндчилнэ.	
Хичээл хоорондын холбоо	Иргэний ёс зүйн боловсрол, хүн орчин	
Өмнөх мэдлэг	2-р ангид үзсэн мэндчилгээний үг хэллэг	

### Хичээлийн явц, аргазүй

Үе шат	Суралцахуйн үйл ажиллагаа	Явцын үнэлгээ
Хичээлийн эхлэл 5 мин Үйл ажиллагаа 1	<p><b>Зохион байгуулалт хийнэ.</b> (2 мин) Сурагч бүр хоорондоо мэндлэх /Ангийн сурагчдаас дараах мэндийн үгээр хэдэн хүүхэд хоорондоо мэндэлж байгааг ажиглан тэмдэглэнэ. Өглөө, өдөр ордог ээлжээс шалтгаалан үгийн сонголтыг анхаарна./ - Өдрийн мэнд/Өглөөний мэнд. - Сайхан амарсан уу? Сайн уу? Сайн уу найз аа. Сайн уу манай ангийнхан гэх мэт багш өөрөө сурагчидтай мэндлэх/үгээр, үйлдлээр/</p> <p><b>Алхам 1.</b> (3 мин) Сэдэлжүүлэх Багш: Та нартай багш нь ..... үйл хөдлөлөөр мэндэлсэн нь хэрхэн таалагдсан талаар ярилцана.</p>	Сурагчид хоорондоо хэрхэн мэндэлж байгааг ажиглах (өөр өөр үг сонгон мэндэлж байна уу.)



Үйл ажиллагаа 2  
Хичээлийн үндсэн  
хэсэг 20 мин

**Алхам 2.** (4 мин)

Харилцан яриа сонгох орчин бүрдүүлсэн байна. Сурагчид биеэ цэх, гараа ширээн дээрээ зөрүүлэн тавих эсвэл 2 өвдөг дээрээ тавьж сууна. (багш хүүхдүүдийг сонсох бэлтгэл хийлгэнэ.)

1. Харилцан яриаг зөв уншаарай.



Харилцан яриаг 3 удаа сонсоно. Сонсох явцад ГА 10 дугаар хуудас ажиглах Сурагчдад хичээлийн сэдэв, зорилгыг танилцуулна. **Алхам 3.** (8 мин) ДАД ... хуудас Багш Даалгаврыг хийж гүйцэтгэх заавар өгнө. Харандаагаар бичүүлнэ. Алдааг засуулна. **Даалгавар 1.** Зургийг ажиглуулна. Өгүүлбэрийг уншуулна. Зөв харгалзуулан холбох дасгалыг хийлгэнэ.

1. Зурагтай зөв холбоорой.

	Өглөөний мэнд	
	Оройн мэнд	
	Сайхан амраарай	
	Өдрийн мэнд	
	Сайхан амарсан уу?	
	Тавтай нойрсоорой	

**Алхам 4 .** (10 мин) (ГА-10-р хуудасны ...)

Харилцан яриаг ширээний 2 сурагчаар харилцан уншуулна. Хэн нэгэнд хандаж хэлснийг ажиглуулна Бид нар хүмүүстэй мэндлэхдээ хандсан үгийг хэрэглэж байна уу? Өглөө, өдөр, орой гэсэн тулгуур дохиогоор хоорондоо харилцах дасгал хийлгэнэ. Аав, ээж, ах, эгч, багш, сургуулийн захирал, сургалтын менежер, эмч, сургуулийн ажилтантай мэндлэх дасгал хийлгэнэ. Үгийн утгыг ялгах даалгаврыг ажиллуулна.

2. Гүйцээн бичээрэй.

Өглөө ээждээ: - Өглөөний мэнд! Сайхан амарсан уу, ээж ээ.  
 Орой аавдаа: - .....  
 Өдөр найздаа: - .....  
 Өдөр багшдаа: - .....  
 Өглөө дүүдээ: - .....  
 Орой эгчдээ: - .....

**Алхам 5.** (8 мин) (ГА-10-р хуудас)

Бичих дасгал хийхдээ Эхний загвар өгүүлбэрийг ярилцана. Орой аавдаа гэсэн өгүүлбэрийг гүйцээн бичүүлнэ. (сурагчдын бичиж байгааг багш явж үзнэ) Эхний 5 хүүхдийн бичсэнийг уншуулна. Оройн мэнд! Аав аа. гэж зөв бичсэн хувилбарыг харуулна. Ижил бичсэн хэдэн хүүхэд байгааг гар өргүүлнэ. Өөр хувилбараар бичсэн сурагчийн жишээг уншуулна. /Сайхан амраарай. Аав аа./ Бусад өгүүлбэрийг зөв бичүүлэх, алдвал засч бичих дасгал хийнэ.

Бататгал

Харилцан яриаг анхааралтай, идэвхтэй сонсоно.

Анхааралтай сонссон эсэхийг зөв дугаарлаж буйгаар үнэлнэ.

Сонсоноо ойлгож, үгийг зурагтай зөв тохируулан холбосныг үнэлнэ.

Өгүүлбэрийг оновчтой хэрэглэн, харилцан зөв уншиж, ярилцаж байгааг өөрсдөөр нь үнэлүүлнэ.

Өгүүлбэрийг гүйцээж зөв бичиж байгаа, дэгийн дагуу бичиж байгааг үнэлнэ.



Санал болгох идэвхтэй арга.	<i>Бусдад унших арга нь үг, өгүүлбэрийн утгын өргөлт гаргах, их, бага зогсолт хийх, уншлагын хурд, өнгө аялгыг тохируулан уран унших чадварт суралцахад давуу талтай.</i>
Үйл ажиллагаа 4. Гэрийн даалгавар (1 мин)	<b>Гэрийн даалгавар:</b> Даалгавар ажиллана. ГА 10-р хуудас 2, ДАД 2-р хуудас даалгавар 3. Гэрийнхэнтэйгээ өглөө, өдөр, орой мэндчилж, хариу мэндлэхдээ тэд чамд ямар хариулт өгч байгааг ажиглаж ирнэ.
<b>Хичээлийн талаар эргэцүүлэн бодох. Энэ хэсэгт хичээл заасны дараа багш дараах асуулыг өөртөө тавьснаар хичээлээ сайжруулах үндэслэл болох юм.</b>	
<ul style="list-style-type: none"> <li>- Хичээлийн зорилгоо зөв тодорхойлсон уу?</li> <li>- Зорилгодоо хүрч чадсан уу?</li> <li>- Зорилгодоо хүрээгүй бол шалтгаан нь юу вэ?</li> <li>- Багш сурагч, сурагч сурагчийн харилцан яриа идэвх, оролцоо ямар байсан бэ?</li> <li>- Хугацаагаа зөв хуваарилсан уу?</li> <li>- Сурагчдад бие даан ажиллах боломжийг олгосон уу?</li> </ul>	
<b>Орчин:</b> Бие биеэ хүндэтгэн мэндлэх  Ангийн орчныг бүрдүүлэх	

**Ээлжит хичээлийн сэдэв:** “Дөрвөн хүсэл” эх

**Бүлэг сэдэв:** БИ





**Хугацаа:** 80 минут

Ээлжит хичээлийн зорилго	Ээлжит хичээлийн зорилт	
Хүүрнэсэн эхийг ойлгон уншина. Үг хэллэгийн дуудлагыг ялгаж, зөв дуудаж, уншиж, бичиж сурна.	<ul style="list-style-type: none"> <li>- “Дөрвөн хүсэл” эхийг сонсож, уншиж, үйл явдлыг асуултын дагуу тайлбарлах (эхлээд, дараа нь, эцэст нь, хэн? хаана? хэзээ? юу? ямар учраас? яав?)</li> <li>- Баатрын үг яриаг цээжлэн тогтоож, харилцан яриагаар дүрд тоглох</li> <li>- Эхийн үйл явдлын дарааллыг түлхүүр үг, асуултын дагуу тоочин бичих</li> </ul>	
<i>Хүрэх үр дүн: Эхийг сонсоод, уншаад ойлгосноо асуулт, загварын дагуу тоочин бичнэ.</i>		
<p><i>Бүх сурагчид:</i> С: Эхийг сонсож ойлгосноо сонгох, нөхөх, харгалзуулах, будах дасгалыг бүрэн гүйцэтгэж бататгана. У: Эхийг уншиж, үйл явдлыг асуултын дагуу тайлбарлана. (эхлээд, дараа нь, эцэст нь, хэн? хаана? хэзээ? юу? ямар учраас? яав?) Я: Баатрын үг яриаг цээжлэн тогтоож, харилцан яриагаар дүрд тоглоно. Б: Асуулт, загварын дагуу тоочин бичихдээ дүрмийн алдаагүй, зөв холбож бичнэ.</p>	<p><i>Ихэнх сурагчид:</i> С: Эхийг сонсож ойлгосноо сонгох, нөхөх, харгалзуулах, будах дасгалыг ихэнхийг зөв гүйцэтгэж бататгана. У: Эхийг уншиж, үйл явдлыг асуултын дагуу тайлбарлана. (эхлээд, дараа нь, эцэст нь, хэн? хаана? хэзээ? юу? ямар учраас? яав?) Я: Баатрын үг яриаг цээжлэн тогтоож, харилцан яриагаар дүрд тоглоно. Б: Асуулт, загварын дагуу тоочин бичихдээ дүрмийн алдаагүй, зөв бичнэ.</p>	<p><i>Зарим сурагчид:</i> С: Эхийг сонсож ойлгосноо сонгох, нөхөх, харгалзуулах, будах дасгалыг бага хэсгийг зөв гүйцэтгэж бататгана. У: Эхийг уншиж, үйл явдлыг асуултын дагуу тайлбарлана. (эхлээд, дараа нь, эцэст нь, хэн? хаана? хэзээ? юу? ямар учраас? яав?) Я: Баатрын үг яриаг цээжлэн тогтоож, харилцан яриагаар дүрд тоглоно. Б: Асуулт, загварын дагуу тоочин бичихдээ зөв холбож бичнэ.</p>
<i>Үгийн сан</i>	<i>Хүнд үгс:</i> Улирал, нахиа, яргуй, тэмдэглэлийн дэвтэр, яасан, цэцэгс, Гэрэл охин, гэрлийн чийдэн, цухуйсан, зугааллаа, байгаасай, дуусаасай	
<i>Хандлага</i>	Уншлагын явцад зохиолын агуулга, үйл явдал дүрслэгдэж буй хүмүүсийн хоорондын харьцаанаас хүүхэд бүр төлөөлж байгаа дүрүүдийнхээ зан чанар, төрх байдал, хүсэл зорилгыг танин мэдэж түүнийг илэрхийлэх чадвараас суралцана.	
<i>Хичээл хоорондын холбоо</i>	Хүн орчин, дүрслэх урлаг	





Өмнөх мэдлэг	<ul style="list-style-type: none"> <li>- “Амин хүүдээ би” шүлгийг сонсож, утгыг үйл, хөдлөлөөр илэрхийлэх замаар цээжлэн тогтооно.</li> <li>- Шүлгийг дууны өнгө, хурд, хэмнэлийг тохируулан унших</li> <li>- Амьсгалаа зөв хуваарилж, дууны өнгө, хурд, хэмнэл тохируулан, түгдрэлгүй цээжээр уншина.</li> <li>- Эр, эм үгийг ялган бичнэ.</li> </ul>
--------------	--

### Хичээлийн явц, арга зүй

Үе шат	Суралцахуйн үйл ажиллагаа	Явцын үнэлгээ
Хичээлийн эхлэл 5 мин Үйл ажиллагаа 1	<p><b>Зохион байгуулалт хийнэ.</b> (2 мин)</p> <ul style="list-style-type: none"> <li>- Сурагчидтай мэндэлж, амжилт хүснэ.</li> <li>- Хичээлийн дэгийг танилцуулна.</li> <li>- “Амин хүү дээ би” шүлгээ хамтын уншлагаар унших</li> <li>- Нэмж тогтоосон эр, эм, саармаг эгшигтэй үгийг нэрлүүлэн олон давтагдсан үг, давтагдаагүй үгийг ялгана.</li> </ul>	Хичээлийн дэг, шинэ үгийг тогтоож байгааг ажиглаж аман үнэлгээ өгнө.
	<p><b>Алхам 1.</b> (8 мин)</p> <ul style="list-style-type: none"> <li>- “Дөрвөн хүсэл” эхийг сонгоно.</li> <li>- Эхийн үйл явдлыг дарааллаар нь харуулсан слайд харуулна.</li> <li>- Улирлын онцлогоор хэсэгчлэн дахин сонгоно.</li> <li>- Хүнд үгсийг хэрчмэл хэлбэрээр эсвэл хүснэгтэн загвараар бэлтгэсэн байна.</li> <li>- Ойлгосныг илрүүлэх даалгавар ажиллана. ДАД 55-р хуудас</li> </ul> <p><b>Алхам 2.</b> Хичээлийн сэдэв, зорилгыг тодорхойлох. Сурагчид хичээлийн сэдэв, зорилгыг уншиж танилцуулна</p>	
Үйл ажиллагаа 2 Хичээлийн үндсэн хэсэг 60 мин	<p><b>Алхам 3.</b> Сонсох даалгаврыг шалгах даалгавар хийлгэнэ</p> <p>"Дөрвөн хүсэл" эхийг сонсоод, доорх даалгаварыг хийгээрэй.</p> <p>Эхэд хэний хүслийн тухай гарч байгаа вэ? Будаарай.</p> <p style="text-align: center;"> <input type="button" value="Аавын"/> <input type="button" value="Гэрлээ"/> </p> <p>Хүслээ хэний тэмдэглэлийн дэвтэрт бичсэн бэ?</p> <p style="text-align: center;"> <input type="button" value="Аавын"/> <input type="button" value="өөрийн"/> </p> <p><b>Алхам 4.</b> Эхийг уншуулна</p> <ul style="list-style-type: none"> <li>- Сурагчид хараагаар уншина.</li> <li>- Төлөөлөн уншуулна.</li> <li>- Асуултын дагуу сонгон уншина.</li> </ul> <p>/эхлээд, дараа нь, эцэст нь, хэн? хаана? хэзээ? юу? ямар учраас? яав?/</p> <p><b>Алхам 5.</b> Зургийг дараалалд оруулан ярина.</p> <p> 2. Эхийн үйл явдлын дагуу зургийг дараалалд оруулж яриарай.</p> <div style="display: flex; justify-content: space-around; align-items: center;">     </div>	<p>Анхааралтай сонссон эсэхийг зөв дугаарлаж буйгаар үнэлнэ.</p> <p>Сурагчдын нэрлэн хэлж байгааг, асуултад хариулж байгаад аман үнэлгээ өгнө.</p> <p>Сонссоноо ойлгож, зөв будаж байгаа эсэхийг үнэлнэ.</p> <p>Зөв дараалалд оруулж ярьж байгааг үнэлнэ.</p>



	<p><b>Алхам 6.</b> Эхийн үйл явдлыг асуултын дагуу ярих</p> <ul style="list-style-type: none"><li>- Хэний хүслийн тухай гарч байна вэ?</li><li>- Гэрэлээ өвөл ямар хүсэлтэй байсан бэ?</li><li>- Хавар ямар хүсэлтэй байсан бэ?</li><li>- Зун ямар хүсэлтэй байсан бэ?</li><li>- Намар ямар хүсэлтэй байсан бэ?</li></ul>																					
	<p><b>Алхам 7.</b> Дүрд тоглоно. 1 баг 5 сурагчтай байна. 1 сурагч аавын дүрд, 4 сурагч Гэрэлийн дөрвөн улирлын онцлогтой дүрд тоглоно.</p> <p>Аавын дүр Гэрэлийн дүр /улирлын онцлогтой/ Багш: Гэрэлийн дүрд тохирсон хувцас бэлтгэсэн байна. Эсвэл дараах орчныг харуулсан зураг, загвар бэлтгэнэ. Өвөл ууланд чаргаар, гол дээр тэшүүрээр гулгах орчин Хавар шинэхэн цухуйсан модны нахиа, хөх яргуйг харуулсан орчин Зун цэцэгс алагласан ой, жимсний төглийг харуулсан орчин Намар ногооны талбайг харуулсан орчин бүрдүүлсэн байна.</p>	<p>Асуултад хариулж дарааллын дагуу ярьж байгааг үнэлнэ.</p> <p>Дүрд итгэлтэй, үгээ тод хэлж тоглож байгааг үнэлнэ.</p>																				
<p>Үйл ажиллагаа 3. Бататгал 10 мин</p>	<p>Алхам 8. Гэрэлийн аавдаа хэлсэн үгийг олж, хичээнгүй сайхан бичих</p> <p> 3. Гэрэлийн аавдаа хэлсэн үгийг хичээнгүй сайхан бичээрэй.</p> <table border="1" data-bbox="279 862 774 963"><tr><td>Өвөл:</td><td>Хавар:</td></tr><tr><td>Зун:</td><td>Намар:</td></tr></table> <p>Алхам 9. Гэрэлээ дөрвөн улиралд юу, юу хийснийг тоочин бичээрэй.</p> <p> 4. Гэрэлээ дөрвөн улиралд юу? юу? хийснийг тоочин бичээрэй.</p> <table border="1" data-bbox="231 1064 774 1198"><tr><td>өвөл</td><td>хавар</td><td>намар</td><td>зун</td></tr><tr><td>.....</td><td>.....</td><td>.....</td><td>.....</td></tr><tr><td>.....</td><td>.....</td><td>.....</td><td>.....</td></tr><tr><td>.....</td><td>.....</td><td>.....</td><td>.....</td></tr></table>	Өвөл:	Хавар:	Зун:	Намар:	өвөл	хавар	намар	зун	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....	.....	<p>Асуулт, загварын дагуу асуултад хариулан тоочин бичсэнийг үнэлнэ.</p> <p>Үгийн зөв сонголт, дүрмийн алдаагүй бичиж байгааг үнэлнэ.</p>
Өвөл:	Хавар:																					
Зун:	Намар:																					
өвөл	хавар	намар	зун																			
.....	.....	.....	.....																			
.....	.....	.....	.....																			
.....	.....	.....	.....																			
	<p><b>Санал болгох идэвхтэй арга.</b></p> <ul style="list-style-type: none"><li>- Төлөөлөн унших аргыг хэрэглэнэ.</li><li>- Асуулт, загварын дагуу асуултад хариулан тоочин бичихдээ үйл явдлын дарааллыг алдагдуулахгүйгээр бичиж сурахад давуу талтай.</li><li>- Дүрд тоглох арга нь өөртөө итгэлтэй, бусдыг хүндэтгэн хамтран суралцана.</li></ul>																					
<p>Үйл ажиллагаа 4. Гэрийн даалгавар 2 мин</p>	<p><b>Гэрийн даалгавар:</b> "Миний нутаг" шүлгийг бүрэн эхээр нь цээжилнэ. Даалгавар ажиллана. ГА 20-р хуудас Б, ДАД 58-р хуудас</p>																					



Үйл ажиллагаа 5.  
Хичээлийн дүгнэлт 3 мин

**Сурагчид өөрийгөө болон хичээлийг үнэлнэ.**  
Өнөөдрийн хичээлээр дүрд тоглосноор юу сурсан бэ?  
Өөрийгөө үнэлэх хүснэгтийг бөглөнө.

Үнэлгээний шалгуур			
Би шинэ үгийн утгыг мэдэж авсан.			
Дүрд тоглохдоо үгээ бүрэн тогтоож, өөртөө итгэлтэй тоглосон.			
Тоочин бичихдээ зааврын дагуу бичсэн.			
Бүх үгийг зөв бичсэн.			

Сурагчид даалгавар бүрийн гүйцэтгэлийн дараа өөрөө өөрийгөө үнэлнэ.

**Хичээлийн талаар эргэцүүлэн бодох. Энэ хэсэгт хичээл заасны дараа багш дараах асуултыг өөртөө тавьснаар хичээлээ сайжруулах үндэслэл болох юм.**

- Хичээлийн зорилгоо зөв тодорхойлсон уу?
- Зорилгодоо хүрч чадсан уу?
- Зорилгодоо хүрээгүй бол шалтгаан нь юу вэ?
- Багш сурагчийн хамтын ажиллагаа амжилттай болсон уу?
- Хугацаагаа зөв хуваарилсан уу?
- Дүрд тоглуулах хугацаа тохирсон уу?
- Сурагчид дүрд тоглохдоо өөртөө итгэлтэй байсан уу?

**Орчин:**

“Дөрвөн хүсэл” эхийн дүрд тоглох ангийн орчныг бүрдүүлсэн байна.

Дүрд тоглохдоо өөртөө итгэлтэй, бие биеэ сонсон, хүндэтгэн оролцоно.

## IV АНГИ. НЭГЖ ХИЧЭЭЛИЙН СЭДЭВ. ГЭР БҮЛ

### Нэгж хичээлийн сэдвийн агуулгын ерөнхий хүрээ

IV ангид “Гэр бүл” бүлэг сэдвийг “Гэр бүлийн гишүүдийн үүрэг хариуцлага”, “Гэр бүлийн бахархал” гэсэн дэд сэдвийн хүрээнд судлахаар тусгасан ба нэгжийн агуулгыг гарын авлага, дасгал ажлын дэвтэрт дараах байдлаар оруулсан.

- Гэр бүлийн гишүүдийн үүрэг хариуцлагын хүрээнд авч үзэхдээ хүүхдүүд гэртээ ямар ажил хийж, гэрийнхэндээ хэрхэн тусалдаг талаар сонсож, уншиж, ярьж, бичих замаар хэлний 4 чадварыг хөгжүүлнэ.



АЖИГЛААД

### Даалгавар 2

**А. Зургийг тохирох өгүүлбэртэй харгалзуулаарай.**



Тулга малаа усалж байна.



Гэрийнхээ цасыг цэвэрлэх дуртай.



Болд цонх угааж байна.



Өдөр бүр хогоо хаядаг.

- Хот хөдөөгийн хүүхдүүдийн гэртээ хийдэг ажил ямар ялгаатай байгааг ярилцаж, дасгал даалгавар ажиллана.
- Сурагчид энэхүү нэгж сэдвийн турш гэр бүл гишүүд бие биесээ хайрлах, ахмадын сургаалыг хүндэтгэх талаар ярилцаж, уншиж, бичих бөгөөд энэ нь гэр бүлийн үнэ цэн, ахмадуудаа ойлгож, хайрлах сэтгэлийг сурагчдад төлөвшүүлэхэд анхаарна.

**А. Танилцуулгыг уншаад асуултад хариулаарай.**

**ЭНЭ БОЛ МИНИЙ ГЭР БҮЛ**

Харин би сайхан сэтгэлтэй, сайн хүн болохыг хичээж байгаа.

Миний аав ухаантай бас хөдөлмөрч.

Эгч маань авъяаслаг бас хичээнгүй. Түүний бие уян налархай, үнэхээр гоё бүжиглэдэг.

Ээж минь сайхан сэтгэлтэй бас ажилсаг.

Миний өвөө маш олон үлгэр мэддэг, амьд ном л гэсэн үг.

Ах минь тамирчин, тэр маш их тэвчээртэй.

Харин эмээ үнэхээр сайхан хоол, бялуу хийдэг.

Манай гэр бүлийн эрхэмлэдэг зүйл гэвэл бие биедээ болон бусдад туслахыг хичээдэг. "Үнэнч шударга, хөдөлмөрч явахад хүн сайхан амьдарна даа" гэсэн өвөөгийн сургаалаар л явдаг даа. Би гэр бүлээрээ маш их бахархдаг.

Гэрийнхэн чинь чамд хайртайгаа хэрхэн илэрхийлдэг вэ?

Гэрийнхнийхээ юунд их баярлаж, талархдаг вэ?

Танай гэр бүлийн эрхэмлэдэг зүйл юу вэ?

Гэр бүлийнхээ юугаар их бахархдаг вэ?

- Хэл зүйн хувьд гэр бүлийн үүрэг хариуцлагатай холбоотой үгийн санд суурилсан төрөл бүрийн эх дэх балархай эгшгийн ялгах үүрэг, хамаатуулах нөхцөлийн хэрэглээ, үгийг үелэх, өгүүлбэрийг зохиох, хувиргах (хүүрнэх, асуух, анхааруулах, захирах өгүүлбэр), дуудлага ижил утга, бичлэг өөр үгсийн утгыг мэдэж хэрэглэнэ.

**Г. Үгийн утгыг ойлгож, цэгийн оронд нөхөж бичээрэй.**

**аргал**

**үхрийн хатсан баас**

Ээж ..... түүх,  
цай чанав.

**аргаль**

**зэрлэг хонь**

..... нь  
уулархал нутагт амьдардаг.

- Дуудлага ижил, утга бичлэг өөр үгсийн утгыг таниулж, хэрэглэж сургахын тулд тодорхой давтамжтайгаар дээрх загварыг оруулж өгсөн. Энэ нь үгийн утгыг илэрхийлсэн зураг болон тайлбар, мөн өгүүлбэр зохиох загваруудыг өгснөөрөө онцлогтой. Багш энэ санааг баяжуулан дасгал даалгаврын сантай болох боломжтой юм. Мөн эх хэлний онцлогоос шалтгаалан дуудлага ойролцоо, урт богино эгшгийн утгыг ялгаж хэрэглэх, зөв дуудуулж сургах зорилготой даалгавруудыг оруулсан.



**Ё. Цэгийн оронд нөхөж бичээд үг, өгүүлбэрийг зөв дуудан уншаарай.**

**ҮНЭ**



**ЭД ЮМСЫГ МӨНГӨӨР  
ҮНЭЛСЭН ҮНЭ**

*Энэ нам хорин таван мянган  
төгрөгийн ..... тэй.*


**ҮНЭЭ**



**ҮХРИЙН ЭМ НЬ**

*Балд ..... ний сүү уус  
дуртай.*

- Үгийг үелэх чадвартай холбоотой суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэхийн тулд үеийн тухай онолын мэдлэгийг заах биш, харин сэдэв бүр дээр жишээ үгийг үеэр таслуулан будуулж, алдаан дээр ярилцсаны үр дүнд сурагчид үеэр зөв тасалж сурах юм. Энэ даалгавар нь үеэр таслан бичихээс илүү бэлэн хүснэгттэй үгийг өнгөөр ялган будаж, байнгын давтамжтай гүйцэтгэж буйгаараа сонирхолтой юм.





 **Б. Үгийг үеэр таслахдаа өнгөөр ялган будаарай.**

С О Н И Р Х О Л Т О Й

 **Д. Үеэр таслан будаарай.**

О Ё Ё У Я Я Х А Я Я

- Нэгжийн гол онцлог нь “үйл үг” дээр төвлөрч, үйл үгийг хэрэглэх, нөхцөлөөр хувилгах, цагийн утгыг гаргах, онцлог ялааг ойлгоход анхаарна. Тухайлбал, ДАД-ын 16-р талын доорх даалгавар нь үйл үгийг нөхөж бичээд өнгөрөхөөр харагдаж байгаа ч нэгжийн хүрээнд сурагчдын ярьж бичихэд маш олон давтагдах, хамгийн чухал хэл зүйн хэлбэр болох юм. Энэ бүгдийг багш та бүхэн мэдрэмжтэй хүлээн авч ойлгон, баяжуулж хичээлээ заах болон сурагчдаа үнэлэхдээ анхаарууштай.

			
1. Би өчигдөр хувцсаа _____	1. Од өглөө нохойгоо _____	1. Би өчигдөр хувцсаа _____	1. Бид өчигдөр цонх _____
1. Би одоо хувцсаа _____	2. Од одоо нохойгоо _____	2. Би одоо хувцсаа _____	2. Бид одоо цонх _____
1. Би маргааш хувцсаа _____	3. Од орой нохойгоо _____	3. Би маргааш хувцсаа _____	3. Бид маргааш цонх _____

**Судлах цаг 15 цаг**

- Нэгж хичээлийн цагийг 5-8 цаг гэж тооцдог. Харин бид Жишиг хөтөлбөрийн нэг бүлэг сэдвийг нэгж хичээлд тооцож төлөвлөлөө. Багш 2 нэгжээр тооцож ажлаа төлөвлөх боломжтой.
- Дөрөвдүгээр ангид нэгжийг 40 минутаар ээлжит хичээлд хуваарилсан болно.
- Багш сурагчдын хэлний болон сурах чадварын түвшнийг харгалзан ялгаатай даалгавар ажиллуулж болно.



## Нэгж хичээлийн зорилго

Гэр бүлийн гишүүдийн үүрэг хариуцлага болон гэр бүлийн бахархалтай холбоотой агуулгыг монгол хэлээр хүлээн авч (сонсох, унших), амаар болон бичгээр (ярих, бичих) илэрхийлэх чадварыг хөгжүүлнэ.

Суралцахуйн зорилт	Нэгж хичээлийн суралцахуйн үр дүн
4.C1. 4.C3. 4.C4.	Хүлээцтэй сонсож, ойлгосноо зураглаж илэрхийлэх, үйл явдлын дарааллыг ялгах, тайлбарлах;
4.Y1. 4.Y3. 4.Y4.	Зөв (дуудан), хурдан (70-110 үг), ойлгож (асуултад хариулах), уран (өргөлт, зогсолтыг зохицуулан) унших, агуулгын зураглал хийх, баатрын сайн, муу үйлийг ялгах;
4.Y1. 4.Y2. 4.Y3.	Шинэ санаа нэмж харилцах, сонирхолтой байдлаар тоочих, ярианы хурд, дууны өнгийг тохируулан бусдад хүргэж ярих;
4.B1. 4.B2. 4.B3. 4.B4.	Дэгийн дагуу, асуултад хариулан тоочих, дуурайн бичих, дарааллын дагуу хүүрнэн бичих, загвар ашиглан, бүтцийн дагуу зохион бичих;
4.X1. 4.X2. 4.X3. 4.X4.	Үеэр зөв тасалж, балархай эгшгийн ялгах үүргийг таньж ялгах эгшигтэй үгийг олж, тайлбарлана. Хамаатуулах нөхцөлтэй үгийг түүж бичнэ. Хүүрнэх өгүүлбэрийг асуух, анхааруулах өгүүлбэр болгож, журамласан толь ашиглан ижил үгийн утгыг ялгах;

## Залгамж холбоо

Чадвар	“Гэр бүл” нэгж хичээлийн хүрээнд		
	3 дугаар ангид	4 дүгээр ангид	5 дугаар ангид
Нэгж хичээлийн хүрээ	<ul style="list-style-type: none"> <li>✓ Гэр бүлийн гишүүдийн үүрэг хариуцлага</li> <li>✓ Гэр бүлийн бахархал</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>✓ Гэр бүлийн гишүүдийн үүрэг хариуцлага</li> <li>✓ Гэр бүлийн бахархал</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>✓ Гэр бүл, төрөл садан</li> <li>✓ Ургийн мод</li> </ul>
Үгийн сан	Зураач, сувилагч, зохион бүтээгч, шоо, хөдөө, хор, алаг нүд, тэврэх, үнэртэх, хөөрхөн, далай, амрах, нагац ах, нагац эгч, хүргэн ах, бэр эгч, тэнгэр, шалын дөл, голын ус, өд	ногоо услах, машин угаах, тоос соруулах, ор хураах, ширээ засах, муур хооллох, тоос арчих, хувцас угаах, хувцас хатаах, нохой салхилуулах, тоглоом хураах, хоол хийх, цонх угаах, хувцас эвхэх, түлээ зөөх, мал услах, төл нэмнэх, аргал түүх, өвс хамах, төл угжих	Иог, усан спорт, эрүүл, чийрэг, авхаалжтай, өгөөмөр, сайхан сэтгэлтэй, мужаан, хүчтэй, зоригтой, гайхалтай сайхан, үл тоох, авга, нагац, үеэл, хаяал, ач, зээ, хүргэн, бэр, зорих, шүүдэр, хувин, бушуухан, ёроол,

## Өгүүлбэрийн загвар

- Сурагчид дэлгэрэнгүй өгүүлбэр, хүүрнэмж зэргийг бичиж сурахад нь туслахын тулд дараах өгсөн өгүүлбэрийн загварууд дээр ажиллуулах боломжтой. Энэ нь багшаас өгч буй “өгүүлбэр зохиож бич, асуултад хариулж бич” гэсэн даалгавруудыг илүү ойлгомжтой болгодгийг бид мэднэ.
- Загварын дагуу өгүүлбэр зохиож бичих дадлагууд нь тэднийг бие дааж өгүүлбэр, эхийг боловсруулж бичих чадварыг хөгжүүлэхэд тусална.

1. Хөдөөгийн хүүхдүүд өвлийн улиралд ..... өмсдөг.
2. Бид зуны амралтаараа эхлээд ..... явсан. Дараа нь .....
3. Би ..... бахархдаг. Учир нь .....
4. Би ..... учраас .....-аар бахархдаг.

..... (хэн) ..... дуртай. .... ном ..... байна.





- Би усанд явсан уу?
- Би гал түлсэн үү?
- Би цай чанасан уу?
- Би хоол хийсэн үү?
- Би ширээ зассан уу? Гэх мэт.

**Юуны дуу вэ?** Гэрийн ажил хийхэд гардаг дууг сонгож нэрлүүлэх. Жишээлбэл: Аяга таваг угаах, тоос соруулах, хог шүүрдэх, хоол хийх, цай самрах, түлээ хагалах гэх мэт.

б) Ярих чадварыг хөгжүүлэхэд ашиглах зарим арга

Ярьдаг хана. Сурагч бүрээс гэр бүлийнхнийхээ зургийг авчрахыг хүсээд ангийн нэг ханаа гэр бүлийн зургийн цомог болгож болох юм. Зураг бүрийн доор гэр бүлийнхээ товч танилцуулгыг бичиж, гэр бүлийн бахархал гэсэн жижиг цаасанд маш товчоор бахархдаг зүйлсийг бичүүлж наана. Ингэснээр ангийн сурагчдын “Гэр бүлийн бахархал” мэдээллийг хана бидэнд “ярьж” өгнө. Ингэснээр сурагчид “бахархал”, “үнэ цэн” гэх мэтийн хийсвэр бөгөөд хүн бүрийн хувьд ялгаатай байдаг ухагдахууныг яриулж, бичүүлэхэд тусалдаг.

**Шуурхай ярилцлага.** Сурагч бүрийн санаа бодлыг түргэн сонсох шаардлагатай үед энэ аргыг хэрэглэнэ. Тэднээс товч хариулт авах үндсэн асуултыг багш тавина. Өгүүлбэрийг эхэлж орхиод, сурагчдаар санааг гүйцээлгэж болно. Жишээ нь, багш “Монгол хэлээр ярьж сурахын тулд ...” эсвэл “Шүлгийг уран, тод уншдаг болохын тулд ...” гэх мэтээр эхлэхэд сурагчид гүйцээн, дор бүрдээ хариулна. Бусдын хариултыг давтахаас аль болох зайлсхийхийг сануулаарай.

Давхар тойргоор ярилцах. Сурагчдыг тэнцүү хоёр хэсэгт хуваан, давхар тойргоор суулгана. Дотор талын тойрогт суусан сурагчид хийсэн ажил, гүйцэтгэсэн даалгавраа бие бидээ танилцуулж, ярилцана. Гадна талын тойргийн сурагчид тэдний яриаг анхааралтай сонсоно. Дараагийн ээлжид гадна талын тойрогт сууж байсан сурагчид дотор талын тойрогт шилжин сууж, ярилцлага дахин үргэлжилнэ. Энэ аргыг хэрэглэхэд хэдийгээр хугацаа их шаарддаг ч танилцуулга ярилцлагад бүх сурагчид оролцох боломжтой байдгаараа ач холбогдолтой юм.

### Орчин

“Гэр бүл” нэгж сэдвийн онцлог нь анги танхимаас гадна гэрийн (харилцааны) орчин чухал нөлөөтэй. Иймээс гэртээ хийх ажилтай нь холбогдуулан хичээлээ зохион байгуулахыг санал болгож байна.

Анги танхимын орчин	Гэрийн орчин (бодит орчин)
<ul style="list-style-type: none"> <li>- Сурагчдыг сэдвийн хүрээний үгсийг ашиглан аль болох тантай болон хоорондоо харилцах орчин бүрдүүлнэ.</li> <li>- Үүний тулд “Айл гэр болж тоглох” дүрд тоглох боломжийг хангасан орчин бий болгож болох юм. Тухайлбал,</li> <li>- Ангийн ширээ сандлын байрлалыг өөрчлөх,</li> <li>- Ангийн ханыг сурагчдынхаа гэр бүлийн цомог болгох (сурагч бүр гэр бүлийн, өөрийн хайртай зургуудаа авчирч байрлуулахыг зөвшөөрөх, байрлуулах)</li> <li>- Мөн уг нэгжийн хүрээнд ашиглах нэр болон үйл үгс, холбоо үг зэргийг томоор бичиж, хананд байрлуулах, энэ нь хүүхдүүд аваад өгүүлбэр зохиож болохоор байх гэх мэт.</li> </ul>	<p>Энэ нь илүү бодит харилцааны орчин юм. Тухайлбал, Гэртээ гал тогооны ажилд туслахыг сонгож “хоол хийж бичлэг хийх ч юм уу, хоол хийсэн дарааллыг бичих, ярих” даалгавар өгч болох юм. (Зааварчилгааны санааг дор өгсөн.) Үүний тулд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Эцэг эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах</li> <li>- Ажлын удирдамжийг тодорхой өгөх</li> <li>- Ашиглах үг хэллэгийн жагсаалтыг гаргаж өгөх</li> <li>- Асуулт болон өгүүлбэрийн загварыг өгөх шаардлагатай.</li> <li>- Хамгийн гол анхаарах зүйл бол монгол хэлийг хэрэглэх гэдгийг санах нь зүйтэй. Энэ нь хийж буй ажлын явцад дандаа юугаар юуг яаж хийж байгаагаа хэлнэ гэсэн үг. “Хийнгээ суралцах” аргыг ийнхүү ашиглана.</li> </ul>

## БУУЗ ХИЙЦГЭЭ

### I үе. Бэлтгэл ажил

- Ангийн сурагчидтайгаа болон эцэг эхтэйгээ ярилцаж, зорилго, хугацаа зэргийг тохирно.
- Хийх ажлаа төлөвлөнө. Тухайлбал,  
Эхлээд: Ямар хоол хийхээ сонгоно, дэлгүүрээс материал цуглуулах  
Дараа нь: Ажлуудыг хэн хэн, ямар дараалалтай хэрхэн хийх вэ?  
Эцэст нь: Болгох, хооллох, хооллох үедээ сонирхолтой яриа өрнүүлэх

### II үе. Ажлын явц

- Энэ ажлыг гэр бүлийн төлөөлөл сурагчид хамтран хийнэ.
- Ашиглах үг, холбоо үг. Материал: үхрийн мах, хонины мах, адууны мах, өөх, сонгино, саримс, дээд гурил, нэгдүгээр гурил, хоёрдугаар гурил, ус, гамбанз, ганжин, жигнүүр, тос, цахилгаан зуух, 25 минут, мах татах, амтлах, гурил зуурах, нухах, гурил, бууз чимхэх, өрөх, жигнэх, сэвэх, жигнүүр тослох
- "Хоол хийхэд тусалдаг" өгүүлбэрийг хэрхэн задалж, зааж болохыг харцгаая.
  - Хоол хийхийн тулд яах вэ? Эхлээд яах вэ? Дараа нь юу хийх вэ? Үүнийг хийхэд юу хэрэгтэй вэ? Хамгийн сүүлд юу хийх вэ? гэх мэт асуултыг асууж ярилцана. Үйл явдлын дараалалтай ярьж, бичих нь хүүрнэсэн эхийн жишээ гэдгийг ойлгуулах боломж юм.
  - Бүх зүйлийг бэлэн байлгах бус, багахан асуудалтай тулгаруулж шийдүүлэхийг хичээнэ. Эдгээрийг эцэг эх, асран хамгаалагчид зохион байгуулна. Асуудал: Жигнүүр байхгүй бол яах вэ? Тог тасарвал яах вэ? Жигнүүр тослох тос байхгүй бол яах вэ? Давсаа мартсан бол яах вэ? гэх мэт.
  - Буузаа хийцгээе.  
Орц: Мах, гурил, сонгино, давс,  
Хийх ажил: Мах татах, амтлах, гурил зуурах, нухах, таслах, элдэх, чимхэх. Эдгээр үйлүүдийг гүйцэтгэж байх явцыг үгээр илэрхийлж хэлнэ.

### III үе. Үр дүнг тооцох

Боломж бололцоог харгалзан үзэж видео бичлэг, цуврал зурагт тайлбар, бичсэн болон ярьсан явцын тайлбараар дүгнэх боломжтой. Хүүхэд бүрийн оролцоог хангахыг багш зохион байгуулах бөгөөд үнэлгээ хийхдээ уян хатан байж, хэлний хэрэглээг үнэлэхэд анхаараарай.

Энэхүү бүлэг сэдвийг I улиралд судлах ба "Хоол хүнс" сэдвийг энэхүү аргаар, уялдуулан заах боломжтой.

## Нэгж хичээлийн үнэлгээ

Явцын үнэлгээг ээлжит хичээлийн хувьд сонсох ярих, харилцах чадварыг үнэлэх, дэмжиж урамшуулахад ашиглана. Ингэхдээ дараах аман болон аман бус урамшууллын арга техникийг хэрэглээрэй. Үүнд:

- Аман: Сайн байна, дөхөж байна, хичээжээ, мундаг, гайхалтай, шилдэг нь гэх мэт. Энэ үнэлгээг ганцаарчилсан болон бүлгээр, анги нийтэд ч өгч болно.
- Аман бус: Инээмсэглэл, дохио зангаа (Эрхий хуруугаа гозойлгох). Мөн төрөл бүрийн урамшууллын карт, зураг, дохио тэмдэг, тэмдэглэгээг ашиглаж болно.



Дараах зүйлсийг анхаарна.

- Сурагчид таны аман бус үнэлгээг уншиж, ойлгож чадаж байна уу?
- Та тэдэнд таны тэмдэглэгээг ойлгох цаг олгосон уу?
- Та дараагийн үйл ажиллагаанд шилжихийн өмнө ажлаа сайжруулах цаг гаргаж өгдөг үү?

Өөрийн болон үе тэнгийнхний үнэлгээ. Өөрийн үнэлгээний даалгавруудыг ДАД-ийн бүлэг сэдэв бүрийн төгсгөлд оруулсан ба эдгээр даалгаврууд нь тухайн бүлэг сэдвээр эзэмшвэл зохих сонсох, унших, ярих, бичих, хэл зүй, үгийн сангийн мэдлэг, чадварыг багтаасан байна.

## Нэгжийн үнэлгээний шалгуур

Нэгжийн суралцахуйн дүн хүснэгтэд сурагч юу сурсан байх вэ гэдгийг тодорхойлж өгсөн бол, харин суралцахуйн үр дүнгийн шалгуурт сурсан эсэхийг яаж мэдэх вэ гэдэг асуултад хариулах юм.



## СОНСОХ ЧАДВАРЫГ ҮНЭЛЭХ

Нэгж хичээлийн суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
		I	II	III	IV
Харилцан ярилцахдаа (илтгэл, хэлэлцүүлгийн үед) дуустал хүлээцтэй сонсож, асуулт асуух	Сонсоод хийх даалгавруудыг гүйцэтгэдэг.	Харилцагчаа сонсдог.	Харилцагчаа сонсож, бусдын дэмжлэгтэй асуулт асуудаг.	Харилцагчаа ярьж дуустал хүлээцтэй сонсож, зарим асуулт нь оновчтой бус байдаг.	Харилцагчаа ярьж дуустал хүлээцтэй сонсож, оновчтой асуулт асуудаг.
Үйл явдлаас орон, цагийг ялгах, оюуны зураглал хийх	Цагийн нөхцөлийг зөв залгаж чаддаг.	Цагийн нөхцөлүүдийг ялгадаггүй.	Цагийн нөхцөлүүдийг сольдог.	Цагийн нөхцөлүүдийг мэддэг ч залгаж бичихдээ алдаа гаргадаг	Цагийн нөхцөлийг зөв хэрэглэдэг.
	Эхийн үйл явдлыг зөв дараалуулж чаддаг.	Эхийг сонсоод үйл явдлыг бусдын тусламжтайгаар дараалуулахдаа ихэнхийг нь хольдог.	Эхийг сонсоод үйл явдлыг бусдын тусламжтайгаар дараалуулдаг.	Эхийг сонсоод үйл явдлыг бусдын тусламжтайгаар дарааллыг хольдог.	Эхийг сонсоод үйл явдлыг бүрэн, зөв дараалуулдаг.

## ЯРИХ ЧАДВАРЫГ ҮНЭЛЭХ

Нэгж хичээлийн суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
		I	II	III	IV
Шинэ санаа нэмж харилцах	Найзтайгаа ярилцахдаа гэр бүлийнхний тухай асуух болон өөрийн гэр бүлийн талаар дэлгэрүүлж ярьдаг.	Гэр бүлийн талаар Асуулт асуудаг.	Гэр бүлийн талаар - Асуулт асуудаг. - Асуултад бусдын тусламжтайгаар, товч хариулдаг.	Гэр бүлийн талаар - Асуултыг оновчтой асуудаг. - Бусдын асуусан асуултад хариулдаг.	Гэр бүлийн талаар - Асуултыг оновчтой, өргөн хүрээнд асуудаг. - Бусдын асуусан асуултад оновчтой, дэлгэрүүлж хариулдаг.
Бусдад хүргэж ярих	Зураг ашиглан эхийн үйл явдлыг ярьдаг.	Эхийн үйл явдлыг зураг ашиглан, салангид үг болон холбоо үгээр, алдаатай ярьдаг.	Эхийн үйл явдлыг зураг ашиглан, оновчгүй үгээр, алдаатай ярьдаг.	Эхийн үйл явдлыг зураг ашиглан, ойлгомжтой, ярьдаг.	Эхийн үйл явдлыг зураг ашиглан, ойлгомжтой, тодорхой, баяжуулан ярьдаг.

## УНШИХ ЧАДВАРЫГ ҮНЭЛЭХ

Нэгж хичээлийн суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
		I	II	III	IV
Харилцан ярианы үг хэллэгийг зөв унших	Харилцан ярианы үг хэллэгийг зөв дуудан уншдаг.	Уншиж чаддаггүй.	Үелж, сул дуугаар уншдаг.	Үг, үе, үсгийг уншихдаа цөөн алдаа гаргадаг, алдсан үгээ засаж, тод уншдаг.	Үг, үе, үсгийг сольж гээлгүй, зөв дуудан жигд хурдаар, тод уншдаг.
Хурдан унших	Минутадад 70-140 үг уншина.	Минутадад 0-70 үг уншдаг.	Минутадад 70-100 үг уншдаг.	Минутадад 100-120 үг уншдаг.	Минутадад 120-140 үг уншдаг.



Шүлэг, оньсого, зүйр цэцэн үг, ертөнцийн гурвыг өргөлт, зогсолт, аялгыг тохируулан уран унших	Шүлгийг өргөлт, зогсолт, аялгыг тохируулан уншдаг.	Шүлгийг нэг жигд хэмнэлээр уншдаг.	Шүлгийг өргөлтийг тохируулан уран уншдаг.	Шүлгийг өргөлт, зогсолтыг тохируулан уран уншдаг.	Шүлгийг өргөлт, зогсолт, аялгыг тохируулан уран уншдаг.
Үлгэр, өгүүллэгийн баатрын сайн, муу үйлийн учир шалтгааныг ойлгож, бодит амьдралтай харьцуулан жишээ татан дүгнэх	Сайн, муу үйлийг ялгаж, бодит амьдралтай харьцуулан оновчтой жишээ татан тайлбарладаг.	Сайн, муу үйлийг ялгахыг оролддог.	Сайн муу үйлийг ялгадаг ч, жишээ авдаггүй.	Сайн, муу үйлийг ялгадаг, зарим жишээ оновчгүй байдаг.	Сайн, муу үйлийг ялгаж, оновчтой жишээ татан тайлбарладаг.

### БИЧИХ ЧАДВАРЫГ ҮНЭЛЭХ

Нэгж хичээлийн суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
		I	II	III	IV
Зохион бичихдээ тууш шугамтай дэвтэрт дэгийн дагуу цэвэр сайхан, алдаагүй бичих	Холбоо үг бүтээн, өгүүлбэр зохиож бичдэг.	Холбоо үг бүтээдэг ч өгүүлбэр зохиож чаддаггүй.	Уялдаа холбоо сайтай ч найруулгын болон хэлзүйн алдаатай өгүүлбэр зохиодог.	Утгын уялдаа холбоотой, зөв бүтэц, найруулгатай ч хэлзүйн алдаатай өгүүлбэр зохиодог.	Утгын уялдаа холбоотой, зөв бүтэц, найруулгатай, хэлзүйн хэлбэржилтийг зөв хийсэн өгүүлбэр зохиодог.
	Өгүүлбэрийг гүйцээн бичдэг.	Өгүүлбэрийг гүйцээн бичиж чаддаггүй.	Өгүүлбэрийг гүйцээхдээ оновчгүй үг хэллэг сонгодог, алдаатай өгүүлбэр бүтээдэг.	Өгүүлбэрийг гүйцээхдээ оновчтой үг хэллэг сонгон авсан ч холбож бичихдээ зарим алдаа гаргадаг.	Өгүүлбэрийг гүйцээхдээ оновчтой үг хэллэг сонгож, зөв холбож, утга төгөлдөр өгүүлбэр бүтээдэг.
Загварын дагуу асуултад хариулан тоочих	Гэр бүлийн танилцуулгыг уншаад асуултад хариулан тоочин бичдэг.	Асуултыг ойлгохгүй, хариулан бичиж чаддаггүй.	Асуултыг ойлгосон ч хариулан бичиж чаддаггүй.	Асуултыг ойлгож, хариулж бичихдээ алдаатай тоочин бичдэг.	Асуултыг ойлгож, хариулж бичихдээ оновчтой, алдаагүй тоочин бичдэг.
Дарааллын дагуу хүүрнэн бичих	Эхлээд, дараа нь, эцэст нь гэсэн үгийг ашиглан дарааллын дагуу бичнэ.	Бичихдээ үйл явдлыг эмх цэгцгүй, урд хойно нь оруулан бичдэг.	Бичихдээ үйл явдлыг тоочин бичдэг.	Бичихдээ үйл явдлыг зөв дараалуулан эхлэл, гол хэсэг, төгсгөл хэсэгтэй алдаагүй бичдэг.	Бичихдээ үйл явдлыг зөв дараалуулан, эхлэл, гол хэсэг, төгсгөл хэсэгтэй, санаагаа ойлгомжтой илэрхийлэн, утгын уялдаа холбоотой, алдаагүй бичдэг.
Загвар ашиглан, бүтцийн дагуу зохион бичих	Загварын дагуу гэр бүлийн гишүүдийн зан чанарыг бичдэг.	Загварын дагуу зохион бичиж чаддаггүй.	Зохиож бичихдээ өгсөн загварыг ашигладаггүй, оновчгүй бичдэг.	Зохиож бичихдээ загварын дагуу, оновчгүй эсвэл товч бичдэг.	Зохиож бичихдээ загварын дагуу, оновчтой, дэлгэрэнгүй бичдэг.



## ХЭЛЗҮЙ, ҮГИЙН САНГ ХЭРЭГЛЭХ ЧАДВАРЫГ ҮНЭЛЭХ

Нэгж хичээлийн суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
		I	II	III	IV
Үгийг үелэх	Үеийн бүх хэлбэрүүдийг ялган таньж үеэр зөв тасалж чаддаг.	Үеэр тасалж чадахгүй.	Нэг үенд хэд хэдэн эгшгийг оруулж үеэр тасалдаг.	Үгийг эгшгийн тоогоор үеэр тасалдаг ч эцсийн гийгүүлэгчийн өмнүүр таслахдаа алдаа гаргадаг.	Үгийг эгшгийн тоогоор, эцсийн гийгүүлэгчийн өмнүүр үеэр зөв тасалж чаддаг.
Балархай эгшгийн үүргийг таних	Балархай эгшгийн ялгах үүргийг таньж ялгах эгшигтэй үгийг олж, тайлбарлаж, зөв бичдэг.	Ялгах эгшгийг танихгүй.	Ялгах эгшгийн байрыг мэдэж байвч үүргийг ялгаж чаддаггүй.	Ялгах эгшгийг таньж нэрлэж байвч, алдаатай бичдэг.	Балархай эгшгийн ялгах үүргийг таньж ялгах эгшигтэй үгийг олж, тайлбарлана, алдаагүй бичдэг.
Нэрийн нөхцөлийг зөв хэрэглэх	Эхээс хамаатуулах нөхцөлтэй үгийг олж танин, түүж бичнэ, хамаатуулах нөхцөлийг зөв залган бичдэг.	Хамаатуулах нөхцөлийг мэдэхгүй.	Эхээс хамаатуулах нөхцөлтэй үгийг түүж бичихдээ хольж, сольдог.	Эхээс хамаатуулах нөхцөлтэй үгийг олж танин, түүж бичдэг.	Эхээс хамаатуулах нөхцөлтэй үгийг олж танин, түүж бичдэг. Хамаатуулах нөхцөлийг зөв залган бичдэг.
Хүүрнэх, асуух, анхааруулах, захирах өгүүлбэр зохиож, хувиргах	Хүүрнэх өгүүлбэрийг асуух, анхааруулах өгүүлбэр болгон бичиж, цэг тэмдгийг зөв хэрэглэдэг.	Хүүрнэх өгүүлбэрийг асуух, анхааруулах өгүүлбэр болгон хувиргаж чаддаггүй.	Хүүрнэх өгүүлбэрийг асуух, анхааруулах өгүүлбэр болгохдоо хольж сольдог, цэг тэмдгийг зөв хэрэглэдэг.	Хүүрнэх өгүүлбэрийг асуух, анхааруулах өгүүлбэр болгон зөв бичдэг, цэг тэмдгийг буруу хэрэглэдэг.	Хүүрнэх өгүүлбэрийг асуух, анхааруулах өгүүлбэр болгон зөв бичдэг, цэг тэмдгийг зөв хэрэглэдэг.
Толь бичиг ашиглах	Журамласан толь ашиглан ижил үгийн утгыг ялгах	Толь бичиг ашигладаггүй.	Толь бичиг ашигласан ч буруу бичдэг.	Үгийг бичихдээ Журамласан толийг ашиглан зөв бичдэг.	Үгийг бичих, хувилгахдаа Журамласан толийг ашиглан зөв бичдэг.

**Нэгж хичээлийн сэдэв.** Эрүүл амьдрал

**Нэгж хичээлийн сэдвийн агуулгын ерөнхий хүрээ**

IV ангид “Эрүүл амьдрал” бүлэг сэдвийг “Хүнсний дэлгүүр, зах дээр”, “Хоолны цэс”, “Дасгал хөдөлгөөн” гэсэн дэд сэдвийн хүрээнд судлахаар тусгасан ба нэгжийн агуулгыг гарын авлага, дасгал ажлын дэвтэрт дараах байдлаар оруулсан.

- Сурагчид энэхүү нэгж сэдвийн турш зөв хооллох, дэлгүүр, зах дээр зөв үйлчлүүлэх талаар харилцаж, уншиж, бичих бөгөөд энэ нь эрүүл амьдралын талаарх ойлголтыг бататгаж, зөв төлөвшилтэй болоход сурагчдад тусална.

### Д. Үгсийг бүлэглэж бичээрэй.

**Ашиглах үгс.** Ааруул, гар утсыг зөв ашиглах, жимс химсгэнэ, биеийн тамираар хичээллэх, хүнсний ногоо, дасгал хийх, мэндлэх, алхах, уучлал гуйх, гүйх, эрт унтах, сүү, хүндлэх

Эрүүл хүнс	Дасгал хөдөлгөөн	Зөв дадал зуршил
1. ....	1. ....	1. ....
2. ....	2. ....	2. ....
3. ....	3. ....	3. ....
4. ....	4. ....	4. ....



**В. Зургийг ажиглаад ярилцаарай.**



**Е. Үгийн утгыг ойлгож аваарай. Цэгийн оронд нөхөж бичээрэй.**

**өрөг** 

**шатрын өрөг**

Би шатрын тэмцээнд зургаан  
..... тоглов.

**өргө** 


**дээш болгох**

Хүнд цурхайг .....  
хэцүү.

- Хэл зүйн хувьд тийн ялгалын нөхцөлийг оноосон болон ерийн нэрд зөв залгах, үгийг үелэх, өгүүлбэрийг зохиох, хувиргах (хүүрнэх, асуух, анхааруулах, захирах өгүүлбэр), дуудлага ижил утга, бичлэг өөр үгсийн утгыг мэдэж зөв хэрэглэнэ.
- Гэр бүл нэгжийн адил дуудлага ижил, утга бичлэг өөр үгсийн утгыг таниулж, хэрэглэж сургахын тулд тодорхой давтамжтайгаар дээрх загварыг оруулж өгсөн. Мөн сурагчдын эх хэлний онцлогтой холбоотойгоор сурагчдын алдаа гаргах магадлал ихтэй байдаг дуудлага ойролцоо, урт богино эгшгийн утгыг ялгаж хэрэглэх, зөв дуудуулж сургах зорилготой даалгавруудыг оруулсан.




**Ё. Зөв дуудаж сураарай. Үгсийн утгын ялгааг ойлгон өгүүлбэрийг гүйцээж бичээрэй.**

**хоол** 

**гараар бэлдсэн идэх юм**

Эожийн хийсэн ..... амттай.

**хол** 

**ойрын эсрэг утга**

Манай гэр сургуулиас ..... .

**Судлах цаг 15 цаг**

**Нэгж хичээлийн зорилго**

Эрүүл амьдрал, эрүүл амьдралын хэв маяг, зөв хооллолт, дасгал хөдөлгөөнтэй холбоотой агуулгыг монгол хэлээр хүлээн авч (сонсох, унших), амаар болон бичгээр (ярих, бичих) илэрхийлэх чадварыг хөгжүүлнэ.

Суралцахуйн зорилт	Нэгж хичээлийн суралцахуйн үр дүн
4.С1. С.2. 4.С3.	Дуустал хүлээцтэй сонсож, асуулт асуух, үйл явдлын дарааллыг ялгах, ойлгосноо зураглаж илэрхийлэх, сонссоноо дүрслэн харуулж тогтоох;
4.У1. 4.У4.	Зөв (дуудан), хурдан (80-120 үг), ойлгож (асуултад хариулах), уран (өргөлт, зогсолтыг тохируулан) унших, сайн, муу үйлийг ялгах;




4.Я1. 4.Я2. 4.Я3.	Шинэ санаа нэмж харилцах, сонирхолтой байдлаар тоочих, дүрд тоглох, ярианы хурд, дууны өнгийг тохируулан бусдад хүргэж ярих;
4.Б1. 4.Б2. 4.Б4.	Загвар ашиглан, бүтцийн дагуу зохион бичих, асуултад хариулан тоочих, дарааллын дагуу хүүрнэн бичих, дуурайн бичих, дэгийн дагуу бичих;
4.Х1. 4.Х2. 4.Х3. 4.Х4.	Үеэр зөв тасалж, балархай эгшгийн үүргийг таних, хүүрнэх, асуух, анхааруулах өгүүлбэрийн тэмдгийг хэрэглэх, хувиргах, тийн ялгалын нөхцөлийг залган бичих, журамласан толь ашиглан ижил үгийн утгыг ялгах өрөг-өргө;

### Залгамж холбоо

Чадвар	“Эрүүл амьдрал” нэгжийн хүрээнд эзэмшсэн		
	3 дугаар ангид	4 дүгээр ангид	5 дугаар ангид
Нэгжийн хүрээ	Хоол хүнс (цагаан идээ) Гал тогоонд (хоолны жор) Хувийн ариун цэвэр	Хүнсний дэлгүүр, зах дээр Хоолны цэс Дасгал хөдөлгөөн	Эрүүл хоол хүнс Эрүүл амьдралын хэв маяг (аялал) Эмнэлэг дээр
Үгийн сан	Махан хоол, загас, тахианы мах, хиам цагаан идээ, айраг, ээзгий, бяслаг, өрөм, шар тос, тараг, зайрмаг, үр тариа, гурил, шар будаа, цагаан будаа, бялуу, жимс жимсгэнэ, чавга, чацаргана, гүзээлзгэнэ, лийр, үхрийн нүд, гадил, жимсний чанамал, саримс, өргөст хэмх, ногоотой хуурга, халуун, түргэн, өнгөгүй, өтгөн, чихэрлэг, амттай	Нүүрс ус, уураг, өөх тос, амин дэм, дасгал хөдөлгөөн, алхах, зугаалах, усанд сэлэх, гүйх, эрч хүч, инээмсэглэл, аз жаргал, жаргалтай, гунигтай, баяртай, уурлах, инээх, гомдох, баярлах, ам зайлах, хийжүүлсэн ундаа, нөөшилсөн хүнс, хорхой, шүүс, утсан мах, хуурах, жаргал, зовлон, хоолны цэс	Эрдэнэ шиш, лийр, усан үзэм, өндөг, улаан манжин, жүрж, үзэм, тарвас, байцаа, аарц, ээдэм, хуурай сүү, тогтмол, шарах, чанах, жигнэх, буцлах, аялал, майхан, гар чийдэн, борооны цув, усны гутал, тэмдэглэлийн дэвтэр, гэрэл зургийн аппарат, дуран, туухай, ундаа, гуурс, цэцэгт байцаа, тэшүүр, агаарын теннис, сүх, луужин, дэнлүү, чүдэнз, аяны хөнжил

### Өгүүлбэрийн загвар

- Сурагчид дэлгэрэнгүй өгүүлбэр бичиж сурахад нь туслахын тулд түлхүүр үг болон өөрсдийн тогтмол хэрэглэдэг үгсээс цэгийн оронд нөхөж бичих” гэсэн даалгаврууд илүү ойлгомжтой болгодог.
- Зөв холбож уншаад өгүүлбэр зохиож бичих дадлагууд нь тэднийг бие дааж өгүүлбэр зохиох болон эх боловсруулж бичих чадварыг хөгжүүлэхэд тусална.

 **В. Зөв холбон өгүүлбэр болгон бичээрэй.**

Өглөө эрт босохын тулд	долоо хоногт нэг өдөр л чихэр иддэг.
Хичээлд явахаас өмнө	бөмбөг тоглодог.
Хичээлээс ирсний дараа	дүрмээ заавал баримталдаг.
Хоол идэхийн өмнө	өдрийн цайгаа уудаг.
Шүдээ хамгаалахын тулд	тогтмол гараа угаадаг.
Найзуудтайгаа тоглоход	орой 22 цагаас өмнө унтдаг.

### Загвар ашиглаж эх зохиох

Загварын дагуу танилцуулга зохиож бичих дасгал нь сурагчдын сонгож эвлүүлэх явцдаа эх зохион бичих чадварт тус болно. Тухайлбал, дараах өгүүлбэр бүрээс зөв утга санаатай өгүүлбэр нэгийг сонгон, гурван өгүүлбэртэй эх бүтээлгэж болно. Мөн яагаад тухайн эхийг сонгосон талаар нь асуугаарай.

### Эрт босохын ач тус

1 дүгээр өгүүлбэр:

- Ном уншихын бага зэрэг өлөн бол тогтоолт сайтай байдаг.
- Ном уншихаар бага зэрэг өлөн бол тогтоолт сайтай байдаг.
- Ном уншихдаа бага зэрэг өлөн бол тогтоолт сайтай байдаг.

2 дугаар өгүүлбэр:

- Түүнээс өглөө эрт босож ном уншдаг.
- Тиймээс өглөө эрт босож ном уншдаг.
- Тэрнээс өглөө эрт босож ном уншдаг.

3 дугаар өгүүлбэр:

- Орой толгой сэргэлэн, гэдэс өлөн байдаг.
- Өдөр толгой сэргэлэн, гэдэс өлөн байдаг.
- Өглөөд толгой сэргэлэн, гэдэс өлөн байдаг.

### Цагийн төлөвлөлт (Ээлжит хичээлийн цагийн задаргаа)

№	Ээлжит хичээлийн сэдэв	Цаг	Эхийн төрөл	Хэрэглэгдэхүүн	Шинэ үг
1.	Эрүүл амьдралд юу чухал вэ?	2	илтгэл	ГА 62-р тал ДАД 41-р тал	зөв хооллох, нүүрс ус, уураг, өөх тос, амин дэм, явган алхах, дасгал хөдөлгөөн, гүйх, сэргэг, эрч хүчтэй, талархах, баяр баясгалан бэлэглэх, хэв маяг, урт наслах
2.	Шүдээ угаая	2	шүлэг	ГА 63-р тал ДАД 42-р тал	хөвсгөр оо, түрхэх, ус балгах, ам зайлах, баруун, зүүн, дээшээ, доошоо, шүд хорхойтох, жаргалтай
3.	Дэлгүүрт	2	болсон явдал (хүүрнэмж)	ГА 64-р тал	үйлчлүүлэгч, кассчин, хүнс, бараа, тасаг, дараалал кассчин бараагаа цуглуулах, тооцоо хийх, бүтээгдэхүүний хугацаа, орц, найрлага, ээлжээ хүлээх, дарааллаар зогсох
4.	Бөөрөнхий	3	өгүүллэг (хүүрнэмж)	ГА 67-р тал ДАД 43-р тал	Бөөрөнхий, дүр төрх, санагдах, эрдэмтэн, гунигтай, зөвлөх, хичээллэх, дасгал хөдөлгөөн, жин хасах
5	Хүүхдийн хоолонд хэрэглэх зүйлс	2	танилцуулга (сурталчилгаа)	ГА 67-р тал ДАД 44-р тал	Давс, хийжүүлсэн ундаа, сахар, чихэр, шоколад, жигнэмэг, бялуу, хийжүүлсэн ундаа, кофе, какао, давсалсан, утсан, нөөшилсөн, хуурах, хайрах, транс тос, үр тариа, түргэн хоол, бэлэн гоймон, чипс, хийм, зайдас
6.	Хоолны цэс	2	танилцуулга	ГА 67-р тал	хоолны цэс, нэгдүгээр хоол, шөл, хоёрдугаар хоол, хуурга, цай, сонголт, хавирга, банш, гурил, жунз, бин, бантан, кимчи, хачир, хуйцай, мантуу, цуйван, гуляш, пүнтүүз, тахианы гуя, өндөг, чинжүү, адууны мах, гахайн мах, бөөрөнхий мах, нарийн махан хуурга, чанах.
7.	Хаан жимс	2	сурталчилгаа	ГА 69-р тал	дотнын хүмүүс, бэлэг барих, шим тэжээл, шүд эрүүлжүүлэх, яс бэхжүүлэх, дархлаа дэмжих, биеийн эсэргүүцэл сайжруулах, цангах

### Нэгж хичээлийн заах арга


Энэ хэсэгт зөвлөмжийн бусад хэсэгт давхардаагүй зарим арга, аргачлалыг орууллаа. Та бүхэн хичээл төлөвлөлтдөө тусган, баяжуулж ашиглаарай.

**Би ч гэсэн.** Энэхүү арга нь сонссон аудио бичлэгийг хэрхэн ойлгож буйг илрүүлэхэд тус дэм болохоос гадна, хүүхдүүдийн анхаарлыг төвлөрүүлж, бусдыг сонсох, ойлгоогүй зүйлсээ ойлгож авахад тус дэм болдог.

*Тоглоомын дүрэм:* Яриаг анхааралтай сонсож сөрөг бодолтой санал нийлэхгүй байх. Жишээлбэл,

- Би хорин хоёр цагаас өмнө унтдаг. "Би ч гэсэн"
- Би өдөр бүр дасгал хийдэг. "Би ч гэсэн"
- Би алхах дургүй. "Би ч гэсэн" Үүнийг хэлсэн сурагч тоглоомоос хасагдана.

## Бидний хичээлийн сэдэв юу бол?




- Хичээл эхлэхээс өмнө самбарт уг зургийг өлгөж, энэ зургийн талаар сурагчидтай ярилцана.
- Сурагчдын шинэ хичээлийн талаарх мэдлэгийг нь оношилж болно.

## Сэдэлжүүлэлтийг шинэ хичээлийн эхлэл болгох.

**Самбарт:** Сагсан бөмбөг, ширээний теннис, хөл бөмбөг, ном унших, тэшүүрээр гулгах зэрэг холбоо үгсийг байрлуулна. Сурагчид илүү холбоо үгийг олно.

Appointment  
Clock  
Buddies

Name \_\_\_\_\_  
Date \_\_\_\_\_



## Найзуудын уулзалт

- Сурагчдад зурагч үзүүлсэнчлэн дөрвөн цагийг тодорхой харуулсан карт тарааж өгнө.
- Сурагчид цаг бүрийн доор хамт тоглохоор урих найзынхаа нэр болон түүнд зориулсан урилга бичнэ. Жишээлбэл, "Би чамайг 12:00 цагт хамт сагс тоглоход урьж байна."
- Ингээд 4 цагийн хугацаанд 4 найзынхаа нэрийг бичнэ. Ижил цагт нэр нь бичигдсэн сурагчид нэг баг болж хамтран ажиллана.

**Энэхүү нэгжийн онцлог нь** эрүүл амьдрахад зөв хооллолт, дасгал хөдөлгөөн болох эрүүл дадал хэвшлээс гадна хүмүүсийн зөв харилцаа бас чухал болохыг анхааран үзнэ.

**Брауны хөдөлгөөн.** ГА 70-р тал. Ааруулын ач тус болон ааруул идэх шалтгааныг яриулахын тулд:

- Ааруултай холбоотой зураг, хийх явц, ач тус гэх мэтийн дэлгэрэнгүй мэдээллийг ангийн хананд байрлуулна.
- Сурагчид анги дотор чөлөөтэй явж, ааруулын талаар мэдээлэл цуглуулна.
- Дараа нь цуглуулсан мэдээллээ ашиглан "Ааруулын ач тус" сэдвээр ярина.

**Хамтдаа бүтээе.** ГА 69-р тал. Сурагчид чацаргана жимсний талаарх мэдлэгээ:

- Эхлээд тус тусдаа нэг нэг асуултын дагуу нэг өгүүлбэрээр бичнэ. Асуултыг самбарт бичсэн байна.

Хэнд зориулах вэ?	Дотнын хүмүүстээ зориулна.
Хэзээ уух вэ?	Цангавал хүйтнээр нь ууна. Өвдвөл халуунаар нь ууна.
Ямар?	Халуун, хүйтэн
Ягаад?	Дотнын хүмүүсийнхээ эрүүл жаргалтай харцыг хармаар байна уу?
	Хаан жимс ид шидтэй

- Дараа нь өгүүлбэрүүдийг нэгтгэж сурталчилгаа бүтээж болно. Сурталчилгаагаа самбарт бичиж, тал бүрээс нь засан сайжруулахад хүн бүрийн үүрэг оролцоог хангах нь зүйтэй. Тэгвэл сурагчид бие дааж сурталчилгаа бичихэд бэлэн болсон байна.
- Мөн өгүүлбэрүүдийг нэгтгэж "Чацаргана жимс" эх зохиолгож болно.

**Хөршөөсөө асууя.** "Би хөршөөсөө асууя" аргыг сурагчид санал бодлоо амаар илэрхийлэхэд ашигладаг.

- Эхлээд сурагчдаас эрүүл мэндээ анхаарахын тулд юу хийдэг талаар нь асууж, дараа нь тэднийг хөршүүдээсээ асууж, санал бодлоо хуваалцахыг хүсээрэй.



Хэрэв сэдэв хэт ерөнхий бол түлхүүр үг өгч, хөршөөсөө тухайн сэдвийн талаар түлхүүр үгийг ашиглан асуугаад, тэмдэглэж авснаа ангидаа ирж ярих юм. Тухайлбал, эрүүл хүнсээ хаанаас хэрхэн сонгож авдаг талаар, дасгал хөдөлгөөн хийхийн тулд хэрхэн цаг гаргаж, хаана ямар спортоор хичээллэдэг талаар асуух гэх мэт.

### Орчин

*Материаллаг орчин:*

Ангийн сурагчдын хичээл ойлголт болон тогтоолт янз бүр байдаг ба сурагчид хийсвэр зүйлийг ойлгодоггүй. Тэдний мэдээллийг хүлээж авах онцлогт нь тохируулж бичил үйлийн орчин бүрдүүлэх хэрэгтэй. Иймд зөвхөн сурах бичиг бус бусад ТӨМ, ажлын хуудас, төрөл бүрийн үзүүлэн таниулах материал, видео болон аудио бичлэг, РРТ зэргийг ашиглан хичээлээ заах нь үр дүнтэй байдаг.

### Харилцааны орчин:

Нэгжийн онцлогоос шалтгаалан хүнсний дэлгүүрт юм уу хоолны газарт, эсвэл биеийн тамирын танхимд гүйцэтгэх даалгавар өгч болно. Тухайлбал,

- Хүнсний дэлгүүрээс хүнс сонгохдоо танилцуулж, сурталчилж болно. Хийжүүлсэн ундаа Кока кола авахын оронд чацарганын шүүс авахыг санал болгоод түүний ач тусыг сурталчлан танилцуулах гэх мэт.
- Хоолны газрын цэсээс хоол сонгож захиалах, ямар учраас энэхүү хоолыг захиалсан тухайгаа тайлбарлах гэх мэт.
- Биеийн тамирын танхимд дасгал хөдөлгөөн хийхийн ач тусыг сурталчилж, энгийн дасгалуудын зааврыг хэлж, биеэр үзүүлж болно.
- Та сурагчидтайгаа тэднийг хөгжүүлэх зорилт тавьсан тэр хэлээрээ харилцана.
- Аль болох хүүхдийг сэдвийн хүрээний үгсийг ашиглан тантай болон өөр хоорондоо харилцахыг дэмжээрэй. Үүний тулд: Бусдыг анхааралтай сонсох, үгсийг зөв дуудах, уран унших, асуулт тавих зэрэг үйлийг хийх нь чухал юм.

### Нэгж хичээлийн үнэлгээний шалгуур:

#### СОНСОХ ЧАДВАРЫГ ҮНЭЛЭХ

Нэгж хичээлийн суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
		I	II	III	IV
Шүлэг, зүйр цэцэн үг, ертөнцийн гурав, оньсогыг сонсож, утгыг зурж дүрслэх замаар цээжлэн тогтоох	Шүдээ угаая дууг (шүлэг)-ийг сонсоод, зураг ашиглан тэмдэглэж, цээжилдэг.	Шүлгийг сонсоод зурагт оновчгүй тэмдэглэдэг, шүлгээс цөөн үг цээжилдэг.	Шүлгийг сонсоод, зураг ашиглан заримыг нь тэмдэглэдэг, цөөн мөр цээжилдэг.	Шүлгийг сонсоод, зураг ашиглан тэмдэглэж, ихэнхийг цээжилдэг.	Шүлгийг сонсоод, зураг ашиглан тэмдэглэж, бүрэн цээжилдэг.

#### ЯРИХ ЧАДВАРЫГ ҮНЭЛЭХ

Нэгж хичээлийн суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
		I	II	III	IV
Шинэ санаа нэмж харилцах	Эрүүл амьдрахад хэрэгтэй зүйлс болон, биеийн тамираар хичээллэдэг талаар дэлгэрүүлж ярьдаг.	Нэгжийн агуулгын хүрээнд салангид үгс, холбоо үгээр ярьдаг.	Нэгжийн агуулгын хүрээнд өгүүлбэрээр ярьдаг. Бусдын тусламжтайгаар жишээ хэлдэг.	Нэгжийн агуулгын хүрээнд бүтэн өгүүлбэрээр, зарим нэгэн жишээ авч дэлгэрэнгүй ярьдаг.	Нэгжийн агуулгын хүрээнд жишээ баримтаар баяжуулан, бүтэн өгүүлбэрээр, дэлгэрүүлж ярьдаг.



Сонирхолтой байдлаар тоочих	Хүнсний дэлгүүрээс хүнс худалдаж авахад анхаарах зүйлсийг зураг ашиглан тоочин ярьдаг.	Зургаас ганц нэг агуулгыг хэлдэг.	Зургийн агуулгаас тоочдог. Ихэнхийг алддаг.	Зургийн агуулгыг бүрэн тоочдог. Цөөн алдаа гаргадаг.	Зургийн агуулгыг зөв, оновчтой, бүрэн тоочдог.
-----------------------------	--	-----------------------------------	---	--	--

### УНШИХ ЧАДВАРЫГ ҮНЭЛЭХ

Нэгж хичээлийн суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
		I	II	III	IV
Харилцан ярианы үг хэллэгийг зөв унших	Харилцан ярианы үг хэллэгийг зөв дуудан уншдаг.	Харилцан ярианаас цөөн үгийг үелж, сул дуугаар уншдаг.	Харилцан ярианы зарим үгийг үелж, сул дуугаар уншдаг.	Харилцан ярианы бүх үе, үсгийг уншихдаа цөөн алдаа гаргадаг, алдсан үгээ засаж, тод уншдаг.	Харилцан ярианы бүх үг, үе, үсгийг сольж гээлгүй, зөв дуудан жигд хурдаар, тод уншдаг.
Үлгэр, өгүүлэгийн баатрын сайн, муу үйлийн учир шалтгааныг ойлгож, бодит амьдралтай харьцуулан жишээ татан дүгнэх	Сайн, муу үйлийг ялгаж, бодит амьдралтай харьцуулан оновчтой жишээ татан тайлбарладаг.	Сайн, муу үйлийг ялгахыг оролддог.	Сайн муу үйлийг ялгадаг ч, жишээ авдаггүй.	Сайн, муу үйлийг ялгадаг, зарим жишээ оновчгүй байдаг.	Сайн, муу үйлийг ялгаж, оновчтой жишээ татан тайлбарладаг.

### БИЧИХ ЧАДВАРЫГ ҮНЭЛЭХ

Нэгж хичээлийн суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
		I	II	III	IV
Загварын дагуу асуултад хариулан тоочих	Хоолны цэсийг асуултад хариулан тоочин бичдэг.	Хоолны цэсээ ганц нэг үг хэлдэг.	Асуултыг ойлгосон ч дутуу тоочдог.	Асуултыг ойлгож, хариулж тоочин бичихдээ цөөн алдаа гаргадаг.	Асуултыг ойлгож, хариулж бичихдээ оновчтой, алдаагүй тоочин бичдэг.
Дарааллын дагуу хүүрнэн бичих	Бөөрөнхий эхийг уншаад эхлээд, дараа нь, эцэст нь гэсэн үгийг ашиглан дарааллын дагуу бичнэ.	Бичихдээ үйл явдлыг эмх цэгцгүй, урд хойно нь оруулан бичдэг.	Бичихдээ үйл явдлыг тоочин бичдэг.	Бичихдээ үйл явдлыг зөв дараалуулан эхлэл, гол хэсэг, төгсгөл хэсэгтэй алдаагүй бичдэг.	Бичихдээ үйл явдлыг зөв дараалуулан, эхлэл, гол хэсэг, төгсгөл хэсэгтэй, санаагаа ойлгомжтой илэрхийлэн, утгын уялдаа холбоотой, алдаагүй бичдэг.

### ХЭЛ ЗҮЙ, ҮГИЙН САНГ ХЭРЭГЛЭХ ЧАДВАРЫГ ҮНЭЛЭХ

Нэгж хичээлийн суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
		I	II	III	IV
Үгийг үелэх	Үеийн бүх хэлбэрүүдийг ялган таньж үеэр зөв тасалж чаддаг.	Нэг үетэй үгийг тасалдаг.	Нэг үенд хэд хэдэн эгшгийг оруулж үеэр тасалдаг.	Үгийг эгшгийн тоогоор үеэр тасалдаг ч эцсийн гийгүүлэгчийн өмнүүр таслахдаа алдаа гаргадаг.	Үгийг эгшгийн тоогоор, эцсийн гийгүүлэгчийн өмнүүр үеэр зөв тасалж чаддаг.



Нэрийн нөхцөлийг зөв хэрэглэх	Тийн ялгалын нөхцөлийг залган бичдэг	Тийн ялгалын нөхцөлийг ашигладаггүй.	Тийн ялгалын нөхцөлийг залган бичихдээ ихээхэн алдаа гаргадаг.	Тийн ялгалын нөхцөлийг залган бичихдээ цөөн алдаа гаргадаг.	Тийн ялгалын нөхцөлийг алдаагүй залган бичдэг.
Хүүрнэх, асуух, анхааруулах, захирах өгүүлбэр зохиож, хувиргах	Хүүрнэх өгүүлбэрийг асуух, анхааруулах өгүүлбэр болгон бичиж, цэг тэмдгийг зөв хэрэглэдэг.	Хүүрнэх өгүүлбэрийг асуух, анхааруулах өгүүлбэр болгон хувиргаж чаддаггүй.	Хүүрнэх өгүүлбэрийг асуух, анхааруулах өгүүлбэр болгохдоо хольж сольдог.	Хүүрнэх өгүүлбэрийг асуух, анхааруулах өгүүлбэр болгон зөв бичдэг, зарим тэмдгийг буруу хэрэглэдэг.	Хүүрнэх өгүүлбэрийг асуух, анхааруулах өгүүлбэр болгон зөв бичдэг, цэг тэмдгийг зөв хэрэглэдэг.

**Ээлжит хичээлийн сэдэв:**

Б.Ринчен “Миний нутаг”

**Бүлэг сэдэв:** Байгаль дэлхий





Хугацаа 80 минут

Ээлжит хичээлийн зорилго	Ээлжит хичээлийн зорилт	
“Миний нутаг” шүлгийг сонсож, цээжилж уран уншиж сурна.	<p>“Миний нутаг” шүлгийг сонсож, утгыг зурж дүрслэх замаар цээжлэн тогтооно.</p> <p>“Миний нутаг” шүлгийг цээжээр, өргөлт, зогсолт, аялга, ярианы хурд, дууны өнгийг тохируулан уран уншина.</p> <p>Шүлгийг тууш шугамтай дэвтэрт том, жижиг үсгийн өндөр, өргөн, налуу, холболтыг зөв хийж, цэвэр сайхан, алдаагүй бичнэ.</p> <p>Өгүүлбэрийн цэг тэмдгийг хэрэглэнэ, хамтрахын тийн ялгалын нөхцөлийг залган бичнэ, үеэр зөв тасална.</p>	
Хүрэх үр дүн: Энэ хэсэг сурагчдын хэлний түвшин, ялгаатай байдлыг харгалзан үр дүнг тооцох зорилготой юм.		
Бүх сурагчид: С: Шүлгийг сонсож, дүрсэлсэн зүйлсийг зурна. У: Шүлгийг цээжээр уншина. Б: Тууш шугамтай дэвтэрт том, жижиг үсгийн өндөр, өргөн, налуу, холболтыг зөв хийж бичнэ.	Ихэнх сурагчид: С: Шүлгийг сонсож, дүрсэлсэн зүйлийг зурж, түлхүүр үгсийг тогтооно. У: Шүлгийг цээжээр, дууны өнгө, аялгыг тохируулан уншина. Б: Тууш шугамтай дэвтэрт том, жижиг үсгийн өндөр, өргөн, налуу, холболтыг зөв хийж, цэвэр сайхан бичнэ.	Зарим сурагчид: С: Шүлгийг сонсож, дүрсэлсэн зүйлийг зурж, дүрслэн, бүрэн цээжилнэ. У: Шүлгийг цээжээр, ярианы хурд, дууны өнгө, өргөлт, зогсолт, аялгыг тохируулан уран уншина. Б: Тууш шугамтай дэвтэрт том, жижиг үсгийн өндөр, өргөн, налуу, холболтыг зөв хийж, цэвэр сайхан, алдаагүй бичнэ.
Үгийн сан	Хүнд үгс: Аарц арц, тунгалаг, тунамал, мандмал, ундармал, гиймэл, анхилмал, рашаан	
Хандлага	Эх орныхоо байгалийн сайхнаар бахардаг болно.	
Хичээл хоорондын холбоо	Хүн ба байгаль, дүрслэх урлаг	
Өмнөх мэдлэг	Ч.Чимидийн “Монгол орон” шүлгийг зурж, дүрслэх замаар цээжлэн тогтоосон Шүлгийн төрөл, бүтцийн талаар мэддэг	





**Хичээлийн явц, аргагүй**

Үе шат	Суралцахуйн үйл ажиллагаа	Явцын үнэлгээ
	Зохион байгуулалт хийнэ. (2 мин) Сурагчидтай мэндэлж, амжилт хүснэ. Хичээлийн дэгийг танилцуулна. Өнгөрснийг давтана.	Хичээлийн дэгийг баримталж буй эсэхийг ажиглаж аман үнэлгээ өгнө.



<p>Хичээлийн эхлэл 8 мин Үйл ажиллагаа 1</p>	<p>Алхам 1. (4 мин) Сэдэлжүүлэх. Слайдаар зураг үзүүлнэ. Сурагчид зургийг ажиглан, багшийн асуултад хариулж, харилцан ярилцана. Зурагт байгаа зүйлсийг тоочин нэрлэнэ.</p>  <div data-bbox="272 555 1139 645" style="background-color: #0070C0; color: white; padding: 5px; text-align: center;"> <p><b>Хичээлийн зорилго:</b> Шүлгийг сонсож, утгыг зурж дүрслэх замаар цээжлэн тогтооно.</p> </div> <p>Зураг дээр юу юу байна вэ? Нэрлээрэй. Манай аймагт ийм байгалийн үзэсгэлэнтэй ямар ямар газар байдаг вэ? Уултай устай ийм газрыг ямар газар гэдэг вэ? Багшийн тайлбар: Хангай Алхам 2. (2 мин) Хичээлийн сэдэв, зорилгыг тодорхойлох. Сурагчид хичээлийн сэдэв, зорилгыг уншиж танилцана</p>	<p>Сурагчдын нэрлэн хэлж байгааг, асуултад хариулж байгаад аман үнэлгээ өгнө.</p>
<p>Үйл ажиллагаа 2 Хичээлийн үндсэн хэсэг 60 мин</p>	<p>2. <b>А. Шүлгийн мөртэй зургийг тохируулж дугаарлаарай.</b></p>  <p>1. Үнэр сайхан өвстэй 2. Өнгийн сайхан цэцэгтэй 3. Хадтай сайхан уултай 4. Хан бүргэд шувуутай 5. Арин сайхан рашаан ундармал 6. Арцны сайхан үнэр анхилмал</p> <p>Алхам 1. (8 мин) Шүлгийг сонсоно. Ойлгосныг илрүүлэх даалгавар ажиллана. Хүнд үгсийг ангийн хананд, харааны түвшинд байрлуулна. ДАД 57-р хуудас Алхам 2. (2 мин) Шүлгийн эхний 2 бадгийг сонсоод зургийг шүлгийн утгад тохируулан будна.</p>	<p>Алхам 1. (8 мин) Шүлгийг сонсоно. Ойлгосныг илрүүлэх даалгавар ажиллана. Хүнд үгсийг ангийн хананд, харааны түвшинд байрлуулна. ДАД 57-р хуудас Алхам 2. (2 мин) Шүлгийн эхний 2 бадгийг сонсоод зургийг шүлгийн</p>
	  <p>Алхам 3. (10 мин) Шүлгийн төгсгөлийн 2 бадгийг сонсоно. Даалгаврыг хэрхэн гүйцэтгэхийг анхааруулж хэлнэ. Сурагчид даалгаврын зааврыг уншиж төгсгөлийн хоёр бадгийг сонсож, шүлгийн утгыг тохирох зурагтай нь харгалзуулан холбоно. Алхам 4. (10 мин) Шүлгийг уншина. ГА 89-р тал Дасгал 3 Шүлгийг уншихдаа өргөлт, зогсолт, аялгыг тохируулан уншихад нь анхаарна. Шүлгийг сурагч бүр өөртөө уншина. Сурагчид шүлгийн анги нийтээр уншина. Хүүхэд бүр 1-1 мөрөөр марафон уншлагын аргаар уншина. Ангийн хэд хэдэн сурагчаар уншуулна. Асуултад хариулж, өөрийн санаа бодлоо илэрхийлнэ. Алхам 5. (15 мин) ДАД -ын 57-р тал Даалгавар 3 А</p>	<p>Анхааралтай сонссон эсэхийг зөв дугаарлаж буйгаар үнэлнэ.</p> <p>Сонссоноо ойлгож, будаж байгааг дөхүүлэх асуулт тавьж үнэлнэ.</p>



<p>Үйл ажиллагаа 2 Хичээлийн үндсэн хэсэг 60 мин</p>	<p><b>В.Тохирох үгсийг нөхөж бичээрэй.</b></p> <p><b>Ашиглах үгс:</b> гиймэл сар, ундармал рашаан, анхилмал үнэр.</p>  <p>Зургийг ажиглан тохирох холбоо үгийг зургийн доор нөхөж бичнэ. Тайлбарлан ярина. Өгүүлбэр зохиож бичнэ. Алхам 6. (15 мин) Шүлгийг зураг дүрслэлийн аргаар цээжээр уншуулна. Анги нийтээрээ уншина Эгнээгээр уншина Ганцаар уншина.</p> 	<p>Сонссоноо ойлгож, зөв харгалзуулж байгаа эсэхийг үнэлнэ.</p> <p>Өргөлт, зогсолт, аялгыг тохируулан уншиж буйг үнэлнэ.</p> <p>Үгийг зурагтай зөв тохируулан бичсэнийг үнэлнэ. Өгүүлбэрийг оновчтой үг хэллэг хэрэглэн, утга төгөлдөр найруулан бичсэн эсэхийг үнэлнэ.</p>
<p>Үйл ажиллагаа 2 Хичээлийн үндсэн хэсэг 60 мин</p>	<p>Алхам 7. ( мин) Хүнд үгийн тайлбар хийнэ. ГА 89-р тал 3 В Багш дараах хүнд үгсийн зургийг үзүүлж, тайлбарлана. Гарын авлагын 69-р нүүр Дасгал 3В Үгийн утгыг ялгах даалгаврыг ажиллуулна.</p> <p><b>В. Үгсийн утгын ялгааг ойлгон зөв дуудаж уншаарай. Өгүүлбэрийг бичээрэй.</b></p> <div style="display: flex; justify-content: space-around;"> <div data-bbox="352 1249 699 1507"> <p><b>аарц</b></p>  <p><b>цагаан идээ</b></p> <p><i>Талар, айргийг буцалсан шар сүүр нь шүүсэн цагаал ..... гэнэ.</i></p> </div> <div data-bbox="767 1249 1114 1507"> <p><b>арц</b></p>  <p><b>ургамал</b></p> <p><i>Өндөр ууланд ургах мөнх ногоон, анхилуун үнэртэй ургамлыг ..... гэнэ.</i></p> </div> </div>	<p>Шүлгийг уншихдаа утга агуулгыг зурагтай холбон зөв дарааллаар, зөв дуудан уншиж байгаа эсэхийг аман үнэлгээгээр урамшуулна.</p> <p>Өгүүлбэрийг гүйцээж зөв бичиж байгаа, дэгийн дагуу бичиж байгааг үнэлнэ.</p>
<p>Үйл ажиллагаа 3. Бататгал 8 мин</p>	<p>Алхам 1. (8 мин) Шүлгийг эхний бадгийг үгийг зөв байрлуулан зурган хэлбэрээс шүлгийг уншиж тогтооно. Шүлгийн эхний бадгийг цээжлэхдээ ашигласан 16 ширхэг зургийг самбарт зөв дараалалд оруулан байрлуулна. 4 сурагч самбарт гарч ажиллана. Сурагч бүр зөв байршуулсан шүлгийн мөрийг уншина. Бусад сурагчид анхааралтай сонсож дэвтэртээ цэвэр, алдаагүй бичнэ. Сурагчид шүлгийг цээжээр уран уншина.</p>	<p>Зургийг зөв байрлуулж, шүлгийг цээжээр уран уншиж байгаа эсэхийг үнэлнэ. Шаардлагатай тохиолдолд засаж хэлнэ.</p>
	<p><b>Санал болгох идэвхтэй арга.</b> Шүлгийн үг, холбоо үгийн утгыг илтгэсэн зургийг зөв байрлуулан унших нь зурган картыг уялдаа холбоотой байрлуулах логик сэтгэлгээ хөгжүүлэхээс гадна, цээжилж тогтоосноо бүтээлчээр илэрхийлэх нэг хэлбэр болно. Харин бусад сурагчдаар шүлгийг мөр бүрээр унших марафон аргыг ашиглаарай. Энэ үед зургийг зөв, буруу байрлуулсныг уншигч хүүхэд илрүүлэн дүгнэж болох ба үе тэнгийнхний үнэлгээ хийлгэж болох давуу талтай.</p>	



Үйл ажиллагаа 4. Гэрийн даалгавар 1 мин	<b>Гэрийн даалгавар:</b> “Миний нутаг” шүлгийг бүрэн эхээр нь цээжилнэ. Даалгавар ажиллана. ГА 89-р тал Б, ДАД , 57-р тал Г. Д																	
Үйл ажиллагаа 5. Хичээлийн дүгнэлт 3 мин	Сурагчид өөрийгөө болон хичээлийг үнэлнэ. Өнөөдрийн хичээлээр би юу сурсан бэ? Өөрийгөө үнэлэх хүснэгтийг бөглөнө. <table border="1" data-bbox="268 577 1129 869"> <tr> <td data-bbox="268 577 683 707">Үнэлгээний шалгуур</td> <td data-bbox="683 577 831 707"></td> <td data-bbox="831 577 979 707"></td> <td data-bbox="979 577 1129 707"></td> </tr> <tr> <td data-bbox="268 707 683 752">Би шинэ үгийн утгыг мэдэж авсан.</td> <td data-bbox="683 707 831 752"></td> <td data-bbox="831 707 979 752"></td> <td data-bbox="979 707 1129 752"></td> </tr> <tr> <td data-bbox="268 752 683 819">Би шүлгийн эхний 2 бадгийг дүрслэх замаар тогтоож авсан.</td> <td data-bbox="683 752 831 819"></td> <td data-bbox="831 752 979 819"></td> <td data-bbox="979 752 1129 819"></td> </tr> <tr> <td data-bbox="268 819 683 864">Би шүлгийг уран уншиж сурсан.</td> <td data-bbox="683 819 831 864"></td> <td data-bbox="831 819 979 864"></td> <td data-bbox="979 819 1129 864"></td> </tr> </table>	Үнэлгээний шалгуур				Би шинэ үгийн утгыг мэдэж авсан.				Би шүлгийн эхний 2 бадгийг дүрслэх замаар тогтоож авсан.				Би шүлгийг уран уншиж сурсан.				Сурагчид даалгавар бүрийн гүйцэтгэлийн дараа өөрөө өөрийгөө үнэлнэ.
Үнэлгээний шалгуур																		
Би шинэ үгийн утгыг мэдэж авсан.																		
Би шүлгийн эхний 2 бадгийг дүрслэх замаар тогтоож авсан.																		
Би шүлгийг уран уншиж сурсан.																		
<b>Хичээлийн талаар эргэцүүлэн бодох.</b> Энэ хэсэгт хичээл заасны дараа багш дараах асуултыг өөртөө тавьснаар хичээлээ сайжруулах үндэслэл болох юм. Хичээлийн зорилгоо зөв тодорхойлсон уу? Зорилгодоо хүрч чадсан уу? Зорилгодоо хүрээгүй бол шалтгаан нь юу вэ? Багш сурагчийн хамтын ажиллагаа амжилттай болсон уу? Хугацаагаа зөв хуваарилсан уу? Төлөвлөлтөөс гажсан уу? Яагаад? Сурагчдад бие даан ажиллах боломжийг олгосон уу?	Орчин: Бие биеэ сонсох, хүндэтгэх Ангийн орчныг бүрдүүлэх.																	

- Ээлжит хичээлийн сэдэв:** Бэлэн хувцасны дэлгүүрт
- Бүлэг сэдэв:** «Хувцаслалт, хувийн соёл»
- Хугацаа:** 80 минут

Ээлжит хичээлийн зорилго	Ээлжит хичээлийн зорилт
“Бэлэн хувцасны дэлгүүрт” харилцан яриаг сонсож, харилцаж, худалдан авалт хийж сурна.	Харилцан ярилцахдаа дуустал хүлээцтэй сонсож, оновчтой асуулт асууж харилцана. Үг хэллэгийг харилцан ярианаас зөв, хурдан, ойлгож, уншина Харилцан ярианд шинэ санаа нэмж оролцоно. Бичихдээ тууш шугамтай дэвтэрт дэгийн дагуу цэвэр сайхан, алдаагүй бичнэ. Үеэр зөв таслах

**Хүрэх үр дүн:** Энэ хэсэг сурагчдын хэлний түвшин, ялгаатай байдлыг харгалзан үр дүнг тооцох зорилготой юм.

<b>Бүх сурагчид:</b> С: Дэлгүүрт худалдагчтай ярилцахдаа дуустал хүлээцтэй сонсож ойлгоно. Я: Харилцан яриаг сонсож ойлгоно. У: Харилцан яриаг хосоор уншихдаа зөв унших Б: Бичихдээ тууш шугамтай дэвтэрт дэгийн дагуу бичнэ	<b>Ихэнх сурагчид:</b> С: Дэлгүүрт худалдагчтай ярилцахдаа дуустал хүлээцтэй сонсож, асуулт асууна. Я: Харилцан ярианд оролцоно. У: Харилцан яриаг хосоор уншихдаа зөв, хурдан, унших Б: Бичихдээ тууш шугамтай дэвтэрт дэгийн дагуу цэвэр сайхан	<b>Зарим сурагчид:</b> С: Дэлгүүрт худалдагчтай ярилцахдаа дуустал хүлээцтэй сонсож, асуулт асууж өөрт хэрэгтэй мэдээллийг олж авна. Я: Харилцан ярианд шинэ санаа нэмж оролцоно. У: Харилцан яриаг хосоор уншихдаа зөв, хурдан, ойлгож, уншина Б: Бичихдээ тууш шугамтай дэвтэрт дэгийн дагуу цэвэр сайхан, алдаагүй бичнэ
---	---	---



Үгийн сан	Хүнд үгс: Пүүз, усны гутал, гэрийн шаахай, илэг, хилэн, ноолуур, таар, сийрс, торго, судалтай, цулгуй, шоотой, одтой, эрээн, хээтэй, томдох, багадах, уртдах, богинодох
Хандлага	Хувцаслах соёл болон үйлчилгээний газарт үйлчлүүлэхдээ харилцааны соёлд суралцах.
Хичээл хоорондын холбоо	Технологи, Монгол ёс хүмүүжил
Өмнөх мэдлэг, чадвар	Харилцан ярианд оролцох, дэлгүүрт болон хувцасны талаарх үгс

### Хичээлийн явц, аргазүй

Үе шат	Суралцахуйн үйл ажиллагаа	Үнэлгээ
Хичээлийн эхлэл 15 мин Үйл ажиллагаа 1	 <p>Зохион байгуулалт хийнэ. (3 мин) Сурагчидтай мэндэлж, амжилт хүснэ. Хичээлийн дэгийг танилцуулна. Өнгөрснийг давтана Алхам 1. (10 мин) Сэдэлжүүлэх. “ДЭЛГҮҮР ХЭСЬЕ” тоглоом тоглоно. Хэрэглэгдэхүүн: Цаасан болон хаягдал материалаар хийсэн хувцаснууд, шошго, сагснууд. Бэлтгэл: Цаас болон хаягдал материалаар хувцас хийж хананд байрлуулна. Хувцас бүр шошготой байх ба шошгон дээр хэмжээ, үнэ, материалын мэдээлэл байна. Явц: Сурагчдыг дараах багт хуваана. Зуслан, Хөдөө, Театр, Сургууль, Тэмцээн (спорт) Багийн нэрээр нэрлэсэн сагснуудыг сонгон авна.</p>  <p>Багийн сурагчид хувцаснуудаас сонгож сагсандаа хийнэ. Багийн нэрдээ тохируулан хувцсаа сонгохыг сануулна. Төгсгөл: - Ямар ямар хувцас авснаа хэлнэ. - Ямар хэмжээтэй, ямар үнэтэй, ямар материалтайг хэлнэ. - Яагаад сонгосноо хэлнэ. - Нийт хэдэн төгрөгийн үнэтэйг хэлнэ.</p> <p>Алхам 2. (2 мин) Хичээлийн сэдэв, зорилгыг тодорхойлох. Сурагчид хичээлийн сэдэв, зорилгыг уншиж танилцана.</p>	<p>Хичээлийн дэгийг баримталж буй эсэхийг ажиглаж аман үнэлгээ өгнө.</p> <p>Багийн нэртэй буюу хувцас өмсөх орчин нөхцөлтэй тохирох хувцас сонгосон эсэх Хэмжээ, материалыг тааруулсан эсэх. Үнийн тооцооллыг зөв гаргасан эсэхээр үнэлнэ. Ярихдаа үгийг оновчтой сонгон хэлбэржүүлж, өгүүлбэрийг зөв найруулж, зөв дуудаж байгаагаар үнэлнэ.</p>
	<p>Алхам 1. (5 мин) Сонсох даалгавар 1. Сонсох хэрэглэгдэхүүн, өнгийн харандаа. Хэн ямар хувцас өмссөнийг зурна. Аав нь саарал ноосон цамц, хөх жинстэй, хар ботинктой байна. Нарны шил зүүж, гартаа жижиг хар цүнх барьжээ. Ээж нь дэрвэгэр хормойтой шар эрээн даашинз, цагаан сандаал, бүрх малгай өмсжээ. Хүзүүндээ шар алчуур зангидаж, гартаа шүхэр барьсан байна. Хүү нь хөх богино ханцуйтай цамц, улаан шорт, шар пүүзтэй байна. Саравчтай малгай өмсөж үүргэвч үүрчээ.</p>  <p>А. Гэр бүлийнхэн ямар хувцас өмссөнийг зураарай.</p> <p>Алхам 2. (10 мин) Сонсох даалгавар 2. Сонсох хэрэглэгдэхүүн. Өнгийн харандаа. ДАД 61-р тал. Харилцан яриаг сонсоод сорил ажиллана. Ойлгосныг илрүүлэх зорилготой тул хүүгийн худалдаж авсан хувцас болон ашигласан зүйлсийг зуруулна. - Хүү дэлгүүрээс юу юу худалдаж авсан бэ?</p> <p>- Ямар цамц авсан бэ? - Ямар гутал авсан бэ? - Хэдээр авсан бэ?</p>	



Алхам 3. (5 мин) СУРТАЛЧИЛГАА зурагт хуудас бүтээе.  
Хүүг дэлгүүрт ороход худалдагч түүнд юу гэж хэлсэн бэ? Түүнийг ашиглан багаараа зурагт хуудас бүтээцгээе.  
Зурагт хуудсыг хаана хаана байрлуулж болох вэ?



Алхам 3. (10 мин) Харилцан яриаг хосоор уншина. ГА 95-р тал. Хосоор уншихдаа зөв дуудаж, хурдан уншихад чиглүүлнэ.  
Зөв дуудаж байгаа эсэхийг сурагчдаар ажиглуулж үнэлүүлнэ. Сонсох бичлэгтэй харьцуулж, давтан хэлүүлнэ.  
Анхаарах үгс: малгайтай ноосон цамц, хайж байна, хэмжээтэйг, өнөөдөр, дэлгүүрийн, түрийтэй, саарал, цагаан, өрөөнүүд, хямдарна, үйлчлүүлээрэй.  
Хурдан уншихад өгүүлбэрээр нь давтан хэлүүлэх арга хэрэглэнэ.  
Алхам 4. (10 мин) Асуултад хариулж бичнэ. ГА 96-р тал.  
Алхам 5. (10 мин)  
Зураг дээр юу юу байна вэ? Нэрлээрэй.  
Манай аймагт ийм дэлгүүр байдаг уу? Хаана байдаг вэ?  
Зураг дээрх түлхүүр үгийг ашиглан танилцуулаарай.

**В. Зургийн дагуу түлхүүр үгсийг ашиглан тоочин танилцуулж яриарай.**



Алхам 6. (5 мин)  
Хүнд үгийн тайлбар хийнэ.  
Багш дараах хүнд үгсийн зургийг үзүүлж, тайлбарлан, дагуулан хэлнэ.  
Үгийн утгыг ялгах даалгаврыг ажиллуулна. Ж: элэг-илэг

Энэхүү даалгавар зурж дүрслэх замаар цээжилж тогтоох зорилготой учраас тогтоосныг зургаа харж нэрлүүлж үнэлнэ. Аман үнэлгээгээр урамшуулаарай.

Сорилыг хэрхэн ажилласныг зөв хариултыг сурагчдад харуулан солилцуулж үнэлнэ.

Зурагт хуудсанд хямдрал болон боломжуудыг багтаасан эсэх, найруулгатай, давуу талыг илэрхийлж бичсэн эсэхээр үнэлнэ.

Асуултыг ойлгож зөв хариулж бичиж байгаа, дэгийн дагуу бичиж байгааг үнэлнэ.

Ярих чадварыг үгийн утгыг мэдэж, хувиргаж, зөв бүтэцтэй өгүүлбэрээр танилцуулж ярьж байгааг үнэлнэ.

Үйл ажиллагаа 2  
Хичээлийн үндсэн хэсэг 55 мин

Үйл ажиллагаа 3.  
Баталгал 5 мин

Алхам 1.  
“ДЭЛГҮҮРТ” дүрд тоглоно.  
Худалдагч  
Кассчин  
Худалдан авагч

Харилцах чадварыг үнэлнэ.



<p>Үйл ажиллагаа 4. Гэрийн даалгавар 2 мин</p>	<p>Гэрийн даалгавар: ГА 89-р тал Б.ДАД 62-р тал Г. Д Хувцасны төрөл, материал, загвар хэмжээг уншиж, дугаарлаж, цээжилж тогтооно. Гэрийнхнээсээ тусламж авч болно. Үеэр тасална.</p>																	
<p>Санал болгох идэвхтэй арга - Дүрд тоглох арга</p>																		
	<p>Зохион байгуулалт-Багт хуваах санаа</p> <ul style="list-style-type: none"> <li>- Сурагчдаар өөрсдөөр нь сонгуулах</li> <li>- Хичээлтэй холбоотой ямар нэг зүйлсийн өнгөөр бүлэглэх (Өмссөн хувцсаар)</li> <li>- Дугаар сугалуулах</li> <li>- Хөзөр ашиглах</li> <li>- Санамсаргүй бүлэг</li> <li>- Энгэрийн зүүлтээр бүлэглэх</li> <li>- Сурагчдын төрсөн сар өдөр, төрсөн аймаг хотын эхний үсгийн дарааллын дагуу бүлэглэнэ.</li> <li>- Мөн дараалуулан тоолуулж бүлэгт хувааж болно.</li> <li>- Дуу дуулах. Дууны нэр тарааж ижил дуу дуулж байгаагаар бүлэглэх</li> </ul>	<p>Энэхүү арга нь бодит амьдралын нөхцөл байдлыг хамгаалалттай, эрсдэлгүй орчинд хэрэгжүүлэх явдал юм. Суралцагсдад хамтран ажиллаж олж авсан ур чадвараа дадлагажуулах боломж олгодог ба шинээр олж авсан чадварыг хэвшүүлэх, тодорхой нөхцөл байдал ямар байхыг төсөөлүүлж, мэдрүүлэх, сурагчдад өөрсдийнх нь зан байдал, үйлийн талаар харуулах ач холбогдолтой юм.</p> <p>Давуу тал: Ур чадварыг хөгжүүлдэг Сурагчдад сурсан зүйлээрээ дадлага хийх боломж олгодог Сурагчдад өөрсдийн зан үйлээ хардаг</p> <p>Сул тал: Зарим оролцогчид айж эмээдэг талтай Нөхцөл байдал бодит байдлаас арай өөр байдаг Маш их төлөвлөж, бэлтгэхийг шаарддаг Ашиглах үгс: Худалдагчийн бараагаа танилцуулах үгс: Сайн байна уу? Манай дэлгүүрт тавтай морилно уу. Та ямар хувцас сонирхож байна вэ? Та өөртөө хувцас худалдан авахыг хүсэж байна уу? Таны биеийн хэмжээ хэд вэ? Өмсөөд үзээрэй. Кассчины тооцоо хийхэд ашиглах үгс: Таны тооцоо .... төгрөг болсон байна. Та төлбөрөө бэлнээр хийх үү? Картаар хийх үү? Та картын нууц үгээ оруулна уу. Энэ таны хариулт мөнгө. Та тор авах уу? Баярлалаа, дахин үйлчлүүлээрэй. Худалдан авагчийн асуултууд: Сайн байна уу? Танайд .... байгаа юу? Ямар үнэтэй вэ? Хямдрал урамшуулал байна уу? Арай том (жигжиг) байна уу? Өөр ямар өнгө байгаа вэ? гэх мэт.</p>																
<p>Үйл ажиллагаа 5. Хичээлийн дүгнэлт 3 мин</p>	<p>Сурагчид өөрийгөө болон хичээлийг үнэлнэ. Өнөөдрийн хичээлээр би юу сурсан бэ? Өөрийгөө үнэлэх хүснэгтийг бөглөнө.</p> <table border="1" data-bbox="272 1541 1217 1794"> <tr> <td data-bbox="272 1541 798 1671">Үнэлгээний шалгуур</td> <td data-bbox="798 1541 941 1671"></td> <td data-bbox="941 1541 1085 1671"></td> <td data-bbox="1085 1541 1217 1671"></td> </tr> <tr> <td data-bbox="272 1671 798 1711">Би тоглоомд идэвхтэй оролцсон.</td> <td data-bbox="798 1671 941 1711"></td> <td data-bbox="941 1671 1085 1711"></td> <td data-bbox="1085 1671 1217 1711"></td> </tr> <tr> <td data-bbox="272 1711 798 1751">Би хосоор уншихдаа зөв, хурдан уншсан.</td> <td data-bbox="798 1711 941 1751"></td> <td data-bbox="941 1711 1085 1751"></td> <td data-bbox="1085 1711 1217 1751"></td> </tr> <tr> <td data-bbox="272 1751 798 1794">Би дүрд тоглохдоо сайн ярьсан.</td> <td data-bbox="798 1751 941 1794"></td> <td data-bbox="941 1751 1085 1794"></td> <td data-bbox="1085 1751 1217 1794"></td> </tr> </table>	Үнэлгээний шалгуур				Би тоглоомд идэвхтэй оролцсон.				Би хосоор уншихдаа зөв, хурдан уншсан.				Би дүрд тоглохдоо сайн ярьсан.				<p>Сурагчид даалгавар бүрийн гүйцэтгэлийн дараа өөрөө өөрийгөө үнэлнэ.</p>
Үнэлгээний шалгуур																		
Би тоглоомд идэвхтэй оролцсон.																		
Би хосоор уншихдаа зөв, хурдан уншсан.																		
Би дүрд тоглохдоо сайн ярьсан.																		
<p>Хичээлийн талаар эргэцүүлэн бодох. Энэ хэсэгт хичээл заасны дараа багш дараах асуултыг өөртөө тавьснаар хичээлээ сайжруулах үндэслэл болох юм. Хичээлийн зорилгоо зөв тодорхойлсон уу? Зорилгодоо хүрч чадсан уу? Зорилгодоо хүрээгүй бол шалтгаан нь юу вэ? Багш сурагчийн хамтын ажиллагаа амжилттай болсон уу? Хугацаагаа зөв хуваарилсан уу? Төлөвлөлтөөс гажсан уу? Яагаад? Сурагчдад бие даан ажиллах боломжийг олгосон уу?</p>		<p>Орчин: Бие биеэ сонсох, хүндэтгэх Ангийн орчныг бүрдүүлэх.</p>																



## V АНГИ. НЭГЖ ХИЧЭЭЛИЙН СЭДЭВ. ГЭР БҮЛ

Нэгж сэдвийн агуулгын ерөнхий хүрээ, хам сэдвийн агуулгын өргөсөл, гүнзгийрлийн IV ангийнхтай харьцуулах үүднээс “Гэр бүл” нэгж хичээлийг сонгон авлаа. Нэгжийн агуулгыг агуулгыг гарын авлага, дасгал ажлын дэвтэр дээр дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

- Гэр бүлийн гишүүдийн зан чанар, харилцааны хүрээнд авч үзсэн. Тухайлбал, зан чанарын хувьд өгөөмөр сайхан сэтгэлтэй, зоригтой, итгэлтэй, уриалгахан, эвтэй, хөгжилтэй байх, гэр бүлийн гишүүд бие биедээ итгэх, хүндлэх гэх мэт.
- Төрөл садан, ураг удам, тэдний холбоог авч үзсэн. Тухайлбал, ураг төрөл (аавын төрөл, ээжийн төрөл, нөхөр, эхнэр, хүргэн, бэр, авга) гэх мэт.
- Хэл зүйн хувьд зөв дуудах (я-ийн төрлийн эгшиг, ь, ь-тэй үгийн утгыг ялган зөв дуудах), зөв бичих (эгшигт, заримдаг гийгүүлэгчийн дүрэм, эгшиг гээгдэх, гээгдэхгүй тохиолдлыг ялгах), үгсийн утгыг (үйл үгийн нөхцөлийг зөв хэрэглэх) ойлгон, ялгаж хэрэглэнэ. Жишээ нь, үйл үгийн нөхцөлийн утгыг ойлгох гэх мэт. Мөн танил бус үг, холбоо үг, хэлц үгийн утгыг тайлбар толь хэлбэрээр гарын авлагад тусгасан.



### Үгийн утгыг мэдье

**шүүдрийн дусал** - өвсний толгойд тогтсон жижиг усан дусал

“Сурагчийн монгол хэлний хураангуй тайлбар толь”-оос

### Судлах цаг 8 цаг

- Нэгжийг эхийн хэмжээ, даалгаврын тоог харгалзан 80 минутаар ээлжит хичээлд хуваарилсан болно.

### Нэгжийн зорилго

- Гэр бүл, ураг төрөлтэй холбоотой агуулгыг монгол хэлээр хүлээн авч (сонсох, унших), амаар болон бичгээр (ярих, бичих) илэрхийлэх чадвараа хөгжүүлнэ.

### Хүрэх үр дүн

Суралцахуйн зорилтууд	Суралцахуйн үр дүн
5.C1, 5.C2, 5.C3, 5.C4, 5.C5.	Харилцан яриа, эхийг идэвхтэй, хүлээцтэй, зорилготой сонсож, чухал зүйлийг хүснэгт, бүдүүвчид тэмдэглэх, зурж, төсөөлөх замаар утгыг ялган, дүгнэлт хийнэ.
5.Y1, 5.Y2, 5.Y3, 5.Y4, 5.Y5.	Уншсан эхийн эхлэл, гол, төгсгөл хэсгийн үйл явдлын ялгааг харьцуулан дүгнэж, агуулгыг тайлбарлах, асуултад (яагаад, ямар учраас, хэрхэн, яаж) хариулах, шүлгийн дүрслэлийн санааг мэдэрнэ.
5.Y1, 5.Y2, 5.Y3, 5.Y4, 5.Y5.	Өөрийн санаа бодлыг жишээ татан, бусдад ойлгомжтой, товч тодорхой, оновчтой илэрхийлнэ.
5.B1, 5.B2, 5.B3, 5.B4, 5.B5.	Эхийн үйл явдлыг учир шалтгааны уялдаа холбоотой, өрнүүлэн цэвэр сайхан, алдаагүй бичнэ.
5.X1, 5.X2, 5.X3, 5.X4, 5.X5.	Эгшигт, заримдаг, онцгой гийгүүлэгчийг ялган таних, ярьж, бичихдээ үйл үгийн өнгөрсөн, одоо, ирээдүй цагийн нөхцөлийн утгыг мэдэж, зөв хэрэглэнэ.

### Агуулгын залгамж холбоо

Чадвар	5 дугаар анги
Сонсох	Харилцан яриа, эхийг идэвхтэй, хүлээцтэй, зорилготой сонсож, чухал зүйлийг хүснэгт, бүдүүвчид тэмдэглэх, зурж, төсөөлөх замаар утгыг ялган, дүгнэлт хийнэ.



Унших	Уншсан эхийн эхлэл, гол, төгсгөл хэсгийн үйл явдлын ялгааг харьцуулан дүгнэж, агуулгыг тайлбарлах, асуултад (яагаад, ямар учраас, хэрхэн, яаж) хариулах, шүлгийн дүрслэлийн санааг мэдэрнэ.
Ярих	Өөрийн санаа бодлыг жишээ татан, бусдад ойлгомжтой, товч тодорхой, оновчтой илэрхийлнэ.
Бичих	Эхийн үйл явдлыг учир шалтгааны уялдаа холбоотой, өрнүүлэн цэвэр сайхан, алдаагүй бичнэ.
Үгийн сан	Гэр бүл, төрөл садан, тэдний зан чанар, харилцааны хүрээнд үг, холбоо үг шинээр эзэмшинэ.

### Цагийн төлөвлөлт (Ээлжит хичээлийн цагийн задаргаа)

№	Ээлжит хичээлийн сэдэв	Цаг	Эхийн төрөл	Хэрэглэгдэхүүн	Шинэ үг
1.	Харилцан яриа	2	Харилцан яриа	Гарын авлагын 17-р хуудасны ДАСГАЛ 1, Гэр бүлийн бодит зураг, аудио бичлэг, зурагт үзүүлэн, загвар эх, бичгийн цаас	Яагаад?, ямар учраас? хэрэв, хэрхэн?
2.	Миний өдрийн дэглэм	2	Танилцуулга	Гарын авлагын 19-р хуудас ДАСГАЛ 2 А, Бичмэл үзүүлэн (Өдрийн дэглэмийн бүтэц, загвар, асуултауд) аудио бичлэг,	Үл тоох, уриалагхан, зан чанар, хөгжүүлэх, дутагдал, өөрчлөгдөх, сэтгэл зүрх, хамаг нууц, итгэлт анд
3.	Ураг удмаа нэрлэж суръя	2	Танилцуулга	Гарын авлагын 20-р хуудасны ДАСГАЛ 2 Б, В, Зурагт үзүүлэн, бүдүүвч, аудио бичлэг	Ураг удам, төрөл садан, үеэл, хаяал, авга, ач, зээ, эхнэр, нөхөр, хүргэн, бэр
4.	Манайхан	2	Шүлэглэсэн эх	Гарын авлагын 21-22-р хуудас, ДАСГАЛ 3 А,Б, Зурагт үзүүлэн, бүдүүвч, аудио бичлэг, зургийн дэвтэр	Уудам тал, уужим ухаан, ханагар уул, цэлмэг тэнгэр, зүйрлэх
5.	Эрэн алчуурт	2	Хүүрнэсэн эх	Гарын авлагын 23-24-р хуудас, ДАСГАЛ 4, Зурагт үзүүлэн, бичмэл үзүүлэн, Үнэлгээний хүснэгт	Шүүдрийн дусал, цэцэгт хөндий, бушуухан, хашхиран зугтах, саравчлан харах, ёроол
6.	Том болсон нь	2	Хүүрнэсэн эх	Гарын авлагын 25-р хуудас, ДАСГАЛ 5 А Б, Зурагт үзүүлэн, өгүүлбэрийн загвар	Мөрөөдөх, өсгийтэй гутал, гайхах, анзаарах, янзлах
7.	“Би том болсон” сэдвээр ярих, илтгэх	2	Харилцан яриа	Гарын авлагын 26-р хуудас, ДАСГАЛ 5 В, Илтгэл тавих төлөвлөгөөний загвар, асуулт	Итгэх, илтгэх, санаа авах, тохируулах, чин сэтгэл, дууны өнгө, сэтгэгдэл,
8.	Бататгал	2	Үнэлгээний даалгавар	ДАСГАЛ АЖЛЫН ДЭВТЭР, АЖЛЫН ХУУДАС	
нийт		16 цаг			

### Нэгж хичээлийн заах арга

Оюуны зураглал хийх уншлагын арга: Ном уншиж байхдаа хийдэг товчлол, бүтцийн зураг зэрэг нь оюуны зураглал хийх аргын нэг юм. Оюуны зураглалын аргаар ном унших арга нь дараах давуу талтай.

- Өнгө, будаг, зураас, зураг дүрсээр дамжин сурагчдын сэтгэх чадварыг дээшлүүлнэ.
- Оюуны зураглалыг зөв хийх чадвар, номын агуулгыг хялбархнаар гаргаж чадна.
- Зангилаа түлхүүр үгийг олох аргаар дамжуулан хураангуйлж ойлгох чадвар, дүгнэх чадварыг дээшлүүлэх бөгөөд түлхүүр гол үг нь цээжлэн тогтоох чадварыг хөнгөвчилж ном бичгийн агуулгыг хялбархан тогтоодог.

Унших эхийг сонгохдоо хэт хүнд биш, хэт хялбар биш, сурагчдын нас сэтгэхүйд тохирсон байхаар сонгох нь зүйтэй.



## Нэгж хичээлийн үнэлгээ

Нэгжийн үр дүнгийн үнэлгээ нь суралцахуйн үр дүнд суурилж, шалгуур, жинг үндэслэн, эзэмшсэн мэдлэг, чадварын түвшин тогтоож, үнэлгээ, дүгнэлт өгөхөд чиглэнэ. Харин хандлагыг өдөр тутмын хичээлийн явцад хичээлийн дэг дээр тусган, төлөвшлийг нь үнэлнэ.

Үнэлгээний нэгж	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэл
Сонсох	Яриа, бичлэгийг сонсож, агуулгыг хүснэгт, бүдүүвчээр илэрхийлэх, дүрслэлийг төсөөлөх, баатруудын хийсэн үйлийг ялган, дүгнэх чадвартай болно.	Зорилготой сонсох	Бусдын яриаг хүлээцтэй, зорилготой сонсож, өөрийн санаа бодлоо илэрхийлж чаддаг.
		Хүснэгт, бүдүүвчээр илэрхийлэх	Гэр бүл, төрөл садны тухай мэдээллийг сонсоод, хүснэгт бүдүүвчээр илэрхийлдэг.
		Сонссоноо төсөөлөн тогтоох	Дуу, шүлгийг сонсоод, зүйрлэлийг төсөөлөх замаар цээжлэн тогтоодог.
		Үйл явдлаас баатруудын үйлийг ялган дүгнэх	Сонссон эхийн баатруудын үйлийн учир шалтгааныг ойлгож чаддаг
		Чухал зүйлийг лавшруулан тодруулах	Өдрийн тэмдэглэлийн агуулгын чухал хэсэг (цаг хугацаа, байршил, үйл явдлын ач холбогдол)-ийг тодруулна.
Унших	Эхээс дүрслэлийн санааг мэдэрч, баатрын болон зохиолчийн үгийг ялгах, эхийн эхлэл, гол, төгсгөлийн хэсгийн үйл явдлыг харьцуулж дүгнэх чадвартай болно	Баатрын болон зохиолчийн үгийг ялгаж унших	Эхээс баатрын болон зохиогчийн үгийг ялгаж чаддаг.
		Зөв уншилт (97-100% бол чадварлаг, 90-96% бол хангалттай, 90%-аас доош бол хангалтгүй)	Танил бус эхийг түгдрэлгүй уншиж, утгыг ойлгож чаддаг.
		Хурдан унших 80-150 үг	Минутад танил бус эхээс 80-110, танил эхээс 120-150 үг уншина.
		Агуулгыг харьцуулан тайлбарлах	Зурагт танилцуулга, дасгал зааврыг уншиж, түлхүүр үг хэллэгийг олж чаддаг.
		Дүрслэлийг ялган, зохиолчийн санааг мэдэрч унших	Шүлгийн хэнийг юутай зүйрлэснийг ойлгож, дүрслэлийг төсөөлөх замаар тогтоодог, мэдрэмжээ хөдөлгөөнөөр илэрхийлдэг.
		Эхийн эхлэл, гол, төгсгөлийн хэсгийн үйл явдлын ялгааг харьцуулах	Богино эхийг уншиж, эхлэл, гол, төгсгөл хэсгийн үйл явдлын учир шалтгааныг харьцуулан ойлгодог.
		Сонгон уншиж, зорилго, бүтцийг тайлбарлах	Өдрийн тэмдэглэлийн бүтэц (цаг хугацаа, байршил, үйл явдал, сургамж)-ийг тайлбарлана.
Ярих	Ярихдаа өөрийн санаа бодлыг оновчтой, товч тодорхой, ойлгомжтой, дэс дараалалтай ярих, мэдрэмж, сэтгэгдлээ илэрхийлэн унших чадвартай болно.	Жишээ татан, баталж харилцах	Санаа бодлоо бусдад ойлгомжтой, тод дуугаар илэрхийлдэг.
		Товч тодорхой тоочих	Болсон явдлыг дарааллаар товч, тодорхой тоочиж ярьдаг.
		Мэдрэмж, сэтгэгдлээ илэрхийлэх	Шүлэг, зүйр үгийн дүрслэл, зүйрлэлийг ойлгож, сэтгэгдэл, мэдрэмжээ илэрхийлэн уншдаг.
		Хэлэх үгийг таамаглан, үг нэмж жүжиглэх	Баатрын үгийг таамаглан, дүрд тоглодог.
		Ойлгомжтой, дэс дараалалтай дамжуулж ярих	Үзсэн, харсан, болсон явдлыг дэс дарааллаар, ойлгомжтой ярьж чаддаг, тодруулж асуулт асуудаг.



Бичих	Эхийн хэлбэрийг дуурайн, үйл явдлыг учир шалтгааны уялдаа холбоотой, баримт ашиглан өрнүүлэн, дэгийн дагуу цэвэр алдаагүй бичих чадвартай болно.	Догол мөрөөр зааглан, цэвэр сайхан, алдаагүй бичих	Эхийн эхлэл, гол, төгсгөл хэсгийг зааглан цэвэр сайхан, алдаагүй бичдэг.
		Хүсэл, мөрөөдөл, зорилгодоо нийцүүлэн бичих	Өдрийн тэмдэглэл, хувийн төлөвлөгөөг агуулга, бүтцийн дагуу бичдэг.
		Хэлбэрийг дуурайн шүлэглэж бичих	Шүлэг, зүйр цэцэн үгийн хэлбэрийг дуурайн 4-8 мөрт шүлэг бичдэг.
		Үйл явдлыг учир шалтгааны уялдаа холбоотой, өрнүүлэн бичих	Эхийн эхлэл, гол, төгсгөл хэсгийн үйл явдлын учир шалтгааныг дүгнэдэг, яагаад, ямар учраас, яаж, хэрхэн зэрэг асуултад хариулдаг.
		Баримт, зураг, график ашиглан, бүтцийн дагуу зохион бичих	Мэдээг баримт, зураг, график ашиглан бүтцийн дагуу зохион бичдэг.
Хэл зүй, үгийн сан	Эгшиг гээгдэх, гээгдэхгүй тохиолдол, үйл үгийн (холбох, төгсгөх) нөхцөлийн утгыг мэдэж, зөв хэрэглэх өгүүлбэрийг хураах, дэлгэрүүлэх, толь бичиг, нэвтэрхий толь, цахим сүлжээ ашиглан танил биш үг, зарим түгээмэл хэлц үгийн утгыг ойлгох	я-ийн төрлийн эгшиг, ь, ь-тэй үгийн утгыг ялган зөв дуудах	Монгол хэлний авиа, үсэг, үг, өгүүлбэрийг зөв дуудан уншдаг, ярьдаг.
		Эгшиг гээгдэх, гээгдэхгүй тохиолдлыг ялгах	Эгшигт, заримдаг, онцгой гийгүүлэгчийг ялгах, зөв бичих, эгшиг гээгдэх, гээгдэхгүй тохиолдлын жишээн дээр тайлбарлана.
		Үйл үгийн нөхцөлийг зөв хэрэглэх	Үйл үгийн зарим төгсгөх (өнгөрсөн, одоо, ирээдүй цагийн), холбох нөхцөлүүдийн утгыг мэдэж зөв хэрэглэдэг.
		Өгүүлбэрийг хураах, дэлгэрүүлэх	Өгүүлбэрийг 2-3 үгээр дэлгэрүүлэх, хураах
		Эх сурвалж ашиглан түгээмэл хэлц үг хэллэгийн утгыг мэдэх (Үгийн нөөц 1500-2000)	Янз бүрийн эх сурвалжаас тайлбар толь ашиглан танил бус үгийн утгыг олдог, тухайн хам сэдвийн хүрээнд 50-аас доошгүй үгээр үгийн сангаа нэмэгдүүлнэ.

## ЭЭЛЖИТ ХИЧЭЭЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Энэхүү ээлжит хичээлээр уншуулах эх нь “Манайхан” эх нь шүлэглэсэн эх байх тул сургалтын жишиг хөтөлбөрийн 5.СЗ, 5.УЗ, 5.ЯЗ, 5.БЗ суралцахуйн зорилтуудыг хэрэгжүүлнэ.




**ЭЭЛЖИТ ХИЧЭЭЛИЙН СЭДЭВ:** “Манайхан” Хугацаа 80 минут

Ээлжит хичээлийн зорилго	Ээлжит хичээлийн зорилт	
Зураг бүхий шүлгийг уран уншиж цээжлэн, дуурайн бичнэ.	Шүлгийг төсөөлөх замаар цээжлэн тогтооно. Шүлгийн дүрслэлийн санааг мэдэрч, уран уншина. Шүлгийг дуурайн зохиож бичнэ. Эгшигт, заримдаг гийгүүлэгчийн эгшигтэй бичигдэх тохиолдлыг мэднэ.	
Хүрэх үр дүн: Шүлгийн санааг ойлгон уншиж, дүрслэлийг нэрлэж, 4 мөрт дуурайн бичих		
Бүх сурагчид: С: Шүлгийг сонсож, дүрсэлсэн дүрсийг тэмдэглэнэ. У: Шүлгийг цээжээр уншина. Б: Шүлгийг түлхүүр үг ашиглан дуурайн бичнэ	Ихэнх сурагчид: С: Шүлгийг сонсож, дүрсэлийг төсөөлөн түлхүүр үгсийг тогтооно. У: Шүлгийг цээжээр уншиж зүйрлэсэн санааг ойлгоно. Б: Зураг ба түлхүүр үг ашиглан дуурайн бичнэ.	Зарим сурагчид: С: Шүлгийг сонсож, төсөөлөх замаар цээжлэн тогтооно. У: Санааг мэдэрч, уран уншина. Б: Шүлгийг дуурайн зохиож бичнэ.





Үгийн сан	Уужим ухаан, уудам тал, цэлмэг тэнгэр, ханагар уул, ургаа мод, зүйрлэл
Хандлага	Гэр бүлийнхээ хүмүүсийг хайрлан хүндэтгэх, бахархах сэтгэл төрүүлнэ.
Хичээл хоорондын холбоо	Хүн ба нийгэм, дүрслэх урлаг, эх хэл
Өмнөх мэдлэг	Төрөл садан, ураг удмаа нэрлэж сурсан.

### Хичээлийн явц, арга зүй

Үе шат	Суралцахуйн үйл ажиллагаа	Явцын үнэлгээ
Зохион байгуулалт хийнэ. 2 мин	Сурагчидтай мэндэлж, амжилт хүснэ. Хичээлийн дэгийг танилцуулна. Өнгөрснийг давтана.	Хичээлийн дэгийг баримталж буй эсэхийг үнэлнэ.
Хичээлийн эхлэл 8 мин Үйл ажиллагаа 1	<p>Алхам 1. (5 мин) Сэдэлжүүлэх. Слайдаар зураг үзүүлнэ (гарын авлагын 21-р хуудас). Сурагчид зургийг ажиглан, багшийн асуултад хариулж, харилцан ярилцана. Зургийг хараад ямар шүлэг болохыг сэргээн санаж, цээжээр уншаарай. Зураг дээр юу юу байна вэ? Нэрлээрэй.</p>  <p>Танил бус үгс байгаа эсэхийг ярилцана. Шинэ үгсийн утгыг тайлбарлаж, ойлгуулна Уужим, уудам, цэлмэг, ханагар, ургаа, зүйрлэл, бөжин Уужим – уудам, цэлгэр; тавиу тайван Уудам – өргөн, тал Ханагар – өргөн Ургаа – ургасан Зүйрлэл – адилтгал Бөжин – туулайн зулзага Алхам 2.(3 мин) Хичээлийн сэдэв, зорилгыг тодорхойлох. Сурагчид хичээлийн сэдэв, зорилгыг уншиж танилцана.</p>	Сурагчдын нэрлэн хэлж байгааг, асуултад хариулж байгаад аман үнэлгээ өгнө. Мөн оролцоог үнэлнэ.
Үйл ажиллагаа 2 Хичээлийн үндсэн хэсэг 55 мин	<p>Алхам 1. (2 мин) Гарын авлагын 21-р хуудсыг ажиглан зургийн дагуу ойлгосныг илрүүлэх даалгавар ажиллана. Зурган болон үгэн карт ашиглан зургийг холбоо үгтэй харгалзуулах даалгавар өгнө.</p>  <p>ургаа мод                  ганган цэцэг                  бөжин туулай                  эрвээхэй уудам тал                  цэлмэг тэнгэр                  ханагар уул                  гэрэлт нар</p> <p>Хэнийг юутай зүйрлэсэн байна вэ?</p> <p>1 Шүлгийн мөр бүрийг асуултын дагуу ярилцъя. Шүлэгт хэн хэнийг юу юутай зүйрлэсэн бэ? Яагаад ингэж зүйрлэсэн бэ? Жишээ нь: Өвөөг “Уудам тал” гэжээ. Учир нь өвөө уужим ухаантай.</p>  <p>(уудам тал, цэлмэг тэнгэр, ханагар уул, ургаа мод, зүйрлэл)</p>	




	<p>Алхам 2. (8 мин) Шүлгийг уран тод уншина. ГА 21-р хуудас Шүлгийг уншихдаа утгыг ойлгож, аялыг тохируулан уншихад нь анхаарна.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Шүлгээ уран уншаарай. Уншихдаа юуг юутай зүйрлэснийг сэтгэлдээ сайн төсөөлж бодоорой. Хөдөлгөөнөөр илэрхийлж болно.</li> <li>- Шүлгийг сурагч бүр өөртөө уншина.</li> <li>- Анги нийтээрээ уншина</li> <li>- Эгнээгээр уншина</li> <li>- Хүүхэд бүр 1-1 мөрөөр марафон уншлагын аргаар уншина.</li> <li>- Ангийн хэд хэдэн сурагчаар уншуулна.</li> <li>- Асуултад хариулж, өөрийн санаа бодлоо илэрхийлнэ.</li> </ul> <p>Алхам 3. (10 мин) Шүлгийг дэвтэртээ цээжээр бичүүлнэ. Даалгаврыг хэрхэн гүйцэтгэхийг анхааруулж хэлнэ.</p> <p>Сурагчид даалгаврын зааврыг уншиж, шүлгийн утгад тохирох зурагтай нь харгалзуулан холбож хэлнэ, бичнэ.</p> <p>Бичсэнээ найзтайгаа дэвтрээ сольж уншаад, үгийн алдаагаа засна.</p> <p>Алхам 4. (10 мин) Шүлгийн зүйрлэлийг ашиглан сурагч бүр зургийн дэвтэртээ гэр бүлээ дүрслэн байгалийн зураг зурна. (Өвөө-уудам тал, эмээ-цэлмэг тэнгэр, аав-ханагар уул, ээж- гэрэлт нар, ах-ургаа мод, эгч-гоё цэцэг, дүү-бөжин туулай, өөрөө-ганган эрвээхэй (охин), барын бамбар (хүү)</p> <p>Зурахдаа хүний тоог харгалзана. Жишээ нь: Хоёр дүүтэй бол хоёр бүжин зурна. Хүүхдүүдийн зан чанарыг зурсан зургаар нь сонжиж болно.</p> <p>Алхам 5. (10 мин)</p> <p>Хүүхдүүд зурсан зургаа бусдадаа харуулж, тайлбарлаж чадаж байгаа эсэхийг ажиглан, багш дэмжлэг үзүүлнэ.</p> <p>Зурсан зургийн дагуу өмнөх шүлгийг дуурайж шүлэг зохиож, уншуулна.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Сурагчдыг самбарт гаргаж ажиллуулна.</li> <li>- Сурагч бүр өөрийн дуурайн зохиосон шүлгээ уншина.</li> </ul> <p>Багш хүүхдүүдийн зохиосон шүлгийн үгийг зурагтай нь зөв тохируулж хэлсэн эсэхэд анхаарна.</p>	<p>Сонссоноо ойлгож, уншиж байгаа эсэхийг үнэлнэ.</p> <p>Шүлгийг уран уншихдаа:</p> <ul style="list-style-type: none"> <li>* Үгийг ойлгомжтой, тод хэлнэ.</li> <li>* Цэг, таслалыг ялган зогсолт хийнэ.</li> <li>* Утга агуулгыг илэрхийлэн уншина.</li> </ul> <p>Багш шүлгийн эхийг слайдаар харуулж, сурагчид алдаагаа засахад ашиглаж болно.</p> <p>Хүүхдүүдийн зурах явцад урамшуулан зарим сурагчдад дэмжлэг үзүүлэх</p>
<p>Үйл ажиллагаа 2 Хичээлийн үндсэн хэсэг 55 мин</p>	<p>Алхам 6. (15 мин) Гарын авлагын 22-р хуудасны зургийн үйл явдлыг анхааралтай ажиглана.</p> <p> Б. Зургийн үйл явдлыг анхааралтай ажиглаарай.</p> <div data-bbox="303 1227 710 1451">  </div> <p>*Миний гэр бүл* сэдвээр 6 мөрт шүлэг зохиож бичээрэй.</p> <p>Сурагчид зургийн үйл явдлыг өөрсдийн ойлгосноор тайлбарлана.</p> <p>Зурган дахь хүмүүсийн хийж буй ажлын талаар ярилцана.</p> <p>Дээрх 6 зургийг ашиглан “Миний гэр бүл” сэдвээр 6 мөрт шүлэг зохионо.</p> <p>Зохиосон шүлгээ найз нартаа уншиж өгнө.</p>	<p>Шүлгийг уншихдаа утга агуулгыг зурагтай холбон зөв дарааллаар, зөв дуудан уншиж байгаа эсэхийг аман үнэлгээгээр урамшуулна.</p> <p>Зургийн үйл явдлыг зөв тайлбарлаж байгаа эсэхийг үнэлнэ. Шаардлагатай тохиолдолд засаж хэлнэ.</p> <p>Сурагчдын идэвх оролцоо, ярих, унших, бичих чадварыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.</p>
<p>3. Бататгал 10 мин</p>	<p>Алхам 1.</p> <p>Сурагчдыг самбарт гаргаж ажиллуулна.</p> <p>Сурагч бүр өөрийн зохиосон шүлгийн мөрийг уншина.</p> <p>Хамгийн сайн бичсэн шүлэг хэнийх байсныг ярилцана.</p> <p>Бусад сурагчид анхааралтай сонсож дэвтэртээ цэвэр, алдаагүй бичнэ. Сурагчид “Манайхан” шүлгийг цээжээр, хөдөлгөөн оруулж, уран уншина.</p>	<p>Шүлгийг цээжээр уран уншиж байгаа эсэхийг үнэлнэ. Шаардлагатай тохиолдолд засаж хэлнэ.</p>
<p>4. Гэрийн даалгавар 2 мин</p>	<p>Гэрийн даалгавар:</p> <p>“Манайхан” шүлгийг бүрэн эхээр нь цээжилнэ. Зургаа гүйцээнэ.</p> <p>Гарын авлагын 22-р хуудас зургийн дагуу “Миний гэр бүл” сэдвээр 6 мөрт шүлэг зохиож бичнэ.</p>	



Үйл ажиллагаа 5. Хичээлийн дүгнэлт 3 мин	Сурагчид өөрийгөө болон хичээлийг үнэлнэ. Өнөөдрийн хичээлээр би юу сурсан бэ? Өөрийгөө үнэлэх хүснэгтийг бөглөнө.	Сурагчид даалгавар бүрийн гүйцэтгэлийн дараа өөрөө өөрийгөө үнэлнэ.																				
	<table border="1" style="width: 100%;"> <tr> <td style="text-align: center;">Үнэлгээний шалгуур</td> <td style="text-align: center;"></td> <td style="text-align: center;"></td> <td style="text-align: center;"></td> </tr> <tr> <td>Би шинэ үгийн утгыг мэдэж авсан.</td> <td></td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>Би шүлгийг дүрслэх замаар тогтоож авсан.</td> <td></td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>Би шүлгийг уран уншиж сурсан.</td> <td></td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>Шүлэг дуурайн бичиж сурсан.</td> <td></td> <td></td> <td></td> </tr> </table>	Үнэлгээний шалгуур				Би шинэ үгийн утгыг мэдэж авсан.				Би шүлгийг дүрслэх замаар тогтоож авсан.				Би шүлгийг уран уншиж сурсан.				Шүлэг дуурайн бичиж сурсан.				
	Үнэлгээний шалгуур																					
	Би шинэ үгийн утгыг мэдэж авсан.																					
	Би шүлгийг дүрслэх замаар тогтоож авсан.																					
Би шүлгийг уран уншиж сурсан.																						
Шүлэг дуурайн бичиж сурсан.																						
<p><b>Санал болгох нь:</b> Хүүхдийг зурсан зургаар нь шинжихүй</p> <p>Хүүхдийн зурсан зургийн тусламжтайгаар тэдний зан чанар, итгэл, хүсэл мөрөөдөл, гэр бүл ойр дотнын хүмүүстэй хандах хандлагыг мэдэх боломжтой. Ихэнх хүүхдүүд зураг зурах дуртай байдаг учраас зураг нь хүүхэдтэй "танилцах" хамгийн тохиромжтой аргуудын нэг болдог. Ганц зургаар ямар нэгэн дүгнэлт гаргаж болохгүй. Хэрэв хүүхэд дараа дараагийн зургууддаа яг л өмнө зурсантай адил зүйлийг давтаад байвал түүний бүтээлүүдийг цуглуулан мэргэжлийн дүгнэлт гаргаж болох юм. Зураг бүр нь салангид биш байгалийн зохицлоор эмх цэгцтэй зурагдсан бол дасан зохицох чадварын түвшин өндөр байдаг. Зураг ерөнхийдөө гэрэлтэй байвал хүүхдийн сэтгэхүй тайван амьдралд дуртай, зан байдлын сайхныг илэрхийлнэ. Бүдэг, хар өнгө эсрэг байдлыг илэрхийлнэ. Гэр бүлийн бүх гишүүдийг дүрсэлсэн бол гэр бүлийн тааламжтай орчныг, дүрсүүдийн хооронд ямар нэгэн зураас элдэв юм зурж саад гаргасан бол гэр бүл зөрчилтэй байх магадлалтай. Хэрэв хүүхэд өөрийгөө хуудасны голд томоор зурсан байвал хүмүүстэй нийцтэй, зан ааш нээлттэй, өөртөө итгэлтэй. Хуудасны голд жижгээр зурсан бол аймхай, өөрөө өөртөө сэтгэл дундуур. Их нямбай зурсан бол зохион байгуулалттай, орон зайн мэдрэмжтэйг илэрхийлдэг байна.</p>																						
Хичээлийн талаар эргэцүүлэн бодох. Энэ хэсэгт хичээл заасны дараа багш дараах асуулыг өөртөө тавьснаар хичээлээ сайжруулах үндэслэл болох юм. <ul style="list-style-type: none"> <li>Хичээлийн зорилгоо зөв тодорхойлсон уу?</li> <li>Зорилгодоо хүрч чадсан уу?</li> <li>Зорилгодоо хүрээгүй бол шалтгаан нь юу вэ?</li> <li>Багш сурагчийн хамтын ажиллагаа амжилттай болсон уу?</li> <li>Хугацаагаа зөв хуваарилсан уу?</li> <li>Төлөвлөлтөөс гажсан уу? Яагаад?</li> <li>Сурагчдад бие даан ажиллах боломжийг олгосон уу?</li> </ul>	Орчин: Бие биеэ сонсох, хүндэтгэх  Ангийн орчныг бүрдүүлэх.																					

## 2.3 НЭГЖ ХИЧЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ЖИШИГ ДААЛГАВАР

Монгол хэлний сургалтын яцын болон үр дүнгийн үнэлгээг хийхдээ сургалтын жишиг хөтөлбөрийн "Үнэлгээ" хэсгийг баримтална. Үүний зэрэгцээ Монгол Улсын боловсролын үнэлгээний байгууллага болох Боловсролын үнэлгээний төвөөс 2018 онд гаргасан "Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон чанарын үнэлгээний журам"-ыг хэрэгжүүлэх зөвлөмж, мөн 2021 онд гаргасан Бага боловсролын хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг хэрэглэх зөвлөмж (Монгол хэл) зэргийг ашиглаарай.



Зөвлөмжийн энэхүү хэсэгт тухайн ангийн түвшинд үр дүнгийн үнэлгээнд ашиглаж болох нэмэлт даалгаврыг үнэлгээний рубрикийн хамт оруулаа. Эдгээр үнэлгээний даалгаврыг боловсруулахдаа нэгж хичээлийн суралцахуйн үр дүн болон сургалтын жишиг хөтөлбөрийн үнэлгээний шалгуурыг баримталсан болно.

Зураг. Сургалтын жишиг хөтөлбөрийн үнэлгээний зорилт

Багш нар сурагчдын монгол хэлний түшингээс хамаарч, анги харгалзалгүйгээр олшруулан хэрэглэх боломжтой юм.

## II АНГИ. ҮНЭЛГЭЭНИЙ ДААЛГАВАР

### 1. Зөв, хурдан унших чадварыг үнэлэх даалгавар

#### Чөлөөт цаг

Намайг Дорж гэдэг. Би хоёрдугаар ангид сурдаг. Миний сайн найзыг Бат гэдэг. Бат бид хоёр нэг ангид сурдаг. Өдөр бүр сургуульдаа хамт явдаг.

Би ном унших дуртай. Надад олон ном бий. Бас зураг зурах дуртай. Бат хичээлдээ маш сайн. Тэр шатар, даам тоглох дуртай. Би найзаасаа шатар тоглож сурсан. Бид хоёр Бямба гарагт монгол хэлний дугуйланд явдаг. Монголоор сайн ярьж, бичиж сурсан. Бас чөлөөт цагаараа хөл бөмбөг тоглодог. Гэрийн даалгавраа хамт хийдэг. Тэр надад үргэлж тусалдаг. Би түүнд баярладаг.

2  
13  
25  
38  
49  
59  
69  
74  
82

### 2. Сонсох-ярих чадварыг үнэлэх даалгавар

а) Эхийг уншаад, асуултад хариулаарай.

1. Доржийн найзыг хэн гэдэг вэ?
2. Тэд хэддүгээр ангид сурдаг вэ?
3. Хэн, юу хийх дуртай вэ? Зургийг харгалзуулна уу.



Бат



Дорж



4. Тэд ямар дугуйланд явдаг вэ? Зөв хариултыг сонгоорой.

- А. Зураг                      Б. Монгол хэл                      В. Хөл бөмбөг

### 3. Бичих чадварыг үнэлэх даалгавар

1. Зурагт тохирох үгийг олж бичээрэй. (зураг зурах, тоо бодох, цэвэрлэх, ном унших, шатар тоглох, унтах)



.....

.....

.....



.....

.....

.....



.....

.....

.....



.....

.....

.....



.....

.....

.....




.....

.....

.....

2. Зургийн дагуу 3-5 өгүүлбэр зохиож бичээрэй.



Three sets of handwriting practice lines, each consisting of a solid top line, a dashed middle line, and a solid bottom line, with a diagonal line from the top-left to the bottom-right.

3. Хэлзүй, үгийн санг хэрэглэх чадварыг үнэлэх даалгавар

а). Үгсийг утгаар нь ялгаж бичээрэй.

(Болд, тоглох, сурагч, бүжиглэх, Мягмар, Лхагва, Хүн ба орчин, хүүхэд, Бямба, багш, унтах, Биеийн тамир, явах, Пүрэв, Хөгжим, дуулах, Математик)

Хүн	Гараг	Хичээл	Үйл хөдлөл

**Нэгжийн үнэлгээний даалгаврын үнэлгээний рубрик**

Даалгавар	Гүйцэтгэлийн түвшин			
	I түвшин (1 оноо)	II түвшин (2 оноо)	III түвшин (3 оноо)	IV түвшин (4 оноо)
Даалгавар 1. Зөв, хурдан унших чадвар	Ихэнх үгсийг алдаж уншина. Нэг минутад 40-өөс доош үг уншина.	5-6 үг алдаж уншина. Нэг минутад 40-өөс 60 үг уншина.	3-4 үг алдаж уншина. Нэг минутад 61-аас 80 үг уншина.	Алдаагүй уншихыг хичээнэ. 1-2 үг алдаж болно. Нэг минутад 80-аас дээш үг уншина.



Даалгавар 2. Сонсох-ярих (хүлээн авах, илэрхийлэх) чадвар	Эхийн дагуу өгсөн 4 даалгаврын 20-30 хувийг гүйцэтгэсэн.	Эхийн дагуу өгсөн 4 даалгаврыг 50-иас дээш хувийг зарим нэг алдаатай гүйцэтгэсэн.	Эхийн дагуу өгсөн 4 даалгаврыг 80 хүртэл хувийг алдаагүй гүйцэтгэсэн.	Эхийн дагуу өгсөн 4 ажил бүхий уншсанаа ойлгосон эсэхийг илрүүлэх даалгавруудыг алдаагүй, бүрэн гүйцэд гүйцэтгэсэн.
Даалгавар 3. Бичих чадвар	Бичих чадварыг илрүүлэх 2 даалгаврыг гүйцэтгэхдээ Зурагт тохирох үгийг олж бичихийг оролдсон. Зургийн дагуу 1-ээс доошгүй өгүүлбэр бичсэн. Зарим нэг үеийг зөв бичсэн.	Бичих чадварыг илрүүлэх 2 даалгаврыг гүйцэтгэхдээ Зурагт тохирох зарим үгийг оновчтой тохируулсан. Зургийн дагуу 2-оос доошгүй өгүүлбэр бичсэн.	Бичих чадварыг илрүүлэх 2 даалгаврыг гүйцэтгэхдээ Зурагт тохирох үгсийг бүрэн тохируулсан. 3-5 өгүүлбэр бичихдээ хэл зүйн зарим алдаа гаргасан.	Бичих чадварыг илрүүлэх 2 даалгаврыг бүрэн гүйцэтгэсэн Хэл зүйн алдаагүй гүйцэтгэсэн.
Даалгавар 4. Хэлзүй, үгийн санг хэрэглэх чадвар	Өгсөн үгсийг 1-2 төрлөөр ангилах оролдлого хийсэн.	Өгсөн үгсийг 2-3 төрлөөр ангилж бичсэн. Зарим үгсийг сольж ангилсан.	Өгсөн үгсийг 4 төрлөөр ангилж бичсэн. 1-2 үгийг сольж ангилсан.	Өгсөн үгсийг 4 төрлөөр бүрэн, зөв* ангилж бичсэн.

\* Болд, тоглох, сурагч, бүжиглэх, Мягмар, Лхагва, Хүн ба орчин, хүүхэд, Бямба, багш, унтах, Биеийн тамир, явах, Пүрэв, Хөгжим, дуулах, Математик гэсэн үгсийг зөв ангилсан байдал

Хүн	Гараг	Хичээл	Үйл хөдлөл
- Болд - Багш - Сурагч - Хүүхэд	- Мягмар - Лхагва - Бямба - Дүрэв	- Хүн ба орчин - Биеийн тамир - Хөгжим - Математик	- Тоглох - Бүжиглэх - Унтах - Явах - Дуулах

### III АНГИ. ҮНЭЛГЭЭНИЙ ДААЛГАВАР

1. Зөв, хурдан унших чадварыг үнэлэх даалгавар

Миний найзын танилцуулга	
Миний найзыг Ержан гэдэг. Тэр найман настай, гуравдугаар ангийн сурагч. Ержан Толбо суманд аав, ээж, дүүтэйгээ амьдардаг. Ержаны аав, ээж хоёр сумандаа талхны жижиг үйлдвэр ажиллуулдаг. Дүү нь нэгдүгээр ангийн сурагч. Дүүгээ хичээлээс нь авч, даалгавраа хийхэд нь тусалдаг гэсэн. Бид хоёр зусланд амрахдаа шатар тоглож танилцсан. Тэр сайхан сэтгэлтэй, тусч хүүхэд. Бас гоёо дуулдаг, домбор хөгжмөөр цоглог ая тоглож, авьяасаа үзүүлсэн. Би найзаараа бахархсан. Тэр ирээдүйд тооны багш болохыг хүсдэг. Тоо бодоход толгой сэргээд, урамтай шүү гэж ярихад нүүр нь гэрэлтээд, нүд нь улам томорсон юм шиг санагдсан. Намайг гэртээ урьсан. Би амралтаараа тэднийд айлчлан очно. Найздаа өөрийн зурсан цуврал зурагтай дэвтрээ бэлэглэнэ.	3 10 24 30 43 53 63 73 84 93 102

Сонсох-ярих чадварыг үнэлэх даалгавар

Зөв хариултыг сонгоорой.

1. Ержан хэний найз вэ?

миний  чиний



2. Тэр хэдэн настай, хэддүгээр ангид сурдаг вэ?

- 8 настай, хоёрдугаар анги       7 настай, гуравдугаар анги
- 7 настай, хоёрдугаар анги       8 настай, гуравдугаар анги

3. Бид хоёр яаж танилцсан бэ? Харгалзуулаарай.

Сургууль дээр



заалгаж

сурсан.

Зусланд



тоглож

уулзсан.

Сумандаа



сурч

танилцсан

### Унших чадварыг үнэлэх даалгавар

4. Өөрийн танилцуулгаа бичээрэй.

1. Чиний нэр хэн бэ?

..... нэрийг ..... гэдэг.

2. Чи хэдэн настай вэ?

..... настай.

3. Чи хэддүгээр ангид сурдаг вэ?

..... сурдаг.

4. Чи чөлөөт цагаараа юу хийх дуртай вэ?

..... чөлөөт цагаараа ..... дуртай.

5. Түлхүүр үгийн дагуу өөрийн танилцуулгыг бичээрэй.

Овог .....

Нэр .....

Нас ..... хүйс .....

Амьдардаг газар .....

Сургууль .....

Чөлөөт цаг .....

Авьяас .....

Зан чанар .....

Гарын авлага болон ДАД-т байгаа хувилбараас түлхүүр үг нэмж хэрэглэвэл хүүхдийн өөрийгөө зөв илэрхийлэхэд дөхөмтэй. Загварыг өөр өөр хувилбараар зохиож ашиглаарай.





2. Сонсох- ярих чадвар	Өөрийн найз гэж ойлгон чиний гэсэн үгийг ойлгосон бол		Танилцуулга бичигчийн найз гэж ойлгон миний гэсэн үгийг сонгосон бол	
	Хоёр үгийг буруу сонгосон бол	Нас зөв, анги буруу сонгосон бол	Анги зөв, нас буруу сонгосон бол	Хоёр үгийг зөв бичсэн бол
	1 үгийг зөв, бүх үгийг буруу сонгож, харгалзуулж холбосон бол	2 үгийг зөв харгалзуулж холбосон бол	3 үгийг зөв харгалзуулж холбосон бол	4 үгийг зөв харгалзуулж холбосон бол
3. Унших чадвар	Танилцуулгын 40-60 хувийг бичиж тэмдэглэсэн байна.	Танилцуулгын 70 хувийг бичиж тэмдэглэсэн байна.	Танилцуулгын 80 хувийг бичиж тэмдэглэсэн байна.	Танилцуулгыг бүрэн бичиж тэмдэглэсэн байна.
4. Бичих чадвар Хэл зүйн санг хэрэглэх чадвар	Өгүүлбэрийг 3-4 үгээр нэмэн, ойролцоо үгийн утгыг бүрэн гарган дүрмийн алдаагүй бичсэн бол	Өгүүлбэрийг 4-6 үгээр нэмэн, ойролцоо үгийн утгыг бүрэн гарган дүрмийн алдаагүй бичсэн бол	Өгүүлбэрийг 5-7 үгээр нэмэн, ойролцоо үгийн утгыг бүрэн гарган дүрмийн алдаагүй бичсэн бол	Бичих чадварыг илрүүлэх 2 өөр хувилбарыг оруулаа. Өгүүлбэрийг 5-8 үгээр нэмэн, ойролцоо үгийн утгыг бүрэн гарган дүрмийн алдаагүй бичсэн бол
	Танилцуулгаас 5-аас дээш үгийг зөв ялган, -ийн, -ын залгаврыг зөв холбон бичсэн бол	Танилцуулгаас 6-7 үгийг зөв ялган, -ийн, -ын залгаврыг зөв холбон бичсэн бол	Танилцуулгаас 8-9 үгийг зөв ялган, -ийн, -ын залгаврыг зөв холбон бичсэн бол	Танилцуулгаас 10 үгийг зөв ялган, -ийн, -ын залгаврыг зөв холбон бичсэн бол

#### IV АНГИ. ҮНЭЛГЭЭНИЙ ДААЛГАВАР

Нэгж хичээлийн сэдэв:

Амьтад

Эхийг анхааралтай сонсоод даалгаврыг ажиллаарай.


##### Арслан унага хоёр

Нэгэн өдөр арслан ойд явж байгаад маш их өлсөв гэнэ. Хоол хайж яваад ойн цоорхойд тоглож буй унагыг олж харлаа. Тэгээд сэмхэн дайрч, барьж идэх гэтэл унага гэнэт эргэн хараад:

- Сайн байна уу? Сайн найз минь! гэж эелдэгхэнээр мэндэлжээ.

Үүнийг сонссон арслан өөрөөсөө ичиж, унагыг идэх бодлоо орхин, өлөн хоосон ходоодтой чигээрээ ой руугаа буцав.

1. Эхийн үйл явдал хаана болсон бэ? Дугуйлаарай.



А.



Б.



В.

2. Эхийн үйл явдал хэзээ болсон бэ? Дугуйлаарай.

А. Өглөө

Б. Өдөр

В. Орой

**Эхийг анхааралтай уншаад даалгаврыг ажиллаарай.**

3. Унага болон арслангийн хийсэн үйлийг зөв холбоорой



унагыг барих гэсэн

Муу үйл



арслантай эелдэг мэндэлсэн

Сайн үйл

4. Арслан унагыг яагаад барих гэсэн бэ?

- А. Ичсэн учраас хамт ан хийх гэж
- Б. Уйдсан учраас хамт зугаалах гэж
- В. Өлссөн учраас идэх гэж

5. Эхэд тохиолдсон зүйл чамд тохиолдож байсан уу? Жишээгээр батлан яриарай.

**Бичих даалгавар**

6. Эхийн үйл явдлын дагуу дугаарлаарай.

- Өвс идэж буй унагыг харсан.
- Ичиж унагыг барьж идэхээ больсон.
- Арслан маш их өлссөн.

7. Дээрх өгүүлбэр болон зургийг ашиглан эхийн үйл явдлыг яриарай.

8. а. Арсланд тохирох шинжүүдийг сонгож "✓" тэмдэглээрэй.

Махан идэштэн	<input type="checkbox"/>	Аймхай	<input type="checkbox"/>	Араатны хаан	<input type="checkbox"/>	Зальтай	<input type="checkbox"/>
---------------	--------------------------	--------	--------------------------	--------------	--------------------------	---------	--------------------------

б. Сонгосон үгсээ ашиглан арсланг тодорхойлж бичээрэй.

---

---

9. Арслан яагаад хоосон ходоодтой буцав? Хариулж бичээрэй.

---

---

10. Үгийн утгыг ялган бичээрэй

Ажил хийхэд \_\_\_\_\_ хэрэгтэй.

Аргал түүхэд \_\_\_\_\_ хэрэгтэй.

арга араг



## Даалгаврын үнэлгээний рубрик

Даалгавар	Гүйцэтгэлийн түвшин			
	I түвшин (1 оноо)	II түвшин (2 оноо)	III түвшин (3 оноо)	IV түвшин (4 оноо)
Сонсох (1,2) Эхийн үйл явдлыг зөв дараалуулж чаддаг.	Эхийг сонсоод үйл явдал хаана, хэзээ өрнөснийг тодорхойлдоггүй.	Эхийг сонсоод үйл явдал хэзээ өрнөснийг тодорхойлдог.	Эхийг сонсоод үйл явдал хаана, өрнөснийг тодорхойлдог.	Эхийг сонсоод үйл явдал хаана, хэзээ өрнөснийг өөртөө итгэлтэй, зөв тодорхойлдог.
Унших (3,4) Сайн, муу үйлийг ялгаж, бодит амьдралтай харьцуулан оновчтой жишээ татан тайлбарладаг.	Сайн, муу үйлийг ялгаж чаддаггүй.	Сайн муу үйлийг ялгадаг ч, жишээ татан тайлбарлаж чаддаггүй.	Сайн, муу үйлийг ялгадаг	Сайн, муу үйлийг ялгадаг.
	Учир шалтгааныг ойлгодоггүй.	Учир шалтгааныг багшийн дэмжлэгтэй ойлгодог.	Учир шалтгааныг ойлгодог.	Учир шалтгааныг ойлгож, оновчтой жишээгээр баталдаг.
Ярих (5, 6, 7) Зураг ашиглан эхийн үйл явдлыг ярьдаг.	Бодит амьдралтай харьцуулж чаддаггүй.	Бодит амьдралтай харьцуулахдаа оновчгүй жишээ татдаг.	Бодит амьдралтай харьцуулахдаа жишээ татаж тайлбарладаг.	Бодит амьдралтай харьцуулан оновчтой жишээ татан тайлбарладаг.
	Эхийн үйл явдлыг илэрхийлсэн өгүүлбэрүүдийг 1-2 алдаж дугаарладаг.	Эхийн үйл явдлыг илэрхийлсэн өгүүлбэрүүдийг зөв дугаарладаг.	Эхийн үйл явдлыг зураг ашиглан, замбараагүй, сул дуугаар ярьдаг.	Эхийн үйл явдлыг зураг ашиглан, ойлгомжтой, тодорхой, тод чанга дуугаар ярьдаг.
Бичих (8, 9)	Арсланд тохирох 1 шинжийг тэмдэглэсэн.	Арсланд тохирох 2 шинжийг оновчтой тэмдэглэсэн.	Арсланг хураангуй өгүүлбэрээр бүрэн биш тодорхойлж бичсэн.	Арсланг дэлгэрэнгүй өгүүлбэрээр бүрэн тодорхойлж бичсэн.
	Эхийн үйл явдлыг дараалуулж чаддаггүй.	Эхийн эхлэл, гол хэсэг, төгсгөлийг сольдог.	Эхийн үйл явдлын гол хэсгийн дарааллыг алдуулдаг.	Эхийн үйл явдлыг бүрэн зөв дараалуулж тэмдэглэдэг.
Хэлзүй, үгийн сан (10)	Дуудлага ижил, утга бичлэг өөр үгийн утгыг ялгахдаа хольж сольдог.	Дуудлага ижил, утга бичлэг өөр үгийн утгыг ялгадаг ч өгүүлбэр зохион бичдэггүй.	Дуудлага ижил, утга бичлэг өөр үгийн утгыг ялгадаг ч алдаатай өгүүлбэр зохион бичдэг.	Дуудлага ижил, утга бичлэг өөр үгийн утгыг ялган, алдаагүй өгүүлбэр зохион бичдэг.

**Нэгж хичээлийн сэдэв:** Уламжлалт ёс заншил

**Шүлгийг анхааралтай сонсоод даалгаврыг ажиллаарай.**

### Мэдэж авлаа

Цагаан сарын шинийн нэгний өглөө  
Цайгаа чанаж, гоёлоо өмсөөд  
Тооноор нар тусахын үед  
Томчууд хүүхдүүд өвөөгийн цуглаад



Гэр дүүрэн хүмүүс хоорондоо  
Гар зөрүүлэн бүгдээрээ золгов.

Ажаад байсан чинь  
Аав ээжтэй золгосонгүй  
Ах бэргэн эгчтэй золгосонгүй  
Авгай нөхөр хоёр хоорондоо золгодоггүй  
Ардын ёс байдгийг мэдлээ.

Д.Санжжав

1. Шүлэгт юуны тухай гарсан бэ?



А.



Б.



В.

2. Шүлгийн утгыг зургаар гаргаарай.

3. Шүлгийг уран уншаарай.

4. Шинийн нэгэн гэж ямар өдөр вэ?

Шинийн нэгний  
өдөр

А Хуучин оны сүүлчийн өдөр

Б Шинэ оны эхний өдөр

5. Хэн хэнтэй золгодоггүй вэ? Зөвийг сонгож "✓" тэмдэглээрэй.

Аав өвөөтэйгөө

Эхнэр нөхөртэйгөө

Эмээ ач нартайгаа

6. Хүү ямар ардын ёсыг мэдэж авсан бэ? Бичээрэй.

---



---

7. Шүлгийн дараах 2 мөрийг дуурайн зохион бичээрэй.

"Авгай нөхөр хоёр хоорондоо золгодоггүй

Ардын ёс байдгийг мэдлээ"

8. Агуулгын зураглалыг ашиглан цээжилсэн шүлгээ уран уншаарай.

9. Хүснэгтийг жишээгээр нөхөж бичээрэй.



Олон тооны нөхцөлтэй үг	Тийн ялгалын нөхцөлтэй үг	Хамаатуулах нөхцөлтэй үг
1.	1.	1.
2.	2.	2.

### Үнэлгээний рубрик

Даалгавар	Гүйцэтгэлийн түвшин			
	I түвшин (1 оноо)	II түвшин (2 оноо)	III түвшин (3 оноо)	IV түвшин (4 оноо)
Сонсох 1,2 Шүлгийг сонсож ойлгон, агуулгыг зураглах	Шүлгийг сонсож ойлгон, агуулгыг зурагладаггүй.	Шүлгийг сонсож ойлгон, агуулгыг алдаатай зурагладаг.	Шүлгийг сонсож ойлгон, агуулгыг ерөнхийд нь зурагладаг.	Шүлгийг сонсож ойлгон, агуулгыг оновчтой зурагладаг.
Унших 3,4,5 Шүлгийг өргөлт, зогсолт, аялгыг тохируулан уран унших	Шүлгийг жигд хэмнэлээр уншдаг.	Шүлгийг өргөлтийг тохируулан уран уншдаг.	Шүлгийг өргөлт, зогсолтыг тохируулан уран уншдаг.	Шүлгийг өргөлт, зогсолт, аялгыг тохируулан уран уншдаг.
	Шүлгийг уншаад утга агуулгыг ойлгодоггүй.	Шүлгийг уншаад багшийн тусламжтай тайлбарлуулж ойлгодог.	Шүлгийг уншаад эхний бадгийг ойлгодог.	Шүлгийг уншаад утга агуулгыг бүрэн ойлгодог.
Бичих 6,7	Асуултыг ойлгохгүй, хариулан бичиж чаддаггүй.	Асуултыг ойлгосон ч хариулан бичиж чаддаггүй.	Асуултыг ойлгож, хариулж бичихдээ алдаатай тоочин бичдэг.	Асуултыг ойлгож, хариулж бичихдээ оновчтой, алдаагүй тоочин бичдэг.
	Шүлгийн хэлбэр бүтцийг дуурайн зохион бичиж чаддаггүй.	Шүлгийн хэлбэр бүтцийг дуурайн зохион бичих гэж оролддог.	Монгол ёсыг сайн мэдэж ойлгоогүй ч шүлгийн хэлбэр бүтцийг дуурайн зохион бичдэг.	Монгол ёсыг мэдэж авсан талаарх шүлгийн хэлбэр бүтцийг дуурайн зохион бичдэг.
Ярих 8 Цээжилсэн шүлгээ уран уншдаг.	Агуулгын зураглалаа ашиглаж чаддаггүй, шүлгийг цээжлээгүй.	Агуулгын зураглалаа ашиглаж чаддаггүй, шүлгийг дутуу уншдаг.	Агуулгын зураглалаа ашиглан, шүлгийн эхний бадгийг цээжилснээ уншдаг.	Агуулгын зураглалаа ашиглан, шүлгийг бүхэлд нь цээжилснээ уншдаг.
Хэлзүй, үгийн сан 9 Тийн ялгал, олон тоо хамаатуулах нөхцөлтэй үгийг ялгадаг.	Нэрийн нөхцөлүүдийг таньдаггүй, түүж бичиж чаддаггүй.	Олон тооны нөхцөлтэй үгсийг эхээс олж, алдаагүй бичдэг.	Олон тоо, тийн ялгалын нөхцөлтэй үгсийг эхээс олж, алдаагүй бичдэг.	Олон тоо, тийн ялгал, хамаатуулах нөхцөлтэй үгсийг эхээс олж, алдаагүй бичдэг.

## V АНГИ. ҮНЭЛГЭЭНИЙ ДААЛГАВАР

### Өвгөн ач хүү хоёр

Нэг өвгөн нас өндөр болж хөгшрөн юм харахгүй юу ч сонсдоггүй, хөл гараа ч олигтой хөдөлгөж чадахаа байжээ. Хамаг шүд нь унасан болохоор хоол амнаас нь эргэн гоожоод байдаг болсон тул хүү бэр хоёр нь аавыгаа ширээнд суулгаж хамт хооллохоо байжээ. Өвгөнийг пийшингийнхээ ард суулган тусад нь хооллодог болж л дээ.

Нэг удаа аягатай хоол аваачиж өгөхөд өвгөн өөртөө ойртуулах гэж байгаад унагаж, аягаа хагалан хоолоо асгахад бэр нь ихэд уурлан,



- Энэ өвгөн хөгшрөөд дэндүү хэцүү болжээ. Гэрт маань байгаа бүгдийг хагалж эвдээд дуусгалаа гээд үүнээс хойш өвгөнийг модон тэвшин дотор хооллож байя гэж загнажээ. Хөөрхий өвгөн юу ч хэлсэнгүй, санаа алдаад өнгөрч гэнэ.

Нэг өдөр эхнэр нөхөр хоёр гэртээ суугаад хооллож байтал Миша хүү нь шалан дээр байсан модон шоонуудыг эвлүүлж нийлүүлэн нааж байхыг хараад аав нь

- Хүү минь чи юу хийж байна вэ? гэхэд хүү:
- Аав минь би тэвш хийж байна. Ээж та хоёрыг хөгшрөхөөр би энэ тэвшиндээ хоол хийж өгнө гэжээ. Хүүгийнхээ хэлэхийг сонссон эхнэр нөхөр хоёр бие биеэ хараад уйлжээ.

Хөөрхий хөгшнийг дэндүү гомдоосондоо маш их ичиж, түүнээс хойш өндөр настай аавыгаа хүндлэн хайрлаж, асран халамжилдаг болсон гэдэг.

1. Эхээс гэр бүл сэдэвтэй холбоотой үгсийг олж бичээрэй.

.....  
 .....

2. Өвгөн Миша хүүгийн ямар хамаатан бэ?

- A. Өвөө нь                      Б. Ээжийнх нь аав                      В. Авга ах нь
- Г. Нагац ах нь                      Д. Тэднийд амьдардаг өвгөн

3. Хүү бэр хоёр нь яагаад аавтайгаа нэг ширээнд сууж хооллохоо больсон бэ?

- A. Юм харахаа больсон нь
- Б. Юу ч сонсдоггүй болохоор
- В. Шүд нь унаад идэх гэсэн хоол нь амнаас нь эргэж гоожоод байдаг болохоор
- Г. Өвгөнийг дулаан пийшингийн ард суулгах гэж

4. Өвгөн яагаад аягатай хоолоо унагаж хагалсан бэ?

- A. Гар хөлөө хөдөлгөж чадахгүй болохоор
- Б. Аягатай хоолоо өөртөө ойртуулах гэж байгаад
- В. Хамт хооллохоо болсонд гомдоод
- Г. Хөөрхий өвгөн санаа алдахдаа

5. Эхийн гол санаа аль нь бэ?

- A. Хүн өтөлж хөгширдөг тухай                      В.Хатуу сэтгэлтэй бэрийн тухай
- С. Ач хүүгийн тухай                      Д. Эцэг эхээ хайрлан халамжлах тухай
- Е.Хөгшин хүний сэтгэлийн тухай

6. Өвгөнийг хоолоо асгахад бэр нь юу гэж хэлсэн бэ?

.....  
 .....  
 .....

7. Миша хүү аавынхаа асуултад юу гэж хариулсан бэ?

.....  
 .....  
 .....



